



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199^I оны II
сарын 15 өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

Ардын Их Хурлын II хуралдааны 5 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9⁰⁰ цагт Ардын Их Хурлын танхимд эхлэв. Хуралдааныг Ж.Уртгасан даргалав.

9⁰⁰ цагт өчигдрийн хуралдааны ирцийг танилцуулав.

Дараа нь депутатуудын ирцийг компьютераар авав. Хуралдаанд 393 депутат ирсэн, ирц 93% байв. Г.Чингэл, Т.Батмөнх, Ц.Охинтогтох, Н.Сампилноров нар өвчтэй, Г.Сүрэнжаргал гадаадад ажлаар явсан байв. /Ирцийг хавсаргав/

9⁰² цагт тус хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон, иргэдээс ирүүлсэн санал, захидал, утас, цахилгааны тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Г.Жагай уншиж танилцуулав.

9¹¹ цагт өчигдөр нээлттэй орхисон депутатуудын хорооны бүрэлдэхүүний тухай хуралдааны дарга танилцуулав. 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн/нэрээ авав/, 231-р тойргийн депутат Ц.Төмөрбаатар нар үг хэлэв. Ж.Уртнасан уг бүрэлдэхүүнд орсон депутатуудыг нэрийг уншив.

245-р тойргийн депутат Ч.Чинбат/нэрээ авав/, 82-р тойргийн депутат А.Сарай/нэрээ авав/, 294-р тойргийн депутат И.Бадарч/нэрээ авав/, 208-р тойргийн депутат З.Жанжаадорж, 340-р тойргийн депутат Б.Сумьяа, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 380-р тойргийн депутат Л.Батчулуун, 145-р тойргийн депутат Л.Лантуу, 307-р тойргийн депутат Ж.Доржсүрэн, 396-р тойргийн депутат Б.Чимид, 94-р тойргийн депутат Б.Сандуйжав/нэрээ авав/, 149-р тойргийн депутат Т.Анигар/нэрээ авав/, 4-р тойргийн депутат К.Зардыхан, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 151-р тойргийн депутат Б.Алагаа, 414-р тойргийн депутат Д.Цэрэн, 343-р тойргийн депутат С.Намсрайжав/нэрээ татав/, 9-р тойргийн депутат С.Зориг, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн/нэрээ авав/, 121-р тойргийн депутат Б.Норжин/нэрээ авав/, 291-р тойргийн депутат Г.Хашбаатар,

185-р тойргийн депутат Д.Жанцан, 360-р тойргийн депутат Д.Найдан, 228-р тойргийн депутат Н.Адъяажав, 260-р тойргийн депутат Ж.Буд/нэрээ оруулах санал/нар үг хэлэв. Депутатуудын олонхийн шаардлагаар санал таслах санал хураав. зөвшөөрсөн 301/82%/ , татгалзсан 54/15%/ , гүдгэлзсэн 11/3%/ , бүгд 366/86%/ , саналыг таслав.

Депутатуудын хорооны бүрэлдэхүүний тоог тогтоох талаар санал хураах болов.

132-р тойргийн депутат С.Чулуунбаатар, 61-р тойргийн депутат Д.Дамбийжанцан, 71-р тойргийн депутат Г.Ядамсүрэн нар хуралдааны дэг, хорооны бүрэлдэхүүнтэй холбогдуулан санал бодлоо илэрхийлэв. Депутатуудын хорооны бүрэлдэхүүнийг нэрийн дарааллаар санал хураав.

| | | |
|--------------------|-----|-----|
| 1. Ж. Гомбожав | 331 | 95% |
| /326-р тойрог/ | 12 | 3% |
| | 9 | 2% |
| | 402 | 94% |
| 2. Ж. Адъяа | 380 | 93% |
| /202-р тойрог/ | 15 | 4% |
| | 13 | 3% |
| | 408 | 96% |
| 3. К. Мизамхан | 370 | 91% |
| /74-р тойрог/ | 24 | 6% |
| | 12 | 3% |
| | 406 | 95% |
| 4. Б. Мижид | 382 | 93% |
| | 16 | 4% |
| | 12 | 3% |
| | 410 | 96% |
| 5. Д. Лундаажанцан | 380 | 93% |
| | 19 | 5% |
| | 11 | 3% |
| | 410 | 96% |
| 6. Ч. Дэмбэрэлням | 358 | 89% |
| | 31 | 8% |
| | 15 | 4% |
| | 404 | 95% |

| | | |
|-------------------------------------|-----|-----|
| 7.Ж.Дэмбэрэл | 350 | 86% |
| | 35 | 9% |
| | 21 | 5% |
| | 406 | 95% |
| 8.Н.Жанцан | 368 | 90% |
| | 31 | 8% |
| | 12 | 3% |
| | 411 | 96% |
| 9.Д.Жагварал | 323 | 79% |
| | 64 | 16% |
| | 22 | 5% |
| | 409 | 96% |
| 10.С.Чулуунбаатар /132-р тойрог/ | 349 | 86% |
| | 44 | 4% |
| | 14 | 3% |
| | 407 | 95% |
| 11.Д.Гомбожав | 334 | 82% |
| | 51 | 13% |
| | 23 | 6% |
| | 408 | 96% |
| 12.Ш.Цэнджаргал | 311 | 76% |
| | 66 | 16% |
| | 32 | 8% |
| | 409 | 96% |
| 13.Ю.Жаргал /46-р тойрог/ | 305 | 75% |
| | 78 | 19% |
| | 24 | 6% |
| | 407 | 95% |
| 14.Ш.Сүрэнжав | 290 | 71% |
| | 98 | 24% |
| | 21 | 5% |
| | 409 | 96% |
| 15.Ж.Бямбаа | 164 | 40% |
| | 215 | 53% |
| | 26 | 6% |
| | 405 | 95% |

| | | |
|----------------|-----|-----|
| 16.Л.Дашням | 268 | 66% |
| /22-р тойрог/ | 119 | 29% |
| | 22 | 5% |
| | 409 | 96% |
| 17.Ц.Энхбат | 291 | 72% |
| /23-р тойрог/ | 91 | 22% |
| | 24 | 6% |
| | 406 | 95% |
| 18.С.Зориг | 287 | 70% |
| | 97 | 24% |
| | 25 | 6% |
| | 409 | 96% |
| 19.Н.Пүрэвдорж | 283 | 69% |
| /41-р тойрог/ | 99 | 24% |
| | 27 | 7% |
| | 409 | 96% |
| 20.Ж.Авхиа | 350 | 86% |
| | 47 | 12% |
| | 11 | 3% |
| | 408 | 96% |
| 21.Ж.Буд | 316 | 77% |
| | 70 | 17% |
| | 22 | 5% |
| | 408 | 96% |

180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар эмэгтэй депутат оруулах/388-р тойргийн депутат Б.Энхтуяаг/ санал гаргав.

| | | |
|-----------------|-----|-----|
| 22. Нороврагчаа | 257 | 64% |
| | 105 | 26% |
| | 42 | 10% |

Нийтэд нь батлав.

| | | |
|------------|-----|-----|
| Зөвшөөрсөн | 362 | 89% |
| татгалзсан | 25 | 6% |
| түдгэлзсэн | 18 | 4% |
| БҮГД | 405 | 95% |

10¹⁸ цагт 119-р тойргийн депутатын сонгуультай холбогдсон хуульчдын дүгнэлтийг Ж.Уртнасан уншиж сонсгов. Уг тойрогт явагдсан сонгуулийн талаар магадлах ажлын комисс байгуулах асуудлаар санал хураах болов.

27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 46-р тойргийн депутат Ю.Жаргал, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 120-р тойргийн депутат Н.Отгон, 283-р тойргийн депутат Ш.Шагдарсүрэн, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 406-р тойргийн депутат Төрбиш нар дээрхи асуудалтай холбогдуулан үг хэлэв.

Ш.Цэен-Ойдовын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн Ардын Их Хурлын 1991 оны II дүгээр сарын II-ны өдрийн 04-р тогтоолыг хүчингүй болгох саналыг зөвшөөрсөн 229 58%
 татгалзсан 97 25%
 түдгэлзсэн 68 17%
 Бүгд 394 97%

413-р тойргийн депутат Н.Насан-Очир, 326-р тойргийн депутат Ж.Гомбожав, 313-р тойргийн депутат Н.Чагнаа, 101-р тойргийн депутат Р.Доржбат, 383-р тойргийн депутат Б.Гүнджалам нар уг асуудлаар нэмэлт үг хэлэв.

293-р тойргийн депутат И.Бадарч Депутатуудын хорооны даргаар Ж.Гомбожавыг сонгох санал гаргав. Депутатуудын зарим нь санал хураах шаардлагагүй, хороо дотроо удирдлагаа шийдвэрлэг гэсэн санал гаргасныг дийлэнх олонхи дэмжиж санал хураахыг болив.

396-р тойргийн депутат Б.Чимид уг хорооны эрх, үүргийг тогтоолд тодорхой зааж өгөх, 157-р тойргийн депутат Б.Одончимэд ерөнхий санал хэлэлцүүлэх, 55-р тойргийн Ц.Адъяасүрэн санал хэлэхэд техник ашиглах, 132-р тойргийн депутат С.Чулуунбаатар хурлын даргад нэрсээ өгөх, 10-р тойргийн депутат О.Дашбалбар индрээс биш танхимын микрофоны араас ярих, 146-р тойргийн депутат М.Мөнхбат, О.Дашбалбарын саналыг дэмжиж тус тус үг хэлэв.

Хуралдаан 10⁵⁸ цагт завсарлаж 11²² цагт үргэлжлэв.

63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва Дэгд түдгэлзүүлсэн гэдгийг ямар учраас түр зогсоох гэдэг үгээр сольсоныг асууж хариулт өгөхийг хүсэв.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан микрофоны дарааллаар үг хэлэх, санал хураалгав.зөвшөөрсөн 253 /64%/, татгалзсан 135/34%/, түдгэлзсэн 5/1%/, бүгд 393/92%/

45-р тойргийн депутат М.Энхсайхан компьютерт бичсэн нэрийн дарааллаар үг хэлэх, 17-р тойргийн депутат Т.Очирхүү бүлэг, зүйл дээр тодорхой ярих, 334-р тойргийн депутат Д.Батсүх, М.Энхсайханы саналыг дэмжиж тус тус үг хэлэв.

Компьютерт өгсөн нэрийн дарааллаар үг хэлэхийг зөвшөөрсөн 194/52%/, татгалзсан 165/45%/, түдгэлзсэн 11/3%/, бүгд 370/87%/

23-р тойргийн депутат Ц.Энхбат, 31-р тойргийн депутат Д.Дожоодорж, 185-р тойргийн депутат Д.Жанцан, 425-р тойргийн депутат Н.Ганзориг, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 11-р тойргийн депутат Ж.Бямба, 84-р тойргийн депутат Н.Самат, 113-р тойргийн депутат Ж.Гүррагчаа, 337-р тойргийн депутат Г.Түмэннаст, 150-р тойргийн депутат Д.Балдан-Очир, 310-р тойргийн депутат Л.Ханд, 351-р тойргийн депутат В.Мөнгөн, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 396-р тойргийн депутат Б.Чимид, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 211-р тойргийн депутат Д.Дагвадорж, 390-р тойргийн депутат Ү.Аварзэд, 340-р тойргийн депутат Б.Сумъяа, 72-р тойргийн депутат А.Божат, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 56-р тойргийн депутат Р.Гончигдорж, 153-р тойргийн депутат Д.Чойжамц, 80-р тойргийн депутат Д.Зарьккан, 296-р тойргийн депутат Л.Батжаргал, 26-р тойргийн депутат Д.Сүрэнхорлоо, Л.Батжаргал, 30-р тойргийн депутат Г.Нямдаваа нар санал хураах журамтай холбогдуулан үг хэлж депутатуудын олонхийн саналаар санал, шүүмжлэл таслав.

12²² цагаас ерөнхий санал шүүмжлэлд оров.

14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 122-р тойргийн депутат С.Банзрагч, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 327-р тойргийн депутат П.Энхсайхан, 211-р тойргийн депутат Д.Дагвадорж, 418-р тойргийн депутат Ж.Оросоо, 407-р тойргийн депутат Б.Нүүрэй,

350-р тойргийн депутат Ц.Давааням, 230-р тойргийн депутат Б.Очирбат, 71-р тойргийн депутат Т.Ядамсүрэн нар ерөнхий санал, шүүмжлэлтэй холбогдуулан үг хэлэв.

Хуралдаан 13⁰⁰ цагт завсарлаж 15⁰⁰ цагт "Өлзий" пүүсээс бэлтгэсэн Монгол улсын сүлд, тугын шинэ төслийн утга агуулгыг тайлбарласан дүрс бичлэгийг үзүүлэв. Уг дүрс бичлэгт урлаг судлаач Ж.Бадраа, МУИС-ийн багш дэд эрдэмтэн С.Дулам, зохиолч П.Бадарч, МСДН-ын дарга Б.Батбаяр, зураач Ш.Тэнгисболд нар туг, сүлдний талаар өөрсдийн санал бодлоо тайлбарлажээ. Дараа нь ерөнхий санал, шүүмжлэл үргэлжлэн явагдав. 2-р тойргийн депутат С.Батмөнх, 415-р тойргийн депутат Н.Ганбямба, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 422-р тойргийн депутат Н.Төмөртоогоо, 371-р тойргийн депутат П.Даш, 320-р тойргийн депутат Ч.Хишигдалай, 200-р тойргийн депутат С.Халзанхүү, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 57-р тойргийн депутат Г.Баасанжав, 262-р тойргийн депутат Б.Доржготов, 245-р тойргийн депутат Ү.Чинбат, 424-р тойргийн депутат Х.Бадамсүрэн, 307-р тойргийн депутат М.Доржсүрэн нар үг хэлэв.

Ардын Их Хурлын хуралдаан 17⁰⁰-17²⁰ цагт завсарлав. Завсарлагын дараагаар 229-р тойргийн депутат Т.Төмөрбаатар, 225-р тойргийн депутат И.Баасандорж, 149-р тойргийн депутат Т.Анигар, 325-р тойргийн депутат Н.Дашзэвэг, 240-р тойргийн депутат С.Пүрэв, 420-р тойргийн депутат Д.Гомбожав, 276-р тойргийн депутат Ш.Содномдаш, 316-р тойргийн депутат Г.Сосорбарам, 140-р тойргийн депутат Т.Гантөмөр, 165-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн нар үг хэлснээр өнөөдрийн хуралдааны санал шүүмжлэлийг таслав.

МоАН-ын дарга, депутат Э.Бат-Үүл зарлал хэлж, нийт депутатуудыг 19⁴⁰ цагт хүлээн авалтанд ирэхийг урив. Мөн 167-р тойргийн депутат Ш.Гүрбазар хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлын талаар саналаа хэлэв. Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан зарим депутатуудын санал хүсэлт, зарлах мэдэгдэх зүйлүүдийг танилцуулав.

Ардын Их Хурлын орлогч дарга Д.Моондой Ардын Их Хурлын II хуралдааны нэр дээр байгууллага, иргэдээс ирүүлсэн захидал, цахилгаан, санал хүсэлтийг танилцууллаа. Өнөөдрийн хуралдаан 19⁰⁰ цагт дуусав.

ТАНИЛЦСАН: АИХ-ЫН ДАРГА *Д. Моондой* Ж. УРТНАСАН
 АИХ-ЫН ОРЛОГЧ ДАРГА *Н. Батбаяр*

Н. БАТБАЯР

Г. ЖАГАЙ

Ц. ЛООХУУЗ

Д. МООНДОЙ

ТЭМДЭГЛЭСЭН:

А. Юндэндорж
Г. Хуралбаатар

А. ЮНДЭНДОРЖ

Г. ХҮРЭЛБААТАР

Ж. Уртнасан -Өглөөний амгаланг айлтгая. Хуралдаанаа үргэлжлүүлье. Манай өчигдрийн хуралдаанд ирвэл зохих 427 депутат байсан. 339 дүгээр тойргийн депутат Чингэл, 376 дугаар тойргийн депутат Батмөнх, 254 дүгээр тойргийн депутат Охин-тогтох, 199 дүгээр тойргийн депутат Самшилноров, I дүгээр тойргийн депутат Баяр, 306 дугаар тойргийн депутат Дэлгэр-мөрөн нар өвчтэй. Депутат Сүрэнжаргал гадаадад явж байгаа.

За хоцорч ирсэн хүмүүс 16 дугаар тойргийн депутат Алтай 20 минут, 143 дугаар тойргийн депутат Зуунай 30 минут, 22 дугаар тойргийн депутат Дашням 40 минут, 344 дүгээр тойргийн депутат Сүхбаатар, 407 дугаар тойргийн депутат Нүүрэй, 409 дүгээр тойргийн депутат Ишцэрэн нар II цагийн завсарлагаанаас хойш, 52 дугаар тойргийн депутат Бат-Үүл үдээс хойшхи хуралдаанд суугаагүй байна.

Эрхэм депутатуудыг ирцээ бүртгүүлэхийг хүсч байна. Ирцээ бүртгэе. За ирц бүртгэж эхэллээ. За баярлалаа. Ирвэл зохих 427 депутатаас 397 депутат буюу 93 хувь нь ирсэн байна. Ийм учраас хуралдаанаа хүчин төгөлдөр гэж үзэж үргэлжлүүлье.

Одоо хөдөлмөрчдөөс ирсэн санал, хүсэлт, мэдээллийн тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Жагай уншиж сонсоно.

Жагай /Ардын Их Хурлын орлогч дарга/ -БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны нэр дээр байгууллага, иргэдээс ирүүлсэн захидал, санал, хүсэлтийг та нөхдөд сонордуулъя.

Ардын Их Хурлын II хуралдааны нэр дээр байгууллага, иргэдээс бичгээр 21, цахилгаанаар 5, утсаар 25, хүлээн авах байраар 2 хүн ирж санал, хүсэлтээ тавьсан байна.

Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн музейн эрхлэгч Гунгаадорж, Октябрийн районы 35 дугаар хорооны ахмад дайчин

Пүрэв, Лэгдэн, Яринпэл, Буян-Очир нарын 18 хүн, Сүхбаатарын районы 29 дүгээр хорооны иргэн Лувсанням утсаар, Архангай аймгийн Өгийнуур сумын хөдөлмөрчид, Төв аймгийн МСДН-ын зөвлөл, Багануур дахь банкны хамт олон, Ардын Их Хурлын 47 дугаар тойргийн сонгогч Ишинравдан нар цахилгаанаар Ардын Их Хурлын үйл ажиллагаанд амжилт хүссэн байна.

Сүхбаатарын районы I дүгээр хорооны иргэн Дагвадорж, Дорж, Жадамбаа нарын 6 хүн, Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн музейн эрхлэгч Гунгаадорж нар утсаар зарим депутат ардчиллын нэр барьж ард түмний эрх ашигт нийцэхгүй хууль гаргуулах гээд байна. Элбэгдорж, Бат-Үүл нар ард түмний үгийг ойлгохгүй, өөрсдийгөө хэт дөвийлгөх хандлагатай байна гэжээ.

Октябрийн районы 18 дугаар хорооны иргэн Бадарч утсаар депутатууд бага, ялихгүй зүйл дээр бухимдаж маргалдаад их зав чөлөөтэй улс шиг харагдаж байна гэсэн шүүмжлэл ирүүлжээ.

Сүхбаатарын районы 10 дугаар хорооны иргэн Надмид, Навга, Дондог нарын 6 хүн, Октябрийн районы 18 дугаар хорооны иргэн Бадарч, Техник туслалцааны трестийн баазын жолооч Бааст нар утсаар хурлын үйл ажиллагааг телевизээр өргөн нэвтрүүлж өгөхийг хүсчээ.

Сүхбаатарын районы 17 дугаар хорооны иргэн Доржсүрэн, Октябрийн районы 6 дугаар хорооны өндөр настан Даваадорж нар утсаар өөрсдийнхөө тойргийн депутат Бямбаа, Нямдаваа нарыг сонгогчидтойгоо уулзаж, бидний санал хүсэлтийг сонсоогүй тухай дурджээ.

Өмнөговь аймгийн нэгдэл дундын үйлдвэрийн жолооч Пүрэв, Дархан хотын иргэн Чулуун, Баасан нарын 15 хүн бичгээр, Дархан хотын 2 дугаар хорооны иргэн Ламзав бичгээр БНМАУ-ын амин сүнс болсон Үндсэн хуулийг ард түмний оюун санаанд хүрсэн хууль болгон гаргахыг нийт депутатаас хүссэн байна.

Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны иргэн Д.Гэндэн, мөн районы иргэн Дорж, Октябрийн районы 35 дугаар хорооны ахмад дайчин Пүрэв, Лэгдэн, Яринпэл, Буян-Очир нарын 18 хүн, Сүхбаатарын районы 29 дүгээр хорооны иргэн 120-иод өндөр настныг төлөөлж Лувсанням, Завхан аймгийн Баянхайрхан сумын малчин Биндэръяа, Өмнеговь аймгийн нэгдэл дундын үйлдвэрийн жолооч Пүрэв, Телефон, радио ашиглалтын станцын техникч Рэгзэдмаа, Оюунгэрэл, Уртнасан нарын 7 хүн, Сүхбаатарын районы ОСГ-ны 9 дүгээр хорооны иргэн Гэндэн, Сүхбаатарын районы 30 дугаар хорооны иргэн Товуу, Аржанчивлан рашаан сувиллын соёл, олон түмний эрхлэгч Оюунбаатар, Орон сууц ашиглалтын 8 дугаар конторын ажилчин Аюурзана, Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны иргэн Дорж, Октябрийн районы 30 дугаар хорооны иргэн Нямсүрэн, Нийслэлийн 89 дүгээр дэлгүүрийн эрхлэгч Магуужин 20 гаруй хүнийг төлөөлж, Октябрийн районы 18 дугаар хорооны иргэн Бадарч нар утсаар БНМАУ-ын нэр, сүлд, төрийн дуулал, далбааг хэвээр байлгах саналтайгаа ирүүлжээ.

Октябрийн районы 18 дугаар хорооны иргэн Бадарч, Найрамдалын районы 1 дүгээр хорооны өндөр настан Дэчин, нийслэлийн 89 дүгээр дэлгүүрийн эрхлэгч Магуужин газрын тухай асуудалд маш болгоомжтой хандаж, газрыг гадаадын хүнд өмчлүүлэхгүй байх талаар заах гэжээ.

Баян-Өлгий аймгийн 59 дүгээр тойргийн депутат Жалел, хүнсний үйлдвэрийн технологич инженер Лиза, Гулзада, Зауреш, материал-техникийн хангамжийн инженер Шамзах нар цахилгаанаар БНМАУ-ын монгол, казах, дөрвөд, буриад урианхай гэх мэт иргэд оршин суудгийг үндсэн хуульд тусгах. Казахын ард түмний зан заншил, газар нутгийн байршил, төвөөс алслагдсан зэргийг харгалзан Баян-Өлгий аймгийг хиллэж байгаа гадаад оронтой худалдаа, эдийн засгийн нээлттэй бүс болгоно гэсэн байдлаар Ардын Их Хурлаас гаргах баримт бичигт тусгаж өгөхийг хүсчээ.

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын хөдөлмөрчид цахилгаанаар улсын болон хуулийн нэрийг хэвээр үлдээх, орон нутгийн засаг захиргааны одоогийн тогтолцоог өөрчлөхгүй байх, Улсын Бага Хурлын тайланг хэлэлцэх үед БНМАУ-ын Тэтгэврийн хууль зэрэг зарим хууль амьдралд нийцэхгүй байгааг хянан үзэх хэрэгцээтэй гэжээ.

Профессор Т.Дашцэдэн, профессор Чой.Лувсанжав, багш Чоймоо нарын II хүн бичгээр монгол бичиг бол манай ард түмний соёл гайхамшигт өв, хүн төрөлхтөний соёлын санд оруулсан их хувь нэмэр мөн. Манай төр, засгийн газраас монгол улсаа бүх талаар сэргээн мандуулах гэсэн ард түмнийхээ санал зоригийг илэрхийлэн монгол бичгийг бүх нийтээр суралцаж 1994 оноос эхлэн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай тогтоол гаргасныг сайшаагаад Их цааз бичигт монгол хэл монгол бичиг бол төрийн албан ёсны бичиг мөн. Монгол бичгийг төрийн албан ёсны бичиг болгон хэрэглэх ба бусад үндэстэн эх хэлээрээ суралцах, ажил хэргээ явуулах эрхээ эдлэхэд саад үл болно гэсэн санааг оруулан батлахыг хүсчээ.

Найрамдалын районы иргэн, өндөр настан Б.Банзрагч бичгээр монгол хэлний хууль зүйн нэр, хууль цаазат төр, эрх зүйт төр, хууль зүйт төр, эрхжсэн төр гэх зэрэг хүн бүр янз бүрээр, санааны зоргоор бичиж ярьж байгаагаас эцсийн эцэст манай улсын гол хууль Үндсэн хууль маань буруу ташаа нэр томъёогоор батлагдахад тулаад байна. Иймд хуулийнхаа нэрийг Хууль зүйн яам, Шинжлэх ухааны академи, Улсын нэр томъёоны комисс, Хэл утга зохиолын хүрээлэн зэрэг холбогдох газрын саналыг авч дүгнэлтийг сонсож тогтоомоор байна гэсэн санал ирүүлжээ.

Налайх хотын 5 дугаар хорооны иргэн Нанзаддорж, Увс аймгийн Сагил сумын иргэн Но.Гэнэн, Ажилчны районы I дүгээр хорооны иргэн Л.Чулуун, нийслэлийн 18 дугаар сургуулийн 5^Б ангийн сурагч Болормаа, октябрийн районы 27 дугаар хорооны иргэн Жамсранжав, Завхан аймгийн Их-Уул сумын Улаанмандал

5.

кампаний ерөнхий захирал Дагийрагчаа нар Үндсэн хуулийн нэрийг хэвээр байх, төрийн бэлгэдлийг хэвээр үлдээх талаар саналуудаа ирүүлсэн байна.

Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны иргэн Гэндэн утсаар Цагаачлалын хуулийг батлахгүй байх тухай саналуудыг ирүүлжээ.

Өмнөговь аймгийн нэгдэл дундын үйлдвэрийн жолооч Пүрэв утсаар Ардын Их Хурлын депутат, зохиолч Гүрбазар, Барамсай нарыг хөдөө орон нутагт явуулж, хөдөөгийн амьдралыг үнэнээр нь найруулж, засалгүй яриулах хэрэгцээтэй байна гэсэн саналуудыг ирүүлсэн байна.

Ж.Уртнасан –За эрхэм депутатуудаа та бид нар хуралдааныхаа, II хуралдааныхаа дэгийн дагуу I2 дугаар зүйлийн 3 дугаар заалт, "Б" хэсгийн санал, асуулт, хариулт явуулах энэ хэсгийг өчигдөр 88 хувийн саналаар тасалсан өнөөдөр бид ерөнхий санал солилцох энэ ажилдаа дэгийн дагуу орох гэж байна.

Үүний өмнө та бидэнд нээлттэй орхисон хоёр асуудал байгаа юм. Бид бас харилцан ойлголцож, сайн учир начрыг нь мэдэж байхын тулд зарим тайлбар тодотгол хийе. Тэгэхээр манай дэгийн саян дурддагийн "д" хэсэг дээр ажлын хэсэг гэсэн ийм үг байгаа юм. Тэгэхээр бас энэ хөдөлмөрчдөөс ч гэсэн энэ нэр томъёон дээр мэргэжлийн хүмүүс ажилласан юм уу үгүй юм уу гэсэн ийм юм яригдаж байгаа юм. Тэгэхээр ажлын хэсэг гэдгийг бид нар ямар ойлголт байна вэ гэхээр энэ манай Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга, манай Ерөнхийлөгчийн гаргасан захирамж байгаа юм. 1991 оны 7 дугаар сарын 26-ны өдөр гаргасан энэ захирамжаар ажлын хэсэг дотроо 10 хэсэгтэй, 72 хүний бүрэлдэхүүнтэй ийм комисс ажиллаж байна. Та бидний хэлсэн үгийг тэмдэглэж бичүүлсэн зүйлийг бичлэгээс авч найруулга, үг хэллэгийн засвар хийж байгаа. Энэ бол шийдвэрлэх эрхтэй хүмүүс биш, зөвхөн техникийн хүмүүс гэдгийг нэгдүгээрт ойлгож баймаар байна. За энэ саян хөдөлмөрчдийн мэдээлэлд эрдэм шинжилгээний байгууллагуудын хүмүүсийг

татан оролцуулмаар юм гэсэн ийм санал гарч байна. Энэн дээр зүгээр 72 хүний нэр унших төвөгтэй юм. Жишээ нь зүгээр зохицуулах хэсэгт доктор Зардыхан ахалж байна. 5 хүнтэй.

Төслийн 1, 2, 3 дугаар бүлгийг Бага Хурлын гишүүн Баяр ахлаж байгаа юм. Гишүүд нь Бага Хурлын гишүүн Энхсайхан... гээд 14 хүн байна. Төслийн 3, 4 дүгээр бүлгийн дөрөвдүгээр хэсгийг хуульч Цог ахлаж байна. Хатанбаатар хуульч... 4 дүгээр бүлгийг Жанцан хуульч ахлаж байна. Төрийн бэлгэ тэмдгийн хэсгийг гэхэд дэд эрдэмтэн, Бага Хурлын гишүүн Маам ахлаж байна. Тэнд түүхийн ухааны доктор Ишжамц, Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Очир зэрэг хүмүүс орж байна.

Депутатуудын саналыг нэгтгэх хэсэгт Адьяасүрэн ахлагчтай хэсэг ажиллаж байна. Онол арга зүйн группт Хууль зүйн сайд Амарсанаа толгойлон ажиллаж байна. Нэр томъёоны хэсгийг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, доктор Цэрэнсоном ахлаж байна. Тооцоолон бодох техникийн хэсгийг манай зохицуулах зөвлөлийн Төмөр, олон улсын байгууллагуудтай харилцах асуудлыг Гадаад явдлын яамны орлогч сайд, дэд эрдэмтэн Чойнхор гэх мэт 72 хүнтэй ажлын групп ажиллаж байгаа.

Харин тэр группүүдийг ажлыг нь нягтруулах, уялдуулан зохицуулах, та бидний саналыг нэгтгэх зорилгоор бид нар төслийг найруулан засаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ийм депутатуудын хороо байгуулъя гэдэг саналыг нээлттэй орхисон. Та бүгдийн саналын дагуу бид энэ депутатуудын хороонд орох хүмүүсийн нэрийг тодотгож санал авсан. За саналыг аймаг, хотын нутаг дэвсгэрийн бүлэг, Ардын Их Хурлын намын бүлгүүдээс боловсруулж та бидний гар дээр ирүүлсэн юм.

Харьяаллын хувьд авч үзвэл Архангай, Баян-Өлгий, Өвөр-

хангай, Дундговь, Сэлэнгэ, Баянхонгор, Увс, Дорноговь, Завхан, Өмнөговь, Хэнтий, Улаанбаатарын депутатууд орж байна. Дорнод, Ховд, Говь-Алтай, Хөвсгөл, Булган, Төв, Сүхбаатар аймгаас депутатууд оролцуулсангүй. Нийтэд нь авч үзвэл Улаанбаатарт байгаа 14, хөдөө орон нутгаас ирсэн 15 депутат орж байна.

Тойргийн харьяаллаар авч үзвэл хөдөө орон нутгаас 20, Улаанбаатараас 9 депутат байна.

Хоёрдугаарт, бид энэ депутатын хороонд орж байгаа хүмүүсийг мэргэжлийн хувьд авч үзэж байна. Эдийн засагч хүн 7 байна. Эмч хүн 2 байна. Хуульч хүн 6 байна. Инженер хүн 4 байна. Нийгэм улс төр судлаач 5 байна, бусад мэргэжлийн 4 хүн байгаа юм.

Эрхэлж байгаа ажлын хувьд бид бас авч ангилалт хийж үзлээ. Аймгийн ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга 2 байна, сумын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга 2 байна, аж ахуй, нэгдэл, сангийн аж ахуйн дарга 6 байна. Төрийн захиргааны ажилтан давхардсан тоогоор 10 байна. Нам, улс төрийн ажилтан 4 байна. Ийм бүрэлдэхүүнтэй комисс депутатуудын хороо байгуулья гэсэн санал ирж байгаа юм. Ингээд та бүхэнд би 29 депутатын нэрийг уншиж сонсоё.

Уг нь энэн дээр санал хураалт явуулах эсэхийг эрхэм депутатууд та бүхэн мэдэх юм. Манай дэгэнд бол 21 гэж заасан байгаа. Ирүүлсэн нэр бол 28 хүний нэр ирүүлээд байна. Доктор Зардыхан өөрийнхөө нэрийг татаж авч та бидэнд зарласан учраас Зардыхан гуайн нэрийг өөрийнх нь хүсэлтийн дагуу эндээс хассан. Ингээд 28 хүний нэр дээр, дэгийнхээ дагуу 21 хүнээр баталъя гэвэл та бид хүн бүр дээр санал хураалт явуулж батлах хэрэгтэй болох юм. Ер нь 28 хүнтэй байж болох юмаа гэж үзвэл дэг зөрчсөн хэрэг боловч 28 хүнтэй байж болохыг үгүйсгэхгүй ийм нэг хувилбар байгаа юм.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

А. Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.15
Кассет № 50
9.15-9.30

Ж.Уртнасан: Тэгэхээр та бүхэнд юуны өмнө дэг танилцуулахын өмнө тоогоо дахин нэг санал хураалт явуулах уу? аль эсвэл 28 хүнээ уншиж сонсгох уу гэсэн ийм санал байна.

55-р тойргийн депутат Ц.Адьяасүрэн:

Би эндээс өөрийнхөө нэрийг татаж авч байна.

238 дугаар тойргийн депутат Г.Төмөрбаатар:

21 гэж тийм тоо байхгүй. Нууц санал хураах комисс л гэж 21 хүний бүрэлдэхүүнтэй байгаа. Тийм учраас энэ 28 байж болох байх гэж бодож байна.

Ж.Уртнасан: За баярлалаа. Тэгвэл та бүхэнд нэрийг уншиж сонсгоё. Энд А.Сарай 82 дугаар тойргийн депутат, нэгдлийн дарга хүн байна. Жамбын Гомбожав 326 дугаар тойргийн депутат, Ардын Их Хурлын дарга, /агсан/, Чимидцэрэнгийн Чинбат 245 дугаар тойргийн депутат, сумын МАХН-ын үүрийн дарга, Ишийн Бадарч 293 дугаар тойргийн депутат, эдийн засагч хүн, Тогтохын Ядамсүрэн 71 дүгээр тойргийн депутат, нэгдлийн холбооны зөвлөлийн ажилтан, Баасангийн Сандуйжав, инженер, 94 дүгээр тойргийн депутат, Баярын Норжин 121 дүгээр тойргийн депутат, эдийн засагч, сангийн аж ахуйн дарга, Тогоочийн Анигар 149 дүгээр тойргийн депутат, Хүний их эмч, К.Мизимхан 74 дүгээр тойргийн депутат, аймгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга, инженер механик, Баярхүүгийн Мижид 163 дугаар тойргийн депутат, аймгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга, инженер, Данзангийн Лундээжанцан 15 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын гишүүн, хуульч, Чулууны Дэмбэрэлням 346 дугаар тойргийн депутат, сумын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга, хуульч, Дамдингийн Дэмбэрэл, 234 дүгээр тойргийн депутат, Завхан аймгийн МАХН-ын хорооны дарга, эдийн засагч,

Наваанпэрэнлэйн Жанцан, 273 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын гишүүн, хуульч, Данзангийн Жагварал 104 дүгээр тойргийн депутат, сумын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны дарга, улс төр судлаач, Самдангийн Чулуунбаатар 132 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын гишүүн, нийгэм судлаач, Дамдинжавын Гомбожав, 420 дугаар тойргийн депутат, сангийн аж ахуйн дарга, улс төр судлаач, Шаравдоржийн Цэнджаргал, 268 дугаар тойргийн депутат, нэгдлийн дарга, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Будын Сумъяа Аймгийн намын ажилтан, нийгэм судлаач, 340 дүгээр тойргийн депутат, Юлтын Жаргал 46 дугаар тойргийн депутат, барилгын инженер, Бяраагийн Чимид 396 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын гишүүн, хуульч, Шаравын Сүрэнжав 44 дүгээр тойргийн депутат, яруу найрагч, Жигжидийн Бямбаа, II дүгээр тойргийн депутат, зохиолч, Лувсандамбын Дашням, 22 дугаар тойргийн депутат, Хувийн их сургуулийн захирал, эдийн засагч, Цэрэндоогийн Энхбат 23 дугаар тойргийн депутат, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн багш, Санжаасүрэнгийн Зориг 9 дүгээр тойргийн депутат, нийгэм судлаач, Нэмэхийн Пүрэвдорж, 41 дүгээр тойргийн депутат, хуульч багш ийм хүмүүс байна. Зардыхан гуай өөрийнхөө нэрийг татаж авлаа. Ингээд 28 хүний бүрэлдэхүүнтэй ийм хүмүүс байна.

245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат: Энэ бүрэлдэхүүнээс нэрээ татаж авъя гэж санал оруулж байна.

82 дугаар тойргийн депутат А.Сарай:

Манай аймгийн дарга Мизимхан орсон байна, тийм учраас би нэрээ татаж авъя. Нэг аймгаас хоёр хун ороод яах вэ?

294 дүгээр тойргийн депутат И.Бадарч:

Салэнгэ аймгаас Нороврагчаа түрүүн нэрээр орсон юм. Би Нороврагчааг оруулаад өөрийнхөө нэрийг татаж авъя.

Ж.Уртнасан: Энэ жаахан замбараагүй болж мэдмээр байна. Орон нутгийн бүлэг, намын бүлгүүд нэр дэвшүүлсэн учраас

бид бас эргэж бодуштай гэдгийг депутатууд болгооно уу?

208 дугаар тойргийн депутат З.Жанжаадорж:

Манай аймгаас хүн орлоо гэж уншсан, уншихад нэр гарсангүй, нэг сумын даргын нэрийг бид нар өгсөн байсан.Ж.Адьяа гэж. Уншихад сая гараагүй.

Хоёрдугаарт, нэр орсон улсуудыг, татгалзаад байгаа улсуудыг хүлээж авахгүй ^{байх нь} зүйтэй гэж бодож байна.

Ж.Уртнасан: Уучлаарай, Жанжаадорж даргаа, дөрөвдүгээрт, Жанчивдоржийн Адьяа 202 дугаар тойргийн депутат, сумын МАХН-ын үүрийн дарга гэж уншсан байх ёстой, энэ мөн байхаа.

З.Жанжаадорж: Уншигдаагүй, за баярлалаа.

340 дүгээр тойргийн депутат Б.Сумъяа: Би өөрийнхөө нэрийг татаж авах хүсэлтэй байна.Үүнд ноцтой шалтгаан байна.Энэ юу вэ гэхээр биеийн эрүүл мэндийн байдалтай холбоотой, би цаашдаа хурал, чуулганы ажиллагаанд бүрэн оролцож чадахгүй төлөвтэй байна.Одоохондоо сууж байна.Ийм учраас өөрийнхөө нэрийг татаж аваад, увс аймгийн /би тойргийнх нь дугаарыг санахгүй байна/ Намсрайжавыг би өөрийнхөө оронд нэр дэвшүүлбэл ямар вэ гэсэн хүсэлтэй байна.

191 дүгээр тойргийн депутат Б.Дханаасүрэн: Тэгэхээр энэ хүмүүсүүд нэрээ татаж авч байгаа нь татгалзам байгаа асуудал их учиртай юм.Бид энэ дээр анхаарлаа хандуулах ёстой. Депутат та нөхдүүд миний үгийг сонсооч, болгооно уу гэж бодож байна.

Тэгэхээр энэ хороо бол асар их үүрэг хариуцлага хүлээнэ. Энд заавал аймгаас нэг хүн мэргэжлийн бүлгүүдээс нэг хүн ингэж оруулах шаардлага байхгүй.Энэ бол ямар, утга учиргүй ийм асуудал.Энэ хороо ямар үүрэг гүйцэтгэх вэ гэхээр бидний

боловсруулаад шийдчихсэн асуудлыг л хэл, найруулга, нэр томъёоны хувьд л найруулж засч оруулах ёстой. Энэ зүгээр нэг төлөвлөж ирсэн тушаал дээр гарын үсэг зурахтай адилгүй, бидний зурдаг шиг. Энэ бол манай тулгуур хуулиа батлах гэж байна. Тэгэхээр энэ хууль, энэ хороо бол гол үүрэг гүйцэтгэнэ. Тэгэхээр жишээ нь, төрийн байгууллага гээд III бүлгийг хэрэв 2 танхимтай байнаа гээд дээд байгууллага маань ингээд шийдчих юм бол бид хэлэлцэх хуулийнхаа 20-иос 60 дугаар зүйлийг бүхэлд нь энэ Их цаазынхаа төслөөс авч хаяад, оронд нь цоо шинээр үүнийг томъёолж, шинээр боловсруулах хэрэгтэй болно. Ийм өндөр хариуцлагатай үүргийг энэ хороо хүлээж байгаа юм. Бид жишээ нь, Ерөнхийлөгчийн засаглалтай байнаа гээд шийдчихвэл ерөөсөө тэр төрийн байгууллын юуг үндсээр нь бүр агуулгаар нь өөрчлөж хэрэгтэй болно шүү дээ. Гэтэл энд чинь зүгээр нэг сумын дарга нар, аймгийн дарга нар оролцоод, үүнийг хийж чадах юм уу?

Тэгэхээр яах гэж байна вэ гэхээр би энд Зардыхан доктор, Чимид гуай нар нэрээ татаж аваад байгаа нь, хуульчид нэрээ татаж аваад байгаа асуудалд би их харамсаж байна. Зүй ёс нь эдгээр энэ хуульчид эрхбиш энэ хууль боловсруулах дээрнэлээн олон жил ажиллачихоан, биднийг бодвол, ийм хуулийн техник, технологийг нь мэддэг, үүнийг чинь нэг үсэг, өгүүлбэрийг өөрчлөх хүртэл их явдалтай шүү дээ. Аягүй бол магадгүй бид дахиад эрдэм шинжилгээний бага хурал хуралдуулах, дахиад эрдэмтэд рүүгээ хандгах, эсвэл гадаадын эрдэмтэд, мэргэдийг урих, энэ бага хугацаанд чинь ингээд үүнийг энэ хэдэн хүн боловсруулж чадах юм уу?

Би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энэ Зардыхан доктор, Чимид гуай, энэ Бага Хурлын эрхэм гишүүд, өмнө 21 нэр байхад байсан, энэ хүмүүсүүдийг та нар оруулаач ээ. Ингэхгүйгээр бид одоо чанартай, ард түмнийхээ сэтгэл санаанд нийцэх ийм хууль боловсруулж чадахгүй, би эргэлзэж байна. Тийм учраас заавал энэ хууль, энэ Бага Хурлын гишүүд, эрдэмтэн, энэ хүмүүсүүдээ бид оруулж, эрхбиш энд ажиллуулах нь зүйтэй байхаа. Энэ бол

асар их хүч, мэдлэг чадвар шаардана шүү.

380-р тойргийн депутат Л.Багчулуун:

Хөвсгөл аймгаас оруулсан саналыг авч хэрэгсээгүй юм шиг байна. Ямар учиртай юм болоо? аймаг, аймгаас орж байгаа юм байна. Дигжгээ гэсэн нэр байх учиртай.

Ж.Уртнасан: Уучлаарай, бид энэ дээр хэлсэн шүү дээ. Саналыг бүх аймаг, хотын нутаг дэвсгэрийн бүлэг, Ардын Их Хурлын намын бүлгүүдээс ^{СОЛДОРУУЛЖ} ирүүлсэн юм. Яагаад ингэсэн юм бол доо, намын бүлэг дээр, орон нутгийн бүлэг дээр ярьж болох байсан. Энэ одоо ний нуугүй хэлэхэд хождож тавьж байгаа санал юм.

145 дугаар тойргийн депутат Д.Лантуу: Бид энэ хорооны бүрэлдэхүүнийг ямархуу янзаар авсан юм бэ? би бас сайн ойлгосонгүй. Яагаад гэхээр бид өөрийнхөө нутаг дэвсгэрийн бүлгээс, намын бүлэг ч гэсэн аль алинд нь саналаа өгсөн. 2-3 хүн ч байсан. Бид Түдэв гуайг энд оруулж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байна. Хуульч Авхиа гуай байж байгаа юм. Нэлээн тулах, түших л хүний нэг гэж би ойлгож байна. Тийм учраас Авхиа гуай байж байна. Хэрвээ бололцоотой бол сум, нэгдлийн дарга олон жил хийсэн, нэлээн сайн туршлагатай Цүрэвдорж гэж хүн байж байгаа. Энэ хүмүүсүүдээс аль нэгийг нь оруулах нь зүйтэй байх. Ялангуяа Түдэв гуайг оруулах нь их ач холбогдолтой гэж үзэж байна.

Ж.Уртнасан: Баярлалаа, депутат Лантав гуай. Тэгэхээр нэг тайлбар хэлье. Говь-Алтай аймгаас гэвэл хуульч Жарантайн Авхиа гуай орж байгаа. Түдэв гуайн нэр ирсэн. Намын бүлэг дээр ярилцахад Түдэв гуай өөрөө татгалзсан учраас, өөрийнх нь хүсэлтээр энэ бүлэгт оруулаагүй, харин зөвлөх, ажлын групп дээр ажиллахыг би дуртайяа зөвшөөрнө гэсэн өөрийнх нь тодотгол бий.


307 дугаар тойргийн депутат М.Доржсүрэн: Бид энэ депутатууд өөрсдөө Хурлынхаа үйл ажиллагааг гартаа авч, идэвхтэй явуулъя гэж өөрсдөө санал тавьж, орон нутгийн бүлгүүдээс санал дэвшүүлж оруулсан.

Ийм учраас энэ татгалзаад байгаа явдал бол буруу байгаа. Аль болохоор бүхий л хүч бололцоогоо дайчилж, мэддэг нь мэддэггүйдээ тусалж, цаана нь хуулийн зөвлөх ажиллаж байна. Энэ ямар хууль тогтоож байгаа биш, эргээд саналаа оруулж ирнэ. Ийм учраас энэ дээр нөхдүүд ухарч, өөрийнхөө нэрийг татаж авч байгааг би буруу байгаа, үүнийг таслан зогсооё гэж бодож байна.

397 дугаар тойргийн депутат Б.Чимид: Юуны өмнө Үндсэн хууль боловсруулж гаргахад депутатын хувьд хариуцлагаа бүрэн ухамсарлаж, болж өгвөл дээд зэргийн идэвхтэй оролцоно. Гэхдээ би энд комиссын журмаар оролцож болохгүй байна. Та бүхэн мэдэж байгаа. Тэр бодлын солбилцол дээр Чимид зүтгүүлээд буруу хууль гаргах гэж байна гэсэн том хэмжээний нүүрийг депутатуудын анхааралд гэсэн ийм гарчигтайгаар, албан ёсоор тавьсан байгаа. Тэр дотор монгол улсын газрыг нь худалдах гэж байна гэх мэтээр том том улс төрийн дүгнэлтүүд байгаа. Ийм учраас энэ группт орж зүтгүүлсэн нэрийг би олон сар зүүж байгаа учраас би тэр хорооны өмнө, мэргэжлээрээ яагаад ийм юм орсныг тайлбарлах үүрэгтэйгээр хорооны бүрэлдэхүүнд орохгүйгээр би ажиллая гэж бодож байна. Өөрөөр хэлбэл саналаа хэлэх эрхтэйгээр, хороо бол зөвхөн хүний хэлснийг найруулдаг хороо байж ерөөсөө таарахгүй, 430 хүн 4-5 янзын нэр томъёогоор, адаглаад ярина. Тийм учраас аль нэгээр нь шийдэхээс аргагүй. Магадгүй тэр газар дээр чинь нэг хэсэг нь эзэмшүүлнэ гэж хэлнэ, нэг хэсэг нь өмчлүүлнэ гэж хэлнэ, нэг хэсэг нь түрээсэлнэ гэж хийнэ гээд гурван юм гараад ирнэ. Гурвууланг нь өрчимөөд та нар аль нэгийг нь ав, мэд гээд ийм судар бэлдээд байж таарахгүй. Тийм учраас хорооны үүргийг зөвхөн механик хүмүүсийн санал нэгтгэгч мэтээр ойлговол Үндсэн хууль ерөөсөө гарахгүй. Олон ажлын группүүд гардаг, олон янзын төсөв хийгээд ирдэг. Түүнийг хэсэг хүн сууж байгаад, нэг хэрчиж байгаа юм. Зөв хэрчиж байгаа юм уу? буруу хэрчиж байгаа юм уу гэдэг бол олон түмэн мэдэх хэрэг. Хорооны үүргийг тийм техникийн үүрэгтэй гэж ойлговол буруу. Ерөөсөө Үндсэн хууль ямар болох нь биднээс шалтгаалах боловч энэ хорогноос шалтгаална.

Тийм учраас хорооны үүргийг багасгаж ойлгоод, ажлын группийн хэмжээнд аваачиж буулгаад, ингэж ойлговол буруу. Улсын Бага Хурал төслөө оруулсан. Манай депутатууд Бага Хурлын төслийг одоо тунгаан хэлэлцэж байна. Тийм учраас Бага Хурлын гишүүн бус улсууд нь тунгааж үзээд, Бага Хурал түүнийгээ ямар учиртайгаа тайлбарлаад, ажиллавал зарчмын хувьд зүйтэй болох юм уу гэж бодож байна. Тэгээд давтан хэлэхэд энэ хуулийг гарт нь уян хатан бөгөөд үзэл бодлыг шинжлэх ухааны үүднээс тодруулахыг оролдоно гэдгээ би хэлмээр байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНШАТ

1991.11.15.
Кассет № 51
9.30-9.45.

Ж. Уртнасан -1-р микрофон хунгүй байна, одоо 2-р микрофон.

Б. Сандуйжав -94-р тойргийн депутат -Саяны хорооны бүрэлдэхүүнээс миний нэрийг хасаж өгнө үү гэж хүсэж байна. 2 үндэслэл байна. 1-рт, энд инженер-техникийн нэр томъёо байхгүй, 2-рт, манай аймгаас хоёр хүн орсон байна. Саяны Батчулууны хүсэлтээр Хөвсгөл аймгаас нэг хүнийг оруулахгүй гэж гэж? гэсэн хүсэлт байна.

Т. Анигар/149-р тойргийн депутат/ -Сая Чимид дарга энэ байдлыг тодорхой тайлбарлах шиг боллоо. Тэхээр хорооны үүрэгт би өөрөө эмч хүн, энд миний боловсрол аль нэг талаар учир дутагдалтай учраас би үүнээс татгалзаж байна.

К. Зардыхан -Би хоёр зүйлийг хэлмээр байна. Үг хэлэхийн өмнө та бүхнээс би уучлалт гуймаар байна. Би нэрээ авч байгаа явдал нь ямар нэгэн тунирхал, гоморхол надад байхгүй. Би хоёр шалтгаанаас бол эндээс татгалзаж байгаа юм. 1-р шалтгаан нь Чимидийн хэлсэн шалтгаантай адилхан. Эхнээс нь боловсруулахад оролцож, ямар нэгэн хэлбэрээр нэлээд оролцсон учраас бусад депутатууд, нөхдүүд сайн ажиллаг. Мөн бусад нөхдүүдийн саналыг харгалзая. Бидний саналын зарим нь магадгүй тусаж, энд буруу, зөрүү болгочихоод байгаа ч юм байж магадгүй юм, гэсэн шалтгаанаар татгалзаж байгаа юм нэгдүгээрт. Би хороонд орохгүйгээр энд оролцож, ярилцах, ямар нэгэн хэлбэрээр тус хүргэх зүйл байвал би үүн дээр огт татгалзах юм байхгүй.

Надад хоёрдугаар шалтгаан байна. Энэ нь их эгзэгтэй, эмзэгтэй шалтгаан юм. Энэ асуудлыг та бүхэн зөв ойлгоорой. Би үүн дээр гурван зүйлийг хэлье. II-р сарын II-ний өдөр Ардын Их Хурал эхэлсэн. Энэ өдрийн Үнэн сонинд ардын Их Хурлын депутатын сонорт МАХН-ын төв хэвлэл Үнэн сонинны сүүдэр "Бод-

лын солбицол" сонинд ийм асуудал бичсэн байна. Үндсэн хууль нь зөвхөн Монгол үндэстний гол хууль байх ёстой. Монгол улс ганцхан Монгол үндэстний улс мөн гэж заасан байна. Энэ нь учир, утгатай зүйл гэж бодож байна. Хоёрдугаарт энэ хуулийг Монгол ясны хүмүүс хийх ёстой гэж бичсэн байгаа юм.

Мөн өчигдөрийн Үндэсний дэвшил сонинг тараасныг та бүхэн мэдэж байгаа. Энэ сонинд биднийг, казах хүмүүсийг цагаачид гэж бичсэн байсан. Нөгөө талаар гэхэд казахуудтай холбогдсон өдий, төдий асуудал бичигдсэн. Энэ нь надад их эвгүй сэтгэгдэл төрүүлж байгаа юм.

Мөн уржигдар гарсан Шинэ үе сонинд Баян-Өлгий аймаг дахь казахуудын асуудал нь ирээдүйд хоолойд тээглэсэн яс болж мэднэ гэж бичсэн байгаа юм. Энэ бүх зүйл нь үнэндээ намайг эмзэглүүлж байна. Би чин зүрхнээсээ тус хүргэх юмсан гэж бодож чадал, чинээгээрээ оролцож, яваа, гэтэл ийм үзэл санаа дэлгэрч, өөрөөр хэлбэл үндэсэрхэг үзэл хүчтэй дэлгэрч байгаа явдал нь миний хэлж, ярьж байгаа зүйлүүд хүмүүсийг эмзэглүүлж харцах сэтгэл төрүүлж болох юм. Тийм учраас би хороонд оролцохгүй, бусад хэлбэрээр оролцох нь зүйтэй гэж үзэж байгаа учраас ийм хоёр шалтгаанаар би ийм хоёр шалтгаанаар татгалзаж байгаа юм. Түүнээс өөр ямар нэгэн гэж, буруу санаа надад байхгүй.

Д.Дожоодорж/ЗГ-р тойргийн депутат/ -Чимид болон Зардыхан нарын ярьсан зүйл үндэслэлтэй гэж би бодож байна. Ийм санал, гомдол ч зүйтэй юм. Тэгээр энэ хорооноос татгалзсан учраа ярьж байгааг би ул үндэстэй гэж би хувьдаа бодож, ойлгож байна. Чимидийн хэлснээр Үндсэн хуулийн эцсийн хувилбарыг гаргах, дэлхий дахин болон ард түмэндээ тунхаглах эцсийн хувилбар нь маш хариуцлагатай юм. Чимидийн хэлж байгаа нь зөв юм. Энэ нь зөвхөн техникийн комисс биш ээ, энэ хуулийг жинхэнэ дээд хэмжээнд нь, уг үсгийн утга санааны бүх талаар нь дээд түвшинд боловсруулсан хуулийг гаргаж ард түмэндээ дэлхий дахинд зарлах учраас энэ комиссын үүрэг нь асар их юм. Тиймээс үүн

дээрээ мэдлэг чадвартай хүмүүсээ, хуулийн болон бусад мэргэжлийн хүмүүс байх нь зүйтэй. Сая аймаг бүрээс нэг хүнийг оруулья гэж ярьж байна. Энэ нь ямар нэгэн хувьчлал болж байгаа биш. Ямар нэгэн өглөг аймаг бүрт хувааж байгаа биш. Үүнд гол нь сайн комисс томилож, үүнийгээ хийх юмсан.

Хоёрдугаарт Үндсэн хуулийг боловсруулах комиссын дарга нь манай Ерөнхийлөгч байгаа юм. Ерөнхийлөгч үүнд орж болдоггүй юм гэхэд Ерөнхийлөгч нь залуурдаж, санал, онолоо хэлж, комиссын эцсийн хувилбарт хүчтэй оролцоор санагдаж байгаа юм. Ерөнхийлөгчийн санал их хэрэгтэй, анхнаас нь оролцсон юм байна. Энэ комиссоо чанартай болгохын тулд нэлээд нухацтай ярих нь зүйтэй болов уу гэсэн бодол байна.

Б.Алгаа/151-р тойргийн депутат/ -Депутатуудын намын хэсэг, депутатын хэсгээс өгсөн саналыг үндэслээд ялих, ялихгүй зүйлээр эмзэглэж болохгүй. Депутат хүн нь зайлшгүй найдлага, шаардлага тавьж байгаагийн дагуу энэ хороонд орж ажиллах нь зүй ёсны хэрэг. Тийм учраас татгалзаж байгаа хүмүүсүүдээ өөрсдийн санал бодлоор чөлөөлөх нь гол биш ээ. Үүнтэй холбогдуулж хэрэв өвчтэй хүн бол аргагүй юм. Нэр орсон хүмүүсийг нэрбүрчлэн нэрээр нь салгаж хэлэлцүүлээд, саналыг нь аваад шийдэх хэрэгтэй юм. Дахин үүн дээр олон үг хэлээд, давтаад байвал хурал сунжраад байна байх.

Л.Пэрэн /414-р тойргийн депутат/ -Хороо байгуулах тухай саналыг депутатууд өгч байна. Дээрх нөхдүүдийн ярьж байгаа хороо нь үнэхээр хариуцлагатай гэдгийг би зөвшөөрч байна. Энэ нь хороо нь зөвхөн хурлын протокол бичих үүрэгтэй биш юм. Түрүүнд ч дээрх нөхдүүд ярьсан. Үүнд асар их хариуцлагатай, бүтээл туурвилах үүрэгтэй. Энэ нь жирийн, түрүүнд Дожоодорж хэлж байсан, энэ тийм биш юм. Тэхээр миний бодож байгаагаар манайд урьдаа барьдаг нийгэм судлаачид, хуульчид, практиктай ийм хүмүүс л орох ёстой. Чимид, Зардыхан нар татгалзаж байна. Би үүнийг хариуцлагаас мултгах гэсэн гэж нэгдүгээрт ойлгож байна.

Хоёрдугаарт нь ялихгүй зүйл дээр өөнтөгжиж гомдсон байдлаа заавал депутатуудын өмнө гаргаж хэлэх шаардлага байхгүй. Бид сонгох хүнээ л сонгоно. Хариуцлагаас айх явдал байж болохгүй гэж бодож байна. Тийм учраас энэ бүрэлдэхүүнийг нэлээд нухацтай хэлэлцэхгүй бол зүгээр нэг хэсэг хүнийг автомаатаар сонгох явдал нь буруу юм. Үүнийг нухацтай хэлэлцэж, дахин санал хураах саналтай байна.

С. Намсрайжав/343-р тойргийн депутат/ -Манай аймгаас сумын дарга Дэмбэрэлням орсон учраас нэг аймгаас олон хүн байх шаардлагагүй гэж үзэж байна. Энэ комисст намайг оруулахгүй байна уу нэгдүгээрт.

Хоёрдугаарт зарим аймгаас хүмүүс байхгүй байна. Жишээ нь Дундговь аймгаас хүн алга байна гэж Жанжаа дарга ярилаа. Тиймээс Дундговь аймгаас хүн оруулъя.

С. Зориг/9-р тойргийн депутат/ -Эрхэм депутатуудад хандаж нэг зүйлийг хэлмээр байна. Юу вэ гэвэл бид хуучин Дотоод яамны сэтгэлгээнээс гарахгүй байна. Юм л бол бие, биенээ хардаж сөрддэг, ялгадаг хандлага гараад байна. Хэзээнээс эхлэж улсдаа амьдарч байгаа хүмүүс бие, биендээ итгэдэг болох юм бэ, үүнийгээ дотроо тунгаагаа чээ. Аймгуудаас заавал оролцох ёстой гэж яриад байдаг, би үүнийг ойлгохгүй байна л даа. Үндсэн хуулинд нэг аймаг нь нөгөө аймгийнхаа эсрэг заалт оруулах гээд байгаа юм уу, тиймээс бие, биенээ хардаад заавал бүх аймгаас оролцох ёстой гэж үзээд байгаа юм уу. Үндсэн хуулинд тийм юм орох нь арга байхгүй шүү дээ. Тийм учраас хэзээ хүн бүр өөрийн гэсэн довийн сэтгэлгээнээс гарах юм бэ?

Бид Үндсэн хуулиа хийж байгаа болохоос биш, ямар нэг төсөв хуваарилах асуудлыг энд ярих гэж байгаа биш шүү дээ. Тиймээс чадалтай, мэргэжилтэй, тэр чиглэлээр ажилласан, тийм хүмүүсээ оруулахаа бодох хэрэгтэй шүү дээ. Хэн ч эрхийг

буулахгүй. Би зарим депутатуудыг гайхаад байгаа юм. Юм тайлбарлана гэхээр ухуулга хийнэ гэж гайгаад байгаа юм. Би ер нь сонсохгүй байсан нь дээр юм. Жишээ нь өнөөдөр сүлдний асуудлыг тайлбарлана гэхээр зарим депутатууд нь би ухуулганд орох байх, үзэхгүй, сонсохгүй, зугтаана гээд байдаг нь юу гэсэн үг вэ? Өөрийгээ тийм жаахан хүүхдийн ухуулганд орох хэмжээнд ойлгоод байгаа юу? Хэрэв та нарт итгэл хүлээлгэсэн бол тэр хэмжээнд өөрсдөө бодоод, шийдвэрээ гаргах чадвартай хүмүүс шүү дээ. Тийм учраас илүү зүйл мэдэхээс айх нь улам харанхуй болохын шинж тэмдэг байж магадгүй. Тиймээс нэлээд буурьтай, жинхэнэ депутат гэдгээ харуулах үүднээс, нэлээд бодолтойгоор аливаа асуудалд хандаа чээ. Комисс томилох асуудлыг би санаж байгаа юм, 21 хүнээр байна гээд батлачихсан. Түүнийгээ нэг хоноод маргаж байгаад мартчих юм. Хурлын дарга, депутатууд ч үүнийг мартчихаад 28гээд дахин батлаж байдаг. 21 хүн гэж батлаад, харин бүрэлдэхүүнийг нь яриад эхэлтэл татгалзаад эхэлсэн. Тийм учраас нэг, хоёр хоногийн өмнө болсон зүйлээ санаад, хэрэв санахгүй бол бичиж аваад түүнийгээ эргэж харж байя л даа.

Т. Ядамсүрэн/21-р тойргийн депутат/ - Надад өөр санал байна. Депутатын хороог цөөн хүнээр байгуулья гэхээр одоо хүмүүсийн ярьж байгаа нэлээд чадалтай, туршлагатай ийм хүмүүсүүд нь үүнээс зугатаж байна. Дараа нь цаана нь энэ хүнд ачааг мэргэжил боловсрол муутай, туршлага багатай хүмүүст үүрүүлэх гэж байгаа явдал нь нэлээд хүнд байна гэж надад бодогдож байна. Тийм учраас депутатын энэ хороог хуулийнхаа, Ерөнхийлөгчийн гаргасан таван чиглэлийн дагуу гаргаж байсантай адилхан бүлэг, тус бүрээр байгуулаад, түүнд өөрсдийн үзэл бодлоор нэгтгээд оролцуулж, түүнийг нь нэгтгэж байж оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энд нэлээд туршлагатай, жишээ нь Авхиа гуай мэтийн хүмүүс байна. Энэ хүмүүсээ оруулаа чээ. Энэ хүмүүсийг хуучин сэтгэлгээтэй хүмүүс гэж ойлгож болохгүй байх гэж бодож байна. Энд Чимид, Зардыхан нар хэтэрхий их тунгирхаж

Ингэж болохгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл чөлөөтэй гээд тодорхой нэг хүний үзэл бодлууд энд яваад байгаа. Ийм зүйлд эмзэглэх, еөнтөглөөд байвал цаашдаа энэ өндөр мөст дээр та нар яаж ажиллаж чадах юм бэ? Үүнийгээ эргэж, бодож хараа чээ гэж үзэж байна. Миний нэр энд мөн орсон байгаа. Надад боловсрол дутуу, өөрөөр хэлбэл би дунд боловсролтой хүн. Тэхээр би ийм зүйлд өөрийгээ чамлаж байна. Тийм учраас би нэрээ татъя. Харин орон нутгаас дэвшүүлж байгаа саналыг харгалзаад Пүрэвдагвыг энд оруулах саналтай байна.

Ж.Уртнасан -Асуудал нэлээд задрах төлөвтэй болж байна. Саналаа таслая гэсэн саналыг зөвшөөрөх үү? Одоо дөрвөн хүн байна. Нэмж санал гаргахаа больё. Микрофоны ард байгаа дөрвөн хүнийг бүртгэж авлаа. Саналаа давхардуулахгүй хэлбэл сайн байна.

Б.Норжин /ИЗГ-р тойргийн депутат/: -Санал давхардуулахгүй. Депутат Дожоодорж, бусад депутатуудын хэлснээр энэ нь аймаг, аймгийн төлөөлөгч шийдэх асуудал биш юм гэж ойлгож санал нэгдэж байна.

Хоёрдугаарт Их Хурлаасаа илүү эрхтэй хороог анх дэг хэлэлцэж байхад би энэ хорооны учрыг олохгүй түдгэлзэж байсан хүн юм. Тийм учраас миний нэр орсон байна. Энэ Их цаазын төслийг эцэслэн боловсруулаад, хянаад, батлаад ард түмний гар дээр тавих өргөн эрхийн үүргийг гүйцэтгэж чадахгүй учраас өөрийнхээ нэрийг татая гэж бодож байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн *Ц.Баярмаа* Ц.БАЯРМАА

Бичээч С.ТУУЛ

Кассет 52
1991-ХI-15
9.45-10.00

Ардын Их Хурлын 291 дүгээр тойргийн депутат Г.Хашбаатар: Тэгэхлээр бид энэ байгуулж байгаа хороог хоёр янзаар ойлгоод байна. Зарим нь хорин нэг гэдэг дээр маргаж байна. Хорин нэг гэдэг бол өөр асуудал. Хэлэлцэж байгаа асуудлаар тусгай маргаантай асуудал гарвал хорин нэгэн хүний бүрэлдэхүүнтэй комисс томилж энэ комиссыг чинь санал хурааж шийдэх ёстой ийм комисс. Одоо энэ байгуулж байгаа хороо бол онцгой хороо. Үндсэн хуулийн энэ асуудлыг бүрэн хэлэлцэж нууссаны дараа эцсийн хэлэлцүүлэгт боловсруулж оруулах онцгой эрхтэй хороо. Энэн дээр аймаг, орон нутгийн чиглэлээр хандаж болохгүй. Бид Бага Хуралдаа итгэх хэрэгтэй. Энд одоо манай хуульч мэргэжилтэн, эрдэмтэн, мэргэд, юмаа мэддэг улсууд бид нарын гаргасан олон санаа оноог бүгдийг нь дүгнэж цэгнээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж оруулах ёстой ийм хариуцлагатай хороо. Ийм учраас бид энэнийг жаахан өөрөөр бодож энэ Бага Хурлаас оруулж байгаа санал, Хурлын тэргүүлэгчдийн зүгээс оруулж байгаа саналыг үндэслэж, үндэстэй шийдмээр байна. Ийм учраас энэ аймаг орон нутгархах энэ боллоос салъя. Ингээд ер нь одоо чадалтай улсуудаараа бүрдсэн хороогоо байгуулъя.

Ардын Их Хурлын 185 дугаар тойргийн депутат Д.Жанзан: Тэгэхлээр зэрэг юүний өмнө бие биен дотроосоо дайсан эрээд байхаа больё. Хардаж, сэрдээд, бие биенээсээ дайсан эрээд байдаг явдал их зохимжгүй байна. Хоёрдугаарт нь зарим улсууд буруу ойлгочих шиг боллоо. Энэ хороо бүгдийг боловсруулах юм, бүгдийг шийдэх юм гээд ингээд яриад, буруу ойлгуулаад байна. Би энэнийг буруу гэж ойлгож байна. Яагаад гэвэл энэ нэгдүгээрт энэ танхим дотор Үндсэн хуулийн энэ заалт ямар байх ёстой юм, яах юм гэдгийг шийднэ, энэ танхим дотор Их Хурал хуралдаанаар шийднэ. Энэ хуралдаанаар шийдсэн асуудлыг хороо бол тэнд боловсруулна. Хороо тэгэхдээ бол хороо өөрөө боловсруулахгүй, доороо бүлэг тус бүр дээр ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсэгт хуульчид, жинхэнэ энэ Үндсэн хуулийн төслийг боловсруулсан

2.

хүмүүс, мэргэжлийн улсууд байгаа юм. Тийм учраас энэ хороо боловсруулах юм, тэр ажлын хэсэг бол ямар ч рольгүй юм шиг ойлгоод ийм юм яриад, энэ тасалгаан дотор шуугичихлаа. Ийм учраас энэнийг бол эмзэглээд байх явдалгүй. Энэ нэгэнтээ бүлгүүдээс тогтсон нэрүүдийг оруулах нь зүйтэй. Гэхдээ өчигдөр бол хорин нэгэн хүнээр гэж баталчихаад өнөөдөр дахиад л хорин найм, хорин есөн хүний нэр оруулаад байдаг бол зохимжгүй юм. Тэр хорин нэгээрээ баталснаараа болмоор байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь өчигдөр хорин найман хүнээс чинь өнөөдөр нэг хэсэг нь нэрээ татаад авчихлаа. Энэнийг хасаад, нэрээ татаж авсан улсуудыг нь хасаад тэгээд хорин нэг болгоод үлдсэнг нь баталчихвал яасан юм бэ гэсэн ийм санал байна. Ийм учраас энэ саяын хэлсэн нэрүүдээр зогсож байгаа улсуудаар санал хураагаад таслаад, саналаа хураалтанд орвол яасан юм бэ?

Ардын Их Хурлын 360 дугаар тойргийн депутат Д. Найлан: Энэ дээр санал давхардуулахгүй хэлэх нэг зүйл байна. Хорооны тухай үндсэн ойлголт бол санал хураалтаар жигдэрнэ гэж бодож байна. Энд нэр татаж авч байгаа депутатуудын санал бас үндэслэлтэй юм гэж би ойлгож байна. Манай сонин хэвлэлүүд, цаана нь байж байгаа янз бүрийн намын хэвлэлүүд дээр депутатуудыг шинээр баталж, эрхийг нь баталгаажуулсан хууль байхгүй далимдуулж ямар нэгэн хэлбэрээр хатгах, биднийг өөнтөглөх ийм яс хаясан ийм зүйлийг хэвлэж байгаа явдал бол Их Хурлын хуралдааныг ямар нэгэн хэмжээгээр саатуулах үйлчилгээ үзүүлж байна. Энэнтэй холбогдуулж хэвлэл, мэдээллийн газруудад ийм зүй бус хэвлэлийн тавьсан нөхдүүдэд хариуцлага тооцох асуудлыг хурлын зүгээс зориуд анхааруулах нь зүйтэй гэж бодож байна. Энээнээс хойшоо гоо улам ч харин хэд хэдэн янзаар ийм зүйл гарч болзошгүй, ийм учраас энэнийг хурлын депутатын хувьд санал болгож байна. Депутатын саналыг баталгаагүй болгосон, хууль ёсоор баталгаажуулаагүй гэж би юу гэж хэлж байна гэвэл Их Хурлын анхдугаар чуулганы дараагаар

3.

Улсын Бага Хурал болоод бусад хуулиуд баталгаажгаад гарсан, Их Хурлын депутатын тухай хуулийг санал авчихаад хуучин хууль хүчинтэй үйлчилнэ ч гэж зарлаагүй, шинэ хуулиа гаргаж баталгаажуулаагүй, ингээд явсаар байгаад одоо дахин баталгаажигүйгээр бүх зүйлийг өөрчлөөц дараагийн хуралцаанд орж ирсэн ийм асуудал байгаа. Энэнийг би тэмцэглэж хэлж байна. Ийм учраас харин энэ хорооны саналууд дээр давхардуулаад хэлэхэд энэ хороо бол хариуцлага ихтэй, мэргэжлийн хуульчдын оролцуулах гэсэн энэ саналыг юу юунаас илүү пэмжих нь зүйтэй гэж бодож байна.

Ардын Их Хурлын 228 дугаар тойргийн депутат Н.Алъяжав: -Дэгийн цагуу Их цаазын төслийг депутатуудын хороогоор хэлэлцэн боловсруулж Их Хуралд оруулах ёстой. Энэ бол зөвхөн депутатуудын бүтээл биш, энэ бол Үндсэн хуулийн комисс, Улсын Бага Хурал энэ байгууллагуудын бүтээл байх гэж би дотроо боддог. Ийм учраас дээрхи байгууллагуудаас манай энэ хороонд оруулж энэ хороогоор энэ Их цаазын төслийг хэлэлцэн боловсруулах байх гэж би бодож байна. Ийм учраас би Хурлын даргаас оруулж байгаа энэ саналыг би пэмжиж байна. Өөрөөр хэлбэл энэ хорин долоон хүнийг, заавал бид хорин нэг гэхгүйгээр бас бүрэлдэхүүнийг нь бас олшруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Дээр нь би хоёр хүнийг нэмж оруулах санал байна. Энд бол Гаравсүрэн депутат байна, Ёндонцэмбэрэл гэсэн ийм хоёр депутат байна. Би тойргийг нь одоохондоо санахгүй байна. Хоёр хуульч хүн байна.

Ардын Их Хурлын 260 дугаар тойргийн депутат Ж.Буд: Би нэг ганц асуудлыг хэлье. Санал давхардуулахгүйгээр. Тэгэхээр бид ер нь энэ Их Хуралцаа оролцож байгаа депутат хүний хувьд үүргээ биелүүлэх нь зүйтэй байх гэж ингэж бодоод миний хувьд тэр хуулийн эрх зүйн талаас нь, онолын талаас нь мэдлэг байхгүй, гэхдээ ерөөсөө депутат хүний хувьд би өөрийнхөө нэрийг энд оруулъя гэж бодож байна. Энэ дээр яах вэ ер нь гол нь эндээс би практик амьдралтай холбож энэ Үндсэн хуулийг хэлэлцэхэд ард түмнийхээ өгсөн үүрэг даалгаврынхаа да-

гуу ямар ч байсан би чадахаараа оролцёё гэдэг энэ талаасаа бол өөрийнхөө саналыг оруулж байна.

Ж.Уртнасан:—Уучлаарай депутатууд аа.Бид тэргүүхэн зарчмын хувьд тохироод авсан.Одоо дөрвөн хүн байна уг хэлүүлье гэсэн хэлчихлээ.Одоо дахин гурван депутат босоод ирсэн байх юм. Саналыг үргэлжлүүлэх үү, таслах уу? Санал хураалт явуулъя.

—Уучлаарай Хурлын дарга аа! Түрүүн таныг дөрвөн хүний тоо тогтооход би зогсож байсан.Тийм учраас надад уг өгөөчээ гэж хүсч байна.

Ж.Уртнасан:—Үгүй цээ.Уучлаарай.Бид одоо биччихсэн л байна.Уучлаарай.Танхимын уур амьсгалыг эвдэхгүйн тулд Хурлын дарга шаардах эрхтэй гэсэн дэг бий.Санал хураалт явуулъя. Саналыг үргэлжлүүлэн хэлэлцье, ингээд тасалъя гэсэн ийм юм байна.Саналыг тасалъя гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна.Санал хураалтанд бэлтгэнэ үү.

За баярлалаа.Санал өгсөн депутатуудын 82 хувь нь буюу 301 хүн саналыг тасалъя гэсэн санал ирүүлж байна.54 хүн буюу 15 хувь нь татгалзлаа.11 хүн буюу 3 хувь нь түүдгэлзэж байна. Олонхийн саналаар энэ хороо байгуулах асуудлаар санал тасаллаа. Одоо та бүгдийн саналыг үндэслэж гурван хувилбар дээр бид санал хурааж болох боломж байх шиг байна.

Нэгдүгээрт нэрээ татаж авах хүмүүсийн хүсэлтийг зөвшөөрье гэсэн нэг ийм хувилбар байж байна.Хоёрдугаарт нь депутатуудын хорооны бүрэлдэхүүнийг анхны төслөөр баталъя гэсэн ийм хувилбар байна.Гурав дахь нь депутатын өөрийнх нь хүсэлтээр нэрийг нэмж оруулна гэсэн ийм гурван хувилбар бидэнд томъёологдож байна.Тэгэхээр энэ дээр санал хураалт явуулъя гэж бодож байна.Зүйтэй юу.Тооны хувьд санал зө-

рөөтэй байгаа юм.Зарим депутатууд тайлбарлалаа.Маргаантай асуудлаар байгуулах депутатын хороог бол хорин нэг гэж тогтсон.Ийм болохоор энэ редакцийн чанартай ажил хийх энэ хороог энэ орон нутаг,намын бүлгээс дэвшүүлсэн нэрийн дагуу байя гэсэн ийм хоёр санал явж байгаа юм.Хоёр тийшээ.Тэгэхээр тоогоо тогтоё гэдэг дөрөв дэх хувилбар дээр санал хурааж болох юм.За тэгвэл эхлээд тоогоо тогтоё гэдэг дээр санал хураалт явуулъя.Тоог дэгэндээ бол хорин нэг гээд биччихсэн байгаа.

-Уучлаарай хурлын дарга аа.Горимын санал танд туслах зорилгоор горимын санал хэлье.Хэрвээ та ечигдрийн баталсан тоог өөрчлөх гэж байгаа бол одоо бид нар уржигдрийн баталсан хорин нэг гэсэн тоогоо өөрчлөх үү гээд санал хураая.Тэрний дараагаар та энэ депутатуудын хороог хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байгуулах вэ гэдэг тоогоор дахиад нэг санал хураачих.Энэ дашрамд хэлэхэд Хурлын дарга, орлогч дарга нарт би зүгээр сайн сэтгэлээс хэлж байна.Энэ дэгээ айхтар сайн судлаачээ.Түрүүн олон депутат үгээ хэлээд байхад та бүхэн ерөөсөө ойлгож авахгүй юм.Тэр энэ хойд талын хоёрдугаар бүлгийн "в" чинь бол депутатын хороо бол заавал 21 хүнтэй байна гэсэн үг биш шүү.Тэрийг сайн болгоогоочээ.

Ж.Уртнасан:-Депутатууд уг нь хоёр талд санал гарсан л даа.Тэр хорин нэгийн тоо дээ.Энэ нэгийн "з" дээр яг бид нарын энэ хэлэлцэж байгаа дээр бол тоо байхгүй шүү.Тоо байхгүй.

-Хурлын дарга аа.Надад нэг санал байна.Хорин нэг гэж баталсан.Нэр уншихад хорин хоёр болгосон шүү дээ.Тийм учраас ерөөсөө тоогоо эхлээд тусгах нь зүйтэй гэсэн санал байна.

-Дарга аа, надад нэг санал байна.Энэ арвын ийм байна.

Энэ арвын нэг дээр чинь ажлын хэсэг комисс хорин нэгээр байгаа. Арван хоёрын "3" дээр чинь жинхэнэ депутатын хороо гэж байгаа. Энэ дээр тоо тогтоогоогүй шүү дээ. Энэ хоёр зүйл дээр хар. Тэгэхлээр хорин нэг дээр бол түрүүн шийдсэн асуудал.

Ж.Уртнасан:—Томьёололд бас хуулийн зөвлөхүүдээс нэг санал ирүүлж байна. Тэгэхээр бид бас хууль зүйн дагуу ажиллах ёстой юм шиг байна. Хэрэв өөрийнхөө хүсэлтээр нэрээ татаж авч байгаа бол санал хураалтаар тулгадаг ийм хууль зүйн эрхийн акт байдаггүй юм байна. Ийм учраас нэрээ татаж авна гэсэн хүмүүсийг бид одоо заавал санал хураалгаж, хүчээр бүрэлдэхүүнд оруулах хууль эрхийн актгүй юм байна. Ийм учраас бидний томьёолж байгаа тэр нэрээ татаж авсан хүмүүсийн хүсэлтийг зөвшөөрөх эсэх гэдэг бол хэтэрхий тулган хүлээлгэсэн ийм хууль бус арга хэмжээ болох төлөвтэй байна. Ийм учраас бид хорооны гишүүдийн нэрийг нэрээ татаж авсан хүмүүсийг бол хасаж уншаад үлдэх улсууд цээрээ санал хураалт, нэгбүрчлэн санал хураалт явуулаад шийдчихвэл яасан юм бэ гэсэн ийм санал оруулж байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

1991-11-15
Кассета № 53
10.00-10.15.

Уртнасан:

-Уучлаарай, бид нар энд нэг бичлэг хараадахлаа.Тэгсэн бид бол хүний тоо 21 байна гэж 372 хүн буюу 82 депутат зөвшөөрсөн байна.22 хүн буюу 5 % нь татгалзаад, 11 хүн буюу 2 нь түдгэлзээд ингэжээ.Хорооны бүрэлдэхүүнд орох 21 хүний нэрийг бид бас анх удаа уншаад авсан байна.Тэгээд энийг бол эцэслэн боловсруулъя.Орон нутаг, нутаг дэвсгэрийн бүлгийн санал, намын бүлгийн санал авъя гээд ингээд тогтсон юм байна.Ийм учраас бид бичлэгээ хараад ер нь 21 гэсэн тоондоо тулгаад л комиссоо байгуулчих нь зүйтэй юм байна л даа.Одоо тэгэхээр томъёолол сүрхий задарлаа.Эцсийн хувилбар бол бид нар энэ хүмүүсийн нэрийг нэг бүрчлэн санал хураалт явуулаад, үлдвэл нэмж санал гаргаад ингээд 21 дээрээ тулгаад зогсох хэрэгтэй болох нь ээ. Ингээд санал хураалт явуулах уу.

/Танхимаас/

-Шууд 21 хүнээ оруулчихаж болохгүй юм уу дарга аа.

Уртнасан:

-21 хүргэнэ гэхэд бид дахиад баахан хүний нэр тавих болов уу гэж жаахан эмээж байна.Болох л асуудал юм.

9 депутат нэрээ татаж авъя гэсэн байх юм.Тэгээд бид 1 юм уу 2 хүн дээр л ярих хэрэг болох нь л дээ.

-За ер нь нэрээр санал хураалт явуулаад үзэх нь зүйтэй юм байна л даа.Санал хураалтанд бэлтгэнэ үү , депутатууд аа. Нэрээр.

-Лханаасүрэн депутатын асуултанд хариулъя.Сая бид нарын орон нутаг,намын бүлгүүдээс гаргаж ирсэн, энэ нэр дээр тулгуурлаж ярина бид нар .Энэ дээр ярина.За нэрээр санал хураалт явуулж эхэллээ.Санал хураалтанд бэлтгэнэ үү. Сарай гуай нэрээ татаж авсан учраас хаслаа.Жамбын Гомбожав дээр санал хураалт, Жамбын Гомбожав нэгдүгээрт, За 95 % нь буюу 381 депутатын саналаар Гомбожав гуай үлдэж байна.Татгалзсан 12, түдгэлзсэн 9. Чинбат нэрээ татаж авсан.2-рт Жанчивдоржийн Адъяа, ^{хуульч} мэргэжилтэй, 202-р тойргийн депутат.Санал хураалт

Нийт санал өгсөн депутатуудын 93 % нь буюу 380 хүн зөвшөөрлөө. 15 татгалзаж, 13 түдгэлзлээ. Жанчивдоржийн Адъяа үлдэж байна. 3-рт, Ишийн Бадарч 293-р тойргийн депутат, эдийн засагч, Уучлаарай, Бадарч гуай дээр бас будлиан гаргаж байна, Бадарч гуай нэрээ татаж аваад нэг хүний нэр дэвшүүлсэн, нэр дэвшүүлэх асуудлыг бид хэлэлцээгүй учраас нээлттэй орхичихье. Ингээд цаашаа явъя.

Анхаараарай, Кунтуганы Мизамханы талаар санал хураалт явагдах гэж байна. Кунтуганы Мизамхан 74-р тойргийн депутат. За баярлалаа, 91 % нь зөвшөөрч, 370 хүн зөвшөөрлөө, 24 татгалзаж, 12 хүн түдгэлзлээ. Мизамхан үлдэж байна, 4-рт Баярхүүгийн Мижид, 163-р тойргийн депутат, Аймгийн АХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, Мижид. 93 % нь буюу 382 депутат зөвшөөрлөө. 16 хүн татгалзаж, 12 хүн түдгэлзлээ. 5-рт Данзангийн Лундаажанцан, УБХ-ын гишүүн, хуульч, Лундаажанцан, 93 % нь буюу 380 депутат зөвшөөрлөө, татгалзсан 19 хүн, түдгэлзсэн 11 хүн байна. Лундаажанцан үлдлээ. 6-рт Чулууны Дэмбэрэлням, 346-р тойргийн депутат, сумын АХГЗ-ны дарга Дэмбэрэлням. 89 % нь, 358 хүн зөвшөөрч, 31 хүн татгалзаж, 15 хүн түдгэлзлээ. Үлдэж байна. 7-рт Дамдингийн Дэмбэрэл 234-р тойргийн депутат, Завхан МАХН-ын хорооны дарга, эдийн засагч, Дэмбэрэл. 86 % нь буюу 350 хүн санал өглөө, 35 хүн татгалзаж, 21 хүн түдгэлзлээ. 8-рт Наваан-Цэрэнлэйн Жанцан, УБХ-ын гишүүн, хуульч. Жанцан. Санал өгсөн депутатуудын 90 % нь буюу 368 хүн зөвшөөрч, 31 хүн татгалзаж, 12 хүн түдгэлзлээ. Жанцан үлдэж байна. 9-рт Данзангийн Жагварал, 104-р тойргийн депутат, Сумын АХГЗ-ны дарга улс төр судлаач. Жагварал. Санал өгсөн депутатуудын 79 % нь буюу 323 хүн зөвшөөрлөө, 64 нь татгалзаж, 22 хүн түдгэлзсэн байна. Жагварал үлдлээ. 10-рт, Самдангийн Чулуунбаатар 132-р тойргийн депутат, УБХ-ын гишүүн, нийгэм судлаач. Чулуунбаатар. Санал өгсөн депутатуудын 86 % нь буюу 349 хүн зөвшөөрлөө, 44 хүн татгалзаж, 14 хүн түдгэлзэж, Чулуунбаатар үлдэж байна. 11-рт Дамдинжавын Гомбожав, 420-р тойргийн депутат. Улс төр судлаач. Санал өгсөн депутатуудын 82 % нь буюу 334 хүн зөвшөөрлөө, 51 хүн татгалзаж, 23 хүн түдгэлзсэн байна. Гомбожав гуай үлдлээ. 12-рт Шаравдоржийн Цэнджаргал 268-р тойргийн депутат, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Цэнджаргал. Санал өгсөн депутатуудын

76 % нь буюу 311 хүн зөвшөөрлөө, татгалзсан 66, түдгэлзсэн 32 хүн байна. Үлдэж байна. 13-рт Юлтын Жаргал, 46-р тойргийн депутат, барилгын инженер Юлтын Жаргал. Санал өгсөн депутатуудын 75 % нь буюу 305 хүн зөвшөөрлөө, татгалзсан 78 хүн, түдгэлзсэн 24 хүн байна. 14-рт Шаравын Сүрэнжав, 44-р тойргийн депутат, яруу найрагч Шаравын Сүрэнжав. Санал өгсөн депутатуудын 71 % нь зөвшөөрч 290 хүн зөвшөөрлөө, 98 хүн татгалзаж, 21 хүн түдгэлзлээ. Үлдэж байна. 15-рт Жигжидийн Бямбаа, 11-р тойргийн депутат, зохиолч, Ж.Бямбаа. За уучлаарай, Жигжидийн Бямбаа гуайд 164 хүн санал өгч, 40 хувь боллоо. 215 хүн татгалзаж, 53 % нь тийм учраас депутатын хорооны нэрсийн жагсаалтаас санал хураалтаар хасагдаж байна. 16-рт, Лувсандамбын Дашням, 22-р тойргийн депутат, Хувийн их сургуулийн захирал. Лувсандамбын Дашням. Санал хураалт явж байна. 66 % нь буюу 268 хүн зөвшөөрлөө, 119 хүн татгалзлаа, 22 хүн түдгэлзэж байна. Дашням үлдлээ. Цэрэндоогийн Энхбат, 23-р тойргийн депутат, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн багш. Энхбат. Санал өгсөн депутатуудын 72 % нь буюу 291 хүн зөвшөөрч байна, 91 хүн татгалзаж, 24 хүн түдгэлзлээ. Энхбат депутат үлдэж байна. 17-рт Санжаасүрэнгийн Зориг, 9-р тойргийн депутат, нийгэм судлаач. Санжаасүрэнгийн Зориг. 70 % нь буюу 287 депутат зөвшөөрч, 97 хүн татгалзаж, 25 хүн түдгэлзлээ. Зориг депутат үлдэж байна. 18-рт нь Нэмэхийн Пүрэвдорж. 41-р тойргийн депутат, хуульч, багш мэргэжилтэй. Нэмэхийн Пүрэвдорж. Санал өгсөн депутатуудын 69 % нь буюу 283 хүн зөвшөөрч, 99 хүн татгалзаж, 27 хүн түдгэлзлээ. Пүрэвдорж депутат үлдэж байна. Ингээд орон нутгийн бүлэг, намын бүлгээс нэр дэвшүүлсэн хүмүүсээс нэрээ татаж аваад 18 боллоо.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш.Бурмаа

1991.XI.15.
Кассет № 54
10.15-10.30

М.Уртнасан: ... 141 дүгээр тойргийн депутат
М.Авхиа, хуульч.

Хуульч М.Авхиа гуайд 86 хувь буюу 350 хүн санал өглөө.
47 хүн татгалзаж, 11 хүн түдгэлзсэн.

Одоо сая өөрөө нэрээ дэвшүүлсэн 260 дугаар тойргийн
депутат М.Буд, Говийн бүсийн мал аж ахуй, эрдэм шинжил-
гээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.

260 дугаар тойргийн депутат М.Буд депутатуудын хорооны
бүрэлдэхүүнд орж байна. 75 хувийн санал авлаа, 316 хүн
зөвшөөрч, 70 хүн татгалзаж, 22 хүн түдгэлзлээ.

Урд эргэж харах ёстой нэг зүйл байгаа. Бадарч гуай өөрийн-
хөө оронд депутат Нороврагчааг нэр дэвшүүлсэн. Депутат
Нороврагчаа.

180 дугаар тойргийн депутат Д.Жумдаанбаатар:
-Тэгэхээр бид нэг эмэгтэй хүн оруулмаар байх юм.
Санал гаргавал Бямбажав. Энхтуяа гэсэн санал дэвшүүлмээр
байна.

М.Уртнасан: -Уучлаарай, юу ч гэсэн Нороврагчаа
дээр санал хураалт явуулъя. Депутат Нороврагчаа.

Санал өгсөн депутатуудын 64 хувь буюу 257 хүн зөвшөөр-
лөө, 105 хүн татгалзаж, 42 хүн түдгэлзлээ. депутат нөхөд
их баярлалаа. Бид 21 хүний бүрэлдэхүүнтэй депутатуудын
хороотой болж байх шиг байна. Ингээд бүрэлдэхүүнийг энэ
21 хүнээр депутатын хороогоо нийтэд нь баталъя гэсэн
санал оруулж байна.

Санал өгсөн депутатуудын 89 хувь депутатын хороог
зөвшөөрч, 362 депутатын олонхийн саналаар хороо байгуул-
лаа. Баярлалаа.

Одоо та бидэнд нээлттэй орхисон нэг эгзэгтэй их анхааралтай хандууштай /намайг депутатууд микрофон дуулдахгүй байна, суугаад ярь гэнэ, би сууж байгаад ярья/, нэн эгзэгтэй нэг асуудал бий.

119 дүгээр тойргийн депутатын талаар.Тэгэхээр бид хуульчдад хандаж олон хоног ажиллууллаа.Манай хууль бас олон онгорхой, цоорхойтой байдгийг бид эндээс харж байна.Тэгэхээр юу ч гэсэн бид энэ хуульчдын дүгнэлтийг та бүхэнд уншиж сонсоё. Тэгээд дараа нь эдний оруулж ирсэн нэг санал бий.Бас гуравдахь хувилбарыг бид дэвшүүлж ярилцах учиртай.Тэгэхээр хуульчдын дүгнэлтийг Хууль зүйн яамны сайд Ж.Амарсанаа, манай хуулийн зөвлөх, Н.Лувсанжав, С.Төмөр нарын оруулж ирсэн нэг дүгнэлт байгаа юм.Үүнийг та бүхний анхааралд толилуулъя.

дүгнэлт.Ардын Их Хурлын Байнгын комиссын дарга депутат н.Жаргалын танилцуулсан дун, Булган аймгийн прокурорын илтгэх хуудсаас үзэхэд 119 дүгээр тойргийн депутатын сонгуульд оролцох ёстой 1498 сонгогчоос 1496 сонгогч санал хураалтад оролцож Цэен-Ойдовын төлөө 174 сонгогч саналаа өгч түүний эсрэг 732 хүн санал өгсөн.Хүчингүйд тооцсон 10 хуудас гарсан дүнтэй байна.

Гэтэл сонгуулийн урьд өдөр саналыг бөөнтүүлэн нэг дугтуйнд илээр авсан 12 сонгогчийн саналыг хасч хүчингүйд тооцвол Цэен-Ойдовын төлөө 742 хүн санал өгсөн гэж үзэх болж байна.Энэ дүнг үндэслэн хувь гаргавал санал хураалтад оролцсон сонгогчдын 49,59 хувь нь Цэен-Ойдовын төлөө санал өгсөн байна.Үүнээс үзэхэд Цэен-Ойдов Сонгуулийн хуулийн 37 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан болзлыг хангаагүй байна.

Хэрвээ дээрх 12 сонгогч нь Ардын Хурлын депутатуудын сонгуулийн хуулийн 35 дугаар зүйлийн 1, 2 дугаарт заасны дагуу уг заалтад дурдсан шалтгааны учир өөрийн саналаар саналаа урьдчилж өгөх тухай хүсэлт гарган сонгуулийн хэсгийн комисст ирж саналаа өгөх ёстой атал тэдгээрийн саналыг комиссоос сонгуулийн урьд өдөр очиж авч, сонгуулийн журам

зөрчсөн тул тэдгээрийг санал хураалтад оролцоогүй гэж үзвэл санал хураалтад 1474 сонгогч оролцож Цэен-Ойдовын төлөө 74% хун санал өгсөн дун гарах юм. Энэ тохиолдолд Цэен-Ойдов нь 50 хувийн санал авч хуулийн 57 дугаар зүйлийн 2 дугаарт заасан болзлыг хангаж чадахгүй байгаа юм.

Энэ хуулийн 58 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт сонгуулийн явцад буюу санал тоолох, түүнчлэн сонгуулийн дун гарах үед БНМАУ-ын Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, тогтоолын энэ заалтыг зөрчсөн бол сонгуулийн тухайн нутаг дэвсгэрийн комисс сонгуулийг хүчингүйд тооцож Ардын Хурлын депутатуудыг бүртгэхээс татгалзаж болно гэжээ. Гэтэл энэ зөрчлийг тухайн үед нь арилгаагүй, улмаар БНМАУ-ын Ардын Их Хурлын 1990 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 3 дугаар тогтоолоор бүрэн эрхийг нь зөвшөөрсөн байна.

Нэгэнт Цэен-Ойдовын депутатын бүрэн эрхийг Ардын Их Хурлаас зөвшөөрч тогтоол гаргасан байх тул Ардын Их Хурлын байнгын комиссын дүгнэлтийг үндэслэн түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай тогтоол гаргах боломжгүй. Энэ талаар хуульд заасан зүйлгүй байна.

Иймээс БНМАУ-ын Ардын Их Хурлын 1990 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 3 тоот тогтоолоор зөвшөөрсөн хавсралт жагсаалтаас Ардын Их Хурлын депутат Цэен-Ойдовын бүрэн эрхтэй холбогдох заалтыг хүчингүй болгосон тогтоолыг Ардын Их Хурлаас гаргах нь зүйтэй гэж үзэж байна гэсэн дүгнэлт ирүүлсэн юм.

Энэ тогтоолын бүрэн эрхийг зөвшөөрсөн тогтоолын заалтаас тэр хэсгийг хасаж болж байгаа. Энд ингэж хасчихаж болмоор байгаа юм. Гэтэл цаад талд нь үр дагавар нь юу вэ гэхээр тойрог сонгогчгүй, энэ ажилд оролцож чадахгүй байна, депутат бүрэн эрхгүй ийм байдал болж байна. Үүнийг яаж засч залруулах юм бэ гэдэг бид дахиад ярилцсан. Хэрвээ ийм тохиолдолд сонгогчийн эрхийг бид нар бүрэн эрхгүй гээд эрхийг тогтоол гаргаад бид эндээс хасчихвал хоёр зам

байх шиг байгаа юм. дахин шинээр болон нөхөн сонгууль явуулах ийм зам байх ёстой. Сонгуулийн хуулийн 40 дүгээр зүйл, I дүгээр заалт. Гэтэл энэ маань сонгууль хүчингүйд тооцогдвал сарын дотор сонгууль явуулна гэсэн хуулийн заалт байдаг байна. Гэтэл бид жил өнгөрчихжээ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, орон нутгаас мөн энэ хугацаанд радио, телевизээр прокурорууд ярилаа. Орон нутгийн Ардын Хурлын захиргаанаас бүрэн эрхийг хэвээр байлгаач гэсэн мэдэгдэл ирж байна. Бас гомдол ирж байна. Энэ будлиан тасраагүй байна. Прокурорын шалгалтыг хүчин төгөлдөр биш, санал өгсөн 12 хүнтэй уулзаагүй. Ийм учраас Ардын Их Хурлаас газар дээр нь ирж шалгаж өгөөч гэсэн ийм гомдол ирсэн. Ийм учраас хуулийн зөвлөхүүд бид ярилцаад ер нь депутатуудын орон нутгийн бүлгээс, Ардын Их Хурлаас, прокуророос шуурхай шалгах группийг явуулж орон нутагт нь ажиллуулахгүй бол бид гоомой шийдвэр гаргах гэж байна.

Ийм учраас энэ Их Хурлын хуралдаанаас гоомой шийдвэр гаргавал бид энэ хурлыг тартал магадгүй, цаашаа дараагийн сонгууль болтол бид маргаантай асуудалд хөл дүрсэн хэвээрээ байх нээ. Ийм учраас гоомой шийдвэр гаргахаас бид зайлсхийж чин шударга, голч шийдвэр гаргахын тулд нээлттэй орхиод магадлах ажлын группийг орон нутагт явуулья гэсэн саналыг та бүхэнд оруулж байна.

Саянн томьёоллоор санал хураалт явуулья.

27 дугаар тойргийн депутат Л. Цүрэвдорж: -Бид энүүнд их болгоомжтой хандах хэрэгтэй юмаа. Ингэж шалгах нь зүйтэй, би энийг дэмжиж байна. Тэгэхээр энэ шалгаж байх хооронд Цэен-Ойдов депутат нэгэнт эрх нь татгалзаагүй, түүдгэлздэгдээгүй учраас Их Хурлын шийдвэрлэнэ гэсэн асуудлуудад орж саналаа өгсөн. Тэгнэ биз ?

А. Уртнасан:

-Тэгнэ.

Д.Цүрэгдорж: -Ингээд дараа нь шалгаад ирэхээр зэрэг хэрвээ/муу ёртой юм гэж битгий бодоорой/ хууль зөрчсөн байгаад эрхийг түдгэлзүүлэх дээр хүртэл тэгсэн нөхцөлд сонгууль хүчингүй болсон нөхцөлд бидний шийдээд Цэен-Ойдовын саналаа өгчихсэн асуудал дотроос ганцхан хүний саналаар шийдсэн асуудал байвал Их Хурлын тэр шийдэл хүчингүй болох ийм аюул гарч мэднэ.Энийг тооцон бодож ярилцъя гэсэн саналыг би хэлж байна.

Бид их хариуцлагатай юм хэлэлцэж байгаа.Үндсэн хуулийнхаа зүйл ангиуд, зарим юмыг санал хураагаад шийдчихсэн байж мэднэ шүү дээ.Тэрнийг ярилцахгүй бол дараа нь тэр зүйлээ даргын дараагаар хүчингүй болгох ийм асуудал болох вий. Энийг ярилцъя гэж бодож байна.

4о дугаар тойргийн депутат Ю.Маргал: -Манай байнгын комиссоос энэ асуудлыг оруулж хэлэлцүүлсэн нөхөр депутатуудад.Тийм учраас дахин депутатуудын хүсэлтээр хуулийн нөхдүүд хянаад сая санал оруулж байна.Байнгын комисс бол нийт депутатуудад оруулж хэлэлцүүлсэн учраас энийг чухам яаж шийдэхийг депутатууд та нөхдүүд шийднэ.Энэ дээр би нэг зүйлийг зориуд тодруулж хэлэх шаардлагатай байгаа учраас хэлье гэж бодсон юм.

Энэ Булган аймгаас сонгогдсон нэлээд тооны Ардын Их Хурлын депутатууд энэ асуудлыг байнгын комисс авч үзэхдээ нөхөр Болдбаатар, өөрөөр хэлбэл, Цэен-Ойдовтой өрсөлдөж байсан Болдбаатарын санал хүсэлтийн дагуу энэ хүсэлтийг Ардын Их Хурлын байнгын комисс авч үзсэн байна гэж нөхөр Болдбаатарт хандаж ийм асуудал тавьжээ.Би энийг үнэхээр зарчимгүй асуудал гэж хэлэх гэж байна.

Цэен-Ойдовтой өрсөлдсөн Болдбаатар манай байнгын комисст биеэрээ болон бичгээр ямар ч гомдол санал гаргаагүй, харин зөвхөн 119 дүгээр тойргийн сонгогчдоос Их Хурлын даргын нэр дээр хоёр удаа, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргын нэр дээр хоёр удаа, манай Байнгын комиссын

нэр дээр нэг удаа, сонгогчдоос ирүүлсэн мэдээллийн дагуу бид энийг шалгасан юм шүү. Түүнээс Болдбаатар энэ Улаанбаатар хотод сууж байгаа, бидний дэргэд байгаа энэ нөхрийн хүсэлтээр шалгалаа гэдэг ийм хачин юм бие биенээ хардсан сэрдсэн ийм юм ярьж явдгийг нөхдүүд минь та нар болиоч ээ. Энийг зөв ойлгооч гэж би зориуд хүсэх гэсэн юм.

Ж. Уртнасан: -Бид үнэхээр хоёр зүйлийг шийдэх шиг боллоо. Бид гоомой шийдвэр гаргахгүйн тулд энэ депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн энэ тогтоолоо одоо эрхийн дор юм, энэ түдгэлзүүлсэн эрхийг хүчингүй болгох, хоёрдугаарт, прокурор, депутатын бүлгийн комисс томилж, шуурхай комисс томилж ажиллуулах ийм хоёр заалттай тогтоол гаргая. Үүнийг хуулийн нөхдүүд томьёолог. Ингээд бид завсарлагааны дараа санал хураалт явуулъя гэсэн ийм саналтай байна.

178 дугаар тойргийн депутат Д. Энхбаатар: -Энэ асуудлаар бол хуулийн байгууллагын шалгалт хийжээ. Тэгээд дүгнэлтээ гаргасан. Аль ч талаас нь аваад үзсэн ерөөсөө энэ будлиантай болжээ гэдгийг тогтоосон. Мандатын комиссоос шалгалт очжээ. Их Хурлаас бас тогтоожээ. Тэгээд гоомой шийдвэр гэж би юугаа хэлэх гээд байгаа юм, би ерөөсөө ойлгохгүй байна.

Аль аль талаас нь хэд хэдэн шатны шалгалт яваад тогтоогоод будлиантай сонгууль болчихлоо гэж хэлээд байхад эргээд нөгөө хэддээ итгэхгүй байх юм. Мандатын комисстой ч итгэхгүй юм, прокурорын шалгалтад ч итгэхгүй юм. Хуулийн байгууллагаас шалгасан, Их Хурлын аль нэг комиссоос шалгасан шалгалтын дүн, ахиад шалгах тийм комисс заавал гарч байх ёстой болж байна уу, тохиолдол бүр дээр. Энэ "гоомой" гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байна. Зөв л дүгнэлт гарсан байна гэж байна. Нэмж, хасаад үзлээ шүү дээ. Аль ч талаараа энэ хүн сонгогдохгүй байсан байна, сонгууль будлиантай

болсон байна гэдгийг сая Амарсанаа тэргүүтэй хуулийн мэргэжлийн хүмүүс бас дахин дүгнэж үзээд хэлсэн байна шүү дээ. Гурав дахь удаагаа ийм дүгнэлт гарч ирж байна. Энэ гоомой гэдгийг чинь би ойлгохгүй байна. Шалгалт бүхний мөрөөр дахин шалгалт гаргаж байх юмуу?


180 дугаар тойргийн депутат Д. Жумлаанбаатар:

-Энэ асуудалд анх гарах үед надад бодогдож байна. Үнэхээр бид бол хуулийг дээдлэх ёстой, бид үлгэр жишээ үзүүлэх ёстой хурал шүү дээ, энэ маань. Гэтэл одоо ингээд эргэж хургаад тэгээд еерийнхөө байнгын комисстоо итгэхгүй ийм байдал гаргаж байгаад үнэхээр харамсаж байна.

Одоо яах вэ гэхээр, үнэхээр хэрэв будлиантай шалгасан байх юм бол тэр бүх хүмүүс хариуцлага хүлээх хэрэгтэй. Хэрвээ байнгын комисс муу шалгасан байгаад, эсвэл тэрэнд оролцсон прокурорт зөвлөл хүлээлгэх хэрэгтэй. Хэрэв үнэн байх юм бол ингэж одоо босгож ирж байгаа хүмүүст зөвлөл хүлээлгэх. Ингэхгүй нэг үргэлжилсэн, уул шиг юм бол одоо бид нэр хүндээ алдах нь байна гэдгээ бодолцооор байна.

Ж. Уртнасан: -Баярлалаа. Яг үүн дээр бид эмзэглэж байгаа юм. Яагаад гэвэл, бид 1991 оны II дүгээр сарын II-ний едрийн 04 тоот ^{Тогтоол} маань үнэхээр хууль эрхийн ямар ч баталгаагүй, бид Ардын Их Хурлын чуулганаас Их Хурлын депутатын эрхийг түдгэлзүүлдэг тийм хуулийн заалт бидэнд алга. Тийм учраас бид өөрсдөө сууж байгаа хууль зөрчсөн аюултай ийм байдалд орж болохоор байна. Ийм учраас үүнийг бид яаралтай комисс гаргаж шалгуулах нь зүйтэй гэдэг ийм нэгдсэн дүгнэлтэд, хууль зүйн зөвлөхүүд маань ийм дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:

 Ж. НАРАНТУЯА
Бичээч Ө. Оюунчимэг

Булганы орон нутгийн бүлэг энэ депутатуудаас Болд-баатарыг асуудлаар ингэж маргаан гаргаж байна гэж Жаргал хэлж байх шиг байна. Манайхаас хэлээгүй шиг байх юм. Хэлсэн бол энэ Булганы депутатуудаас хэн нь тэгж хэлснийг Жаргал дарга тодруулж өгвөл яасан юм бэ? Ингэж бүхэл бүтэнд нь зэвүүн үг хэлэхийн хэрэг байна уу? үгүй юу?

283 дугаар тойргийн депутат Ш.Шагдарсүрэн: Энэ асуудлыг их их ойлгож ядаад байна. Яагаад вэ гэхээр эхлээд депутатын бүрэн эрхийн комисс дүгнэлтээ гаргаж ирсэн, араас нь шалгаж, хуулийн талаас нь ингээд дүгнэлтээ гаргасан байна гэж би ойлгож байна. Тэгэхээр тэнд, хэний ч тухай байсан, хүний тухай яригдахгүй байгаа юм шиг байна. Сонгууль хүчинтэй болсон уу? үгүй юу гэдэг дээр л ярих ёстой болж байгаа юм. Тэгсэн чинь юу болоод ирж байна вэ гэхээр хоёр газраас дүгнэлт гараад ирэхээр хувьдаа хүрээгүй байна, сонгууль хүчин төгөлдөр бишээ гэсэн ийм юм гарч ирээд байгаа юм. Би ингэж ойлгоод байна. Энэ бол зөвбайх гэж бодож байна. Тэгэхдээ бид нар ингэж үнэхээр л хууль зүйн үндэсгүй тогтоол, II-ний тогтоол бол үнэн байх. гэж бодож байна.

Гэхдээ бид бол депутатыг ард түмнээс сонгосон, эндээсээ бид депутатыг сонгохгүй байх юмсан гэж бодож байна.

191 дүгээр тойргийн депутат Б.Лханаасүрэн: Би товчоон санал хэлье. Бид энэ асуудлыг хэдхэн хоногийнөмнө ярилцаад шийдсэн. Шийдсэн тухай бүх хэвлэл дээр гараад ирсэн, биччихсэн байсан. Хуулийн дагуу аваад үзэхэд энэ сонгууль хүчингүй болсон нь үнэн. Тэгэхдээ яагаад нэг хүний хүсэлтээр, тэр депутатуудынх нь хүсэлтээр энэ асуудлыг дахин дахин авч хэлэлцээд байгааг би ойлгохгүй байна.

Өнөөдөр Ардын Их Хурал хуулийг хүндэтгэдэг, хуулийг дээд эрхмээ болгодог гэж үзэж байгаа юм бол нэгэнт хүчингүй, сонгууль нь хүчингүй болчихсон энэ депутатын бүрэн эрхийг бид хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Тэгэхээр ямар санал оруулж байна вэ гэхээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн өмнө, хоёр хоногийн өмнө гаргасан тогтоолын хүчингүй болгоё. Өнгөрсөн оны 9 сарын 3-нд депутатын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн, энэ сонгуулийн энэ тойрогт явуулсан сонгуулийг хүчингүй болгож тооцох нь зүйтэй. Ингэхгүй бол аль ч талаар нь аваад үзсэн, энэ 12 хүн оролцоогүй нь, өөрийн нь санал өгснөөс хасаад ингэхэд ч хувьдаа хүрэхгүй байна. Нийт оролцсон сонгогчдын тооноос хассан ч гэсэн хувьдаа хүрэхгүй байна. Тэгэхээр одоо хүчинтэй боллоо гэж тооцох ямар ч үндэс алга байна. Хэрэв энэ талаар одоо түдгэлзүүлэх бүрэн эрхийг нь хэвээр хүлээн зөвшөөрөхийм санал хураалгах, санал хураалт явуулах гэж байгаа бол би энэ санал хураалтанд оролцохгүй гэдгээ одоо хэлье. Би энэ гарах шийдвэрийн хариуцлагыг хамт хуваалцахыг хүсэхгүй байна.

Ж.Уртнасан: Тэр таны эрхийн асуудал.

406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш: Би түрүүнд тооны хувь хэлсэн юм. Тэр 12 хуудсыг хүчингүй гээд хасчихад, Цэен-Ойдовын төлөө 742 хүн саналаа өгсөн болж байгаа юм. Нөгөө Болдбаатарын төлөө 732 хүн саналаа өгсөн болж байгаа юм. Зайлшгүй 10 санал илүү байгаа юм. Хоёрдугаарт, депутат Бадарч хэлсэн шүү дээ. Бид өнгөрсөн жилийн сонгуульд, байгаль, цаг уурын бэрхшээлтэй, ийш тийшээ шилжих, янз бүрийн шалтгаантай бол нэг хоногийн байтугай, сарын өмнө дугтуйгаар саналыг нь авч байсан шүү дээ. Тэгэхдээ тэр болдоггүй юмаа гэж үзсэн ч гэсэн 10 саналыг илүү авсан Цэен-Ойдов гуайн хувь яагаад 50,3 хувьд хүрээд байх юм. Үүнийг ямар санаанаас заавал хүрээгүй болгож хувь гаргаад байгааг ойлгохгүй байна.

Ж.Уртнасан: Ер нь депутатуудыг ойлгосон гэж бид ойлголт нэгдэж байгаа юм. Хамгийн гол эмзэглэж байгаа, Лханаасүрэн

депутат сая хэлж байна хэвлэл дээр гарчихсан гэж. Залруулж болно л доо. Хамгийн гол асуудал бол бид өөрсдөө чуулганаараа хуулиа зөрчижчихсэн байгаад эмзэглэж байгаа. Өөрөөр хэлбэл АИХ-ын чуулганаас депутатын эрхийг түдгэлзүүлдэг тийм хууль хаа ч алга. Бид хуулинд байхгүй ийм үйлдэл хийчихсэн байна. Ийм учраас бид хамгийн түрүүн 1991 оны II дүгээр сарын II-ний өдрийн 4 тоот тогтоолыг хүчингүй болгох ийм санал хураалт явуулах хэрэгтэй болох нь ээ. Хоёрдугаарт, зөвлөхүүд бас тайлбарлаж байна аа. Сонгуулийг нийтэд нь хүчингүй болсон гэж үзэхгүй ээ. Сонгууль бол хүчинтэй. Харин орон нутагт комисс явуулна гэдэг маань олонхийн саналыг авч чадах уу үгүй юу гэдэг тал дээр бид дахин шалгалт явуулах юмаа. Тэр санал өгсөн 12 хүнтэй очиж учир байдлыг тодотгоно. Тийм учраас групп гаргая гэдэг дээр л байгаа юм. Ингээд эрхийг түдгэлзүүлнэ гэдэг маань үндсэндээ бид хууль зүйн ямар ч эрх баримтгүйгээр хийчихсэн ийм ажиллагаа болжээ. Ийм учраас бид энэ тогтоолыг яаралтай хүчингүй болгох шаардлага гарч байна. Дараа нь бид комисс томилж шалгуулах асуудлаар ярьж болох юм. Түүнээс биш Жаргал депутатын хэлж байгаагаар бол бид мандатын комисс, байнгын комиссын ажлын юманд эргэлзэж байгаа юм бишээ. Бид бол тодотгол хийх гэж байгаа юм. Учрыг ойлгоно уу. Ингээд түдгэлзүүлсэн ийм томъёолол орж байна, депутатууд анхаарна уу.

БНМАУ-ын АИХ-ын депутатуудын бүрэн эрхийн асуудал эрхэлсэн байнгын комиссын илтгэлийг хэлэлцсэн дунгийн тухай гээд БНМАУ-ын АИХ-ын 1991 оны II дүгээр сарын II-ний өдрийн 4-р тогтоолыг хууль зүйн үндэсгүй гэж хүчингүй болгосугай. Үүнийгээ бид залруулъя. Энэ тогтоолыг хүчингүй болгосон тогтоол гарах гэж байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

-4 дүгээр микрофон. Уртнасан даргаа зөвшөөрөл өгөхгүй юу. Явж явж юугий нь шалгах гэж байгаа юм бэ, тэрнийг хэлээд өгчихгүй юу. 12 хүнтэй уулзаад тэр чинь хүчингүй гээд л хасчихна биз, одоо яах юм бэ. Энэ чинь байнгын комисст, шалгасан комисст итгэхгүй юм шиг ийм үйлдэл хийгээд. Шалгасан гэдгийгээ

Энэбиш хэлсэн шүү дээ. Уулзаад яахав хүчингүй л болъё л доо. Тэгээд юугий нь шалгах юм бэ. Би хувьдаа ийм л санал байна. Аймгийн Ардын хурлын тэргүүлэгчид тэнд байгаа. Их хурлаас үүрэг өгөөд аймгийн дарга Гүндэнбал байж байгаа. Гүндэнбалд үүрэг өгөөд л өөрөөр нь шалгуулчих хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд Их хуралд бид заавал нэг депутатын Их хурлынхаа ажиллагаанд оролцоход нь заавал саад болох зардал гаргаж байх ямар хэрэг байна вэ. Аймгийн ерөнхий прокурор байж байна, аймгийн дарга байж байна. Биечлэн шалга, очоод мэдэгд гэвэл болоо юм биш үү. Заавал эндээс нэг нисдэг тэрэг унаж хүн явуулж байх ямар хэрэг байсан юм бэ.

Уртнасан -Тэгье. Хамгийн хялбар, хамгийн хямд төсөр хувилбарыг бүгдээрээ бодож олъё. Юуны өмнө депутатууд анхаарлаа хандуулна уу. Бид хууль зүйн эрхгүй **гаргасан** энэ тогтоолоо хүчингүй болгох талаар санал хураалт явуулчихъя.

326 дугаар тойргийн депутат Гомбожав -1951 онд сонгууль явагдсанаас хойш бид АИХ-д ч, орон нутгийн хуралд ч олон удаа депутатын эрхийг түдгэлзүүлж шийдвэр гаргаж байсан. Тэр ямар хууль зүйн үндсэн дээр тэгэж гарч байсан юм бэ?

Уртнасан -Депутат Гомбожав гуай бид БНМАУ-ын АИХ-ын депутатуудын сонгуулийн хууль 1990 оны сонгуулийн хуулийг л бариад байгаа. Бусад дээр би хариу өгөх. Энэ хуулинд түдгэлзүүлнэ гэсэн юм алга байна.

Гомбожав -Олон удаа. Энд бол Цэен-Ойдовын тухай ч, Болдбаатарын тухай ч ярьж байгаа юм биш. Уг сонгууль нь хүчингүй болчихсон учраас л, нэгэнт тэнд сонгогчид сонгогдсон хүнийг түдгэлзүүлээд тэд нараар өөрсдөөр нь шийдүүлэх байх гэж бодоод байгаа шүү дээ.

Уртнасан -Тэр хувилбарыг бид бодолцсон. Хэрэв тэгэхэд хүрвэл тойрог сонгогчгүй, депутат бүрэн эрхгүй дахин сонгууль явуулахад хүрнэ. Дахин сонгуулийг хүчингүй гэж үзвэл сарын дотор явуулдаг тэр заалтыг бид бас зөрчөөд, алдчихаад жил болчихоод байгаа юмаа. Үүнийг болгооно уу.

7 дугаар микрофон, 313 дугаар тойргийн депутат Чагнаа - Сонгууль бол хүчинтэй юм байна. Сонгогдсон хүний ч буруу биш, ерөөсөө сонгуулийн комиссын буруу юм байна. Тэрнийг буруугүй гэж үзвэл сонгуулийг дахин хийх шаардлагатай. Сонгуулийн хуулинд байж байгаа. Сонгуулийг дахин хийх шаардлагатай, өөр энд юу ч байхгүй. Хичнээн шалгаад ч сонгууль дахин хийх л гэж гарна. Өөр зүйлгүй. Одоогоор бол тэр сонгогдсон депутат эрх байхгүй, бүрэн эрхгүй. Яагаад гэвэл сонгуулийн хуулинд заасан тоо хэмжээг авч чадаагүй. Тийм учраас дахин шалгалт хийлгүйгээр сонгуулийг дахин хийлгээ гэсэн сонгуулийн комиссын тогтоол гаргуулна аа. Өөр арга байхгүй. Сонгуулийн хуулиндаа байж байгаа. Өөр ямар ч хууль хэрэг байхгүй.

Уртнасан - Депутат Чагнаа энэ сонгуулийн 8 дугаар бүлгийн 40 дүгээрхийг бид түрүүн тогтсон. Энэ дээр 9 дүгээр зүйлийн 3 дугаар заалт дахин сонгуулийн тухай АИХ-ын депутатуудын ээлжит сонгууль болсноос хойш 30 хоногийн хугацаанд явуулна гэдэг ийм заалт бий. Бид жил болчихоод байгаагаараа бас хууль зөрчөөд байна аа. Ийм л маргаантай байгаа юм. Тэгээд та бүхний оюун ухааныг энэ дээр төвлөрүүлж, хамгийн зүй зохистой шийдвэр гаргахад чармайлт хиймээр байна. Одоо юуны өмнө хэрэв та бүхнийг зөвшөөрвөл санал хураалт явуулъя.

101 дүгээр тойргийн депутат Доржбат - Хурлын даргаа, энэ асуудал чинь 30 хоногийн дараа биш бүтэн жилийн дараа илэрлээ шүү дээ. Тэр асуудал чинь 30 хоногийн дараа илэрсэн юм биш. Бүхэл бүтэн жил болсны дараа илэрсэн учраас дахин сонгууль явуулах, илэрсэн өдрөөсөө хойш л 30 хоног байгаа шүү дээ. Дахин сонгууль явуулж болох үндэстэй гэж үзэж байна.

383 дугаар тойргийн депутат Гунджалам - Томьёололд би эргэлзэж байна. Ер нь Үндсэн хуулийн нэмэлтийн хуульд заачихсан байгаа шүү дээ бидний эрхийг, их хурлын эрхийг. АИХ өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар ямар ч асуудлыг авч үзэх эрхтэй шүү дээ. Хууль зүйн үндэсгүй шийдвэр гэдэг бол энэ бол болмооргүй санагдаад байна. Хуулинд заавал заачихсан гээд

заагаагүй гээд бид нар шийдвэр гаргаж болохгүй гэсэн юм байхгүй шүү дээ. Бид нар шийдчихвэл тэр бол шийдвэр. Тэгэхээр өөрөө өөрснийхөө эрхийг бас эргэж хармаар байна, ойлгомсоор байна. Өөрсөндөө эрх өгөхгүй, эрх байсаар байтал эрхээ эдлэхгүй, хууль зүйд тэгэж заагаагүй гээд шийдвэрээ эргээд нуцлаад байх нь болмооргүй юм шиг санагдаж байна. Хоёрдугаарт энэ дэгэнд заачихсан байгаа шүү дээ. Дэгэнд заагаад баталчихсан. Энд бол бүрэн эрхийг нь хүчингүйд тооцсон тогтоол гаргаж болно гэж заачихсан байгаа шүү дээ.

Уртнасан - Гүнджалам депутатын санал яг бидний санал хураалт явуулахад шийдэгдэх асуудал л даа. Бид хүчингүй болгох уу үгүй юу гэдэг мэдээж хэрэг энэ шийдээд гараад ирнэ. Санал хураалтанд нилээд жигдэрлээ гэж бодож байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү. Томьёоллыг дахиж хэлж өгье. БНМАУ-ын АИХ-ын 1991 оны II дүгээр сарын II-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай. Үүний эсрэг утга нь Гүнджаламын хүсэлт биелэгдэнэ. Дахин хэлье. БНМАУ-ын АИХ-ын 1991 оны II дүгээр сарын II-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгох тухай гэсэн томьёоллоор санал хураалт явуулж байна.

-За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 58 хувь нь буюу 229 хүн хууль зүйн үндэсгүй гарсан гэж үзэж тогтоолыг хүчингүй болгох санал ирүүлээ. 97 хүн татгалзаж, 68 хүн түдгэлзсэн байна. Ингээд бид тогтоолыг хүчингүй болголоо. Харин депутатын байнгын комисс прокурор бид нийлж хуулийн зөвлөхүүдтэйгээ нийлж дараагийн асуудлыг яаж шийдсэн талаар та бүхэнд мэдээлэл өгье. Ингээд хуралдаанаа үргэлжлүүлье.

293 дугаар тойргийн депутат Бадарч - Түрүүн бид нар хороо байгуулсан. Энэ хороо маань даргатай байж таарна. Дэгд энэ талаар юм ороогүй. Бид нар хуралдаад даргаа сонгох уу, бид сонгох уу гэдэг байхгүй байгаа. Тийм учраас бид сонгоё даргыг нь. Даргыг сонгох сонгохдоо Гомбожав даргыг сонгоё гэсэн санал оруулж байна. Санал хураалт явуулж өгөхгүй юу.

Ж.Уртнасан -Эрхэм депутатууд аа.Депутат Бадарчийн саналын талаар санал хураалт явуулах уу?


Депутатууд -Хэрэггүй ээ.

Ж.Уртнасан -Хороо даргаа өөрөө шийдэх үү.

Депутатууд -Тэгье.

Ж.Уртнасан -За баярлалаа.Ил тод цаг хэмнээд ярьчихлаа. Хороо дотроо өөрөө даргаа шийдээд та бицэнд мэдэгдье.Энд бид оролцохоо больё.Одоо дэгийнхээ дагуу нээлттэй брхисон хоёр асуудлыг чадан ядан шийдвэрлэж байна.

СОРОНЗОН ХАЛБСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



/Д.БАЯНДУҮРЭН/

Бичээч Д.Энэбиш

Ж.Уртнасан -За одоо бид дэгийнхээ дагуу хороотой болчихлоо.Та бидний хэлсэн ярьсан энэ юмнууд. Одоо бид чөлөөт хэлэлцүүлэгтээ орох гэж байна.Энэ дэгийн дагуу ерөнхий санал солилцох энэ хэсэг.Та бүгдэд энийг их шуурхай, түргэн болгохын тулд нэг хүсэлт байна.Босож уг хэлж байгаа депутатууд өөрийнхөө томъёоллыг тун тодорхой бичээд тэр томъёоллоо шууд ажлын группт өгчихөж баймаар байна.Тэгвэл бид санал хураалт явуулсны дараа томъёоллуудыг бид авмаар байна.

Энд бид ийм зүйлийг л бид анхаарах ёстой шүү дээ.Ерөнхий санал солилцохдоо төслийн зүйл ангийг өөрчлөх зарчмын саналаа бичгээр бүрэн томъёолж, хуралдааны даргад өгөх буюу, уншиж сонсгоно.Томъёоллоо уншиж сонсгоно, тэгээд санал хураана шүү дээ.Харин найруулгын чанартай засварыг еөрт нь тараасан эх дээр тэмдэглэж, ажлын хэсэгт өгч болно.Тэгээд зарчмын шинжтэй асуудлууд гэдэг бол хэлэлцэж байгаа нэг асуудал бүрийг л бид зарчмын шинжтэй асуудал гэж үзэж байгаа гэдэг дээр ойлголт нэг гэж үзэж байна.За ингээд санал хураалт явуулна.

Б.Чимид /396 дугаар тойргийн депутат/ -Энэ комиссоо байгуулсан тогтоолоо гаргамаар байна.

Ж.Уртнасан -Тогтоолын төсөл бид бэлтгэж байна, одоо уншиж та бүхэнд сонсгоно.

Б.Чимид -Тэгээд тэр хорооны тогтоол, тэр хорооны чинь эрх үүргийг зааж өгмөөр байна.Энэ бол ерөөсөө, уучлаарай, жирийн нэг хурал биш шүү дээ.Энийг бид хэлэх нэг хэцүү, байх нэг хэцүү байна.Хороо үүрэгтэй.Энэ бол Бага Хурлын оруулсан төсөл байгаа.Тэгэхлээр хороо ингээд Бага Хурлын төслөөс Бага Хурлаас гадуур авч явахгүй байх гэж би найдаж байна.Ер нь хууль тогтоох байгууллагаас оруулсан төсөл.Тэгэхээр хороо бол хорооны өмнө, өөрөөр хэлбэл, Их Хурлын чуул-

2.

ганыг төлөөлж байгаа хорооны өмнө Бага Хурал тэр төслөө хариуцах ёстой болж ирж байна, одоо. Энэ бол зөв. Тэгэхдээ, энэ төсөл дээр депутатуудын саналаас гадуур бусад саналууд орж ирвэл яах вэ гэдэг их ээдрээтэй асуудал болж ирнэ. Би бол саналаа тулгах үүднээс ярьж байгаа биш, бүр задраад хачин юм болох вий гэсэн үүднээс хэлж байна. Ний нуугүй ярья. Тэгэхээр задрах асуудал гарч ирвэл, нэгэнт чуулганаар хэллцээд өргөн мэдүүлсэн Бага Хурал, нэгэнт чуулганаас зөвшөөрөл аваад илтгэсэн Ерөнхийлөгчийн саналыг сонсож байх тухай энд оруулбал депутатууд зөвшөөрөх үү үгүй юу. Ийм асуудлуудаа тогтоод авъя. Энэ бол хууль зүйн үйлдэл.

Би нэг сонин жишээ хэлье. 1924 онд Үндсэн хууль баталсан протокол надад номонд байна. Цэрэндорж гуай нэг үг хэлэлцүүлсэн байгаа юм. Сүлд, тэмдэг гэж. Тэмдгийг нь хасахаар тогтов гээд протоколд биччихсэн байгаа юм. Гэтэл Үндсэн хуульдаа сүлд, тэмдэг гээд биччихсэн байгаа юм. Энэ чинь ийм гээд комиссын хариуцлага ингээд гараад ирсэн байхгүй юу. Их Хурлын шийдвэр нэг өөр, хууль нэг өөр. Ийм учраас бол энэнээс санаа авч маш нарийлах ёстой, нэгдүгээрт.

Бас нэгэнт боссоных, Энэ Үндсэн хуулийн эхийг барих нэг хүн байх ёстой шүү. Тэр хүний бүх л толгой, чих юу байдаг юм тэрүүгээр бүх үг цувж гарсан байх ёстой. Ийм л юм байна. Жинхэнэ эх, ганц эх. Янз бүрийн газраас оруулаад ирсэн, янз бүрийн юмыг цохиод бичээчээс ингэж авахгүй. Жинхэнэ хорооноос оруулсан эхийг, албан ёсны эхийг оруулж ирэх ёстой. Бид бол жинхэнэ эхээ Уртнасан даргад өгчихсэн байгаа. Тэгээд батлаад гаргасны хамгийн сүүлд эртээд би нөгөө чөлөө аваад явсан. Тэр хойгуур Ерөнхийлөгч зурах эсэх тухай ярьсан юм байна билээ. Тэгэхээр тэр бол нөгөө хуулийн дор үсэг зурдаг шиг асуудал биш. Харин тэр эх гэдэг нь мөн гэдгийг бичдэг манай Үндсэн хууль баталж ирсэн хуучин практик бий. Тэр бол толгой дээр нь зурдаг. Энэ бол Их Хурлаас баталсан үг мөн. Бусад зарим оронд төчнөөн үг, төчнөөн өгүүлбэр, төчнөөн

таслалтай гэж баталдаг юм. Ийм нарийн юмнуудыг бол бас зөвлөх гэдэг юм уу, мэдээлэх журмаар хэлмээр байна.

Ж. Уртнасан -Баярлалаа. Зарчмын ач холбогдолтой чухал санал байна. Үүнийг бид энэ тогтоолын төсөлдөө тусгая.

Л. Одончимэд /157 дугаар тойргийн депутат/ -Уртнасан даргаа тэгэхээр бид нар чинь ингэж ойлгож байгаа шүү дээ. Сая бол та чухал хоёр гурван асуудал шийдүүлчих шиг боллоо. Тэгэхээр хороо томиллоо. Хорооныхоо тогтоолд, би бол Чимид гуайн санааг дэмжиж байна. Энэ бол хариуцлагатай, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, та одоо нөгөө юун дээр ерөнхий санал явагдах ёстой. Одоо энэ Бага Хурал хэр ажилласан юм, яаж ажилласан юм. Одоо ард түмний санал онол гээд өчигдрөөс хойш олон юм ярилаа шүү дээ. Энийгээ бид ярих ёстой болохоос биш, одоо нэгийн нэгд тэгж заажээ, энийг ингэж өөрчилье гэдгийг ярих цаг арай болоогүй байх гэж бодож байна. Ийм учраас Уртнасан дарга та одоо ерөнхий санал хэлэлцүүлж өгнө үү гэсэн ийм хүсэлттэй байна.

Ж. Уртнасан -Баярлалаа. Би яг тэрийг хэлэх гэж байсан юм. Баярлалаа депутатуудаа.

За одоо дэгийнхээ дагуу ерөнхий санал солилцох ажилдаа орёе. Бидэнд бас завсарлахад даруй 7 минут дутуу байна. За микрофонн дарааллаар нэгээсээ эхлээд ингээд явдаг зарчмаараа явъя. За ерөнхий санал солилцох асуудлыг замбараатай болгохын тулд өчигдөр зарим депутатууд ер нь санал солилцох хүн энэ индрийг ашиглаж ярих нь зүйтэй. Бид тэртээ тэргүй цувж ярих юм гэсэн ийм санал гаргасан. Ийм учраас хэрэв депутатууд зөвшөөрвөл ерөнхий санал солилцох хүн шууд энэн дээрээс ч ярьж болох юм шүү.

Ц. Адъяасүрэн /55 дугаар тойргийн депутат/ -Ерөнхий са-

нал шүүмжлэлээ нэгэнт тэр индэр дээр ярихын тулд бид нар техник хэрэгслээ ашиглаад энэ гартаа байгаа юунхаа санал гэдэг дээр дараад тэрнийхээ дэс дараалал та нарын урд гарна шүү дээ. Тэр дэс дарааллаар нь та дуудаад тэрэн дээр ярьж, санал шүүмжлэл явуулъя.

Ж.Уртнасан –Маш зүйтэй.Бид энэн дээр техник хэрэгслээ ашиглая.Тэгэхээр уг хэлэх хүмүүс санал гэсэн нэрээ өөрсдөө дарна уу.Тэгэхээр тэнд компьютерт бичигдчихнэ.Тэр нэрийг би эндээс барьж аваад дэс дараалан уншаад уншаад сонгоод байя. Энэн дээр санал тогтох уу? За баярлалаа.Одоо дахин нэг давтаж хэлье.Уг хэлэх, санал солилцох хүсэлтэй депутатууд өөрийнхөө санал гэсэн товчоо дарна уу.

Д.Дагвадорж /218 дугаар тойргийн депутат/ –Энэ хүмүүс чинь бүгдээрээ зэрэг дарчихвал та яаж дарааллыг нь олох юм бэ?

Ж.Уртнасан –Энэ цахим техник бид нарт дараалалтай бичиж өгөх байх.Арай ч бүгдийг нь зэрэгцүүлээд биччихгүй байх. Тэр дарааллыг барья.

С.Чулуунбаатар /132 дугаар тойргийн депутат/ –Тэгэхээр энэ ингэх байхаа.Би зүгээр сайн мэдэхгүй байна.Энэ компьютерт нэрээ бичүүлнэ гэхээр зэрэг энэ программ нэгээс эхлээд 427 хүртэл тогтсон дугаартай байгаа байх.Тийм болох учраас нэгдүгээрт тэр л дугаараараа энэ улсуудын нэр гарна.

Хоёрдугаарт ирц буюу санал гэсэн дээрээ бүгдээрээ дарчих байхаа.Тэгэхээр зэрэг 427-уулаа ерөнхий санал шүүмжлэлд оролцоно гэвэл энэ ерөөсөө бүтэхгүй юм болно.Тэгэхээр зүгээр танд нэрээ өгвөл ясан юм бэ дээ.Энэ компьютерийг би ашиглах, энэ удаа ерөнхий санал шүүмжлэлд оролцох хүмүүсийн нэрийг тогтооход компьютерээр гэдгийг би нэг л жаахан эргэлзэж байна шүү.Энийг болгоогоорой.

5.

Ж.Уртнасан –Уучлаарай, Дашбалбар депутатаа.Нэг тайлбар хэлье.Бид бас энэ хооронд техникийн хэсгийнхэнтэй зөвлөлөө. Энэ хэн эхлэж дарна, тэрний дарааллаар гарна.Тойргийн дарааллаар гарахгүй шүү гэж байна.Тийм учраас санал гаргахад товчоо дарья, нэгдүгээрт энэн дээр тогтоё.

Хоёрдугаарт тэр бичсэн улсууд чинь бүгд санал хэлэхгүй гэдэгт би бат итгэж байна.Яагаад вэ гэвэл санал давхардвал зайлшгүй босох хэрэггүй болчихно шүү дээ.Тийм учраас санал гэдэг товчлуураа дараад нэрээ бичүүлье.Компьютер хэн өхлөж дарсан тэр дарааллаар биччихнэ.

Танхимаас : –Уртнасан
даргаа надад нэг санал байна.Тэгэхээр энэ бол би депутатуудад нэг юмыг хэлээд байгаа.Аливаа операцид давтахаа больё гэж.Бид саналаа хэлэх, уг хэлэхдээ бүгд энэ бэлтгэсэн микрофонууд дээрээс уг хэлээд байгаа хэр нь, яагаад ерөнхий санал ярих болохоор заавал энэ журмаар, энэ чинь бидний хэлж байгаа уг ямарваа нэгэн юманд бас хаалт болоод байна.Тийм учраас бид жагсаад энэ микрофоныхоо араас дарааллаараа хэлэх юмаа хуучин журмаараа явъя.

М.Мөнхбат /146 дугаар тойргийн депутат/ –Би саяын депутатын саналтай санал нэг байна.Бид анхдугаар хуралдаанаар мөн энэ арга барилаар яриад сурчихсан.Одоо бид энэ микрофон микрофон дээрээ зогсоод ингээд дэс дарааллаа олоод энэн дээр өөрсдийнхөө саналыг хэлэх нь үнэхээр ач холбогдолтой. Заавал тэндээс нэрээ дуудуулж, заавал тэр индэр дээр гарсан, хэлсэн уг бол их ач холбогдол өгнө гэсэн ийм утгаар биш, бид энэ микрофоныг ач холбогдолтой ашиглах хэрэгтэй. Эндээсээ л ярих нь зүйтэй.Зарим нь бичгээр ч өгдөг шүү дээ. Энийг анхаарч үзээчээ гэж санал гаргаж байна.

Ж.Уртнасан –За баярлалаа.Депутатуудаа санал хураалт явуулъя.Уучлаарай депутатуудаа түр сууна уу.Бас 3 минут

байна. Амжуулъя. Ийм л санал ирж байна шүү дээ. Депутатуудын нэг хэсэг нь бол нэрээ компьютерт бичүүлчихээд тэрүүгээрээ босоод байя гэж, нэг хэсэг нь микрофонхоо дарааллаар явъя гэж байна. Тэгэхээр хажуугийн саналыг санал хураалгая. Тэгээд шийдчихье.

Микрофоны дарааллаар явуулна гэдгээр санал хураалт явуулахад бэлтгэнэ үү.

За завсарлага 20 минут.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Мурза

ЭНХТҮЯА

Бичээч Уранчимэг

Ж.Уртнасан -За эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая.Хурлаа үргэлжлүүлье.Эрхэм депутат Пүрэвдагвад асуулт байгаа юм уу?

Х.Пүрэвдагва /63 дугаар тойргийн депутат/ -Ардын Их Хурлын даргаас нэг асуух зүйл байна.Энэ бол цаашдаа бидний үйл ажиллагаанд хэрэгтэй юм.Дэгийг хэлэлцэж байхдаа Ардын Их Хурлын депутатын бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай асуудал хэлэлцэж баталсан.Гэтэл батлагдаад бид нарын гар дээр хэвлэгдээд гараад ирсэн хүчин төгөлдөр болсон дэгэнд 7 дугаар зүйлийн хамгийн сүүлийн өгүүлбэр, харин аль нэг депутатын бүрэн эрхийг зөвшөөрөхөд ноцтой харшилсан асуудал гарвал түүнийг шалган тогтоох шаардлагатай гэж үзвэл уул депутатын бүрэн эрхийг түр зогсоосон тухай тогтоол гаргана гээд гараад иржээ.Тэгэхээр энэн дээр би, ер нь Ардын Их Хурлаас гарч байгаа баримт бичиг болгон хуулийн нэр томъёоны хувьд үндэслэлтэй тогтсон, уг болгон цаанаа агуулгатай байх ёстой гэж бодож байна.

Ийм учраас энэ түдгэлзүүлсэн гэдгийг яагаад хэвлээд гараад ирэхдээ энэ хуулийн улсууд юм уу, ажлын хэсэг энэний эрхийг түр зогсоох гэдгээр солив? Энэ хоёрын хооронд ямар ялгаа байна вэ? Ялгаатай байна уу? Ялгаагүй байна уу? Миний хувьд бол энийг хуульчдаас асууж байна.Энэ бол том ялгаатай асуудал.Тэгээд ийм ийм байдлаар энэ гарч байгаа, Их Хурлаас гарч байгаа баримт бичгийн редакцид иймэрхүү байдлаар хандвал сүүлдээ бид нарын үйл ажиллагаа, хэлэлцэж байгаа юманд маргаантай зүйлүүд, бантан болно гэдэг юмнууд нэлээн гарах нь ээ.Энэн дээр анхаарвал яана вэ? Энэн дээр хариу өгөхгүй юу?

Ж.Уртнасан -Ойлголоо хуулийн зөвлөхүүд хариу өгөх байх.

За хуралдаанаа үргэлжлүүлье. Тэгэхээр бидэнд нэг хүндрэлтэй юм байх шиг байна. Санал хураалт явуулж шийдэхгүй бол болохгүй юм гэдгийг бид мэдэрч байна. Тэгэхээр нэгдүгээр микрофон дээр уг хэлэх хүмүүс гээд хоёр ийм бичиг ирүүлсэн байна. Нэгдүгээр микрофон дээр, энэн дотор нэгэнд нь 18 хүн, нэгэнд нь 13 хүнтэй, тэгэхдээ эхлээд хоёр хүний дараагаас эхлээд зөрөөд эхэллээ. Маргалдаан гарах нь. Жишээ нь нэгэнд нь Лхагвасүрэн, Очирбат, Халзанхүү, Төмөрбаатар... гээд эхэлсэн байх юм. Гэтэл нөгөөдөхөд нь Лхагвасүрэн, Очирбат, Сүрэнжав, Лхагвасүрэн, Халзанхүү, Гантөмөр... гээд ингээд дараалал дотроо өөрчлөгдлөө. Энийг нь барьж зарлах юм уу, энийг нь барьж зарлах юм уу гэдэг надад их төвөгтэй болж байна.

Ц. Давааням / 350-р тойргийн депутат / - Даргаа нэгдүгээр микрофон 18 хүнтэй нь хүчинтэй шүү. Тэр нь сүүлчийнх, хүчинтэй нь тэр шүү.

Ж. Уртнасан - Хүчинтэй нь сүүлчийх үү. За. Тэгэхээр энэ байдал их төвөгтэй болгож мэдэхээр байна. Би санал хураалт явуулахыг хүсч байна, зарчмын. Нэгдүгээрт нь энэ ихэнх хүмүүс микрофоны дарааллаар уг хэлье гээд байгаа. Хажуугийн санал. Микрофоноор уг хэлье гэдэг нэг санал байна. Компьютерт нэрээ бичүүлчихээд шууд энэ нэрээрээ дуудаад дуудаад ингээд тэр уг хэллээ, тэр бэлтгэж байгаарай гээд хуралдааны хуучин уламжлалт зарчим юм даа. Хуучинсаг гэхгүй байх. Ер нь зүгээр дэс дарааллаараа, за одоо Уртнасан уг хэллээ, дараа нь Батхүү, дараа нь Дамдин бэлтгэж байгаарай гэдгээ хэлбэл их зарчимтэй та бүгдийн хөл өвдөхгүй амар сууж байгаад яримаар байх юм. Энэ долоон микрофоны ард далан хүн зогсчихоор хэдэн цагийн дараа угээ хэлнэ гэж бодож зогсох билээ бидэнд их ядаргаатай байх болов уу гэж бодох юм. Би нөлөөлөх гэж оролдож байгаа юм биш.

Тэгэхээр хоёр санал хураалт явуулъя. Хоёр хувилбараар. Нэгдүгээрт...

/ танхимаас/

-Энэн дээр

яг өөр санал, яг иймэрхүү маягаар энийг ингэж хийж болно. Микрофоны өгсөн дарааллаар нь та тэндээс найруулаад дуудчихаж болно шүү дээ. Тэгээд дуудчихвал яадаг юм бэ?

Ж. Уртнасан -Уучлаарай, би хоёр санал хураалт явуулъя. гэдэг санал оруулж байна. Нэгдүгээрт микрофоны дарааллаар уг хэлбэ гэдэг нэг ийм хувилбар байна.

Хоёрдугаарт, компьютерт нэрээ бичүүлчихээд босож үгээ хэлбэ гэдэг ийм хоёр хувилбар байна. Эхлээд санал хураалтанд бэлтгэнэ үү. Микрофоны дарааллаар уг хэлбэ гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна. 253 хүн буюу 64 хувийн саналаар энэ микрофоны дарааллаар явах юм шиг байна. 135 хүн татгалзаж байна. За дэгийн дагуу цөөнхийн саналыг нэг сонсьё. Цөөнх саналаа хэлдэг дэг бий шүү дээ бидэнд.

М. Энхсайхан /45 дугаар тойргийн депутат/ -Хурлыг замбараатай явуулах үүднээс энэ асуудлыг би цөөнх болж ярьж гэсэн юм. Бид хэрэв микрофоноор ингээд дараалал бичнэ гэдэг юм уу, эсвэл микрофон дээр уралдана гэх юм бол их тэнцвэргүй байдал бий болгох нь. Микрофонд ойрхон байгаа улсууд их амархан явах гээд байна. Хэн микрофоныг бичиж байх вэ гэдэг асуудал хүртэл маргаантай. Тийм учраас, яагаад компьютерийг ярьж байгаа юм гэхээр. Компьютерт бидний хийсэн санал гэсэн дарааллыг компьютер өөрөө бол автоматаар бүгдийг нь дараад өөрсдийг нь хутгаж байгаа. Тэгээд хэн нь ч хамаагүй жагсаалтад оруулаад тэгээд захаас нь хэлээд явах нь илүү журамтай байна шүү дээ.

Тэгэхгүй бол бид бүгдээрээ микрофоны ард гараад, дараачийн зүйл анги дээр би түрүүнд нь уг хэлмээр байна гэвэл би одоо хоёр, гурван цагийн өмнө гараад энд нь зогсож байх хэрэгтэй болох нь байна шүү дээ. Тийм учраас ингэж явах юм бол туйлын замбараагүй байдалд хүрэх байх гэсэн ийм бодолтой байна. Тийм учраас компьютерээр хураагаад, компьютер бол хам-

гийн шударга, хэнийг ч урьд нь өмнө нь шилэхгүй. Өөрөө. Тийм учраас тэр байдлаар явбал ясан юм бэ гэсэн санал байна.

Т.Очирхүү /17 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр ерөнхий санал шүүмжлэлд орох асуудлаа ярьж байна л даа. Энэ бол дэгийн дагуу явж байгаа гэж би ойлгож байна. Гэхдээ дэгийн зарим зүйлийг бид өөрсдөө зохицуулж явах эрхтэй байх гэж бодож байна. Тэгэхээр Бага Хурал дээр ямарваа асуудлыг хэлэлцэхэд нэг ийм зүйл байдаг юм. Эрүүгийн хуулийн төслийг бэлтгэхийн тулд тэрний үзэл баримтлалыг бэлтгэх чиглэлийг Бага Хурлаас өгөх гэж эхлэж Ерөнхий санал шүүмжлэл явуулдаг. Тэгээд зарчмын гол асуудлууд дээр тогтчихвол түүнийг баримтлаад хуулийнхаа тодорхой төслийг боловсруулж ирэх үүрэг өгдөг. Энэ бол илүү амар байдаг.

Гэтэл өнөөдөр Үндсэн хуулийн төсөл бол улсын Ерөнхийлөгч уншиж танилцуулаад, Бага Хурлаас өргөн бариад, Улсын Их Хурал тэрнийг хүлээж авчихаад байгаа. Өнөөдөр ерөнхий санал шүүмжлэл хийгээд, энэ төслийг зүйл зүйлээр нь юм уу, тодорхой асуудлуудаар нь ярихад тэрэн дээр санал хураагаад, дараа нь төслөө нөгөө саяхан байгуулсан хороондоо эргэж задлаж бэлтгэхээр ингэж хийх гэж байна уу? Тэгэх юм бол энэ бүтэхгүй ажил болж цаг алдах нь ээ.

Үүн дор бол бүлэг, зүйл дээр маш тодорхой санал шүүмжлэлийг харилцан хоёр тал өөр өөр санал бодолтой яваад байвал системтэй явагдах юм биш үү гэсэн ийм бодол байна. Цаг хайран байна. Ерөнхий санал шүүмжлэлээр ерөнхий концепцийн шинжтэй асуудал тодроод тэгээд дахиж төсөл дээрээ суудаг шүү дээ. Түүнээс биш нэгэнтээ зүйл, заалттай, бүлэгтэй, нэг бүхэл бүтэн цогцолбор болоод орж ирсэн юмыг эргэж задлахгүй л гэж байгаа бол энэ бас нэг үр ашиг муутай гэж бодож байна.

Тийм учраас шууд санал шүүмжлэлдээ ороод бүлэг дээрээ маш тодорхой яриад явбал бид илүү үр дүнтэй гэж бодож байна.

Жишээлбэл, парламентын болон Ерөнхийлөгчийн засаглалын юм уу, засаг хуваарилалтын асуудал гарах байх, зарчмын юм. Тэрнийг тухайн бүлэг дээр өнөөдөр ерөнхий шүүмжлэл ярих гэж байгаа улсууд яривал илүү дээр.

Засгийн газрын юм уу, Бага Хурлын тайланг авбал ерөнхий шүүмжлэл бас өөр. Улс орны ерөнхий байдлын зураглалыг өөрийн нутаг дэвсгэр, сонгогчдын хэлсэн захиснаар ярьж болно. Энэ бол тодорхой хуулин дээр зүйл ангиар ярих гэж байгаа шүү гэдгийг бас бодолцож үзэхгүй юу гэсэн санал байна.

Ардын Их Хурлын даргаас миний энэ саналыг депутатуудад санал хураалгаж өгөөч гэсэн хүсэлт байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Мийланз

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.15
3 Кассет 58
II.36-II.50

Ж.Уртнасан: Энэ чинь^{дэгээ}+зөрчих л саналбайна шүү дээ.Ерөнхий санал солилцоно гэж биччихээд, зүйл бүрээрээ эхлээд ярьж гэвэл дэгээ зөрчинө л гэсэн үг шүү дээ.

17 дугаар тойргийн депутат, Улсын Бага Хурлын гишүүн Т.Очирхүү:

Энэ бол дэгээ зөрчөөгүй.Дэгэнд эхний удаа ерөнхий санал шүүмжлэлээс гадна бүлэг, зүйл болгоноор ерөнхий саналшүүмжлэл хийж болно гэж байгаа шүү дээ.Тэгэх юм бол байгуулагдсан хороонд ч амар, бидний цаганд ч хэмнэлттэй, асуудал маань системтэй тавигдана.

Ж.Уртнасан: Бүлэг, зүйл тус бүр дэс дарааллаараа, тэр зөрчигдөхгүй.Бүлэг тус бүр дээрээ л...Ерөнхий санал шүүмжлэлээ, тэгээд л тогтоод явъя.

334-р тойргийн депутат Л.Батсүх:

Түрүүний Энхсайханы саналыг нэгдүгээрт дэмжиж байна.Компьютраар энэ саналыг авах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, нэг гомдол мэдүүлэхэд, түрүүн ч депутатууд яриад байсан.Энэ голд суусан улсууд хэлмэгдээд байна.Ерөөсөө үг хэлэх ч эрх алга, нэгдүгээрт.

Хоёрдугаарт ийшээ гараад явна, хувцсанд хүртэл хамгийн сүүлд оочерлож гарах юм, үүнийг анхаарч үзээч ээ.Их хэцүү байна.

Ж.Уртнасан: Бид цөөнхөө хүндэтгэж олонхийн саналаар шийддэг.Бид энэ цөөнхийн саналыг хүндэтгэж санал хураалт явуулъя.

Бид 64 хувиар микрофоны жагсаалт гарчихаад байна. Энэ бол надад амар л юм. Нэг, хоёр, гурав гэж тоолоод л дээрээс нь нэрийг нь тойргийн дугаартай дуудаад байж болж л байна. Тэгэхдээ бид цөөнхийг хүндэтгээд нэг санал хураалт явуулаад үзэе. Компьютер, цахим техникээ ашиглана. Компьютерт нэрээ өгөөд тэр дарааллаараа нэр хэлнэ, уг хэлнэ гэсэн санал хураалт явуулж байна. Цахим техникийг ашиглая. Санал хураалтанд бэлтгээрэй.

Ж. Уртнасан: уучлаарай, та бүгдийн саналыг хүндэтгэж санал хураалт явууллаа. 64 хувьд хүрэхгүй байна. 194 хүн буюу 52 хүн цахим техник ашиглая гэж байна. 64 хувь нь микрофоны ард зогсож үгээ хэлье гэсэн учраас өнөөдөртөө бид энэ зарчмаа баримтлая.

23-р тойргийн депутат Ц. Энхбат:

Сүүлчийнхээ санал хураалтаар явахгүй юм уу. Сүүлчийн санал хураалт, цөөнхийн саналыг сонсоод, ер нь зүйтэй юм байнагээд 52 хувийн саналаараа өгчихлөө шүү дээ. Одоо энэ компьютерээрээ явах нь зүйтэй байх гэж бодож байна.

31-р тойргийн депутат Д. Дожоодорж:

Тэгэхээр би анхнаасаа энэ очирхүүгийн саналыг дэмжсэн. Энэ чинь ерөнхий хэлэлцүүлэг болно гээд, хүн бүхэн 7 минут ч юм уу, 10 минут ярих юм бол энэ чинь замаа алдах нь. Зөвхөн түүний Цэен-Ойдов дээр энэ лав 150-иад мянган төгрөг үрчих шиг байна. Зөвхөн ийм юман дээр. Ингэж улсын хөрөнгийг үрж байх хэрэг байна уу? үгүй юу? Тэгэхээр би юу хэлэх гэж байна вэ гэвэл ерөөсөө очирхүүгийн хэлдгээр, зүйл зүйлээрээ эхэлж хэлэлцье. Улсынхаа нэрээс эхлээд ярих хэрэгтэй. Энэ чинь ерөнхийдөө бүгд орно. Цаашаа бүгд задарч орно. Тэгэхээр үгүй бол нэг хүн хоёр дахин ярих болж байна. Нэг Ерөнхий гэж 10 минут ярьчихаад, дараа нь мөн үүнийгээ задалж ярих болж байна. Ийм хэрэг ердөө хэрэгцээ байхгүй.

Энэ бол ингэж ярих юм бол 430 депутат ингэж ярих юм бол лав 10 өдөр үүнийг ярих гэж байна. 8 цагаар ажиллах юм бол 10 юм уу 9 өдөр энэ ерөнхий зүйлээ яриад өвөлжих нь байна шүү дээ.

185 дугаар тойргийн депутат „Улсын Бага Хурлын гишүүн Л.Жанцан:

Тэгэхээр сая хэлж байна л даа. Бүлэг тус бүр дээр ерөнхий санал шүүмжлэл гаргаад явах бол 5 бүлэг дээр гэхэд нэг хүн 5 удаа босч Ерөнхий санал шүүмжлэл гаргана. Энэ ёстой их цаг иднэ. Тийм учраас ерөөсөө нэг хүн ерөнхий санал шүүмжлэлээр 5 бүлэг дээр бүгд дээр нь хэлээд явах юм бол цаг хэмнэнэ л дээ. Үүнийг ингэж ойлгомоор байна.

Хоёрдугаар асуудал, түргүн энэ нэрсээ өгчихсөн, депутатууд. 64 хувийн санал аваад энэ микрофоны дарааллаар үг хэлнэ гэсэн. Энэ нэрсийн дарааллаар үг хэлүүлэхийг дарга тэндээсээ удирдаад ажилдаа ормоор байна. Тэгэхгүй ингээд зарим нь компьютерээр өгнө гээд компьютер бол замбараагүй. Бага Хурлын танхимд байгаа 50 хэдэн компьютер бол замбараагүй байдаг юм чинь энэ 400 хэдэн компьютер бол замбараагүй болно. Тийм учраас үүнийг заавал энэ дарааллаар, нэрсийн дарааллаар зориуд авмаар байна.

425-р тойргийн депутат Н.Ганзориг:

Депутат нөхөр Энхбатнн саналыг дэмжиж байна. Энэ чинь урьд нь 64 хувь гэж өгснийгөө 52 хувь гэж бид дахин засч байгаа учраас урьд 64-тэйгээ 52-нгоо харьцуулаад (ө энэ биш юмаа гэж жуучнаараа тогтох бол буруу юм. Ерөнхий санал юм бол ерөнхий л байх хэрэгтэй. Зүйл бүрээр нь ярьж байх хэрэггүй байх.

14р тойргийн депутат С.Лхагвасүрэн:

Би Энхсайхан депутатын хэлсэн үгтэй санал нийлэхгүй байна. Микрофоноор бид урьд нь яаж байна вэ гэхээр нэрсийнхээ

жагсаалтыг өгчихсэн. Энэ будилаантуулна гээд байна. Компьютерээр өгнө гэдэг энэ асуудал бол үнэндээ би компьютерт нэгдүгээрт итгэхгүй байна, хоёрдугаарт яаж байна вэ гэхээр энэ үндэслэл биш, үүний цаана өөр шалтгаан байна гэж би бодож байна.

Би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр өнөөдөр яаж байна вэ гэхээр улс төрийн тэмцэл гэдэг бол Засгийн эрхийн төлөө тэмцэл байдаг. Засгийн эрхийн төлөө тэмцлийг бол намууд бол хийдэг. Гэтэл өнөөдрийн байр сууринаас ингээд харахад энэ Засгийн эрхийн төлөө тэмцэл засаглалын хооронд явагдаад байна. Бага Хурал, Их Хурал гэсэн хоёр хэсэгт хуваагдчихсан.

Эцсийн эцэст энэ засаглал гэдэг чинь эцэст нь завхруулж иронийг та бүхэн бол мэдэж байгаа шүү дээ. 70 жил манайхыг завхруулж ирлээ. Ингээд би юу хэлэх гээд байна вэ гэхээр түрүүн дахиад Бага Хурлын гишүүн Өчирхүү депутат босоод уг хэлж байна. Түрүүнд нь бид дэгээрээ тохирсон зүйл байсан. Тэнд юу гэж тохирсон бэ гэхээр бид ерөнхий санал шүүмжлэл ярина гэсэн тийм асуудал байсан шүү дээ. Гэтэл одоо бодоод үз, бүлэг зүйлээр нь гэдэг чинь юу гэсэн уг вэ? Үүнийг би нэгдүгээрт ойлгохгүй байна.

Хоёрдугаарт юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ Их цаазан дотор бүлэг зүйлээрээ хоорондоо зөрчилдсөнх маш олон асуудал байна.

Хоёрдугаарт яаж байна вэ гэхээр төрийн тогтолцооньхоо хувьд ~~ми~~ депутат миний хувьд хүлээж авч болохгүй асар том асуудлууд зөрчилтэй зүйлүүд байна. Үүнийг депутатууд бид бүгд ойлгох хэрэгтэй. Яг энэ бүлэг зүйлээр яваад байх юм бол уг, үсгээр хөөцөлдсөөр байгаад, эцсийн эцэст энэ Их цаазын Үндсэн агуулга, улс төрийн тогтолцоо, засаглалын ялгаануудын хоорондын энэ нарийн ширийн ялгааг депутатууд мэдэхгүй баталчина. Эцсийн эцэст үүгээрээ тойроод улс төрийн том

хэмжээний, Ерөнхийлөгчийн засаглал юм уу, парламентын засаглалыг тойрсон том болохгүй зүйл бий болчих гээд байна. Үүнийг би дараа тодорхой ярьж гэж бодож байгаа. Дэгээрээ хэлнэ, микрофонд өгсөн саналаараа явна, харин тэндээс юу гэж хэлж байна вэ гэхээр дуудаад хэлээд өгөх хэрэгтэй, жагсаалтыг нь тэнд гаргаад.

Ж.Уртнасан: Жагсаалт нь надад байгаа.

11 дүгээр тойргийн депутат Ж.Бямбаа: Ерөнхий шүүмжлэл явуулна гэж бид нэгэнт тохирсон учраас ерөнхий шүүмжлэл явуулах нь зүйтэй гэж бодож байна.

Ерөнхий шүүмжлэл дээр манайхан хэлэхдээ бүлэг, зүйлээр ярих үедээ тэнд ярих юмаа ерөнхий шүүмжлэлдээ битгий оруулж яриач гэж хүсч байна. Ийм учраас бид ерөнхий шүүмжлэлийг ямар сэдвээр явуулах вэ гэдгээ ярилцаж тохирвол зүгээр байна. Жишээ нь БН улс гэх үү, Монгол улс гэх үү? Их цааз гэхүү? Үндсэн хууль гэх үү? Төрийн тогтолцоог ерөнхийлөгчийн засаглалтай байна гэх юм уу? Парламентын засаглалтай байна гэх юм уу? Их Хуралтай, Бага Хуралтай байх юм уу? ганц Их Хуралтай байх юм уу? Засгийн, орон нутгийн засаг захиргаа аймагтай байх юм уу? мужтай байх юм уу? хошуу болгох юм уу? үгүй юу? сумыг, аймгийг хуваах уу? одоонхоороо байхуу? гэсэн ийм үндсэн гол зүйлүүдээ ярьж тохирч байж, тэгээд эд нар дээрээ ерөнхий санал шүүмжлэл явуулахгүй бол сүүлдээ энэ ердөө болохгүй болно.

84 дүгээр тойргийн депутат Н.Самат:

Би очирхуу гуайн саналыг дэмжиж байгаа юм. Бид нар бол ерөнхий шүүмжлэл гэж явуулаад эхлэх юм бол бид нар ерөөсөө өнөөдөр маргааш нөгөөдөр, эцэс төгсгөлгүй маргаан болно. Бужигнаан болно. Эцсийн эцэст бид Үндсэн хуулийнхаа концептуаль-ний өөрчлөх ч хэрэг гарч магадгүй.

Тийм учраас бид нар нэгэнт энэ Бага Хурлаас оруулж ирсэн төслийг бид нар гол болгож хэлэлцэх гэж байгаа юм бол энэ төсөл дээрээ бүлэг бүлгээр нь ерөнхий шүүмжлэл явуулаад, дараа нь зүйл зүйлээр яваад цаашаа явах хэрэгтэй байна. Ер нь сая депутат Лхагвасүрэн хэлж байна л даа. Энд тогтолцооны хоорондын зөрчил явж байнаа, жаахан эрүүл бус гэж. Би харин өчигдрөөс нааш бол манай хурлын уур амьсгал аятайхан болж ирж байна гэж бодож байна. Их аятайхан болчихлоо шүү дээ, бид нэг нэгийгээ одоо л ойлгож эхлээд, Бага Хурлын гишүүд ч гэсэн депутат юм байна гэдгээ одоо л ойлгож байна.

Харин саналыг компьютерээр авах нь зөв гэж бодож байна. Яагаад гэвэл бид нар заавал ингээд эхэлж босоод, эхэлж хэлэх ёстой гэсэн тийм юм байхгүй байх гэж бодож байна. Депутатууд өөрийнхөө хэлэх гэсэн юмыг хаана ч хэзээ ч хэлж болно. Эцэст нь юм уу, эхлээд ч юмуу. Тийм учраас компьютерээр нэрээ гаргаад, тэр компьютерийн дагуу саналаа хэлсэн нь дээр байх. ТЭР нь арай замбараатай байх гэж бодож байна.

113 дугаар тойргийн депутат Ж.Гүррагчаа:

Тэгэхээр би ингэж бодож байгаа юмаа. Ерөнхий хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй. Гэхдээ бид ерөөсөө бидний энэ Их Хуралдааны үндсэн зорилгоо бол энэ үндсэн хуулийг л сайн хууль хийе.

Тийм учраас би үүнийг аль болохоор системтэй сайн явуулахсан гэж бодож байгаа юм. Тэгэхээр би ямар юм хэлэх гээд байна вэ гэхээр ерөөсөө үүнийг Үндсэн хуулийг хэлэлцүүлэх схем энэ юм шиг надад санагдаж байгаа юм.

Миний үүнийг юу гэж ойлгох вэ гэхээр ингэж ойлгож болох юм. Бид магадгүй өнөөдөр энэ Үндсэн санал шүүмжлэлээ явуулж байгаад, дараа нь зүйл зүйлээр нь ярилцаад эхэлнэ.

Ингээд тодорхой зүйлүүд дээр, тодорхой хэсгүүд дээр, тодорхой бүлгүүдийг бид тохироод явчихна. Гэтэл дунд хирд нь явж байгаад онц чухал асуудлууд тухайлбал засаглалын асуудал ч гэх юм уу? ийм асуудал дээр төслөөр харагдсанаас төслөөр тооцсоноос өөрөөр асуудал шийдэгдэж болно. Тэгэхээр бидний эхний шийдсэн асуудал, саяны шийдсэн асуудал хоёр зөрчилдөөд ирнэ. Тэгэхээр зэрэг би юу гэж хэлж байна вэ гэхээр энэ схемийг их сайхан зөв хийх юм бол хамгийн Үндсэн чухал асуудлуудаа бид гол орой болох асуудлаа шийдээд авах хэрэгтэй юм. Үүнийхээ дараагаар бусад тэр үндсэн санаа, туг далбаа ч байдаг юм уу, нэр усны асуудал хамгийн чухал нь бишээ.

Хамгийн гол асуудал тэр юмнууд дээрээ бүр тодорхой сайхан схем хийгээд, энэ схемнийхээ дагуу хэлэлцэх юм бол эхнээсээ аваад дуустал журамтай сайхан явах болов уу гэж бодож байгаа юм. Энэ миний саналыг депутат нөхдүүд сайн бодож тунгааж үзээч ээ гэж би хүсэх байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.15.
Рассет № 59
11.50-12.05.

-Ганцхан хүсэлт байна. Микрофоноос хол суусан бид ийшээ, тийшээ гарч микрофон дээр оочирлож нэрээ бичүүлж чадсангүй үлдлээ. Тэхээр бид горимын санал өгөх гэсэн юм. Хол суусан хүмүүс бид нэрээ бичээд өгье. Микрофоны завсраар биднийг тэнд гаргаж яриулах эрх олгоо чээ. Дараа нь дарааллаа танд явуулъя. Эсвэл компьютерээр нэрээ аваад, түүнийхээ дарааллаар явмаар байна.

Д.Балдан-Очир/150-р тойргийн депутат/ -Минутын үнэ цэнэ, хөрөнгө мөнгөний тухай ярьж байна. Энэ нь бодох л асуудал. Гэхдээ Үндсэн хууль нь бүхэл бүтэн цогц, амьд организм учраас хүнтэй төлөөлөөд аваад үзэхэд зөвхөн нүд, зүрхний тухай шууд ярьж болохгүй байна. Магадгүй зүрх нь баруун талд ч очиж болно. Тэхээр энэ амьд организм энэ хүн ямар байх ёстой толгой нь дээд талдаа, зүрх нь зүүн талдаа гэсэн ийм ерөнхий рам дотор маш нарийн ойлголцсоны үндсэн дээр уураг, тархи нь ямар бүтэцтэй байх вэ гэсэн маягаар ярих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл ерөнхий санал шүүмжлэлийг маш ойлголцолтой, цогц хэмжээгээр нь авч ярих ёстой. Бид ингэхгүйгээс болж деталчилсан маяг руу орвол жинхэнэ ноён нуруу, гол замаар явна, явахгүйгээ олж харж чадахгүй.

Даргад хандаж хоёрдахь санал байна. Хурлын аль болох түрэн шуурхай явуулах үүднээс надад ийм санал байна. Төрийн гол тогтолцооны талаар, ялангуяа хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглал, нутгийн захиргааны бүтэц, бүрэлдэхүүний талаар манай депутатуудад бүгдэд нь бүдүүвчилсэн тойм, схем зураг байх ёстой. Бид одоо зөвхөн дөрвөлжин цаасан дээрээс хараад ярьж байгаа. Гэтэл хүн нь танин мэдэхүйн бүх бололцоогоо ашиглаж чадахгүй байгаа шүү дээ. Ийм үүднээс депутат бүрт гол гол тогтолцоонууд, зарчмын асуудлуудаар бүдүүвчилсэн зураг схем зэрэг нарийн зүйл байвал ажил шуурхайчлах байдал нь илүү нөлөөтэй байх болов уу гэдгийг хэлмээр байна.

Л.Хал/310-р тойргийн депутат/ -Их Хурлын даргаас асуух хоёр асуулт байна. I-рт, урьдчилсан байдлаар хичнээн хүн ерөнхий санал шүүмжлэл гаргахаар тоо гаргасан вэ гэдгийг нэгдүгээрт хэлж өгмөөр байна.

Хоёрдугаарт нь цагаа хэмнэх үүднээс заавал амаар биш, бичгээр санал авбал яасан юм бэ гэсэн хоёр санал байна.

Ж.Уртнасан -Уг хэлэх хүмүүсийн тоо нэмж ирсээр байна. Та бүхэнд одоо урьдчилсан тоо хэлье.Бид нэрээ авчихаад байна одоо сонсгоё.Тоолож байх хооронд та бүхэнд сонордуулах зүйл байна. Энэ нь горимын санал юм.

I32-р тойргийн депутат С.Чулуунбаатар бидэнд ийм санал ирүүлж байна. Депутатын хороо байгууллаа.Одоо хэлэлцүүдэгт орох гэж байна. Үүний өмнө санал гаргаж байсан. Хуулийн эрхийг баригч гэж. Жинхэнэ эрх хуулиа барьж байх энэ хүнийг томилж, сонгож батлах хэрэгтэй байна. Тэр хүн нь үндсэн эхээ барьж, зарчмын санааг тэмдэглэж, депутатуудын хороонд туслах үүрэгтэй байх юм.Эх баригчаар Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Чимидийг би санал болгож байна. Хэлэлцүүлэх асуудлын өмнө миний саналыг депутатуудын сонорт хүргэнэ үү гэсэн горимын санал ирж байна. Бидэнд магадгүй хуулийн техникийн ажил хэцүү. Бид өөрийн санаа бодол, депутатын сонгогчдын даалгаварт хөтлөгдөөд, хаашаа ч явж мэднэ. Тэхээр жинхэнэ Улсын Бага Хурлаас оруулж ирсэн тэр эхийг барьж байх хүнийг томилж нь зүйтэй болов уу гэсэн санал оруулж байна.

Депутатууд аа! санал хураалт явуулах уу.Санал хураалт явуулъя.Санал хураалтандаа бэлтгэнэ үү. Хуулийн эхийг баригч гэдэг дээр.

Б.Мөнгөн /35I-р тойргийн депутат/ -Санал байна.Хуулийн эхийг хоёр хүнээр бариулах саналтай байна.Бага Хурлын гишүүн Лүндээжанцанг Чимид гуай дээр нэмэх санал байна.

Ж.Уртнасан -Та өөрийнхээ саналыг хэлэхгүй юу, хоёр дахь хүн хэн байх юм бэ?

Б.Мөнгөн -Харин Лүндээжанцан юм.

Ч.Хурц /287--р тойргийн депутат/: -Хурлын даргаа, дэгд байхгүй асуудал хэлэлцүүлээд байх уу? Ингэж байгаагаас болоод бид эргээд гол ярих гэж байсан зүйлээсээ өөр юм дундуур орж ирээд үймүүлээд байхаар та өөрөө хурлаа үймүүлээд байна шүү дээ. Бага Хурлаас энэ хороонд 5-6 хүн орж байна. Тэхээр заавал эх барих хүн гаргаж ирээд, Бага Хурлаас орж байгаа хүн нь эхээ бариад яваг л даа. Яагаад дэгэд байсан зүйлээсээ өөр юм гаргаж ирээд дахиад санал хураагаад байдаг ийм замбараагүй байдал гаргахгүй бол сайн байна. Би саналаа хэлье гэж бодсон юм.

Ж.Уртнасан -Горимын санал оруулж байгаа шүү дээ. Түүнээс бид дэг зөрчсөн юм алга.

Ч.Хурц : -Горим гэдэг чинь дэг шүү дээ.

Ж.Уртнасан -Баярлалаа депутатууд аа! Бид үүнийг нээлттэй орхёё. Үдийн хоолны өмнө хороог бид авчүзэж ярилцана. Хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилно. Тэнд энэ эх баригчийг давхар томилёё. Энэ нь амжих байх.

8-р микрофон: Ч.Хурц: -Би хэлэлцүүлэгтэй холбогдуулж санал хэлье гэж бодож байна. Тэхээр одоо ийм асуудлууд гараад байна. Улс орон даяар энэ хуулийг хэлэлцчихсэн. Хэлэлцүүлэгт ороход бид ерөнхий хэлэлцүүлэгт орёё гэсэн дэгээ батлачихсан. Үүнийгээ явуулаад эхлэхэд гол зарчмын асуудлууд дээр давхардсан санал гарахаар шинжтэй байна. Тухайлбал БНМАУ-ын нэр, улсын нэр, сүлд, далбаа, хуулийн нэр г.м. асуудлууд дээр. Үүн дээр депутатууд их яриад байлгүйгээр санал хураасан ч бэлэн хэмжээнд хүрчихсэн байна. Бидний асуудал нь нэр томьёогоор хөөцөлдөж, бие, биенээ мунхруулж, ингэж суухгүй шүү. Бид гол хэлэх санаа нь төрийн тогтолцоо ямар байхыг яримаар байна. Төрийн тогтолцоо нь дээрээ ч ямар хэсэгтэй

төрийн дээд байгууллага байх юм, орон нутагтаа ямар хэлбэртэй байх юм. Энэ хоёрын хоорондын холбоо ямар байх юм, мөн ард түмний холбоо хуультайгаа ямар байх юм гэсэн зүйл дээрээ гол анхаарлаа бид төвлөрүүлвэл зүйтэй байна. Тийм учраас Их Хурлын депутатуудаас хүсэхэд саналаа давхардуулахгүй байвал их сайн байна. Урьд хэлсэн хүний саналыг дэмжих маягаар хэлнэ үү гэхээс биш, дахин түүн дээр тодотгол хийхгүй бол сайн байна гэж бодож байна.

Хоёрдугаарт гол зарчмын асуудлууд хэдэн удаа гараад ирсний дараа шууд санал хурааж, ийм журмаар үндлээ гэдгийгээ тохирч баймаар байна. Бидэнд хуулиа хамгийн түрүүнд ярилцахад эхдээд гарах асуудлын зарчмын саналуудыг нөхдүүд хэлэх байх. Хамгийн хүнд асуудал нь ер нь ямар хэлбэрийн улс байх юм бэ? Парламентын БНУ гээд Бага Хурал саналаа ирүүлчихээд байна. Зарим нөхөд Ерөнхийлөгчийн БНУ гэсэн санал байж байгаа юм. Гуравдахь нь Монгол улсын өөрийн гэж нэг юм гаргаж ирье гэсэн энэ хоёрыг хольсон юм байгаа. Ингэхээр бид зарчмын том асуудлууд дээрээ цагаа авбал сайн байна, Их Хурлын депутатууд аа, түүнээс биш бие, биенээ үг, амаар идсэн зүйл байхгүй бол их сайн байна. Би үүнийг депутатууддаа хүсэх гэсэн юм.

С. Дхагвасүрэн/14-р тойргийн депутат/ - Үндсэндээ Хурц депутатын саналтай нэг байна. Бид эхний ээлжинд улс төрийн тогтолцооны тухай асуудлаа яриад ерөнхийд нь тохирчихмоор байна нэгд. Хоёрдугаарт, үүнтэй холбогдуулж нэг зүйлийг хэлье. Ямар, ямар асуудлаар ерөнхийд нь ярих вэ гэсэн асуудлыг депутатуудын дунд санал, асуулга явуулаад шийдчихмээр байна. Өөр зүйл рүү хальж оролгүйгээр, дараа нь бид хоёрдугаар хэлэлцүүлгээр бүлэг, зүйлээр, үг өгүүлбэрээр нь авч хэлэлцэнэ шүү дээ. Ийм горимын саналтай байна.

Б. Чимид/396-р тойргийн депутат/ - Депутат Бямбаагийн хэлсэн зүйл надад нэг зүйлийг санагдууллаа. 1945 он шиг санагдаж байна. Ялтын хэлэлцээр дээр гурван их гүрний

5.

удирдагч асуудал хэлэлцэх болсон. Германы тухай хэлэлцэнэ гэсэн. Герман гэдэг үгийн ойлголтыг одоогийнхоор авч үзье гэсэн юм. Тэрүүнийх шиг ерөнхий хэлэлцүүлэг гэдгийн ойлголтыг маш тодорхой болгоё гэж нэлээд хэдэн хүн хэллээ. Тэхээр жишээ нь засгийн хэлбэрийн тухай асуудлыг хэлэлцэнэ гэж байгаа бол Үндсэн хуулийнхаа 3-р бүлгийг эхлэж хэлэлцэх нээ. Дайраад гарга гэдгээр хэлэлцвэл бүх асуудлыг илтгэсэн Ерөнхийлөгчийн илтгэлийг давтах нээ. Тийм учраас хуулийн эхнээс нь явахдаа ерөнхий зүйлээ ерөнхий оршил дээр нь яриад, улсынхаа мөн чанарын асуудлыг, хэлбэрийг нь биш, нэгдүгээр зүйл дээрээ яриад, БНУ байх уу, БН биш улс байх уу гэдгээ. Мөн хүний эрхээ яриад, түүн дээрээ хүний эрх гэж байх уу, эсвэл иргэн гэж байх уу гэдгээ яриад, гуравдугаар бүлэг дээрээ манай төрийн тогтолцоо гэж та бүхний хэлж байгаа төрийн байгууллагын тогтолцоо ямар байх вэ гэдгээ, Парламентын гэж байх уу, Ерөнхийлөгчийн байх уу гэдгээ яриад, хэрэв Ерөнхийлөгчийн гэж байна гэвэл түүнийгээ дээгүүр гаргаад ирэх жишээтэй, энэ нь зайлшгүй давтагдана. Өөрөөр хэлбэл бид хууль хэлэлцэх технологийн дагуу явбал болохгүй юм юу байх вэ? Ийм л зам байна. Эсвэл тооцоо хийж үзэхэд 210 депутат хэлнэ гэвэл 4 өдөр ярих нээ. Ингээд хурлын 50 хувь нь явчихна. Тийм учраас шууд ажилдаа ороод, улсын нэрийн тухай асуудал гэдэг нь эхэндээ байгаа юм. Хурц депутатын хэлдгээр уг хэлж, саналаа авчихаад, санал олонх, цөөнх гээд хэлэлцээд явчихлаар нөгөө Бүгд Найрамдах гэж хэлэх нь ийм учиртай, г.м. Тайлбаргүй хэлчихье.

Намууд саналаа ирүүлчихсэн байгаа. Хувьсгалт намаас харьцуулаад жагсаалт гаргачихсан байна. Тэр нь тусдаа байна, ийм, ийм саналтай байна гээд, нэг ийм зам байна. Өөр нэг зам юу байна вэ гэхээр бид депутатын бүлэг гэж байгуулчихсан чинь хурлын доторхи ажлын зохион байгуулалт шүү. Уг нь депутатын бүлэг нь саналаа нэгтгээд, дундаасаа хамгийн компетентний гэсэн хүнээ, мэдлэгтэй гэсэн хүнээ юм уу, энэ асуудлаар сайн гэсэн хүнээ томилоод, энэ нь унавал би ард нь хамгаална шүү гэж хийдэг Парламентын ёс байдаг.

Бид тойргийнхоо сонгогчдод нэрээ дуулгана гээд бүгдээрээ хэлэх гэж дурлаад байвал 410 депутат хэлвэл яг 8 хоног ерөнхий санал, шүүмжлэл явна. Ингэхлээр хугацааны гуравны хоёр нь алга болчихоод байна. Тийм учраас Парламентын ерөнхий нийтлэг журмын дагуу шууд л нэрнээсээ эхлээд, Хурцын хэлснээр саналаа хураагаад явбал яасан юм бэ?

Э.Бат-Үүл/52-р тойргийн депутат/ -Хурлын дарга ерөнхий санал шүүмжлэл гэж юуг хэлээд байгааг тодруулж өгөхгүй бол депутатууд концепцийн асуудал юм уу энэ нь, аль эсвэл нэгмөсөн нэг амьсгаараар зүйл бүр дээр өөрийнхээ саналаа депутатууд хэлэх гээд байгаа юм уу гэсэн хоёр асуудал хутгалдчихаад болж өгөхгүй байна шүү дээ.

Очирхүү депутатын ярьж байгаагаар концепцийн тухай асуудал, хэрэв тэгвэл бид эцэс, төгсгөлгүй аймшигтай маргаанд ороод, хэрэв концепцийн асуудал хэлэлцэх гэж байгаа бол Ерөнхийлөгчийн илтгэл дээр хэлэлцэх ёстой юм. Яагаад гэвэл Ерөнхийлөгч Их цаазын концепц оруулж ирсэн учраас. Тэхээр Ерөнхийлөгчийн илтгэлд нэгэнт хэлэлцээгүй бол Очирхүү депутатын хэлж байгаагаар явах болно. Өөрөөр хэлбэл бүлэг бүр дээр саналаа ярих болно. Тэр концепцийн асуудал дээр ярих болбол жишээ нь би ухаандаа 52-р тойргийн Ардын Их Хурлын депутатын хувьд, депутатууд үргэлж төр, засаглалын асуудлыг цөм асуудал гэж яриад байгаа юм. Гэтэл бид концепц дээрээс хүний эрхийн асуудал цөм асуудал гэж ярих болно. Хэрэв тэгвэл ямар асуудлыг цөм асуудал гэхээс эхлээд хэлэлцүүлэг явах болно. Үүнээс болж маргаан гарна. Хурц депутатын ойлгож байгаагаар нэг амьсгаараар нэгмөсөн тодорхой бүлэг дээр байгаа өөрийн саналыг бүгдийг нь хэлье гээд байна л даа. Хэрэв тэгвэл энэ нь бүлэг бүр дээр тэртэй, тэргүй хэлэлцэгдэнэ шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг тодруулмаар байна. Концепцийн асуудал гэж ойлгох юм уу, эсвэл нэг депутат босоод бүлэг бүр дээр өөрийн тодорхой байр сууриа нэгмөсөн хэлнэ, үүнийг ерөнхий хэлэлцүүлэг гэж ойлгож байгаа юм уу гэдэг энэ хоёр асуудлыг ялгаж өгмөөр байна л даа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Л.БАЯРМАА

Бичээч С.Туул

Кассет 60
1991-XI-15
12.05-12.20

Ардын Их Хурлын 211 дүгээр тойргийн депутат Д. Дагвадорж :-
Хурал эхлээд тав хонож байдаг, Их цаазын төсөл ярина гэсээр байгаад тав хоногоо авчихлаа. Эхлээгүй л байна. Энэнийг бас олоо анхаараад, ерөнхий асуудлыг шийдэхгүйгээр тодорхой асуудал шийднэ гэж байхгүй. Бүр алхам тутамдаа ерөнхий асуудлыг шийдээгүй юмтайгаа тулгарна. Ийм учраас ерөнхий санал шүүмжлэл явуулаад зарчмынхаа асуудлыг шийдчихээд ингээд бүлэг, зүйл уруугаа орох нь зүйтэй гэж үзэж байна. Горимын санал байна. Нэрээ өгсөн улсуудыг нэрээр нь дуудаад, нэр нь бичээгүй улсууд байвал бичээд өгчихвөл яасан юм бэ?

Ардын Их Хурлын 390 дүгээр тойргийн депутат Ү. Аварзэд :-
Хурлыг хөнгөвчлөхийн тулд нэг ийм санал байна. Зайлшгүй ерөөсөө шууд санал хураалтаар бүх хэмжээндээ ойлгогчигож болмоор есөн юм байх шиг байна л даа. Хаанаасаа юу ч гэж тайлбарласан бид ийм л санал өгнө гэдгээ депутатууд шийдчихсэн байгаа болов уу гэж бодож байна. Тайлбар яриа бол байлгүй яах вэ. Хүн бүхэн л хүч нэмж санаандаа хүрэхийн тулд юмыг давхарлаж ярина. Жишээлбэл улсын нэрийг тэгье гээд цөмөөрөө л нэг юм хэлнэ. Тэгж байхын оронд бол ерөөсөө улсын нэрийг яах вэ? Хуулийн нэрийг юу гэж тусгах вэ? Сүлдийг яах вэ, тамга, тамгыг шувуутай байх уу, арслантай байх уу гэх мэтээр юм ярина л даа. Төрийн дууллын үгийг өөрчлөх үү? Улсын нийслэлийн нэрийг яах вэ? Аймаг, хошуу, багийн асуудлыг яах вэ гэсэн иймэрхүү хэдэн юмыг бол ерөөсөө урьдчилсан байдлаар санал хураачихвал ерөнхий бодлого гарчих юм биш үү. Энэ дээр эрдэмтэд, мэргэд тайлбараа өгөг л дээ. Дараа нь бид жинхэнэ саналаа өгөөд батлах юм. Ингэхгүй бол ерөөсөө хүн бүгд туг, сүлд гэж яриад, минут идээд болохгүй байх учиртай. Харин энэний цаана засаглал, элдвийн нарийн ширийн юм, хүний эрх, тэр цагаачлалын асуудал, газрын асуудал энэ бүх юм бол тодорхой ярьж байж шийдэхээс болохгүй зүйл байх аа. Ер нь бол би-

дэнд саяны хэлдэг зүйлүүдийг урьдчилсан байдлаар санал хураагаад за ерөөсөө энэ бол хөдлөхгүй юм байна. Энэ бол хөдлөх юм байна гэсэн өнгө бол санал хураахад л гарчина. Энэ бол хэвлэл, радио, телевиз, хүмүүсийн яриа шүүмжлэлээс бидэнд мэдлэг, материал гүйцсэн. Ерөөсөө санал өгөх л үлдчихсэн ийм хэдэн юм байна гэж бодож байна. Ингэх юм бол асуудал их хөнгөрнө. Харин ерөнхий санал шүүмжлэл гэдэг зүйл, бүлгээр нь одоо энэ бүлгийг хэлэлцье, одоо тэр зүйлийг хэлэлцье гээд явах юм бол энэ маш их хугацаа сунах байх, харин ерөнхий ерөнхий л учраас, хэн боссон хүн, хэн юу сонирхож байгаа, юу мэдэж байгаагаа л яриг л даа. Энэ дотроос нь шүүж аваад орхихлоор ёстой ерөнхий дүгнэлт гарна. Тэгээд ерөнхийгөөс нарийн уруугаа ордог юм байгаа биз ээ гэж бодож байна.

Ардын Их Хурлын 340 дүгээр тойргийн депутат Б.Сүмбья:--Нацад ганцхан санал байна. Ер нь зүгээр ерөнхий шүүмжлэл явуулах уу үгүй юу гэдэг асуудлаа бид дэгээр шийдчихсэн гэж бодож байна. Хэрхэн яаж явуулах уу гэхлээр бид явуулж чадахгүй дуусгаж магадгүй байна. Тийм учраас миний бодоход ямар тохиолдолд бүлэг зүйлээрээ явж болох вэ гэвэл бүлэг, зүйлийн тухайд ямар нэгэн яриа байхгүй, тэр байгаа төсөл дээр нь ярих тийм хэмжээнд хүрсэн цагт л эхнээс нь аваад бүлгээр нь зүйлээр нь явчихаж болно. Тэгэхлээр энэнтэй зөрж байгаа ямар нэгэн хэмжээгээр шинэ бүлэг нэмье гэдэг юм уу, эсвэл томоохон хэсэг нэмэх ч юм уу хасах ч юм уу иймэрхүү тийм бүтэцтэй холбоотой тийм зүйлүүд, нөгөө талаар тэр Үндсэн хуулийг жинхэнэ кондицид нь жинхэнэ шаардлагын хэмжээнд хүргэж боловсруулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой ч асуудал байдаг юм уу, тийм цөөхөн, маш явцуу хүрээний дотор ерөнхий шүүмжлэлийгээ явуулаад тэгэхлээр тэр ерөнхий шүүмжлэлийг явуулж байхад жишээлбэл одоо нэг цоо шинэ бүлэг нэмэх ч байдаг юм уу, эсвэл хоёр гурван бүлгийг нэгтгээд нэг болгох ч байдаг юм уу, эсвэл тэр төрийн тогтолцооны тухай асуудлыг бүр цоо шинээр хийх ч байдаг юм уу, ийм юмнуудыг тэр ерөнхий шүүмжлэл явуулж байх хооронд ажлын групп нь байна уу, тэр хороо нь байна уу, бүр одоо тэр хооронд тэр томъёолуудыг өөрсдийнхөө ойлголтоор, бололцоогоор

З.

бэлтгээд, тэгээд тодорхой бүлэг, зүйлээр ярьж хэлэлцэхэд л тэрнийг бэлэн болгоод, тодорхой вариантуудыг санал болгож өгвөл сайн юм шиг санагдаж байна л даа. Тийм учраас ерөнхий шүүмжлэлийг маш богино хугацаанд, маш явцуу хүрээнд явуулуштай санагдаж байгаа юм. Дараа нь нэгэнт үнэндээ тэр депутатуудын хэлээд байгаа үнэн. Дараа нь бид төрийн тогтолцоо тийм байх ёстой гээд ерөнхий шүүмжлэл дээрээ баахан ярина, дараа нь бүлэг, зүйл дээрээ баахан ярина. Харин би тэрний юуг нь дэмжиж байна вэ гэвэл тэр тэртээ тэргүй маргалдаад маргалдаад сар ч маргаж болохоор, гэтэл хүн бүр тодорхой өөрийн үзэл баримтлал тогтчихсоч тэр Аварзэд гуайн хэлдэг ч байдаг юм уу, арай тэрнээсрөөн ч асуудал дээр юм уу санал хураагаад тэгээд дараа нь бол тэр санал хураасны үндсэн дээр гаргасан томъёоллоо хэлэлцээд, бүлэг зүйл дээр нь, тохирох таарах бүлэг зүйл дээр нь хэлэлцээд явбал яасан юм бэ гэсэн ийм санал байх юм даа.

Ардын Их Хурлын 72 дугаар тойргийн депутат А.Болат:--Би энэ асуудалд ерөнхий санал шүүмжлэл явуулах асуудлыг бүх зүйл анги дээр түгээмэл баримтлах зарчим болгохгүйгээр асуудал тус бүр дээр өвөрмөц байдлаар хандах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Бид ерөнхий санал шүүмжлэл явуулснаараа эрхийн зорилго, өөрөөр хэлбэл шийдэл хүртлээ дөрвөн дамжлага дамжих болж байна. Эхлээд ерөнхий шүүмжлэл, дараа нь бүлэг, дараа нь зүйл, эцэст нь цөөнхийн санал гэж дахиад санал шүүмжлэл явагдана. Ингээд дөрвөн дамжлага явагдсаны дараа сая нэг тохиролцоонд хүрч, шийдлээ сонгож тогтоох нь ээ. Ингэхлээр бидний зам хэтэрхий уртдаад байх шиг байна. Бид маш их цаг алдах нь шиг байна. Тийм учраас бүх зүйл дээр ерөнхий санал шүүмжлэл байх ёстой гэсэн энэ ойлголтоо бид эргэж үзэх арга байхгүй юу? Жишээлбэл улсын нэр, хуулийнхаа нэр гэхэд би зүгээр буруу ойлгож байж магадгүй, эрхэм депутатууд намайг уучлаарай. Энэ хоёр зүйл дээр шууд санал хураагаад цөөнхийн утгаар бид санал шүүмжлэл явуулах бүрэн бололцоотой. Өчнөөн, төчнөөн тайлбарлаж яриад, улсынхаа нэр гэхэд хоёрхон хувилбар дээр бид тогтоно. Би бол энэ дээр ерөнхий санал шүүмжлэл явуулах юм бол магадгүй зуун депутат босч магадгүй, зуун депутат яриад яриад

4.

эцэст нь хоёрхон сонгосон нэрэн дээр тогтох юм шүү дээ. Тийм учраас бүх зүйл анги дээр ерөнхий санал шүүмжлэл явуулна гэсэн энэ ойлголтоосоо бид татгалзвал яасан юм бэ? Харин нөгөө утган дээр жишээлбэл улс төрийн тогтолцооны хувьд бид ойлголтоо нэгтгэхийн учир ерөнхий санал шүүмжлэл заавал байхаас арга байхгүй. Тийм учраас би зүгээр ийм санал хэлмээр байна.

Зүйл тус бүр дээр нь, бүлэг тус бүр дээр нь ерөнхий санал шүүмжлэл явуулах уу үгүй юу гэдэг дээрээ санал хурааж олонхийнхоо саналаар шийдээд шууд санал хурааж цөөнхийн утгаар ярилцъя гэдэг тийм асуудлыг бид тогтоож болохгүй юу?

Энэ утган дээр санал солилцож үзвэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Ардын Их Хурлын 258 дугаар тойргийн депутат Ш. Гунгаадорж:
-Тэгэхлээр ерөнхий санал шүүмжлэл явуулна гэдгийг нэгэнт бид тогтсон, ерөнхий санал шүүмжлэл , жинхэнэ хэлэлцүүлэг хоёроо бас нэг жаахан ялгаа заагтай ойлгомоор байна. Ерөнхий санал шүүмжлэл бол Үндсэн хуулийн агуулга, бүтэц, тэрэн дотор байгаа, би бол концепцийн асуудал биш гэж ойлгож байна. Ер нь санал зөрүүтэй байгаа, нэлээн маргаж болох хэд хэдэн гол асуудал байгаа. Тэр дотроосоо бол төрийн тогтолцооны асуудал, дээрээсээ аваад доороо хүртэлх энэ хэсэг бол гол анхаарал татах асуудал, энэ талаар депутатуудын ерөнхий санал, хандлага ямар байгаа юм гэдэг дээр ерөнхий санал шүүмжлэлийн нэлээд хэсэг чиглэгдэх байх. Санал шүүмжлэл яваад эхэлсний дараа давхардаж эхэлнэ энэ. Тэр үед бид нар хэлэлцүүлэгтээ л орох ёстой болох байх. Тийм учраас санал шүүмжлэлээ эхлэх нь зөв өө.

Харин энд нэг санал гарч байгааг би бас зөвшөөрч боломгүй байна. Ерөнхий санал шүүмжлэлээр хэлэлцэж байгаа асуудлаар санал хураагаад шийдээд явъя гэдэг бол болохгүй байх. Энэ бол жинхэнэ хэлэлцүүлэг эхлэхээр бүлэг, зүйл бүрээрээ энэ чинь ярих асуудал. Энд бол зүгээр хандлага ямар байна вэ гэдгийг ерөнхийд нь мэдэхээс биш тэрүүтээр шууд шууд шийдээд,

5.

за төрийн тогтолцоо Ерөнхийлөгчийн засаглал байна, Парламентын засаглал байна шийдэх үү, шийдье ийм санал гарлаа гээд ингэхгүй байх. Энэний тулд ерөнхий санал шүүмжлэл явж байгаа биш ээ. Бид ингэж ойлгож байна. Тийм учраас шийдээд явна гэдэг бол одоо би санал шүүмжлэлийн явцад энэ шийдэхгүй, хэлэлцүүлгийн явцад шийдэх ёстой гэдгийг бас нэг заагтай ойлгоосой гэж бодож байна.

Ардын Их Хурлын 56 дугаар тойргийн депутат Р. Гынчигдорж:
 -Та бүхэн Бага Хурлын даргын хувьд надад тавьж байсан асуудлуудаас аваад үзэх юм бол бид нарт энэ ерөнхий санал солилцох энэ асуудлыг нэлээн тодорхой болгохгүй болбол бид нар их цаг алдана. Тийм учраас өнөөдөр ерөөсөө ямар асуудал дээр санал солилцох вэ гэдгээ Заргачихаад тэр асуудлынхаа хүрээнд саналаа солилцоод, тэгээд тэр асуудлынхаа хүрээнд шийдвэрлэх боломжтой нөхцөл бүрдсэн үед шийдвэрлээд ингэх, ингэж болох хэдэн асуудлууд байна.

Энэ бол улсын нэр, хуулийн нэр, сүлд, далбаа, эхний ээлжинд энэ дөрвөн асуудал. Энэ дөрвөн асуудлыг зарлаад одоо улсын нэрний тухай гээд, ингээд ярьчихад.

Дараачаар нь парламентын байх уу, ерөнхийлөгчийн байх уу гэдэг бол өөрөө тэр доторхи асуудлаасаа ургаж гарч ирж байж тодорхойлогдох асуудал. Ийм учраас энд бол доторхи асуудлынхаа дотроос ярьж ургуулж гаргаж ирээд дараачаар нь эндээс хүмүүст төрөх саналаар энэ илэрхийлэгдэх учиртай учраас энэнийг бол яг энэ дөрвөн асуудалтай адилтгаж болохгүй. Дараачаар нь хошуу гэх үү, сум гэх үү гэдэг нэр бол бас нутгийн засаг захиргааны тэр хэсгийгээ хэлэлцэж яваад тэндээс энэ ингэж нэрлэх нь зөв үү үгүй юу гэдэг асуудал өөрөө гарах, зөвхөн нэрний тухай асуудал биш, агуулга нь тэгж төсөлд ороод байгаа шүү дээ. Тийм учраас миний санал бол эхлээд энэ хурлын дарга асуудлаа зарлаад энэ асуудал дээр ингээд явах юм бол их тодорхой горимтой, цаг алдахгүй ийм л учир холбогдолтой юм. Тийм учраас санал солилцох гэж томъёолж байгаа энэ эхний хэсгийг ингэж л явбал зүйтэй юм уу л гэж бодож байна.

6.

Ардын Их Хурлын 153 дугаар тойргийн депутат Д.Чойжамц:
 -Түрүүн дэг хэлэлцэж байхад би саналаа хэлсэн юм. Энэ яах вэ
 эрхэм депутатуудын анхааралд нэг их сайн хүрсэн үү үгүй юу?
 Тэгэхлээр ерөнхий хэлэлцүүлэг бол зайлшгүй хэрэгтэй.

Ерөнхий хэлэлцүүлгийг яаж явуулах вэ гэхлээр зэрэг
 бичгээр урьдчилаад авъя. Нийт депутатуудаас Авсан материалыг
 нь ямар нэгэн хэмжээгээр хэвлэлд нийтэлъе. Тэр дундаасаа
 өнөөдрийн, одоо саяны хүмүүсийн ярьж байгаа байдлаас түүвэрлээд
 хэлэлцүүлъе гэсэн ийм санаа дэвшүүлж байсан юм. Одоо энэнийгтээ
 би бас дахиж хэлъе гэж бодож байна. Энэ талаар санал хураалгаж
 өгөөчээ.

Ардын Их Хурлын 80 дугаар тойргийн депутат Д.Зарьккан:
 Энэ Үндсэн хуулиа бид хэлэлцэж эхлээгүй байна гэж би ойлгож
 байна. Гэтэл хэлэлцэж эхлээгүй байхад хажуудаа байгаа кнопоо
 дараад санал хураачихъя гэдэгтэй санал нийлэхгүй байна. Ер нь
 Үндсэн хуулиа хэлэлцэхдээ ингээд кноп дарах байдлаар явах
 юм бол энэ хууль биш болж таарна. Ийм учраас ерөнхий санал
 шүүмжлэл байх ёстой. Ерөнхий санал шүүмжлэл дээр бид ярих
 юмаа ярьж байгаад, энэ Үндсэн хууль маань агуулга, бүтцийн
 хувьд болж уу, юу нь нэмэгдмээр байна, юу нь хасагдмаар
 байна, яаж найруулмаар байна. Энэ ерөнхий санал шүүмжлэл ярьс-
 ны дараа тодорхой бүлэг, зүйл дээр ярих нь зүйтэй гэсэн ийм
 саналтай байгаа юм. Энэ талаар бид ер нь түрүүн дэг дээрээ
 баталчихсан. Одоо дахиад ухрах хэрэггүй болов уу гэж бодож
 байна.

Ардын Их Хурлын 296 дугаар тойргийн депутат Л.Батжаргал:
 -Турав, дөрвөн асуудал дээр юм хэлмээр бодогдож байна.
 Нэгдүгээрт нь, хурлын даргаас хүсэхэд хурлын хэлэлцүүлж
 байгаа асуудлыг нэг мөр түргэн шийдэж баймаар байна. Бид
 эхлээд компьютерээр яах уу, бичгээр, энэ жагсаж яах уу
 гэдэг асуудлыг дэвшүүлсэн, энэ мэт ийм нэг асуудлаа шийдэх-
 гүй хоёр гурав дахь асуудал уруу орчихоод хурлыг хорь, гучин
 хувиар сунжруулж байгаа гол дутагдал удирдлагад байна гэж

7.

дүгнэж байна. Тийм учраас одоо энэ юуний өмнө компьютерээр яах уу, бичгээр яах уу гэдгээ нэг мөр шийдчихмээр байна.

Үндсэн асуудал цээр компьютерээр гээд гарч ирсэн.

Тэгэхлээр компьютерээрээ явмаар байна. Учир нь юу гэхлээр бичгээр гэхлээр бичиг дамжуулаад одоо бас соёлын талаасаа ч тэр, ажиллагааны талаасаа ч тэр, эхний удаа бичгээр ч байдаг юм уу, компьютерээр эхэлж байтал сүүлд аандаа соёлд орж, хэн саналтай нь цэс дараалалцаа орж ирэх байх аа гэж ингэж бодож байна. Ер нь техникээ эзэмшиж сурахаасаа ч авъя, цаашдаа хурдан шинжтэй болох талаасаа компьютерээрээ явбал яасан юм бэ гэж бодож байна.

Хоёрдугаарт нь үлдэж байгаа хоногт бүх хэлэлцэх асуудлынхаа үндсэн ^{дэс} дарааллын дагуу хоногоо тогтоож хуваамаар байна. Ажлын комисс. Цаад аппарат. Энэнийг хамт олноороо хэлэлцүүлж, жишээлбэл бидний өнөөдөр хэлэлцэх асуудал бол эхнийхээ шатны асуудлыг, Үндсэн хуулиа бид хоёр шаттай хэлэлцэнэ гэж байгаа шүү дээ. Тэр хоёр шаттай хэлэлцэхийн эхний нэгдүгээр шатыг энэ өдрийн хуралдаанаар шийдэх байх л гэж бодож байна. Ийм байцлаар эхний бүх хэлэлцэх асуудлыг эргэж хоногтоо хувааж үзэж гаргамаар байна.

Танхимаас:


—Дэгээрээ явъя л даа. Дахиад санал хураагаад ямар хэрэг байна аа. Бид ерөнхий санал шүүмжлэлдээ ороод л түрүүчийн хүн нь угтээ хэлж баймаар байна. Ингээд л дахин дахин санал яриад ямар хэрэг байгаа юм бэ?

Л. Батжаргал:— Энэ санал гэж ер нь хоногоо тооцохгүй бол бид хоноггүй байна шүү дээ. Хоногоо тооцож хоногтоо хуваамаар байна. Өнөөдрийн энэ хуралдаанаар бол өнөө маргаашийн хуралдаанаар эхний нэгдүгээр шатны асуудал ерөнхий хэлэлцүүлгээ хэлэлцэж баталмаар байна.

И. Уртнасан:—Баярлалаа. Эрхэм депутатууд аа. Ер нь зарчмын

...тэгэхээр депутат нөхөд өө .Бид хоёр хувилбараар санал хураалт явуулаад микрофоны ард ирсэн, нэрийн жагсаалт гарчихлаа. Жишээ нь 168 хүн үг хэлье гэж саналаа ирүүлсэн байна. Та нарт микрофоны байдлаар хэлбэл нэгдүгээр микрофон дээр 18 хүн, хоёр дээр 22 хүн, гурав дээр 35 хүн, дөрөв дээр 23 хүн, тавд 16, зургаад 11, долоод 29, наймд 14 хүн байна. Хэрвээ нэмж үг хэлэхээр бидний энэ 168 хүн магадгүй бид ойлгож байна. Тодорхой нэг эргэлзэж байгаа арваад асуулт байгаа юм. Түрүүн зарим депутатууд хэллээ. Тэр хуулийн нэр, улсын нэр, далбаа, сүлд, бэлгэ, тэмцгийн асуулал төрийн зохион байгуулалт гээд. Тэрэн дээр эргэлзэх байх. Хэрвээ энэ 168 хүн дотор санал нь давхардаад гарчихвал заавал үг хэлэхийн төлөө хэлэхгүй байх. Тийм учраас бид ерөөсөө дэгээ баримтлаад ерөнхийгээс тодорхой уруу орё. Анхны хэлэлцүүлэг явж байна. Микрофонхоо дарааллаар яриад эхэлвэл яасан юм бэ?

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

Уртнасан:

-Уучлаарай, бид бас нэг жаахан горимтой, журамтай баймаар байна.Одоо шууд ерөнхий хэлэлцүүлгээ эхэлье.Санал тохирлоо,

Танхимаас:

-Горимын санал хэлмээр байна шүү дээ, хэлэлцүүлгийн өмнө.

-Ерөнхий хэлэлцүүлгэндээ улсын нэр, хуулийн нэр,далбаа энэ тэрнийг оруулалгүй хэлцмээр байна шүү дээ.Яг тэрэн дээрээ очоод тэрнийгээ хэлэлцье.

14-р тойргийн депутат С.Лхагвасүрэн: -Би туг далбаа, улсын нэрийн асуудлыг би ярмааргүй байна.Эхлээд Монгол улс ямар улс байх юм гэдгийг эхэлж хэлнэ.Төрийн тогтолцоо ямар байх вэ энүүнээсээ үндэслээд туг, сүлд далбаа ямар байх нь ойлгомжтой болох байх гэж бодож байна.Хүний эрхийн асуудлын дараа дараадахиж уг хэлнэ.Төрийн тогтолцооны талаар уг хэлэх гээд байна.Улсын их цааз, улсын их цаазын төсөлд монгол улсыг парламентын бүгд найрамдах улс гээд тодорхойлоод заачихсан байж байгаа.Гэтэл үнэн хэрэгтээ энэ их цаазын төслийг би өчигдөр хараад байж байхад үнэн чанартаа бол Ерөнхийлөгчийн онцгой эрхтэй Ерөнхийлөгчийн засаглалтай улс болохоор ингээд дотор нь заачихсан байна.Нэг үгээр, нэлээн хатуухан хэлэх юм бол Ерөнхийлөгч маань одоо манай засаглалын шүүх засаглалыг үндсэнд нь гартаа авчихсан, нэг үгээр хэлэх юм бол цаашдаа Ерөнхийлөгч орсон 12 хунтэй, улс төрийн том мафи үүсэх эрх зүйн үндэс энд тавигдчихсан байна гэж үзэж байна. Ийм учраас би яаж байна вэ гэхлээр энүүнээс шал өөр, мөдгийн надад бас санал байгаа.Энийг бол би болж өгвөл бичгээр өгөх саналтай байж байгаа.Монгол улс бол өнөөдөр Ерөнхийлөгчийн засаглалтай байх юм уу, Парламентын засаглалтай байх юм уу гэдэг асуудлаар бид эхний ээлжинд саналаа солилцмоор байна.Мүний хувьд монгол яаж байна гэхлээр парламентын засаглалтай, парламент нь дотроо 2 танхимтай байх нь зүйтэй гэсэн миний хувийн санал байгаа.

222-р тойргийн депутат Д.Банзрагч:

-Ерөнхий хэлэлцүүлэг гэдэг дээр би ингэж ойлгож байна,Ер нь одоо бид нар хэлбэрийн тухай асуудал дээрээ голчлоод агуулга дээ-

рээ ерөөсөө санаа тавихгүй байна. За энэ дээр ер нь одоо ерөнхий хэлэлцүүлэг бараг хэрэггүй байсан юм уу гэдэг бодол гарч ирж байна. Энэ дээр бид нар саян Лхагвасүрэнтэй санал нэг байна. Тэр нэрнүүдийн асуудал болгоны хэлбэрийн асуудал. Энд ерөөсөө ярьж хэрэг байхгүй. Хэрвээ ерөнхий хэлэлцүүлэг дээр ярих юм бол бид нар засаглалын хэлбэр, тухайлбал ер нь санал эсрэг байна. Ерөнхийлөгчийн засаглалтай байх нь зүйтэй гэсэн, энэ бол гол концепцийн асуудал гэж үзэж байна. Тухайлбал танхимын асуудал байна. Танхимын асуудал дээр өчигдөр уур амьсгал ямар байсан гэхдээр эрх тэнцүү 2 танхим байна гэж ярьж байсан. Тэгвэл энэ дээр нэг нь нэгэндээ хяналт тавьдаг, ер нь одоогийн тогтолцоо бол ер нь одоо их ойролцоо баймаар юм шиг санагдаж байгаа юм. Шүүх засаглал ихтэй, энэ юман дээрээ бид нар яримаар байна. Тэрнээс тэр ер нь одоо уур амьсгал бол тэр нэрийн чанартай, хэлбэрийн чанартай юм руу ингэж хөтлөгдөж явчихаад гол агуулга руу гаа бид ерөөсөө анхаарал хандахгүй байна. Ер нь энэ агуулгаараа, энүүгээр ярихгүй гэвэл ерөөсөө ерөнхий хэлэлцүүлгээ болих нь вүйтэй байна. Ер нь одоо яривал энэ ямар танхимтай байх вэ, ямар засаглалтай байх вэ гэдэг асуудлаа л яривал яасан юм. Ийм л байна.

9-р тойргийн депутат С.Зориг:— Би тэр томъёог ерөөсөө ойлгохгүй байна.

—Дарааллаараа явъя.

55-р тойргийн депутат Ц.Адьясүрэн:
—Нэгэнт ерөнхий хэлэлцүүлэг хийнэ гэж тохирсон учраас ерөнхий л юм ярина шүү дээ. Энэ завшааныг ашиглаад ерөнхий юмаа ярьж. Тэгэхээр зэрэг энд хамгийн гол асуудал нь юу байх вэ гэхлээр зэрэг бид нарын үндсэн хуулийн гол цөм бол миний бодлоор засаглалын асуудал байгаа юм. Засаглалыг зүгээр өөрийнхөө бодлыг хэлэхэд бид улсын их хуралтай, Засгийн газартай байхаар л хувааж тогтоох нь зүйтэй байх, энэ дээр бол шүүх засаглал байна. Ерөөсөө Ерөнхийлөгчгүй байж гэсэн ийм хувилбарыг би энэ дээр хэлбэ гэж бодож байгаа юм. Ерөнхийлөгчгүй байх нь бол ямар давуу тал байна вэ гэхлээр зэрэг I-рт төрийн нэрийг илт гаргах боломж бол багасна. 2-рт нэг

хүний гарт их эрх мэдэл төвлөрч, дарангуйлал үүсэхгүй. 3-рт бол ерөнхийлөгчийн зүгээс Засгийн газарт хутгалдан орж тийшээ бол тийм дарамт үзүүлэхгүй, Засгийн газар харьцангуй биеэ дааж үйл ажиллагаагаа явуулах бололцоотой. 4-рт ерөнхийлөгчийн аппарат гээд парламентын хажууд тийм зэрэгцсэн аппарат ажиллахгүй болно. Ийм давуу талууд бас байгаа юм. Тэгэхээр зэрэг Улсын их хурлыг бол 2 танхимтай байх нь зүйтэй байх гэж үзэж байна. Дээд танхим, доод танхим гээд. Дээд танхим нь бол 60 орчим, доод танхим нь 40 орчим гишүүнтэй байх болов уу. Дээд танхимын гишүүдийг ард түмнээсээ шууд сонгодог, доод танхимыг бол намуудын нэрээр санал авдаг ийм танхим байх нь зүйтэй. Тэгэхдээ энэ 2 танхим бол хоёулаа ажиллана. Доод танхимаас гарсан хуулийг дээд танхим байнга хянаж баталж гаргаж байдаг ийм л байх юм бол зохистой гэсэн ийм бодол оруулж байна. 3 дахь нэг санаа бол Засгийн газрын гишүүн хүн бол Парламентын гишүүн байж болно. Энийг оруулах нь зүйтэй гэсэн санаа байна. Ингээд Улсын их хурлыг байгуулахдаа 4 жилийн хугацаагаар байгуулах нь зүйтэй гэсэн ийм санаа байгаа юм. За орон нутгийн засаг захиргааны хувьд одоонийхоор оруулж байгаа тэр аймаг, сум, баг гэдгээр нь үлдээх нь зүйтэй байх гэсэн ерөнхий санал бодолтой, энэ чинь ерөнхий хэлэлцүүлэг яаж байгаа шүү дээ. Эцсийн эцэст улсын нэр, улсын бэлгэ тэмдгийн асуудлаар бид харж үзэхгүй бол болохгүй. Энэ дээр хэрэв бид нар улсынхаа нэрийг солихгүй энэ бэлгэ тэмдэглэлүүдээ солихгүйгээр хэвээр үлдээчихвэл 70 жил ноёрхож ирсэн тэр хуучин тогтолцоогоо үнэндээ АИХ хүлээн зөвшөөрчихсэн хэрэг болно шүү. Хэрэв бид нар үнэхээр ардчилалд орж байгаа гэж үзэж байгаа юм бол энийг тодорхой хэмжээгээр солих шаардлагатай. Ийм л саналыг энэ дээр хэлбэ гэж бодож байна. Эцэст нь газрын асуудал байгаа. Газар дээр бол бид нар эргэж харах хэрэгтэй. Энэ Бага хурлаас оруулсан төслийг бол дэмжих шаардлагатай. Яагаад гэвэл бид нар бол зөвхөн тэр суурин, төв суурин газрын газрыг бол монгол улсын иргэн хүнд өмчлүүлж болно гэж энэ дээрээ байгаа. Бүлчээр болон бусад газрыг бол өгнө гэж байхгүй шүү дээ. Гэтэл тэр газрыг хэрэв өгөхгүй бол хуучин бид нар дундын улсын өмч гэсээр байгаад бүгдээрээ сүйтгээд тал талаас нь байгалийг сүйтгээд дуусч байна. Та нар УБ хот болоод бусад газруудын эргэн тойронд яваад үз. Хичнээн их газар болбол сэндийлж ухаж сүйтгэсэн байна вэ, хичнээн их газар хог шороо хаясан байна вэ,

ерөөсөө ямар ч эзэнгүй болгоод дундын өмч болгоод ингээд сүйтгэ-
чихээд байна шүү дээ. Гэтэл тэрнийг эзэнтэй болгоод монгол хүн
еерөө эзэмшээд ирвэл энэ шал өөр болох юм шүү. Энийг та бүхэн
бодоорой. Ингэж газрын үржил шимийг сүйтгэж болохгүй юм шүү.

327-р тойргийн депутат П. Энхсайхан: - Энд нэг 2 санал
хэлбэ гэж бодож байна. Парламентын бүгд найрамдах улс байна
гэдгийг дэмжиж байна, гэхдээ одоогийн энэ асуулт хариулт энэ
бүх мнаас хараад, ойлгоц авахад одоогийн Их хурал, Бага хурал
гэдэг энэ хэлбэр нь бол манай одоогийн яг хэлбэр бол нэг тан-
химтай гэдэг ойлгоцоор явах юм байна гэсэн ойлгоц орлоо. Тэгэхээр
зэрэг ер нь нэг танхимтайгаа байгаад их хурлын гишүүний тоог
үндсэндээ 2 дахин нэмэгдүүлж болох юм, тэрнээсээ бага хурлаа
сонгоод ингээд одоогийн хэлбэрээр бага хурлынхаа тайланг их
хурал нь сонсдог, ийм хэлбэр байж болохгүй юу гэж бодож байна.
Ер нь бол заавал хөгжилтэй орны гадаад Англи, Америк гэсэн
орны тэр 2 танхим энэ бүхнийг заавал хуулж тавьж байх шаард-
лагагүй, байх, өөрийн өвөрмөц нөхцөл онцлог байх болов уу гэж
бодож байна. Засаг захиргааны нэгж дээр бол бид ингэж ойлгож
байгаа. Ажлын эдийн засгийн цогцолбор байдал, нутаг дэвсгэр
хүн хүчний хуваарь өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэхэд одоогийн
байгаа аймаг нь багадаад байгаа юм уу, энийг бол аймгаа цөөлж
томруулах шаардлагатай гэж байгаа юм шиг байна. Дундын хэлбэр нь
2-3 сумыг нэгтгээд нэг хошуу болгоно гэж байгаа юм байна.
Зүгээр сум болгоныг хошуу болгоно гэж хавсралт хуульд заасан
шиг ингэх юм бол дотроо 2, 3 багтай сум байгаа, энэ дээр
миний эцсийн гол хэлэх гээд байгаа юм бол хошуу нь сумтай
байвал яасан юм бэ гэсэн ийм санал оруулж байна. Хот нь хороо,
хороо нь хоринтой байна гэж байгаа нь тэр хороо хорин гэдэг шиг
сум баг гэвэл олон түмний ойлгоцыг энэ илүү нийцэх болов
уу гэж бодож байна. Ийм л байна.

211-р тойргийн депутат:

-Дагвадорж:

-Өөрийнхөө ерөнхий гэж ойлгосон 4, 5 асуудлаар ярьж.
Газрын тухай төсөлд оруулж ирсэн саналыг дэмжиж байна. Бид
улс орноо хөгжүүлэх, урагш нь ахиулах тухай асуудлыг ярихдаа
нээлттэй эдийн засгийн бодлогын тухай гадаадын хөрөнгө оруулалтын

тухай ярьж байгаа. Бид гадаадын томоохон нэр бүхий пуус, газруудад газар түрээслэх эрх олгохгүйгээр дээрх асуудлыг шийдэх ямар ч арга байхгүй. Ийм учраас тэр үндэслэлээр нь тэр төслөө дэмжиж байгаа юм. Тэр, засгийн 3 гол өндөрлөгүүдийг эрх мэдэлд хуваах асуудлаар төслөөс эсрэг саналтай байгаагаа хэллээ. Энэ дээр би Америк маягийн 2 танхимтай, парламент, Засгийн газраа тэргүүцдэг Ерөнхийлөгч байх саналыг ярьж байна. Одоогийн төслөөр бол үндсэндээ өнгөрсөн I жилийн хугацаанд баримталж бидний ажиллаж байсан тэр тогтолцоог бараг хэвээр нь оруулаад ирчихэж. Их Хурлыг бага хурлаа л их хурал гээд нэрлэчихэж байгаа болохоос үндсэндээ хэвээрээ байна. Ийм тогтолцоо явцгүй гэдгийг өнгөрсөн жилийн туршлага харуулсан. Их хурал, бага хурал хоорондоо, бага хурал ерөнхийлөгч хоорондоо эрх мэдлээ булаацалдаж, эцэс сүүлдээ аягүй бол тодорхой асуудлаар түүхийн өмнө хариуцлага хүлээх газар, байгууллага, улс төрийн хүчингүүд болчихож мэдэхээр. Жижигхэн жишээ илэрч байна гэж. Тэр асуулт хариулахыг хэн нь хариулах вэ, ерөнхийлөгч үү, бага хурлын дарга уу гээд ингээд сэм будилад үлдээд байх жишээтэй. Иүгээд жижигхэн юмнаас эхлэх гээд байгаа юм. Ингэх дээр зэрэг эцэст нь ерөөсөөн улс орны өмнө түүхэн хариуцлагаа хүлээх үүднээс ерөнхийлөгч нь Засгийн газраа тэргүүцдэг, ийм Америк маягийн статустай парламент бүрдүүлэх ийм засаглал бүрдүүлэхийг сонирхож байгаа юм. За тэр аймаг, хошуу бага одоо орон нутгийн зохион байгуулалтын талаар санаагаа хэллээ. Тэр 30, 40-өөд онд 50-иад оны эхэн үед баг гэж ямархуу янзтай юм байсаныг яг мэдэхгүй юм, ер нь хүмүүсээс асууж мэдсэн хэмжээнд харьцуулж үзвэл өчигдөр тэр наг малчин депутат хэлсэн Дамдиндорж гуай, одоогийн сумын төв гэдэг чинь үйлчилгээнийл л төв юм. Тэгэхдээр хэрвээ багийн дарга байна гэж үзээд ажиллах юм бол баг чинь өөрөө нийтийн хурал зохион байгуулна гэж байгаа. Сум бол 3-5 мянга орчим хүнтэй. Нийтийн хурал хийнэ гэж байгаа. Нийтийн хурал чинь төлөөлөх үгээр 3 мянгыгаа цуглуулаад хурал хийгээд байж чаддаг болов уу. Тэр суманд байгаа сургууль, соёл, цэцэрлэг, эмнэлэг, шуудан холбоо, хоршоо худалдаа энэ бүгдийг ганц багийн дарга дороо аппаратгүй явж чадахгүй. Аппараттай байж таарна. Ингэх дээр зэрэг л одоогийн сумын захиргааны аппаратаа түшиглэсэн сумын даргаа багийн дарга гэж нэрлэсэн ийм л тогтолцоо бүрдэх гээд байна. За багийн дарга гээд нэрлэчихвэл

багийн даргад нь эрх мэдэл өгчихвөл тэр, засагтаа ойртно гэж, энэ худлаа. Одоогийн сумын дарга дорoo аппараттайгаар хурч чадаж байгаа юм чинь бага болгоод тавьчихвал бүр л холдоно гэсэн үг. Ийм учраас яг одоогийн байгаа тогтолцоогоор нь байлгахыг зүйтэй гэж үзэж байна. Мөн одоо Их хурлын гишүүний эрх үүрэгтэй холбоод нэг ийм асуудал байгаа юм. Тэр 3-ын I заалт, ард түмэн бол төрийн үйл хэрэгт өөрсдийн сонгон байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж заасан байгаа. Гэтэл Их хурлын гишүүний тэр статусыг тодорхойлохдоо улсын их хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг, сонирхлыг эрхэмлэнэ гэсэн болохоос биш эргэх холбоо нь байхгүй байгаа юм. Ийм учраас энэ дээр бол улсын их хурлын гишүүн тодорхой хугацаанд тэр 2 парламентын гишүүн аль нь ч байж болно. Тодорхой хугацаанд эргэж тойролтоо сонгогчдын өмнө тайлагнаж байх ийм үндсэн ийм асуудал байх нь зүйтэй гэж үзэж байна. Тэр янз бүрийн нэрүүдийн талаар шууд санал хураах ийм саналтай байна. Энийг бид янз бүрийн хэлэлцүүлгээр сониноор, хэвлэлээр тайлбараар олон сонслоо. 2 талаасаа ойлголтгоо ижилхэн авчих шиг боллоо. Бага хурал талаасаа ч тайлбарлачихлаа, нийт сонгогчид талаасаа ч ойлгочихлоо. Одоо ер нь энийнийгээ тэгээд ер нь санал хураагаад шийдчихвэл яадаг юм. Тэр шүүх эрх мэдэл дээд шүүхтэй холбоотой бас нэг асуудал байгаа юм. Дээд шүүхийн ерөнхий шүүгч бөгөөд шүүгчдийг шүүхийн ерөнхий зөвлөл их хуралд оруулна гэсэн байгаа юм. Ерөнхийлөгчтэй зөвшилцөж. Тэр ерөнхий зөвлөл гээч кмыг хаанаас хэн байгуулах гээд байгаа нь тодорхойгүй байгаа. Энийг эзэнтэй, тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа Ш: БУРМАА

1991.XI.15.
Кассет № 62
12.35-12.50.

418 дугаар тойргийн депутат Ж.Орсоо: -Тэгэхээр энэ ерөнхий хэлэлцүүлгээр асуудлын ерөнхий чиг хандлагыг сонсох гэж байгаа болов уу гэж ойлгоод бүлэг тус бүр дээр саналаа ярьж гэж бодож байна, ер нь ямар байгаа.Ухаан нь энэ дээр бол төрийн бэлгэдлийн асуудлыг ярихгүй бол болохгүй.Ард түмэн ч энийг хүсэн хүлээж байгаа шүү дээ.Энийг зүгээр нэг кноп дараад шийдчихнэ, энийг больё гэж болохгүй.Ямар ч байлаа гэсэн депутатуудын санал хэрэгтэй байх.Хэн нь юу гэж бодож байгаа, сонгогч нь юу гэж хэлж явуулсан юм.

Энэ дээр би эхлээд хэлье.Төрийн бэлгэдэл, тэмдэг, улсын нэрийн тухайд.Тэгэхээр сонгогчид бидэнд хэлэхдээ БНМАУ гэсэн энэ нэрээ битгий өөрчлөөрэй гэсэн.Тэгэхээр надад ийм санал байна, энийг өөрчлөхгүй байя.Их цааз гэдэг Үндсэн хуулийн нэрийг "Үндсэн хууль" гэдгээр нь авъя.Одоогийн байгаа сүлдээ өөрчлөхгүй байя.Энэ дээр би ийм саналтай байгаа юм.Энийгээ хэлье.

Дараа нь газрын асуудал байна.Газрыг хувийн өмчид өгөх тухай асуудал.Энэ дээр бол газрыг хувийн өмчинд өгөх тухай асуудал дээр нэлээн нухацтай яримаар байна.Миний өөрийн депутатын хувьд санаж байгаагаар бол санал ийм байна.Их цаазын I дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн I-д байгаа заалтыг "БНМАУ-ын газар, түүний баялаг гагцхүү ард түмний мэдэлд улсын онцгой өмч байна" гэж томъёолмоор байна.

6 дугаар бүлгийн 5-д байгаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүст газрыг түрээслүүлэн эзэмшүүлэх асуудал.Энэ дээр ихээхэн нухацтай тал талаас нь ярих хэрэгтэй байх.Энийг зөвшөөрч өгснөөрөө Монгол орны эдийн засагт чухал ийм үр нөлөө байж болох юм, энийг үгүйсгэхгүй.Гэлээ гэхдээ энэний цаана бид гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүст газраа түрээсээр өгчихөж.Энд томоохон пуус, компанийн мэдэлд түр зуур ч гэлээ гэсэн орж энд барилга байшин, байгууллага бариад эхэлжээ.10, 20, 30 жилийн дараа байдал ямраар өөрчлөгдөх юм, яах юм бэ гэдгийгээ одооноос бодох хэрэгтэй байх.Тэгэж байж

энэ асуудлыг шийдэхгүй бол Их цаазын төслийн хувилбараар хам хумхан шийдэж болохгүй гэж үзэж байгаа юм.

Миний хувийн санал бол энэ заалтыг хасах саналтай байгаа хүн.

Засаглалын хэлбэрийн хувьд бол парламентын засаглал байх нь зүйтэй гэж үзэж байгаа. Парламентын засаглал байхад хоёр танхимтай, Их Хуралтай, Бага Хуралтай. Их Хурал бол 120 гишүүнтэй, Бага Хурал бол 50-иад гишүүн, одоогийн байгаа гишүүнтэй болох юм гэсэн санал байгаа юм. Ингээд Бага Хурал бол Их Хуралдаа тайлагнаж байдаг, ажлаа.

Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарыг орон тооны хүмүүс байлгах асуудлыг энэ дээр авч хэлэлцэж болохгүй юу. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бол төрийн дээд эрх барих байгууллагаас орон нутгийн гүйцэтгэн захирамжлах байгууллагууд хоёрын хооронд ерөөсөө холбоо муу явж ирсэн гэж үзэж байгаа. Ийм учраас энэ бол ороны тооны байг. Нэлээн хүчтэй-хэн арга хэмжээ авч, хууль цаазынхаа биелэлтэд хяналт тавьж энийг биелүүлэх асуудлыг олон түмэнтэй нягт холбож өгмөөр байгаа юм. Ингэж чадалгүй явж ирсэн. Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд бол төсөлд байгаа саналыг дэмжиж байна.

Энэний дараагаар шүүх засаглалын асуудал байна. Шүүх засаглал шүүгчдийг ямар ч хугацаагүйгээр томилохоор энд орсон байна. Анхны Үндсэн хууль хэлэлцүүлгээр бол 12 жил бил үү нэлээн удаан хугацааны жил заасан байсан. Энийг хөдөлмөрчдөөс хэлэлцүүлэхэд ийм удаан хугацаагаар байж болохгүй. Тийм учраас энийн хугацааг наашлуулъя гэдэг санал хөдөлмөрчдөөс тавиад байхад энэ төсөл дээр ерөөсөө хугацаагүй сонгохоор байгаа.

Тэтгэл энэ шүүх засаглалын хэрэг мөрдөх, ял төлөвлөх энэ асуудал дээр нь хяналт тавьдаг прокурорын байгууллагыг 6 жилийн хугацаагаар томилж байна. Тэгээд хяналт тавих байгууллагыг 6 жилийн хугацаа өгч томилоод дараа нь шүүхээ хугацаагүй байдаг нь ямар учиртай юм бэ? Энэ дээр хугацаа

заах нь зүйтэй.Хугацаатай томилох хэрэгтэй гэсэн саналыг оруулж байна.

дараачийн санал бол орон нутгийн засаг захиргааны нэгж.Өнөөдөр манай улсын эдийн засаг ямар байна.Хөрөнгө, мөнгө маань ямар байна вэ? Юу юугүй орон нутгийнхаа одоогийн бүтцийг эвдэхээр, тэрийг өөрчлөхөөр бид өнөөдөр ярихад хэцүү байна.Аймгийг нэгтгэх, сумдыг нэгтгэж хошуу болгох энэ асуудлууд.Энэ үнэхээр хэцүү.Энийг ард түмэн үнэхээр сэтгэл эмзэглэн харж байгаа, сонсож байна, сумыг маань нэгтгэх үү, яах нь вэ гэж.Энийн урьд хоёр сум нэгдээд одоо болтол шийдэж чадаагүй, дахин сумыг минь байгуулж өгөөч гэдэг хүсэлт аягүй бол Их Хурал руу ирж байгаа ийм юм бий шүү.Гэтэл дахиад энийг одоо хошуу болгоод ингээд гурван сум нэгддэг юмуу, дөрөв сум нэгддэг юмуу, иймэрхүү байдлаар ярихад хэцүү байна. Ийм учраас энэ дээр депутатууд анхаарлаа хандуулж өгч үзээрэй.Ерөөсөө засаг, захиргааны нэгжийг одоохондоо хөндөхгүй орхъё.Энийг нэлээн хугацааны дараагаар авч үзэж болохгүй юу. Улсын эдийн засаг энэ хямралаас гараг.Хөрөнгө нөөцтэй болог. Энэ асуудлыг шийдэх боломжтой болсон үедээ эргэж авч үзэхэд энэ болохгүй гэх газаргүй гэж бодож байна.

407 дугаар тойргийн депутат Б.Нүүрэй: -Улсын нэр, сүлдийг өөрчлөх, Үндсэн хуулийн нэрийг өөрчлөх асуудлын талаар өмнөх депутатуудын саналтай нэг байна.Энэ талаар Бага Хурлаас оруулж ирсэн санал, Бага Хурлын гишүүдийн тайлбар өгч байгаа асуудал, энэ бол миний хувьд хангалтгүй мэт санагдаж байна.

Ингээд газрын талаар нэгдүгээрт, саналаа хэлье. Тэгэхээр газар өмчлүүлэх, түрээслүүлэх асуудал бол манай газар нутгийн 0,3 хувийн асуудал яригдаж байна.Цаана нь 99,7 хувийн газрын баялгийг ашигтай эзэмших, оновчтой ашиглах талаар энэ асуудлыг Үндсэн хуульдаа оруулж тавих асуудал юм.Газрыг эзэмших, өмчлүүлэх нь нийт хүн амын 0,5 хувийн асуудал байна.Тийм учраас энэ асуудал бол нийт ард түмний нийтлэг эрх ашгийг харуулсан ийм асуудал

биш ээ. Ийм учраас Үндсэн хуулиас энэ асуудлыг хасч энэ асуудлыг бусад хууль эрхийн актаар зохицуулах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Хоёрдугаарт, төрийн байгуулалтын хувьд. Төрийн байгуулалтын хувьд хоёр танхимтай, парламентын засаглалтай ийм байгуулалттай байвал зүгээр юм гэж бодож байна. Тэгэхдээ хоёр танхим бол бие биенээсээ тусгайдаа хоёр танхим биш, нэг нь нөгөөдөө захирагддаг, одоогийн зохион байгуулалттай төсөөтэй ийм танхим байх нь зөв юм гэсэн бодолтой байна.

Хурлын үргэлжлэх хугацаа. Бүх шатны хурлыг би 4 жилийн хугацаатай байх нь зүйтэй юм болов уу гэж бодож байна. Мөн Үндсэн хуулинд байгаа Ардын Их Хурлын гишүүдийн цалин, шуугчдийн цалин хөлсийг энд дурдсан байна. Зарим, энэ дээр миний бодол нийгмийн шударга ёс алдардаж байна гэж үзэж байна. Зарим гишүүд нь, зарим хөдөлмөр хийж байгаа гишүүд нь болохоор өндөр хангамжтай, цалин авч байдаг. Гэтэл хөдөлмөрийн хууль дээрээ заагаад өгөхөөр ажилчин, малчин, сэхээтнүүд өөрийнхөө хөдөлмөрийн хөлсийг авч байдаг. Энэ хоёр асуудал бол хоорондоо зөрчилдөж байгаа учраас энэ бол хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан хууль биш ээ. Нийт ард түмний, нийтлэг эрх ашгийг хамгаалсан ийм хууль байх ёстой учраас цалингийн асуудал, хангамжийн асуудлыг заавал Үндсэн хуульд тусгаж баталгаажуулах хэрэг байхгүй. Энэ асуудлыг бусад хуулиар зохицуулж болох учраас хасах саналтай байгаа юм.

Засаг захиргааны хуваарилалтын асуудал. Засаг захиргааны хуваарилалтаар бол одоогийн байгаа сум, аймгуудын засгийн хуваарилалт бол үйлдвэрлэх хүчний хөгжил байршлын асуудалтай зөрчигдөж байгаа гэж ярьж байгаа. Гэтэл үнэн хэрэгтээ шинжлэх ухааны үндэстэйгээр энийг гаргаж тавьсан, судалсан асуудал бол өнөөдөр бас л байхгүй. Сум байгаад хошуу болоход ямар эдийн засгийн үр ашиг гарах юм. Аймгуудыг нэгтгэснээр ямар эдийн засгийн үр ашиг гарах юм. Үйлдвэрлэх хүчний хөгжил байршлын схемийн хувьд энэ талаас авч

үзсэн асуудал байхгүй учраас энийг авч хэлэлцэх үү, үгүй юу, Үндсэн хуульд тусгах уу, үгүй юу гэдгийг авч хэлэлцэх асуудал гэж үзэж байна.

Хамгийн сүүлд хэлэхэд, бид нар ямарваа нэгэн асуудлыг оруулж ирэхдээ Засгийн газар, Бага Хурлаас оруулахдаа урьдчилсан шинжлэх ухааны үндэслэлтэй, өөрийн орны эрдэмтэд, мэргэдийн саналыг тусгасан тийм буурьтай суурьтай судалгааны асуудал их дутагдалтай байна.

Ардчилалд орно гээд ард түмнийг хошууруулсан, үнэн хэрэгтээ ямар хэлбэрээр орох вэ, манай орны өвөрмөц нөхцөлд ардчилал яаж хэрэгжүүлэх вэ энэ бол тодорхой судалгаа байхгүй. Өмч хувьчлуулна гээд одоо явагдаж байдаг, энэ бол ард түмний бодит амьдралд тохирохгүй ийм асуудал явагдаж байна. Ард түмний сэтгэл санаа энд бол бодит амьдралын түвшинг харгалзах талаар бас их дутагдалтай байна.

Их цаазад тусгагдсан газар өмчлүүлэх, түрээслэх асуудал бас л ийм байдалтай орж ирж байна. Мөн төрийн тогтолцооны асуудал ч гэсэн, засаг захиргааны хуваарилалтын асуудал ч гэсэн бас л урьдчилсан буурьтай, суурьтай судалгаа хийсэн асуудал маш хангалтгүй байгаа. Ийм учраас ийм нарийн асуудлыг энэ дээр бид нэлээн нухацтай авч үзэх ёстой гэсэн ийм л саналтай байна.

350 дугаар тойргийн депутат Ц. Давааням: -Төрийн тогтолцооны хувьд одоогийнх шиг зохион байгуулалттай байх нь зүйтэй. Гэхдээ хоёр зүйл дээр энд анхаарвал яасан юм бэ гэсэн санал байна.

Нэгдүгээрт, гишүүдийн тоо цөөхөн байна. 70 гэдэг бол шаардлага хангах тоо биш ээ гэж депутатын хувьд үзэж байна. Ийм учраас 150-аас доошгүй байх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгчид өгөх эрх мэдэл нь одоо-

гийнх шиг биш баймаар байна. Жишээлбэл, Засгийн газар дам-
пуурч байдаг, унаж байдаг, дураараа авирлаж байдаг асуудал
их гарч байна. Энийг Ерөнхийлөгч гайхаад суугаад байх юмуу,
та нар мэд гээд эрх мэдлийг нь олгоод ажиглаад суугаад
байх юмуу, зогсоох юмуу, ийм байдлаар Монгол улсын нэгдүгээр
зэргийн хүн бол хэн бэ? Тэр хүн бол шууд мэднэ, чадна,
шийдэж байдаг, үүнийхээ төлөө хариуцлага хүлээхэд ч бэлэн
байдаг ийм тогтолцоог өгөхгүй бол өнөөдрийн байдалд хүргэж
байна.

Хоёрдугаарт, засаг захиргааны нэгжийн хувьд дээрх
хүмүүсүүд ярилаа. Бас давхардуулах шаардлагагүй юм. Дахин
хөдөө ажиллаж байдаг хүний хувьд хэлэхэд өнөөдрийн сумын
захиргааны албан хаагчид хичнээн байгаа билээ, тэд яаж
ажиллаж байгаа билээ. Ингээд үзэхэд байдал дээрдэхгүй байгаа.
Гэтэл цаацдаа хошуу болгож төвлөрүүлээд, төрийн аппаратуудыг
төвлөрүүлээд байх юм бол орон нутаг бол төр орон нутгаасаа
нэлээн тусгаарлагдана, сална гэсэн ийм бодолтой байна. Ийм
учраас хошууны зохион байгуулалтыг, зөвхөн Үндсэн хуульд
тийм нэр оруулснаар нь маргааш гэнэтхэн зарлиг гараад хошуу
болгоорой гэдэг ийм шийдвэр орон нутагт бид аваад байгаа
шүү дээ. Ийм учраас энийг болсон цагт нь хэлдэг ямар арга
байдаг юм. Энэ талын юмыг бодохгүй бол болохгүй байна.

Дараачийн нэг асуудал бол саяын дээр гарсан сүлд, туг,
далбааны тухай асуудлууд байна. Ер нь танайх туг чинь муухай
байна, сүлд чинь муухай байна, сольсон цагт харьцая гэж
байгаа орон байхгүй байх гэж бодож байна. Ийм учраас энийг
задлаад солих манай эдийн засгийн чадавхи байхгүй байгааг
харгалзаж үзээд түр хойшлуулбал яасан юм бэ? Хуучин хэвээр
нь хэрэглэвэл яасан юм бэ гэдэг санал байна.

Жишээлээд би ярья, тэр сүлдэн дээр байгаа шувуу сэг
дээр суусан хон хэрээ шиг юм надад бодогдож байна. Ийм учраас
бидний сэтгэл санаанд байгаа сайхан сүлдээрээ байя. Энд
өчигдөр Гончигдорж дарга хэллээ. Болохгүй юм гэж байхгүй.

Одоогийн сүлд, далбаа, туг болж л байгаа. Болж байгаа юм бол одоо жаахан байвал яасан юм бэ? Хүчин чадалтай болж авч байж солих тухай асуудлыг яривал яасан юм бэ гэсэн саналтай байна.

дараа нь газрын тухай асуудал байна. Газрыг хэзээ ч хувьд худалдаж болохгүй улсын онцгой өмч байлгах талаас нь би саналтай байдаг хүн. Яагаад гэвэл, өнөөдөр газар худалдаж авсан хүн чинь 5-10 жилийн дараа гадаадын ямар нэгэн иргэнд мөнгөний шаардлагаар, нэгэнтээ би худалдаад авчихсан газар учраас ямар ч үнээр хамаагүй худалдахад би бэлэн байна, яаж зарцуулах нь миний мэдлийн асуудал гэж худалдчихвал яах вэ? Ер нь зохицуулах хууль гарах байх. Гэвч энэ асуудлуудыг, онцгой өмчийнх нь хувьд улс гартаа авбал яасан юм бэ?

Бусад асуудлуудын талаар шууд санал хураахад болохгүй юм алга аа. Бүтэн зунжин ярилцлаа, хэлэлцлээ, ойлгомжтой болж байна гэж үзэж байна.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Б.Очирбат /230 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр энэ түүнийн депутатуудын хэлсэн улсын нэр, хуулийн нэр, бэлгэ тэмдгийн зүйл дээр хуучин нэрээр нь байя гэсэн ийм саналтай байна. Яагаад вэ гэхээр манай Бага Хурлын гишүүд, бусад хүмүүсээс тайлбарласан тайлбар дотор үнэхээр болохгүй, бүтэхгүй болчихсон юм алга байна. Зүгээр өчигдөр сүлдийг тайлбарлаж байхад, болохгүй ноцтой юм нь энэ ЗХУ-ын бүгд найрамдах улсуудынхтай адил болчихсон гэсэн ийм юм нь болохгүй юм шиг юм хэлнэ билээ. Энэ зөвлөлттэй ижил болчихсон юмаа бид цөмийг нь өөрчилнө гэвэл биднийг нас хүрэхгүй. Бүх юм ижил. Ийм учраас энийг хуучнаар нь байлгах нь зүйтэй болов уу. Энэ олон түмний санаа бодлыг харгалзаж үзэх нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байна.

Хоёрдугаарт, хүний эрхийн талаар урьд өмнөх Үндсэн хуульд тусаж байгаагүй олон сайхан тусчээ. Энэ их зүйтэй. Зөвхөн энийг одоо баталгаатай хангах тийм эрх мэдэл, хөрөнгө, бололцоог тэр, засгийн газартаа өгч, энэ эрхийг хангуулах асуудал бол чухал байна. Хий хоосон Үндсэн хууль дээр тунхагласан тийм хоосон, урьдын адил хоосон эрх үлдвэл энэ бас учир дутагдалтай болно гэдгийг хэлэх байна.

Нөгөө талаар хүний эрхийн асуудалд байж байгаа хөдөөний хөдөлмөрчид энэ Үндсэн хуулийг нэлээн нарийн судалсан байгаа. Ухаан нь тэр хүний эрхийн асуудалд хүн боловсрохдоо ерөнхий боловсролын сургуульд үнэ төлбөргүй боловсрол олгоно гэсэн, энэн дээр чинь ухаан нь ингээд үзэхэд чинь зөвхөн багш нарын мөнгийг өгөхгүй, нөгөө дотуур байрны хүүхдийн чинь хоолны үнэ, байрны үнийг авах болоод байгаа юм шиг байна шүү энэ чинь гэж хэлж байгаа юм. Яг уншихаар бас тийм байдал агуулагдаж байгаа учраас энэ зах зээлд шилжиж байгаа үед тэр хүнийг сургах энэ эрхийг нь бүрэн дүүрэн эдлүүлэхэд төрөөс их анхаармаар ийм зүйл тэрэн дээр тусгах нь зүйтэй гэж бодож байна.

Мөн тэр төрийн байгуулалтын хэсэгт байна. Энэн дээр бусад, түрүүчийн депутатуудын ижил хоёр танхимтай байх энэ асуудал чухал юм. Ер нь ярьж байгаад тэгш эрхтэй хоёр танхим байх юм уу, нэг нь нөгөөгийнхөө удирдлагад байх ийм танхим байх юм уу гэдгийг депутатууд ярьж байж зохицох нь зүйтэй гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүний насны талаар бас нэлээн ярьж байгаа. Энэ нас Их Хурлын гишүүдийн насыг 25-аас гэсэн байгаа юм. Энэ насыг өнөөдрийн Бага Хурал бүрэлдүүлж байгаа гишүүдийнхээ настай харгалзан үзэж энийг ухаалаг тогтоож өгөх нь зүйтэй шүү гэж хөдөлмөрчид их үзэж байгаа. Энийг бас харж үзэх нь зүйтэй болов уу гэсэн ийм санал байгаа юм.

Шинэ Үндсэн хуулийн төсөлд Засгийн газрын талаар зүйлүүд орсон байна. Тэгэхээр Засгийн газрыг ажиллах бололцоогоор хангах тал дээр энэн дээр бас нэлээн анхаарч үзвэл зүйтэй гэсэн ийм ерөнхий санал байна. Одоогийн байдлаар үнэн хэрэг дээрээ манай Засгийн газрын бодлого, Бага Хурлын бодлогууд чинь зарим үед зөрөөд байна. Дэмжихгүй байна. Ийм учраас энэ бодлого Засгийн газрын зөв бодлогыг дэмжиж, тэрний үйл ажиллагаанд Ерөнхийлөгч болоод Бага Хурлын зүгээс зохих ёсны дэмжлэг үзүүлж байх талаар Үндсэн хуульд тусгах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Дөрөвдүгээр бүлэгт энэ засаг захиргааны нэгжийн талаар нэлээн учир битүүлэг зүйлүүд орсон байна. За энэн дээр тэр хошууг би зөвшөөрч байдаг хүн хувьдаа. Гэхдээ энэ цаг нь болоогүй, одоо энэ Үндсэн хуулийн нэмэлтэд 1995 оноос гээд ингээд заачихвал олон сум энэ 1995 оноос чинь наана алга болно шүү. Энийг тэгж он тодорхой заах хэрэг байгаа юм уу. Ер нь хошуу болгох асуудлыг дороос нь хөдөлмөрчид, ард түмнээс саналыг нь аваад дээрээ шийдвэрлэвэл ямар байсан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм.

Мөн тэр аймгийн Засаг даргын тухай асуудал байна. Энэ

3.

томилгох, баталгаатай болгох хэлбэрийн юм орсон байна. Энэ бол одоо аймаг, орон нутгийн засаг захиргааны удирдлагыг туйлын тогтворгүй болгох ийм төсөл байна. Гурван жилийн хугацаатай, Хурлаас тавьсан шийдвэр биелэхгүй бол огцрох, тэгвэл одоо энэ бүтэхгүй л ийм асуудал байх юм. Энийг тэр зүйл анги дээр нь тодорхой ярина.

Суулчийн нэмэлт хуульд нэг зүйл байна. Энэ Үндсэн хуулийг өөрчлөхөд ер нь хэдэн танхимтай байсан ч тэр одоо Их Хурлын гишүүд өөрчилнө гэсэн ийм зүйл байна. Энийг би санал нийлэхгүй байна. Үндсэн хуулийг өөрчлөхөд Их Хурал хичнээн гишүүнтэй байсан ч тэр гишүүдийн тоотой тэнцүү хэмжээний хөдөлмөрчдийн төлөөлөгчдийг оролцуулсан ийм бүрэлдэхүүнээр Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж өгөх талаар Үндсэн хуульд тусгах хэрэгтэй гэсэн ийм санал байна.

Т. Ядамсүрэн /71 дүгээр тойргийн депутат/ - Үндсэн хуулийн төслийн комисс, Улсын Бага Хурлаас оруулсан төсөлтэй танилцлаа. Их хөдөлмөр зарсан байна. Гэвч хуулийг боловсруулахад хэдэн зуун жилийн өмнөхийг сэргээх гэсэн нэг хандлага, эсвэл хэт ирээдүй рүү хол харсан бас нэг хандлага хэт давамгайлаад, өнөө үеэ багахан харж байна уу гэсэн ийм сэтгэгдэл төрж байна. Ийм учраас ирээдүй, одоо, өнгөрсөн гурван цагаа шүтэлцэж байгаад, энэ орон зай дотор нэлээн ухаалаг бодож энэ хуулийн төслийг ярих нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд нэгдүгээрт би, улсынхаа нэрийг Бүгд Найрамдах Улс гэсэн нэртэй байлгах нь зүйтэй гэж үзэж байгаа. Аливаа юм тодорхой нэг нэртэй байдгийн учир ялгарддаг ийм онцлогтой. Ийм учраас олон монголын дотроос бүгд найрамдах гэдэг нэрээр бид ялгагдаж явах нь зүйтэй гэдэг энэ ард түмний санал, хүсэлтийн талд байна.

Гэвч ард гэдэг улсыг хасах ёстой /үгийг/. Ард гэдэг үг бол ангийн чанартай үг юм. 1924, 1940 оны үед баталсан хуульд

нийгмийн байдлыг ард тайж, ван, гүн, хутагт, хувилгаад гэж тодорхойлж байсан. Энэ ангийн ялгаанууд алга болсон юм 1940-өөд оны үед. Өнөөдөр бидний дотор саятан төрөөд гарна. Лам нарын бүтэн анги буй болж байна. Хутагт хувилгааднууд тодрох ийм процесс явагдаж байна. Ийм учраас энэ ард гэдэг үг бол аяндаа өөрчлөгдөх ийм шаардлагатай учраас, ард гэдэг үгийг хасаад Бүгд Найрамдах Монгол Улс гэж нэрлэх ийм саналтай байна.

Хоёрдугаарт, хуулийн нэрийг Үндсэн хууль гэх нь зөвөө. Үндэстэй бүхэн үржин төлждөг жамтай. Бид монгол хүний амны билгээр билэгшээн үеийн үед үржин төлжих бэлгэ дэмбэрлийг бодож хуулиа Үндсэн хууль гэж нэрлэх ийм саналтай байна. Энэ үүднээс төрийн маань дараа дараачийн хуульд нь үржиж төлжих ийм бэлгэ дэмбэрэл оршиж байг гэж, энэ санааны үүднээс хэлэх гэсэн юм.

Гуравдугаарт, улсыг тусгаар тогтнол, бүрэн эрхийн бэлгэ тэмдэг, төрийн сүлд, туг, тамга, дууллаа одоо хамтынхаа оюун ухаанаар бид улсынхаа зан заншил, түүх, соёл, бэлгэ дэмбэрлийг нь бодож, одоо, ирээдүй энэ цагаа харьцуулан үзэж, зарим өөрчлөлтийг хийх нь зүйтэй гэдэг талд байна.

Хуулийн төсөлд байгаа шувуу, шувуунд таван сум атгуулсныг төрийн бэлгэдэл болгож хэрхэвч болохгүй. Өүлэн ээж бидэнд таван сумаараа эв нэгдлийг илэрхийлж, хойч үедээ, ухаант хүмүүсдээ том гэрээслэл үлдээсэн. Ийм учраас энийг өөрчилж, монгол хүний хийморь, цол золыг бадраасан ямар ч байсан морио сүлдэндээ үлдээх нь зүйтэй гэсэн энэ санал бодолд байж байгаа.

Төрийн далбааны хувьд бид одоо энд хоёр өнгө байгаа. Эндээс сүүн цагаан өнгөө нэмье. Монгол хүний сүүн цагаан өнгө нь сэтгэлийн бэлгэдэл болж яваг. Ийм саналтай байна.

Энэний дараа энэ хуулиуд маань хууль зүйн баталгаагүй болчихвий гэсэн ийм сэтгэл надад их бодогдож байгаа. Бид ба-

талгаагүй хууль гаргачих юм биш байгаа гэсэн. Жишээ нь энд нэг ганц иргэний эрхэн дээр, хүний эрхийн асуудал дээр байгаа. Амьд явах эрхтэй гэж ингэж заасан. Зөвхөн үүнд олон баталгаа шаардаж байна. Тухайлбал, танхай балмад үйлдлээс болоод хүний амь нас өнөөдөр хохирч байна. Энэнээс хамгаалах ямар баталгааг төр бий болгох вэ?.

Хоёрдугаарт, энэ эмнэлгийн үйлчилгээ дутмаг, түргэн тусламжийн тэрэг, машин хүрэлцэхгүй байгаагаас хөдөө орон нутагт олон хүний амь нас хохирч байгаа. Тэгвэл үүний хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Өнөөдөр төр, ард түмний өмнө хариуцлага хүлээж байна гэж ийм хууль гаргаж байгаа. Тэгвэл хүн нас бараад энэ эрхээ эдэлж чадахгүйгээс болоод нас барсан тохиолдолд энэнийг сумын захиргааны дарга хариуцах юм уу? Аймгийн дарга хариуцах юм уу? Ерөнхий сайд хариуцах юм уу гэдэг үг гарч ирнэ. Энэ байдлаас аваад үзэхэд хуулийг бол ямар ч баталгаагүй, ийм тунхаглалын чанартай хууль гаргаж хэрхэвч болохгүй. Түрүүн Ерөнхийлөгчийн илтгэлд өнгөрсөн далан жилийн хууль тунхаглалын чанартай байсан гэсэн. Энэнд бидэнд баталгаа байхгүй. Хэзээ ийм баталгааг бий болгоно гэдэг тийм эдийн засгийн суурь бааз байхгүй учраас, зарим юмыг хэтэрхий олон улсын жишиг ийм байна гэдгээр урагшаа хамаагүй том алхвал сүүлдээ бид энэний хариуцлагыг, депутат бид хүлээх болно гэж үзэж байна.

Нөгөө талаар Ерөнхийлөгчөөс Засгийн газрыг хөндийрүүлчихсэн ийм явдал нэлээн байх шиг байна. Засгийн газрын эрхийг гүйцэтгэн захирамжлах гэдэг эрхээр нэлээн хязгаарлаад Улсын Бага Хурал, Их Хурал маань хамаг хууль үйлдвэрлэдэг төр ачаагийг нь үүрч явдаг ийм хэлбэр рүү шилжчих гээд байгаа ийм төслийн юм бодогдож байгаа. Ийм учраас энийг анхаарч үзэх ёстой болов уу.

Нөгөө талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд хийсэн хүн бүр шүүхийн өмнө адил тэгш эрхтэй байна гэсэн. 17-гийн хоёрт

хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно гэж заасан. Гэтэл 29 дүгээр зүйлийн гуравт Ардын Их Хурлын гишүүн гэмт хэрэг зөрчилд холбогдсон тухайд гарцхүү Ардын Их Хурлын чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн хуулийн дээрх заалтыг зөрчиж, онцгой эрх тогтоосон нь зарчмын хувьд буруу байна гэж ингэж үзэж байгаа.

Төрийн тогтолцооны хувьд парламентын төр байлгая. Хоёр шаттай байлгая. Улсын Их Хурлын гишүүдийн тоог 100-110-аас хэтрүүлэхгүй байя. Улсын Бага Хурлын гишүүдийн тоог 25-30-ийн дотор байлгах нь зүйтэй. Хугацааг дөрвөн жилээр болгоё. Сольё гэдэг, шинэчилье гэдэг тийм утга агуулгыг тусгай байх нь зүйтэй болов уу гэсэн ийм санал байна.

Ж. Уртнасан - За баярлалаа депутат нөхөд өө. Бид одоо дэгийн дагуу завсарлах болж байна. Зарлалын чанартай гурван зүйл байна. Сонсоно уу.

Өнөөдөр 14 цагт Монголын ардчилсан намын бүлгийн депутатууд "ж" зааланд цугларна уу гэж зарлаж байна.

Үдийн завсарлагын дараа 14.30 цагт МАХН-ын бүлэг "з" танхимд цугларахыг зарлаж байна.

Одоо депутатын хорооны 21 гишүүн энд үлдэнэ уу.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Эваснофф

Д. БАЯНДУҮРЭН

Бичээч Уранчимэг

Ж.Уртнасан -Одоо бид дэгийнхээ дагуу ерөнхий хэлэлцүүлэг явж байна.Нэрийн жагсаалт гарчихсан.Тэгэхээр бид бас нэлээд хэдэн хүн үг хэлсний дараа санал давхардвал зарим хүмүүс нэрээ татаж авах байх гэсэн ийм бодолтой байгаа байх.За одоо хуралдаанаа цааш нь үргэлжлүүлье.Гуравдугаар микрофон Батмөнх.

С.Батмөнх /2 дугаар тойргийн депутат/ -Их цаазын төслийг үзэхэд яахав их олон шуултуурээр орсон нь ойлгомжтой байна.Анх гарч байсан төсөл, бидэнд тараасан сая "Ардын эрх" сонинд гарсан энэ төсөлтэй харьцуулахад үнэхээр их өөрчлөгдсөн байгаа.Ер нь бол улсын нэрэн дээр ярья гэж санаж байгаа.Энэ бол элдэв тодотголгүйгээр монгол улс гэж байх нь зүйтэй болов уу гэж санаж байна.Их цаазын төсөл гэдэг бол үнэхээр өнөөдрийн ард түмнийхээ бид бол санал хүсэлтийг харгалзах ёстой.Энэ бол Үндсэн хууль байхад аль ч талаараа төдийлөн харшлахгүй гэж бодож байна.Энэ бол Үндсэн хуулиараа байж болно.Үгүй юм бол Их засаг гэдэг үг дээр тухайн үед нь ярьж болох юм гэж санаж байна.

Их цааз гэдэг, ялангуяа бидний энэ байгуулж ирсэн нийгэмтэй холбогдоод цааз гэдэг үг бол үнэхээр хүмүүст их өөрөөр бууж байгаа юм.

Сүлд тэмдгийн онцлогийн тухайд бол бид сая кино үзсэн.Надад бол үнэхээр буухгүй байгаа.Би бол сэтгэлгээний хувьд хоцрогдсон хүн гэдгээ сая ойлголоо.Энэ шувуу бол үнэхээр буухгүй байгаа.

Бид одоо жишээ татах дуртай, америк улсын төрийн бэлгэдэл их олон талаараа санагдаад байгаа шүү дээ.Та бүхэн тэр дээд талынх нь таван хошуунуудаас эхлээд харах хэрэгтэй.Энэ бол яг л тэр бусад улсын юмтай их ойролцоо, дүйгээд байгаа.Тэр дээр үед байсан монгол улсын цагаан шувуу гэдэг чинь

бас арай өөр юм шиг харагдаад ингээд ерөөсөө болохгүй байгаа учраас би энэн дээр эргэлзчихээд гэх юм уу, ер нь бол шувуу бол яаж ч сайнаар бодоод, нэлээн тайлбарласан улсуудынх нь ихэнхийг таньдаг, адилхан уран бүтээлч гэж бодлоо ч гэсэн ерөөсөө буухгүй байгаа юм. Энийг маш сайн бодох хэрэгтэй.

Ер нь тэр далбааны хувьд харин их дэмжиж байгаа. Бид бол үнэхээр юмыг өөрчлөхийн тулд өөрчлөх биш, энэ өндөр гэгээний үеэс тэрт ёсны олон зуун жилийн уламжлалтай монголын ард түмний цаг хугацааны шалгарлыг даваад ирсэн тэр алтан соёмбо гэдгийг үнэхээр дээдлэх нь зүйтэй. Тийм учраас би бол тэр соёмбо тэмдэгтэй тэр далбаа байхыг зөвшөөрч байна.

Парламентын засаглалыг дэмжиж байна. Улсын Их Хурал хоёр танхимтай байхыг үгүйсгэж болохгүй байгаа. Тэгэхдээ энэ хоёр нь ажлаа бие биедээ тайлагнадаг, одоогийнх шигээр ингэж байх нь ер нь одоогийн байдлаас харахад нэлээн үрэлгэн, бүтээлийн хувьд төдийлөн сайнгүй юм уу гэж харагдаж байгаа. Гүрүүн ч гэсэн улсууд их ярьсан. Ер нь учир нь олодохгүй юмнууд их болсон гэж. Бага Хурал нь ч дээрээ ордог юм уу, Ерөнхийлөгч, тэдний дунд чинь олон юм байна. Засгийн газрын тогтоол, шийдвэр ч яадаг яадаг гээд энэн дээр юм яриад байгаа учраас энд бол өөрөөр хэлбэл тэр парламентыг сонгож авах механизмыг сайн бодмоор байгаа юм.

Бидний өөр дүгнэлт хийх нэг зүйл бол жил гаруйн хугацаанд Улсын Бага Хурал их зүйл хийсэн. Гэхдээ тэр Бага Хурлын гишүүд гэдэг тэр гол улсуудаа сонгоход намаар хийдэг энэ механик аргаас бид аль болохоор болих хэрэгтэй. Тэгэхгүй зүгээр гудамжинд явсан над шиг юмыг хүртэл авчраад тэр хэдэн нэрэнд оруулаад ингээд оруулчихдаг, би Бага Хурлын гишүүдийг нэр сүрийг нь муутгах гэж юм уу, ингэж доромжлох юм уу ийм маягаар хандаагүй шүү. Яагаад гэвэл монгол улсын хувь заяаг бид үнэхээр авч явах ёстой юм бол яг тэр улсуудыг нь олж гаргах тийм механизм бий болгохгүй юм бол би зүгээр хэдэн намаар

хуваадаг ч юм уу, ийм маягаар төдийлөн нэг их үр дүнд хүрэхгүй байх гэж санаж байгаа. Энийг харуулах жишээ бол нэлээн олон бий. Энийг нэг их юу яаж тайлбарлах хэрэггүй гэж санаж байна.

За өөр нэг зүйл бий. Яахав би тодорхой юман дээр саналаа хэлнэ. Энд зориуд хэлэх нэг зүйл бол монгол бичгийг үнэхээр төрийн албан хэрэг эрхлэн хөтлөн явуулах ийм саналтай байгаа. Яагаад гэвэл нэгэнт бид бүх нийтээрээ монгол бичгээ хэрэглэнэ гэж байгаа юм бол монгол бичгийг үнэхээр энэн дээр оруулах ёстой гэсэн ийм саналтай байна.

За мөн Их цаазад цааш нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааны талаар гэх юм уу даа, шүүхийн эрх, баталгааны талаар нэлээн өргөн тусгасан байна. Гэтэл орон нутгийн эрх барих байгууллагын талаар Үндсэн хуулиар олгогдсон тийм тодорхой эрх, баталгаанууд үгүйлэгдэж байгаа. Энийг бас анхаарах нь зүйтэй юм уу гэж санаж байна. Ингээд цаг хэмнэхийн үүднээс би их товчхон ярилаа. Зүгээр тодорхой зүйлүүд дээр саналаа тодорхой хэлбэ гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Ганбямба /415 дугаар тойргийн депутат/ -Төгэхээр зэрэг, санал хэлэхийн өмнө ер нь зүгээр саяын ерөнхий хэлэлцүүлэг эхэлснээс хойш гарч байгаа санаанууд голдуу гурав, тавдугаар бүлгүүд рүү ороод нэлээн давхацсан санаанууд гараад байх шиг байна.

Би хувьдаа ерөнхий хэлэлцүүлгийн явц дунд хуулийн гол агуулга, бүтэц рүүгээ орж тогтож явбал ясан юм бол гэж нэг ийм санаа төрөөд байна. Өөрөөр хэлбэл бид энэ хуралдааны өдрүүдийн явцаас харж байхад манай депутатууд сонгогчдынхоо захиа даалгавар гэж олон сайхан санаа өвөртлөж ирсэн бололтой юм. Төгэхээр зэрэг бид эхлээд ерөнхий хэлэлцүүлгийн явц дунд шинэ Үндсэн хуулийнхаа агуулгыг тогтоод ямар ямар харьцаагаа шинэ Үндсэн хуулиндаа тусгах вэ гэдгээ эхлээд тогтоод авчих юм бол нэлээн шуурхай, цаашдаа хурлын ажиллагааг хөнгөвчлөхөд

нэлээн нэмэртэй юм болов уу гэж бодож байна. Учир нь гэвэл одоо ерөөсөө Үндсэн хуулинд заавал тусгах шаардлагагүй маш олон харьцааны асуудлыг энэ хэлэлцүүлгийн явц дунд хөндөж гарч ирэх нь ээ. Тийм учраас эхлээд ерөөсөө агуулгаа тогтож авмаар байна. Магадгүй цаашаа нэлээн явах юм бол энэ Үндсэн хууль, төрийн гол баримт бичгийг чинь программын чанартай баримт бичиг ч юм уу, цаг үеийн зорилт тусгасан хөдөлмөрийн чанартай баримт бичиг болгож болзошгүй ийм саналууд нэлээн гарах төлөвтэй юм болов уу гэж бодож би энэ агуулгын асуудлыг хөндье гэж бодож байна.

Ер нь ямар ч байсан бидний ойлгож байгаагаар шинэ Үндсэн хуульд маань төрийн бүрэн эрх, төрийн байгууллагуудын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, мөн иргэдийн эрх, эрх чөлөө, үүрэг, төр, иргэний харилцааг тусгасан ийм баримт бичиг байх агуулга дээрээ тогтоод, энд орхисон өшөө ямар харьцаа байх вэ? Энд илүү орчихсон хасмаар ямар шинэ заалт, харьцаанууд байна вэ гэдэг ийм асуудал руугаа эхэлж ороод яриад тогтчихвол, ер нь цаашдаа жаахан шуурхай явчих юм биш байгаа гэж ингэж бодож байх юм.

Магадгүй ингээд тэр иргэний нийгэмд очих, хүрэх арга замыг тодорхойлж ч гэдэг юм уу, өмчийн хэлбэрүүдийг тусгая ч гэдэг юм уу баахан ийм саналууд гарч болзошгүй юм шиг байгаа юм. Тийм учраас би болгоомжилсон нэг ийм эмзэглэл төрөөд байна.

Ер нь ч бид урьд өмнөх Үндсэн хуулиуд маань нөгөө хайрцаглаж ирсэн улс орны үе шатуудын зорилтуудыг тусгаж ирсэн тэр практикаасаа татгалзах гэж байгаа бол эхлээд бид энэ агуулга дээрээ тогтож аваад цаашаа явбал яасан юм бол гэж. Миний санаалаар бол төсөлд Үндсэн хуульд тусгах ёстой шаардлагууд орсон юм болов уу гэж бодож байна. Харин зүгээр ганц нэгэн тийм илүү санаа, заалтууд байх шиг байгаа юм. За бүлэг, заалт дээр ярих үеэрээ заримыг нь нэгтгэх, барих ийм саналуудаа ярина. Зүгээр энэ удаа 14 дүгээр зүйлийн хүн бүр эрх зүйн субъект байх эрхтэй гэсэн энэ нэг учир нь олохгүй заалт, би өчигдөр тодруулаад Бага Хурлын даргаас асуусан. Тэртээ тэргүй хүн эрх зүйн

субъект байдаг, гол хуулинд заасан заагаагүй ийм субъект байх ёстой шүү дээ. Ингээд Бага Хурлын даргаас сонирхоод асуухад, субъект байдгаа өөрөө мэдэж байх ёстой гэсэн нэг ийм ерөнхий тайлбар хэллээ. Хэрэв ийм тайлбараар хийсэн бол, би өөр үндэслэгээ байж магадгүй гэж бодсон юм, зөвхөн энэ тайлбараар хийсэн бол энэ заалтыг хасъя гэсэн саналтай байгаа юм.

Цаашилбал, ерөнхий хэлэлцүүлгийн явцад нэг ярих асуудал, энэ шинэ Үндсэн хуулийг хэлэлцэх явцад тохиолдож байгаа хэд хэдэн бэрхшээлээ бид мэдэж байгаа гэж бодож байна. Би энд ганцхан бэрхшээлийн тухай хөндье гэж бодож байна. Энэ нь юу вэ гэхээр монгол орны үндэсний удирдлагын концепци өнөөдөр нарийвчлан томъёологдоогүй байгаа. Ер нь ч монгол орны улс төрийн амьдрал социологийн талаар нарийн судлагдаагүй байгаа ийм үед бид нар шинэ Үндсэн хууль боловсруулах гэж байгаа явдал бидний гол бэрхшээл болов уу гэж бодож байна. Энэнтэй холбогдуулаад өчигдөр Бага Хурлын даргад тодруулах гэж асуулт тавьсан.

Зуны депутатуудын бүсчилсэн зөвлөлгөөн дээр энэ тухай санал гаргасан. Харин Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Чимид гуай их чухал санал байна. Энэ комисс дээр ярья гэж авч явсан. Өчигдөр би энэ зориуд Бага Хурлын даргаас асуудал тавьсан чинь, нэлээн өөр маягаар ойлгосон уу, яасан, төвлөн удирдах ардчилсан зарчим гэвэл өөр хэрэг гэсхийгээд хаячихна билээ. Бид нар ерөөсөө энэ хууль монгол хөрсөнд буулгах, энэ хуулийн урт удаан наслахын үндэс бол ерөөсөө энэ үндэсний удирдлагын концепци гэдэг ийм томъёололгүйгээр хууль боловсруулах юм бол төвөгтэй байх. Улс орны практикт байдаг л зүйл. Тийм учраас бид нэг иймэрхүү бэрхшээлтэй үед ийм гол хуулиараа оролдож байгаа гэдгээ нэлээн мэдрэмжтэй хандах нь зүйтэй юм болов уу гэж бодогдоод байгаа юм.

Ер нь энийг боловсруулахад бол төрт ёсны уламжлал, ард түмний жирийн харьцаа, тэр айл саахалтаараа яаж сааль, сүүгээр, үс ноосныхоо ажлыг хамтарч авч байсан, жаргал зовлонгоо яаж хувааж байсан, энэ олон харьцаанууд. Өнөөдөр алдагд-

сан байгаа олон харьцаанууд, ахмадаа хүндэтгэх гэх мэт. Энэ харьцаануудыг судалсны үндсэн дээр нэг ийм барагтай томъёолол, төсөөлөл заавал гарах учиртай. Өнөөдөр зүгээр менежментийн онолын хүрээнд гээд тэр икс, игрит, зэт онол, өшөө америк, японы хувилбар, америк, канадын хувилбар, японы хувилбар гээд ярьж байна. Энэ аль ч хувилбар өнөөдөр манай хөрсөнд буухгүй. Тийм учраас бид үндэсний удирдлагын концепци гэж ярих гээд, оролдох гээд байгаа юм бол энэ асуудлыг зайлшгүй хөндөж ярих ёстой байсан юм гэж, бид хэлэлцүүлгийн явц дунд ч нэлээн ярьсан гэсэн үг шүү дээ.

Уучлаарай, энэ нэг бүлгүүдтэй холбоотой санал уг нь ерөнхий хэлэлцүүлгийн явц дунд ерөнхий асуудлууд ярих ёстой. Энэ гуравдугаар бүлэг нэлээн зонхилж, энэ гуравдугаар бүлгийг тойрсон нэлээн маргаах гарах нь шиг байна. Би энэ талаар түрүүчийн ярьсан депутатуудтай нэг санал солилцдог юм уу гэж бодож байна.

Нэгдүгээрт, миний хувийн бодлоор парламентын бүгд найрамдах улсын хэлбэрийг хэвээр хадгалаад, одоогийн төсөлд зааснаас арай өөр нэг санаа бол Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр шаттай явуулж байгаа сонгуулийг нэг шаттай болгоод, ард түмнээс шууд сонгох иймэрхүү нэг санал төрөөд байгаа юм. Энэ ард нийтийн хэлэлцүүлгийн явц дунд их эсэргүүцэлтэй, онолын түвшингээс маш том няцаалттай тулгарч ирсэн. Ард түмнээс сонгогдох л юм бол парламентын бүгд найрамдах улс гэдэг тогтолцоо чинь биш болоод явчихна гэж. Гэтэл дэлхийн практикт ч байж байдаг юм байна. Исланд, Ирланд, Финлянд гээд энэ парламентын бүгд найрамдах улсуудын тогтолцоон дотор Ерөнхийлөгчөө ард түмнээс сонгодог ийм практик нэгдүгээрт байгаа юм.

Тэгэхдээ би зүгээр дэлхийн практикийг дуурайя гэдэг санаагаар хэлж байгаа юм биш, бидний улс төрийн философи маань юм л даа. Ер нь хаант төр зонхилж ирсэн. Төрт ёсны маань уламжлал. Нөгөө талаасаа бид өнөөдрийг хүртэл авторитар,

Тоталитар дэглэмээс бид өнөөдөр ардчилсан дэглэм рүү шилжиж байгаа үед аргагүй ердийн ухамсрын түвшинд манай нийгмийн сэтгэл зүйн уур амьсгалд бол энэ нэг хүний удирдлага энэ тэр гэсэн хүссэн хүсэлтүүд нэлээн байгаа. Тэгэхдээ би парламентын бүгд найрамдах улсын энэ хэлбэрийнх нь талд зогсож байгаа хүн л дээ. Тэгэхээр зэрэг бид өнөөдөр ард түмнийхээ энэ нэг ийм ард нийтийн хэлэлцүүлгийн дунд нэлээд хувийн санал авсан энэ нэг санал, энэ нэг төсөөллийг харгалзаж үзээд Ерөнхийлөгчийг ард түмнээс сонговол яасан юм бэ гэсэн санал байгаа юм.

Хоёр дахь үндэслэл гээд, энэ төсөл дотор Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгочихоод, тэгээд Улсын Их Хурал дээр бүрэн эрхийг нь зөвшөөрсөн нэг хууль гаргаад цэцийн дүгнэлтийг харгалзаад огцруулах ийм заалтыг хасъя гэсэн бодолтой байгаа юм. Энд бас зөрчилтэй санаа байна. Өөрөөр хэлбэл ард нийтийн хэлэлцүүлэг, ард түмний 50-иас илүү хувь, магадгүй 60-70 хувийн санал авсан Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлаас огцруулна гэдэг бол нэлээн зөрчилтэй санаа юм уу гэсэн бодомж байгаа юм. Ийм ийм үндэслэгээгээр ерөөсөө парламентын бүгд найрамдах улсынхаа тогтолцоон дотор Ерөнхийлөгчөө ард түмнээс сонгодог нэг ийм хэлбэрээ барьж явбал яасан юм бол гэж. Ерөнхий санал л даа, энэнтэй холбогдуулаад шаардлагатай бол бидний хэсэг депутатууд томъёолол гаргаад, ингээд Их Хурлын даргад өгнө гэж бодож байна.

Ер нь парламентын бүгд найрамдах улсынхаа хэлбэрээ хадгалахдаа өнөөдрийнхөө энэ сул тал, өнөөдрийн парламент нэг жил ажиллалаа, парламентын ёс эхлээд явж байна. Энэний сул тал боловсронгуй биш механизмуудыг жаахан янзалж явах учиртай юмнууд гарах байх.

Төрийн албан ёсны шашинтай болож талаар тэр 10-ны өдрийн цуглаанаас нэг ийм санал ирж байсан юм. Би энэ талаар өөр саналтай байгаа гэж. Өөрөөр хэлбэл өнөөдөр төсөлдөө байгаа саналаа тусгая гэсэн бодолтой байна. Өнөөдөр бол, бид нар чинь нөгөө хаант төр, бүгд найрамдах төрийн бүгд найрамдах төрөө сонгож

авчихаад байж байгаа, голцуу дэлхийн практикт хаант төрт л албан ёсны, ямар нэгэн шашныг албан ёсны болгодог ийм практик бий. Бид уламжилж ирсэн хоёр ёсны зарчим, түүний агуулга, шашин төрөө хүндэтгэдэг, төр нь шашнаа хүндэтгэдэг, шашин төрөө дээдэлдэг гэсэн энэ зарчмаараа явбал яасан юм бол гэсэн санаа байгаа юм.

Эцэст нь энэ, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал гэсэн энэ санаан дээр жаахан хэллэг, найруулгынх нь хувьд жаахан өөрчилмөөр ийм юмнууд байна. Би ойлгохдоо өнөөдрийн ойлгож байгаа депутат маань нөгөө ард түмний төлөөлөгч, төрийн төлөөлөгч, эрхийн статусаар засаг төлөөлдөг шинжтэй байтал, төлөөлөгч гэдэг уг маань зөвхөн дороос сонгогдоод дээшээ мөчирлөдөг ийм хоёр үндсэн утгаар нь ойлгоход энэ хурал шал өөр. Өнөөдрийн хуралд тусгасан хурал. Нөгөө өөрөө удирдах ёс, төрийн удирдлагын хослол дээр, энэ хэллэгийнх нь хувьд жаахан засмаар санаа байна.

Би бүлэг, заалттай холбоотой санаануудаа тухайн үед нь дэлгэрэнгүй хэлье.

Д. Жумдаанбаатар /180 дугаар тойргийн депутат/ - За бид түүхэнд байгаагүй хариуцлагатай мөчид тулж ирлээ. Чухам ямар байдлаар энэ хурал үр дүнтэй дуусахыг би мэдэхгүй байна. Ямар ч байсан энэ хурал түүхэнд ул мөрөө үлдээх юмаа. Энэ хурлын гол асуудал шинэ Үндсэн хууль шаналж төрөх шатандаа орлоо.

Энэ үед үнэнээс хүмүүс эмзэглэхдээ янз бүрийн арга хэрэглэхийг оролдох, арай илүү мэддэгээ дээш нь гаргахгүй, уг хөлуүлдэггүй, хардаж сэрдэж, шахаж хавчиж хэлмэгдүүлдэг гашуун хар түүх бүү давтагдаасай билээ гэж миний хувьд бодогдож байна. Тэгээд ч олон мянган хүнийг төлөөлсөн төрийн том хүмүүсээс бүр ч гарахгүй байх гэдэгт итгэж байна.

Түүнээс гадна "Ардын эрх" сонинд энэ хэлсэн уг яг тэр чигээрээ гараасай билээ гэж бодож байна. Ноднин жил бас зарим уг-

нууд бол яг өөрсдийн бодлоор ингэж өөрчилж бичих хандлага гарсан. Энийг дахин бүү гараасай гэж бодож байна.

Энэ хурал хийгдэж байгаа үед хүмүүсийн хэлсэн үгээр хурлын материал гараасай. Ер нь урд хурлуудад бүгд материал гарч байсан. Гэтэл манай анхдугаар хурлын ч материал байхгүй, одоо энэ түүхэнд мөрөө үлдээх энэ хоёрдугаар хурлын материал гарчихад болохгүй юм байхгүй болов уу гэж бодож байна. Ингээд өөрийнхөө санал бодлоо хэлье.

Тэгэхээр энэ улсууд энэ 70 жилийн сайхан муухайг ярих юм. 70 жилийн сайхан муухайгаар бид хөөцөлдөөд яах вэ? Энэ чинь түүхийн нэг асар богинохон тийм нэг зурвас үе шүү дээ. Харин урагшаа, хойшоогоо хэдэн зуун жилээр алслан харж, одоо үеийн нөхцөл байдлаа тусгаж, тэгээд одоо нэлээн далайцтай сэтгэж, жинхэнэ монгол хүний уужуу ухаанаар бодож санаж, голч мэргэн оюунаар төв шугам барьж, тэр нэр, сүлд, далбаагаа шийцвэл ямар байна вэ гэж бодож байна.

Эхлээд ямар ч байсан, ямар төрийн байгуулалттай байх вэ гэдэг амин сүнс асуудалд би өөрийн бодлоо хэлье. Тэгэхээр хоёр танхимтай Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс байх нь зүйтэй болов уу гэж санагдаж байгаа юм. Яагаад хоёр танхимтай, ганц болчихвол одоогийн Бага Хурал шиг итгэл алдвал хэн түүнийг авч хэлэлцэх юм бэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь ард түмнээсээ ингээд хөндийрчихнэ гэсэн ийм хоёр байдлаас болж хоёр танхимтай байх нь зөв болов уу гэж бодож байна.

Улсын Их Хурлыг 200 орчим гишүүнтэй, энэ бол тухайн үеийн орон нутгийн хуваарилалтаас болох байх, хүний тоо. Бага Хурлыг 30 гаруй гишүүнтэй, одоо 50 хүнтэй хурал чинь 40 хүнтэй юм уу 30 хүнтэй хуралддаг юм шиг байна. Тэгэхлээр 30 хүнтэй хурал хорин хэдэн хүнтэй хуралдаад, ядахдаа нэг гарч байгаа

хуулиудаа шүүлтүүр болоод байж барах байх гэж бодох юм.

Ерөнхийлөгчийн гэдгийн хувьд төрийн гурван өндөрлөгийн шилжилтийн хүнд үед ЧИГЛҮҮЛЖ, эв нэгдэл, эмх цэгц, дэг журмын баталгаа бий болгогоор надад ингэж санагдаж байгаа юм. Үүнтэй холбогдуулж хэлэхэд ер нь хоёр танхимтай нь илт байх шиг болж байгаа юм, зүгээр ингэж бодогдож байна, хүмүүсийн ярианаас харахад. Иймээс үүнд санал хурааж, түүнээ эртхэн шийдвэл хуулийн төслөө өөрчлөн, одоо нэг танхимтайгаар голлон хийчихсэн байгаа төсөл, ийм учраас хоёр танхимтайгаар өөрчлөхөд анхаарвал яасан юм бэ гэж бодож байна.

Үндсэн хуулиар төр, улс маань тусгаар тогтнолоо улам баталгаажуулна. Тэгэхдээ олон улстай амьд хэлхээ холбоо, найрамдалтайгаар хүн төрөлхтөний ухаалаг, давуу талаа ашиглан цаг хугацаа, орон зайны маш хязгаарлагдмал энэ хэцүү үеэ хамгийн үр ашигтай ашиглаж, урьдчилан төсөөлж мэдэхгүй байгаа аюулаас урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулж, эртний Чингисийн монголынхоо үе залгамжилсан байдлаа нэр төртөйгээр ингэж сэргээх юмсан гэж надад бодогдож байна.

Харин энэ үедээ олон зуун жил худалдаа, наймаанд зүгширсэн их гарын улсуудтай хүүхдийн зангаар биш хал үзэж, дол цохисон хүний байдлаар хий зайгүй хандах нь чухал болов уу. Үүнтэй холбож харин газрын талаар өөрийнхөө орон нутагт ямар байдлаар хэрэгжүүлэхэд саналаа хэлье.

Энэ үед ер нь газар эзэнтэй болох л хэрэгтэй байна. Тэгвэл ан амьтан, хөрс, ус бүрэн эзэнтэй болж, хулгайлах, алж хядах, усаа бохирдуулах, уул усаа сүйтгэх байдал багасах болов уу гэж ингэж бодогдох юм. Энэ хуулин дотор хүний эрхэнд их анхаарчээ. Хүний эрх нь хэт олноод, үүрэг нь багадаад ийм хэцүү үед явахгүй болов уу даа гэж надад санагдаж байна. Учир зүйгээ ойлгодог, хуулийг жинхэнэ ёсоор дээдэлдэг улсуудын дэргэд ёс заншлаа нэлээн гэсэн, хууль сахихаа нэлээн хазайсан

манай улс нэлээн онцлогтой хандмаар байна.

Хүмүүст эрх олгох гэж өрсөлдөж, үүрэггүй болгоод, тэр ч байтугай монгол улсынхаа төлөө хүчин зүтгэх, улсын нэр хүндийг өндөрт өргөхийн төлөө нэн, тэргүүн анхаарах тухай үүргэнд тусгаж, энэ үүргээр тархай үзэл бодлоо нэгтгэж эмхлэх нь чухал юм шиг надад санагдаж байна. Ийм саналууд миний хувьд байна.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

В. М. Улаа

ЭНХТУЯА

БИЧЭЭЧ УРАНЧИМЭГ

Н.Төмөртөгөө /422 дугаар тойргийн депутат/ -За манай эрдэмтэд, мэргэд, түүхчид, манай Бага Хурлын гишүүд өнөөдөр Ардын Их Хуралд Монгол улсын Их цаазын төслийг толилуулан бариад байна.Энэ бол манай энэ хөдөлмөрчид, дээр гарсан хүмүүсийн хөдөлмөрийн үр бүтээл, үр шим, удаан жил хөдөлмөрлөсөн, олон хоног хөдөлмөрлөсөн хөдөлмөрийн үр дүн юм гэж би депутатын хувьд үзэж байна.

Хэн боловч өөрийнхөө хийсэн бүтээсэн, бичсэн өгүүлбэрийг хамгаалахын төлөө тэмцдэг.За энэний дагуу манай дээрх энэ хуулийн төсөл боловсруулсан хүмүүс энийг бас өөрийнхөө зүйлийг бид бүхэнд анх ойлгуулахын төлөө тэмцэж л байна.Гэхдээ энийг би нэг талаасаа зүйн хэрэг гэж үзэж байна.Нөгөө талаасаа ерөнхий ард түмний санаа бодол, уур амьсгал, тэднийг төлөөлж байгаа депутатуудын уур амьсгалыг бас бодолцох хэрэгтэй.Ерөнхий их муйхарлаж битгий зүтгүүлээд байгаачээ гэж бодож байна. Жишээ нь саяын кино гарахад эхлээд морь гарсан.Тэгээд цовхорч байсан морь маань гэнэтхэн алга болоод л шувуу болоод хувирчихсан гэх мэтчилэн ийм юмнуудыг бас битгий их гаргаж үзээчээ гэж хүсэх байна.

Тэгээд Их цаазын төсөлд ер нь тусгай анги, бүлэг хэлэлцэх үед бол өөрийн тодорхой саналыг хэлнэ.Ерөнхий хэлэлцүүлэг явж байгаа учраас хэд хэдэн зүйл дээр санаа оноогоор ерөнхий журмаар хэлье.

Нэгдүгээрт, улсын нэр, Үндсэн хуулийн нэрийг одоо ер нь ард түмнээс гарч байгаа саналыг их анхаарах хэрэгтэй байна. Тэгэхээр өнөөдөр манай ард түмэн маань юу ярьж байна вэ гэхээр энэ нэрээ бодитойгоор хадгалж үлдье, ер нь аятайхнаар байлгая гэсэн ийм чиглэлээс яриад байх шиг байна.Дорнод европын орны ард түмэн бол юу ярьж байсан бэ гэхээр энэ социализмын үеийн нэр бол манай улсад тохирохгүй байна.Энэ сүлд, тэмдэг тохирохгүй байна гэдэг үүднээс тэр орны парламентууд энийгээ өөрчилсөн байгаа.Манай монгол хүн, монгол сэтгэлгээ, энэ өвөрмөц байдлыг

өноедөр энэ хуулийг шийдэхдээ харж үзмээр байна уу гэж би бодож байна.

Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан улсын нийслэлийн талаар орсон заалт бол одоо надад таалагдаж байна. Ер нь нэг иймэрхүү байвал алсын хараатай, бодолтой байж болох юм гэж. Өчигдрийн Бага Хурлын даргын хэлсэн үг ч гэсэн надад нийслэлийн хувьд зохицож байна.

Сүлд, төрийн далбааны хувьд энэн дээр эргэж карах, сайн бодууштай юм их байна шүү. Ер нь яаж ч бодоод байсан, сая ч нэлээн ухуулга авлаа, нэлээн ч харлаа, яаж ч бодоод байсан нэг л бууж өгөхгүй л байна. Миний хувьд. Энэ ч яахав, түрүүний тэр нэвтрүүлэгчийн ярьж байдгаар сэтгэл санааны хомсдолтой хүний нэг нь байгаа юм болов уу даа гэж би өөрийгөө дүгнэж байна даа.

За 20 дугаар зүйл рүү орё. Энэ монгол улсын төрийн байгууллын талаар би нэг хэдэн үг хэлье гэж бодож байна. Өноедөр бол төрийн байгуулал төсөлд орж ирсэн, Үндсэн хуулийн төсөлд орж ирснээр ойлгоход бас учир дутагдалтай юм байна гэж би депутатын хувьд дүгнэж байна. Тэгэхээр нэгдүгээрт энэ ард түмнийхээ жинхэнэ дунд нь амьдардаг, орон нутгийн онцлогийг сайн мэддэг, олон төрлийн ажил төрөл эрхэлдэг, нийгмийн давхаргыг төлөөлж чадах ийм хүмүүсээс бүрдсэн, гэхдээ өноедрийн олон ийм дөрвөн зуу гаруй биш, хоёр зуу гаруй 250 орчим депутаттай Их Хурал байвал бид одоо олон давхаргыг төлөөлсөн депутатуудыг энд сонгож ирж чадах юм. Тэгээд дараа нь энэн дотроосоо Бага Хурлаа сонгох юм бол мөн л өноедрийн системийн маягаар, тэгэх юм бол одоо жинхэнэ хуулийн талаар мэргэжсэн, хууль тогтоох арга туршлагатай, ер нь ийм хүмүүсээ сонгоод, ийм хүмүүсээ намууд нь байдаг юм уу, орон нутгийн хэсэг бүлгүүд байдаг юм уу, ингэж гаргаж ирээд сонговол зүгээр нэг 75, 76 тойрог дээр хэдэн хүний нэр дэвшүүлээд, тэнд дөрөв таван хүн уралдаад, янз бүрийн байдлаас гарч ирээд нөгөө Их Хурал бүрэлдчих юм бол мэргэжлийн хувьд ч тохиромж муутай ийм болчихож магадгүй байна.

Ийм учраас энэ хоёр талыг их сайн анхааран үзэж, түрүүний депутатуудын гаргаж байгаа санал шиг хоёр танхимт гэж нэрлэдэг юм уу, нэг танхимт гэж нэрлэдэг юм уу, ер нь өнөөдрийн, одоогийн бидний нэг жил мөрдөж байгаа энэ байдлыг жаахан харж үзээд депутатуудынхаа тоог аль аль шатанд нь Их Хуралдаа, Бага Хуралдаа цөөрүүлээд, Их Хурлын хуралдах хугацааг багасгаад, өөрөөр хэлбэл уртасгаад, нэг жилд биш жил хагаст байдаг юм уу ийм байдлаар ингэж зохион байгуулбал ямар вэ? Энэ бол нэлээн тал болгоноосоо харахад зүйтэй юм уу гэж бодож байгаа юм.

Манай хөдөө орон нутгийн ард түмэн, манай хөдөлмөрчид бол төрийнхөө сүлдэнд залбирч, төртэйгээ ойр байж, төрөө өөрийнхөө төлөөлүүлж төрөө сонгосон хүнтэй харьцаж байх их дуртай. За бидний ярьдаг хүнд суртал гэж ярьдаг, тэрнийг давах нэг арга бол нөгөө хөдөлмөрчин хүн маань депутаттайгаа уулзаад орон нутгийн байгууллагууд шийдэж өгөхгүй байгаа юмыг бас шийдчихдэг бас ийм тал ч бий. Зарим орон нутгийн байгууллага бол депутатын тусламжтайгаар шийдсэн юмыг шийдээд өгчихдөг ийм тал ч бий. Ийм учраас хөдөлмөрчин олон түмэн чинь, ард түмэн маань тэр төрийнхөө төлөөлөгчтэй ойр харьцаж байхыг их хүсдэг юм. Энэ нь бол ер нь их тодорхой. Тийм учраас 75 гишүүнтэй болох юм бол энэ ойр харьцах юм нь улам холдох ийм төлөвтэй байна.

Байдлаас харахад ер нь манай, одоо бидний мэдэж байгаа сүүлийн далан хэдэн жилд ч гэдэг юм уу, төр удирдсан хүн маань бүгд буруудлаа. Тэгэхээр энийг хянаж шалгаж байх, ер нь ард түмнээс сонгосон хоёр гурван талын хяналттай ийм юм байвал тэр хүний алдаа дутагдлыг бага дээр нь засаад авчихдаг ийм ардчилсан хэлбэртэй ч гэдэг юм уу, хяналт шалгалт сайтай ийм хоёр талын бие биэндээ хяналт тавьчихдаг ийм парламент байвал ер нь зүгээр юм уу гэж бодож байна.

За нэг минут үлдэж байгаа бол би шууд 61 дүгээр зүйлд орж нэг хэдэн асуудал хэлбэ гэж бодож байна. За энэ орон нутгийн засаг захиргааны асуудал. Орон нутгийн засаг захиргаа гэдэг чинь өнөөдөр манай хөдөөгийн хөдөлмөрчдийн нийгмийн, соё-

хуульд найдаад ямар ч хараа хяналтгүй ийм байж болмооргүй юм шиг. Энэ чинь нөгөө гуч, дөчөөд оны үеийн дотоод яамны ноогоон малгайтнууд гэгчээр юм болчихвий дээ гэсэн шиг ийм юм бас бодогдоод байгаа юм. Тийм учраас энэ чинь одоо ямар системээр энэ алдаа дутагдал гаргахгүй явж болох ийм зохицуулалт хийсэн юм болоо гэдэг энэ тухай юман дээр бас нэг ярилцаж санаа бодлоо солилцож, ойлголцмоор байгаа юм. Хэрэв тэгэхгүй бол би одоо энэ талд гараа өргөж баталж бас нэг чадахгүй болмоор шинжтэй байгаа юм.

Дараагийн асуудал нэгэнт сонгогч олноосоо санал асуулга явуулж, санаа бодлыг нь сонссоны хувьд хэлэхгүйгээр өнгөрч болохгүй нэг зүйл байна. Энэ бол олон нэрнүүдийн тухай асуудал. Энэ санал асуулгад оролцсон сонгогчдын 88 хувь нь улсын нэрийг, 59 хувь нь Үндсэн хуулийн нэрийг, 76 хувь нь төрийн бэлгэдлүүдийг өөрчлөхгүй юмсан гэсэн ийм саналыг өгсөн байгаа юм. Тэгэхээр энэн дээр зайлшгүй шаардлага гарч ирчихээд байгаа юм нь бас ховор юм шиг. Зүгээр сүлд тэмдэгний хувьд ярилцах юм ч байх шиг л байгаа юм. Өгөх хариулттайгаар энд өөрчлөх юманд өөрийнхөө санаа бодлыг оруулаад өөрчлөөд гараа өргөж болох байх. Зүгээр тийм тодорхой нэг шаардлагагүй, тайлбаргүй ийм юмыг хүлээж авч болмооргүй юм шиг ингэж санагдаад байгаа юм.

Тэгэхээр эндээс би юуг хэлэх гэж байна гэхээр зэрэг ер нь одоо ард түмнийхээ уур амьсгалыг бас нэг бодож үзэх нь зүйтэй юм уу гэж. Энэ чинь одоо нэг хэдэн нэр өөрчлөгдөөд очихоор зэрэг идэж, өмсөх хэрэглэх юмгүй байж байхад хэдэн нэрийн хойноос хөөцөлдлөө гэсэн ийм уур амьсгалтай болж хүмүүсээ бухимдуулчихвий гэсэн үүднээс би энийг хэлж байна.

Нөгөө нэг асуудал хүний эрхийн тэр асуудалтай холбоотой ч гэх юм уу, ер нь бас л нэг бодогдоод байдаг, зарим газар ч яригдаад байдаг нэг зүйл байгаа юм. Энэ хүний эрхийн асуудал. Амьд явах эрхтэй гээд ингээд заачихсан байх юм. Тэгвэл бас одоо амьд явахгүй байх эрх гэж одоо байж болдоггүй юм уу гэж. Одоо

жишээлбэл өчигдөр ч бид нарт тулган шаардах бичиг ч гэл үү, юу ч гэлээ юм уншиж байсан. Энэ сүлд, далбаагийн чинь өөрчлөх юм бол одоо таалал төгслөө шүү гэж та нарт зарлаж байна гэсэн. Гэтэл нэг нь өөрчлөхгүй бол би бас амьд явж чадахгүй нь байна шүү гэж хэлбэл одоо яах юм бэ? Гэтэл аль нэгийг нь хийж л таарна шүү дээ. Тийм учраас энэ чинь хэрэв тийм эрхийг нь эдэлдэг байсансан байх юм бол ямар нэгэн байдлаар тэр хүн өөрөө өөрийгөө шийдэх л байх. Хэрэв тиймгүй байх юм бол олонхийн саналаар батлагдсан тэр хувилбарыг дэмжээгүй хүн л тэнд таалал төгсөх болох нь байна шүү дээ. Төгэхээр иймэрхүү асуудлуудыг ер нь энэ хууль зүйдээ ч гэсэн авч хэрэглэвэл ямар байсан юм бэ гэж ингэж бодож байна. Бусад асуудлыг тухайн үед нь ярья.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

Ийм учраас энэ хоёр талыг их сайн анхааран үзэж, түрүүний депутатуудын гаргаж байгаа санал шиг хоёр танхимт гэж нэрлэдэг юм уу, нэг танхимт гэж нэрлэдэг юм уу, ер нь өнөөдрийн, одоогийн бидний нэг жил мөрдөж байгаа энэ байдлыг жаахан харж үзээд депутатуудынхаа тоог аль аль шатанд нь Их Хуралдаа, Бага Хуралдаа цөөрүүлээд, Их Хурлын хуралдах хугацааг багасгаад, өөрөөр хэлбэл уртасгаад, нэг жилд биш жил хагаст байдаг юм уу ийм байдлаар ингэж зохион байгуулбал ямар вэ? Энэ бол нэлээн тал болгоноосоо харахад зүйтэй юм уу гэж бодож байгаа юм.

Манай хөдөө орон нутгийн ард түмэн, манай хөдөлмөрчид бол төрийнхөө сүлдэнд залбирч, төртөйгээ ойр байж, төрөө өөрийнхөө төлөөлүүлж төрөө сонгосон хүнтэй харьцаж байх их дуртай. За бидний ярьдаг хүнд суртал гэж ярьдаг, тэрнийг давах нэг арга бол нөгөө хөдөлмөрчин хүн маань депутаттайгаа уулзаад орон нутгийн байгууллагууд шийдэж өгөхгүй байгаа юмыг бас шийдчихдэг бас ийм тал ч бий. Зарим орон нутгийн байгууллага бол депутатын тусламжтайгаар шийдсэн юмыг шийдээд өгчихдэг ийм тал ч бий. Ийм учраас хөдөлмөрчин олон түмэн чинь, ард түмэн маань тэр төрийнхөө төлөөлөгчтэй ойр харьцаж байхыг их хүсдэг юм. Энэ нь бол ер нь их тодорхой. Тийм учраас 75 гишүүнтэй болох юм бол энэ ойр харьцах юм нь улам холдох ийм төлөвтэй байна.

Байдлаас харахад ер нь манай, одоо бидний мэдэж байгаа сүүлийн далан хэдэн жилд ч гэдэг юм уу, төр удирдсан хүн маань бүгд буруудлаа. Тэгэхээр энийг хянаж шалгаж байх, ер нь ард түмнээс сонгосон хоёр гурван талын хяналттай ийм юм байвал тэр хүний алдаа дутагдлыг бага дээр нь засаад авчихдаг ийм ардчилсан хэлбэртэй ч гэдэг юм уу, хяналт шалгалт сайтай ийм хоёр талын бие биэндээ хяналт тавьчихдаг ийм парламент байвал ер нь зүгээр юм уу гэж бодож байна.

За нэг минут үлдэж байгаа бол би шууд 61 дүгээр зүйлд орж нэг хэдэн асуудал хэлье гэж бодож байна. За энэ орон нутгийн засаг захиргааны асуудал. Орон нутгийн засаг захиргаа гэдэг чинь өнөөдөр манай хөдөөгийн хөдөлмөрчдийн нийгмийн, соё-

лын бүх л ахуй амьдралыг шийдэх ийм байгууллага болж байгаа. Манай хөдөөгийн хөдөлмөрчид бол тээвэр, холбоо, сургууль, эмнэлэг, ерөөсөө л ахуй үйлчилгээ, хоршоо, дэлгүүр энэ бүх юм чинь тэр юмтайгаа шууд холбоотой, өөрөөр хэлбэл сум гэдэг юмтайгаа шууд холбоотой, сумнаас бид бүх юмаа авч харьцаж байна гэдэг ийм ойлголттой байгаа. Энийг төвлөрүүлээд холдоод ирэх юм бол манайх шиг таруу оршин суудаг ийм орон нутагт хэцүү хүндрэлтэй, ард түмэндээ хүндрэл учруулж магадгүй болж байгааг депутатууд бас их сайн ойлгоно биз. Ялангуяа хөдөөгөөс сонгогдсон депутатууд энийг яс махандаа хүртэл мэдэж байгаа байх. За анхаарал тавьсанд баярлалаа.

Ц. Даш /371 дүгээр тойргийн депутат/ - Би сонгогч олоноо төлөөлж хэдхэн үг хэлье гэж бодсон юм. Тэгэхлээр тойргийнхоо сонгогчидтой хамт амьдарч, нэг дор байж, санаа бодлыг нь сонсож, зарим асуудлаар санал асуулга хүртэл авч байсны хувьд би тэднийгээ төлөөлж хэдэн үг хэлэх эрхтэй гэж бодож байна.

Манай сонгогчдын санал асуулганд оролцсон хүмүүсийн 75 хувь нь ийм санал гаргаж байсан юм. Монгол улс Ерөнхийлөгчийн засаглалтай улс байвал яасан юм бэ? гэж. Тэгээд энэ тухай асуудлаа ч Бага Хуралдаа, Их Хуралдаа илтгэж байсан. Тэгэхдээ энэндээ нэг үндэслэл хэлээд байгаа юм.

Нэгдүгээрт, энэ ардчилал хөгжиж хүмүүс маань үгээ хэлдэг боллоо. Буруу зөвийг ойлгодог, ялгадаг боллоо. Энэ асуудал маань Ерөнхийлөгчөө ганцаар төр захирах тийм эрх мэдэлтэй хүн болгочихгүй байхаа гэж ингэж хэлж байх юм. Нөгөө талаар олон намын систем нэгэнт бүрэлдэн тогтсон учраас энэ хараанаас хаашаа ч гарч зайлахгүй биз дээ. За нөгөө нэг асуудал бол Ерөнхийлөгч асуудлыг ганцаараа шийдэхгүй юм. Ерөнхийлөгчийн дор чинь бүхэл бүтэн аппаратууд ажиллаж байна. Энэ чинь парламентын засаглалтай ч бай, Ерөнхийлөгчийн засаглалтай ч бай, энэ одоо байдгаараа байх л байх даа гэж. Ийм нэг саналуудыг хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг тойрч ярилцвал ямар байсан юм бэ гэсэн

ийм нэг саналыг хэлмээр байна.

Хоёрдугаарт, төслөөр бол ганц байгаа Ерөнхийлөгчөө нэг л бүтэлгүй хүнээр дүрсэлсэн юм шиг юм харагдаад болж өгөхгүй юм. Ерөнхийлөгч буруу зарлиг гаргана л гэнэ, тэрийг нь хүчингүй болгоно л гэнэ. Ерөнхийлөгч буруу хэрэг хийнэ л гэнэ. Огцруулна л гэнэ. Ерөнхийлөгч огцорно л гэнэ. Дахин сонгууль хийнэ л гэнэ. Ерөнхийлөгч таалал төгсөнө л гэнэ. Оронд нь Бага Хурлын дарга орлоно л гэнэ. Одоо нэг иймэрхүү юм. Энэ асуудлыг бол би нэг их энэн дээр байгаад байхаар асуудал ч мөн ч юм уу даа, ер нь одоо юм болгоныг тусгай хуулиар зохицуулна гээд хэлчихсэн байдаг. Тэр том сав руугаа хийчихвэл яасан юм бэ гэдэг нэг ийм санааг энд хэлмээр байна.

Ер нь Ерөнхийлөгчийн энэ их алдаа дутагдлын талаар бол би нэг их айгаад байхгүй байгаа юм. Нөгөө нэг анхаарлаа хандуулчихмаар ийм асуудал юу байна вэ гэхээр зэрэг шүүх эрх мэдлийн хувьд хэдэн зүйл санагдаад байгаа юм.

Тэгэхээр шүүх бол ямар ч хараа хяналтгүй, зөвхөн л одоо хуулинд захирагдсан ийм л улсууд байна гэсэн ийм ойлголт төрүүлээд байгаа юм. Тэгэхээр ганцхан хуулинд захирагдана гэдэг чинь ганц хуулийг ямар ч байдлаар хэрэглэж бас болмоор ч юм шиг байгаад байгаа шүү дээ. Жишээлбэл, хүний эрхийн тухай асуудлаар энд амьд явах эрхтэй л гээд ингээд заачихсан байгаа. Амьд явах эрхтэй гэдэг чинь эрхээ эдэлбэл амьд явна биз, эрхээ эдлэхгүй бол үхнэ биз гэсэн шиг иймэрхүү санаа болчих юм биш биз дээ, жишээлбэл.

Тэгэхээр, хуулийг чинь янз бүрийн байдлаар хэрэглээд байдаг юм шиг ийм юм урьд өмнө нь харагдаад байгаа юм. Одоо Отгонбаярын хэрэг гээд их зартай сүртэй хэрэг одоо хэрнээ шийдэгдээгүй байж байгаа. Энэ чинь тухайн үедээ хуулийнхан зөв ажиллаад байсан юм шиг, суул руугээ болохоор хуулийнхан буруу ажиллаад байсан юм шиг, одоо ер нь аль ч учир нь оллохгүй шахуу болчихсон ийм нэг асуудал байж байгаа. Тэгэхдээ зөвхөн

320 дугаар тойргийн депутат Ч.Хишигдалай:

Улсын нэрийн хувьд Монгол улс гээд нэрлэхэд болохгүй юмгүй юм шиг байна.

Үндсэн хууль гэдэг нэрийн хувьд бол болж өгвөл нэг их өөрчлөөд байх онц шаардлагагүй болов уу. Үнэхээр шаардлагатай юм гэлээ гэхэд ямар ч байсан Их цааз гэж өнөөдөр нэрлэж, ард түмнийхээ дургүйцлийг хүргэх нь бас ч нэг талаар хэрэггүй юм болов уу гэж бодож байна. Тийм учраас үнэхээр Үндсэн хууль гэдэг нэрийг өөрчлөх гээд байгаа бол Их засаг хууль гэдэг юм уу юу гэдэг юм тийм маягаар өөр нэр хайсан дээр байх.

Сүлд, тэмдэг, далбааны хувьд бол Монгол улсын сүлд, далбаа ямар ч байсан монголын ард түмний түүхэн уламжлалыг нэг талаар тусгасан, нөгөө талаар монголчуудын хүсэл, эрмэлзлэлийн бэлгэдлийг тусгасан байх байх гэж бодож байна. Үүнийг тусгаж чадвал сүлд далбааны загвар үндсэн үүргээ биелүүлэх байхаа гэж бодож байна.

Дараагийн нэг юм нь хүний эрхийн талаар, бусад асуудлын талаар сүүлд тухайн үед нь ярьж. Гол анхаарал татсан юм бол Монгол улсын төрийн байгууллын талаарх асуудал байгаа. Энэ дээр өөрийнхөө саналыг хэлж.

Одоогийн Их цаазын төсөлд байгаа тусгагдсан төрийн байгууллын талаар нэлээн анхаарах зүйлс байна гэж боддог.

Нэгдүгээрт, засаглалыг хуваарилах онол гэдэг зүйлийг хэт өрөөсгөл барьж, гүйцэтгэх засаглалыг буруу хуваарилсан байна гэж үзэж байна.

Хоёрдугаарт, гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэх гол төрийн байгууллага, засгийн газрын эрх хэмжээг хэт хязгаарласан

юм шиг байна.

Гуравдугаарт нь, гүйцэтгэх засаглалыг мөн хэт их тарааснаас болж ард түмний өмнө, Засгийн газрын хариуцлагыг хэн нь хүлээх нь төдийлөн их ойлгомжгүй хэмжээнд үлдсэн юм болов уу? гэж бодож байна.

Дөрөвдүгээрт, энд хэрцгий ноёрхлыг тодорхой хэмжээнд нэлээн удаан хугацаагаар ч магадгүй, тогтоох боломжийг энэ төсөл олгож байгаа юм болов уу гэж.

Тавдугаарт, Засаглалын тогтолцоо нь Монгол улсын төрийн төвшин, хүчтэй байлгах тэр шаардлагад хараахан нийцмээргүй юм шиг санагдаж байна. Харин ч энэ нь засаглал булаачалдсан ийм сөргөлдөөн бий болгоход хүргэн болов уу гэж ойлгогдмоор юм шиг болчихож гэж бодож байна.

Ингээд депутат та бүгдэд энэ дэгийн 12-ийн "х"-д зааснаар монгол улсын төрийн байгууллын талаар өөрийнхөө санал болгож байгаа хэсгийг уншаад сонсгочихье.

Эхлээд улсын Их Хурлын талаар санал болгох зүйл бол ийм байна.

Нэгдүгээрт нь, Монгол улсын Их Хурал бол төрийн эрх барих, дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү улсын Их Хурал хадгална.

Хоёрдугаарт нь, Монгол улсын Их Хурал төлөөлөгчдийн хурал, нутаг дэвсгэрийн хурал гэсэн хоёр танхимтай байна.

Төлөөлөгчдийн хурлыг тэнцүү тооны хүн ам тутмаас Улсын Их Хурлын нэг гишүүн байхаар 5 жилийн хугацаагаар сонгоно.

Нутаг дэвсгэрийн хурлыг Монгол улсын нийслэл, аймаг бүрээс 3 гишүүн байхаар 5 жилийн хугацаагаар сонгоно.

Улсын Их Хурал хуралдаанаараа төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох боловч дараах асуудлыг зөвхөн хоёр танхим тус тусын чуулганы ч хэлэлцэн баталсны дараа улсын Их Хурал хуралдаанаараа авч хэлэлцэж, нэгэн шийдвэр гаргаснаар хүчин төгөлдөр болно.

Энд хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, төрийн дотоод гадаад бодлогын үндсийг тодорхойлох, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, улсын хил тогтоох, ерөнхийлөгчийн санал болгосноор Монгол Улсын Дэд ерөнхийлөгчийг томилох, Их цаазын цэцийн гишүүдийг томилох, Улсын Их Хурлын дарга, орлогчдыг сонгох, гэсэн ийм асуудлыг хоёр танхим хоёулаа тус тусдаа баталснаар сая Их Хурлын хуралдаан авч хэлэлцэх ийм эрхтэй болох юмаа гэсэн ийм санаа байна.

Улсын Их Хурал түүний танхимууд байнгын ажиллагаатай байна. Улсын Их Хурлын хуралдааныг аль нэгэн танхим буюу Ерөнхийлөгчийн санал болгосноор шаардлагатай үед нь хийнэ гэсэн ийм байр суурь байвал зүгээр юм уу?

Ингээд бусад хэсгийг дараа нь үүнийгээ өгөх учраас тодруулъя. Ингээд Монгол улсын Ерөнхийлөгчийн талаар ийм зүйл байвал зүгээр юм уу гэж бодож байна.

Монгол улсын Ерөнхийлөгч бол төр, засгийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. Монгол улс нь Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс байна. Эсвэл үүнийг Монгол улс Ерөнхийлөгчийн засаглалтай байна гэсэн ч болох болов уу гэж бодож байна.

Улсын Их Хуралд хамгийн олон суудал бүхий хоёр нам буюу намуудын эвслээс олонхийн санал авч, нэр дэвшүүлэх хүнийг шалгаруулан Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд

нийтээрээ чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргана гээд ингээд Ерөнхийлөгчийг шууд сонгууль хэлбэртэй ойлгох нь зүйтэй юм уу гэж бодож байна.

Ингээд цаг дуусч байгаа учраас энэ саналаа Хурлын даргад өгнө. Тэгээд эцэст нь орон нутгийн нутаг захиргааны удирдлагын талаар нэлээд анхаарах зүйлүүд энэ дээр бий. Түүнийгээ дараа хэлье.

Ж.Уртнасан: Саналаа бичгээр өгч болно шүү дээ, Хишигдалай.

200 дугаар тойргийн депутат С.Халзанхүү:

Шинэ Үндсэн хуулийн төслийг нийт ард түмнээр хэлэлцсэн дунгийн тухай бид сонслоо. Тэгэхээр энэ Үндсэн хуульд орж байгаа, шинэ үндсэн хуулийн төсөлд орж байгаа нэр томъёонуудын хувьд зарим бэлгэ тэмдгийн загваруудын хувьд үнэндээ сонгогч түмэн болоод надаас эхлээд ер нь үүний утга учир, цаад нарийн явдлыг нь сайн ойлгож мэдэхгүйгээс, ийм байдлаас болж энд тогтсон нэгдсэн санаа гарахад ч гэсэн ихээхэн бэрхшээлтэй байгаа гэдгийг би хэлмээр байгаа юм.

Өчигдрийн хэлэлцүүлсэн дүн, Энд Ерөнхийлөгч болон Улсын Бага Хурлын дарга нарын тавьсан асуулт, хариултын байдал саяны сүлдний талаар, сүлд болсон энэ бэлгэ тэмдгийн талаар саяны гаргасан кино, дүрс бичлэгээс харж, эрхбиш нэгийг зүг чиг ийм байдаг юм байна гэсэн юмыг томъёолж байна.

Тэгэхээр үүнээс аваад үзэхэд ер нь сүлд далбаа бэлгэ тэмдгийн тухайд бол ер нь хуулийн нэрийн тухайд ч гэсэн энэ тайлбараас үзэхэд онцон энэ ард түмний, ялангуяа сонгогч хөдөлмөрчдийн маань олонхийн саналыг аваад байгаа, олонхи нь нэлээн хошуураад байгаа энэ юм хуучнаараа байхад ер нь юу нь болохгүй байна вэ гэсэн ийм асуултанд бас хариулж болж байна гэж миний хувьд ойлгож байна.

Тэгэхээр энэ бол энэ хариулт, тайлбаруудаас үзэхэд тийм ноцтой харшлаад байгаа зүйл бол бага юм уу гэсэн ийм сэтгэгдэл төрлөө. Өчигдөр Улсын Бага Хурлын дарга зүүн Германыг Баруун германтай нэгдэхэд мөнгөн тэмдэгтийн тухай асуудлыг яаж шийдсэн гэдэг талаар хариулт өгч байсан. Энэ дээр Германы мөнгөн тэмдэгтийн тухай асуудал бол цаашдаа, уучлаарай паспортын тухай, тэгэхээр үүнтэй адилаар монгол орон энд еерийнхөө Үндсэн хуулийг батлахдаа хуучин бэлгэ тэмдгүүдийг хэрэглэх бас ийм ч юм байж, зарлаж тунхаглаж болохгүй юм уу гэсэн ийм санаа төрж байгаа юм.

Засаглалын хувьд бол ер нь депутат Дашийн гаргасан саналтай санал нэг байна. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч засгийн тэргүүн байж, явуулахад манай орны тухайд болохгүй байх уу? гэсэн ийм санал байна. Энэ бол түрүүн тайлбаруудыг хэллээ. Нэг намын хуучин тогтолцоонд байсан энэ систем задарлаа. Өөрөөр хэлбэл одоо ард түмэн бол сонгох сонгуульдаа оролцох энэ оролцоо бол шал еер боллоо. Өөрөөр хэлбэл сэрлээ. Энэ бүгд бол одоо их цаазын цэц ч гэсэн Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавьж байх ийм бүрэн боломж болсон зэргийг харгалзаж үзэхэд Ерөнхийлөгчийн засаглалтай байж болох юмаа гэсэн ийм санал байна.

Үндсэн хуулийн төсөлд орж байгаа хуулийн зарим заалтууд бол цаашид хэр зэрэг биелэх баталгаатай вэ гэдэг асуудал бас зарим талаар тодорхойгүй байна. Өчигдрийн асуулт хариултын байдлаас ч тийм сэтгэгдэл төрлөө. Тухайлбал улсын Их Хурлын 76 гишүүний 50 хувийг яаж сонгох вэ? тухайн үе дээрээ шийдмээр юм шиг ойлгогдож байгаа. Энэ бол зүйрлэж хэлэх юм бол барилгын хундаментыг тавьчихаад, үүнийг хоёр давхар барилга барих уу? нэг давхар байх уу? гэдгийг явц дундаа шийднэ гэсэн ингэж ойлгож болмоор юм шиг харагдаж байгаа.

Тэгэхээр үүнийг ингэж урьдчилж харууштай санагдаж байна. Газрын тухай нэг санал тавимаар байна.

Энд олон янзын санал байна. Зарим саналууд зөргүтэй байна. Газрыг бол өөрийн орны иргэдэд ялангуяа хөдөөд өмч хувьч-чилж байгаа үед ялангуяа бэлчээрийн талбай, тэр дундаа өвөлжөө, хаваржааны бэлчээрийн асуудлыг өмч нөлөөн хувьч-лагдаж ирсэн үед зохих хэмжээгээр түрээслэх ийм юм зэрэг-цэж хийх шаардлагатай гэж бодож байна.

Улсын гэсэн нэр, өмчин дээр дангаараа одоо хувийн өмч ингэж явбал бас газрыг эзэмших, цаашид байгаль орчноо хамгаалах энэ асуудал ч гэсэн нөлөөлж магадгүй юм. Ийм учраас энэ талд их анхаарч үзэх хэрэгтэй. Ялангуяа ашиг шимтэй, бүс нутгийн газрыг зохих ёсоор түрээслэх, хувьчлах асуудал хийгдэх нь зүйтэй болов уу гэсэн ийм санал байна.

Засаг, захиргааны нэгжийн хувьд бол одоогоор Үндсэн хуульд ингэж ойлгож байна. Үндсэн хуульдаа ер нь ямар ч гэсэн хошуу, нутаг гэдгээр оруулья гэсэн ийм юм хийгээд дараа нь хойшид яа ямар янзтай байх вэ гэдгээ боловсруулья гэсэн ийм шинжтэй байна. Сумыг хошуу гэж нэрлээд ингээд явбал одоогийн иргэд хүрэх хүрэлцээ, одоогийн сумын хэмжээндээ байвал одоо хүрэх хүрэлцээ бол дэнтэй, дунтай байгаа л даа. Үүнийг еер цааш нь төвлөрүүлэх юм бол учир дутагдалтай болох юм болов уу гэсэн ийм санал байна.

10 дугаар тойргийн депутат О. Лашбалбар:

Депутат нөхөд өө? Та бүхнийг анхаарлаа төвлөрүүлэхийг туйлаас хүсч байна. Яагаад гэвэл Үндсэн хуулийн төсөл, Их цаазын хавсралт хууль, одоо мөрдөж байгаа Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль гурав, хэрвээ бид туйлын анхааралтай уншиж, энд ^{сонор} эсбэргөг байхгүй бол аюул болж мэдэх нь ээ гэдгийг би хэлэх гэсэн юмаа. Яагаад гэхээр Үндсэн хуулийн хавсралтын ёсоор энэ бүх ажлыг нарийн аваад үзвэл Үндсэн хуулийн замаар төрийн эрхийг одоо булаан авах ийм оролдлого байж магадгүй ийм юм ажиглагдаж байна. Энд би хэлье гэж бодож байна. Яагаад гэвэл БНМАУ-ын Ардын Их Хурал дор дурдсан зөвхөн өөрийн шийдвэрлэх онц эрхийн асуудлаас гадна төрийн дотоод, гадаад

бодлогын ямар ч асуудлыг санаачилгаараа хэлэлцэн шийдвэрлэнэ гэж байна. Тэгэхээр бүрэн эрх, онц эрх хоёроо ялгахгүй, тийм хуульчид, тийм хууль тогтоох байгууллага байхгүй байх гэж би санаж байна. Өнөөдөр биднийг ойлгохгүй байна гэж загнаад юм уу, ойлгуулах гэж ядаад байх шиг байна. Хэрэг дээрээ манай депутатууд ойлгохгүй байгаадаа биш, ойлгогдохгүй хууль хийчихсэндээ юм болов уу гэж бодож байна. Үнэхээр нарийн аваад үзэх юм бол бүрэн эрхийнхээ дотор онц эрх нь багтаж байдаг. Тэгвэл Үндсэн хуулийн нэмэлтэн дээр төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг санаачилгаараа хэлэлцэн шийдвэрлэнэ гэж бүрэн эрхийг нь заасан байна. Энэ үндсэн хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг батлах, сонгох, Бага Хурлыг сонгох, мөн бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн хяналтын зөвлөл байгуулах, Ерөнхийлөгчийн санал болгосноор, Ерөнхий сайд, Ерөнхий прокурорыг томилох гэсэн энэ бол 6 зүйл байгаа. Онц эрх нь юмаа. Онц эрхийг та бид зөвхөн энэ хурлыг хуралдаж байх хугацаанд л эдэлж байгаа. Яагаад би Үндсэн хуулийн замаар энэ бол төр засгийн эрхийг булаан авах гэсэн оролдлого гарч ирж байна вэ гэдгийг хэлэх гээд байна вэ гэвэл, энэ бол санаатай ч байж магадгүй, санаагүй байж магадгүй. Үүнийг би одоо энэ Хавсралтын хуулийг аваад үзье гэж бодож байна. Хавсралтын хуулийг аваад үзэх юм бол ингэж заасан байгаа юм. Улсын Их Хурал Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, тэдвээрийн бүрэн эрх эхлэх хүртэл хугацаанд БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа хэвээр үргэлжилнэ гэж байна. Ингэчихээд цааш нь бүрэн эрхээ заагаагүй, энэ хугацаанд гээд онц эрхийг заачихсан байгаа. Өөрөөр хэлбэл Ардын Их Хурлын депутатууд, өнөөдөр энэ хуралдаанаа хийж дуусаад, тэгээд та бид үүнийг батлаад дуусгахад, та биднийг өрөөсөө автоматаар огцруулчихаж байгаа юм. Та бид зөвхөн тэмдэг зүүсэн 430 хун л үлдэх ийм л боломжтой болж байна. Ийм учраас энэ бол би ноцтой гэж үзэж байна. Яагаад гэвэл энэ зүйлийн 2 дугаарт бол ингэж заасан байна. Монгол улсын хууль тогтоох Улсын Бага Хурал нь энэхүү хавсралт хуулиар ардын Их Хурлын онцгой эрхэд

хамааруулснаас бусад асуудлаар монгол улсын хууль тогтоох дээд байгууллагад Их цаазаар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж. Улсын Бага Хурал Их цаазаар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс Ардын Их Хурал Их цаазаар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх ямар ч боломжгүй болж байна. Та нар хэрвээ энэ Хавсралтын хуулийг нарийн аваад үзвэл энд та бидний төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг санаачилгаараа хэлэлцэн шийдвэрлэнэ гэсэн энэ бүрэн эрх чинь байхгүй болжээ.

Бүрэн эрхгүй ийм депутатууд бий болгоод өнөөдөр төр, засгийг ямраар ч хааш нь эргүүлж болно. Та бидэнд хяналт тавих ямар ч боломж байхгүй болно. Хэрвээ та бид Улсын Бага Хурал, Ерөнхийлөгчийн үйл ажиллагаа, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, өөрсдийн санал санаачилгаа оруулах, төрийн хуулийг буруугаар явлаа гэхэд түүнд ямар ч юм хэллээ гэсэн танд тийм эрх байхгүй гэдэг, ийм асуудал гарч ирэх боломж бий болжээ.

Ийм учраас энэ Үндсэн хуулийн хавсралтын хуулийг хийсэн хүмүүсийг би энэ дотроос би бол дээд шүүх, прокурорт бол итгэхгүй байна. Депутатуудын дотроос экспорт гаргах хэрэгтэй гэж үзэж байна. Энд Нэмэхийн Пүрэвдорж, Чагнаагийн Пүрэвдорж, Сэндэнжав, Гаравсүрэн, Ёндондэмбэрал гээд голдуу хуульч хүмүүсээр үүнийг гаргаад, үүнийг зайлшгүй ярих хэрэгтэй. Энэ бол Үндсэн хуулийн замаар төрийн эргэлт хийх гэсэн оролдлого гэж үзэж болох бүрэн үндэстэй гэж үзэж байна.

Хоёрдугаарт, Ардчиллын төлөө явдаг нөхдүүд минь та нар их ардчилал гэж их ярьдаг. Хэрэг дээрээ та нар Үндсэн хуулийн цэц гэдгийг 9 хүнтэй байгуулах юм бол Монгол улсыг дахиад нэг дарангуйллаас, нөгөө дарангуйлал руу оруулах гэж байна. Дарангуйллын нэг хэлбэрийг л сольж байна. Энэ 9 хүн чинь хэрэг дээрээ Улсын Их Хурлаас илүү их эрх мэдэлтэй, хэнд ч дарамт үзүүлж чаддаг, юуг ч хийж болох ийм онцгой эрхтэй 9 хүн бий болж байна дүү. Ийм учраас энэ 9 хүн бол ерөөсөө ч байж болохгүй гэж үзэж байна. Ийм онц ажилтай юмыг депутатууд маш нарийн үзэж өөрсдөө анхаараасай гэж санаж байна.

Би бол сэтгэлийн хөдөлгөөнд автдаг хүн. Гэхдээ энэ удаад автаад байгаа юм байхгүй гэдгийг бас анхаараасай гэж бодож байна.

Тэгэхээр би ийм л юм бодож байна. Дараагийн сонгууль хүртэл БНМАУ-ын Ардын Их Хурал улс орныхоо үйл ажиллагаанд ямар ч хяналт тавьж чадахгүй, ямар ч үүрэг гүйцэтгэж чадахгүй, ардын Их Хурлын бүрэн эрх, зөвхөн Улсын Бага Хурлын гарт шилжих юм байна. Үлдсэн энэ бүх хугацааны туршид хагас жил ч юм уу? Монгол улсыг хааш нь ч яаж ч туйвээсэн ямар ч хяналт байхгүй байх юм байна гэсэн ийм ойлголт төрж байна.

Нэг ноцтой юм санагдаж байна. Хэрвээ бид би бол Ерөнхийлөгчийн хүчтэй засаглал тогтоох талд байдаг хүн. Эвсэл, холбоодоос тавьсан шаардлага тийм байгаа. Гэхдээ өөрийнхөө саналыг муйхраар тулгах гэвэл бид оролцоогүй. Яагаад намууд парламентын засаглалтай байя гэж хүсээд байгаа юм бэ гэдгийг бид сонирхсон, анализ хийж үзсэн. Ингээд парламентын засаглалтай байх нь зүйтэй юм байнаа гэдэг дүгнэлтэнд хүрсэн. Үүний учир нь гэвэл хэрвээ парламентын засаглалтай байхгүй бол төрийн эргэлт гарах ийм бүх боломжууд бүрдэж байгаа юм байна. Жишээ нь бид, Засгийн газарт улсын аюулаас хамгаалах байгууллага, цагдаагийн ерөнхий газар хоёрыг хоёуланг нь өгчихөж байна. Ингээд Ерөнхийлөгч эзгүй хооронд ерөнхий сайд төрийн эргэлт хийх боломж бий болчихож байна. Ингэж үзэж болно.

Нөгөө талаар гэвэл энд нэг ноцтой юм харагдаж байна. Үүнийг юу гэж үзэх ёстой юм бэ би мэдэхгүй. Энэ бол үнэхээр хуулинд тусгагдаагүй байна. Бид дээд танхим, доод танхим гэж байгууллаа ч гэсэн хоёулангий нь ард түмэн сонгох ёстой. Доод танхимаа бол дээд танхим нь сонгох ёстой. Хэрвээ тэгэхгүй юм бол сүүлд нь биднийг сонгогдсон байгууллагадаа л тайлагнадаг болохоос биш өөр юманд тайлагнадаггүй учраас Улсын Их Хурал нь, Улсын Бага Хурлынхаа дэргэд юу ч биш, дахиад л энэ байдал хэвээрээ үргэлжилнэ. Ийм учраас Улсын Их Хурал бол ямар ч байлаа гэсэн тэр үйл ажиллагаа, өдөр тутмын үйл ажиллагаа

явуулдаг хүмүүстээ тайлангий нь сонсдог ийм байдал хэвээрээ үргэлжлэх ёстой гэж үзэж байна.

Ж.Уртнасан: Нэг минут үлдэж байна.


О.Лашбалбар: Би эндүүрээгүй бол 3 минут үлдэж байх шиг байна. Би түрүүн цаг харсан.

Ж.Уртнасан: Бид бас эндүүрээгүй болов уу гэж бодож байна.

О.Лашбалбар: Нөгөө талаас гэвэл би нэг юм бодоод байна. Намууд доод танхимд санал авч чадахгүй бол яах вэ? Хэрвээ сонгуулиар намуудын нэрийг оруулчихаад, бүх намууд санал авч чадахгүй уначихвал, тэр доод танхим чинь бүтэхгүй, та бидний баталсан Үндсэн хууль маань автоматаар дахиад унах болж байна.

Үүнийг бид яаж зохицуулах юм байгаа юм мэдэхгүй. Ийм учраас, намаар санал хураалаа ч гэсэн аль ч намын төлөө хүн санал өгөхгүй байвал яах юм бэ? Ерөөсөө тодорхой санал авч чадахгүй болчих ийм тохиолдол гарч болно шүү дээ. Ийм байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Г.Баасанжав/57-р тойргийн депутат/ -Би юуны өмнө

Их цаазын төслийн талаар өөрийн дүгнэлтийг хэлэхийг хүсч байна. Их цаазын төсөлд сонгогч олон түмэн, депутатуудын саналын дагуу ярилцах, авч үзэх, өөрчлөх зүйл нэлээд байгаа боловч ерөнхийдээ энэхүү хуулийн төсөл нь нэлээд чамбай боловсрогдсон, цаашдаа зохих завсарыг хийгээд батлаж болох хуулийн ноён нуруу болсон ийм төсөл болсон байна гэж үзэж байна.

Хуулийн төсөл боловсруулах комисс Бага Хурал энэ талаар ихээхэн хүч чармайлт гаргасныг би зориуд тэмдэглэн хэлэхийг хүсч байна. Энэхүү төсөлд дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц байдлыг харгалзан манай улс олон хэвшил бүхий эдийн засагтай байх явдлыг эрх зүйн талаар баталгаажуулсан байна.

Мөн хүний эрх, эрх чөлөөг дэлхий нийтийн хүлээн зөвшөөрсөн төвшин, хэм хэмжээнд аль болохоор хургэхийг анхаарч, батлагаажуулах талаас нь хандсан байна гэж үзэж байна. Мөн тэрчлэн нэг буюу хэсэг хүний удаан хугацааны дарангуйлал тогтох явдлаас энэ хууль болгоомжилсон асуудлуудыг оруулсан байна.

Их цаазын төслийг би нэлээд удаан хугацаанд цаашид мөрдөж болох, алсыг харсан, ирээдүйтэй төслийн ноён нуруу болжээ гэж үзэж байна.

Эцэст нь би цаг хэмнэх зорилгоор учир шалтгааныг тайлбарлаж цаг барахгүйгээр хуулийн төслийн талаар сонгогч олны санал, бодлыг тусгасан хэдэн санал давхардуулан хэлэхийг хүсч байна.

Нэгдүгээрт энд Улсын нэр, хуулийн нэрийг хэвээр байлгах саналтай байна. Сүлд, далбаа, тэмдгийг өөрчлөх шаардлага байна гэж үзэж байна. Энэ нь төрийн хуучин тогтолцооны үеэс шинэ

тогтолцоонд шилжиж, нэг үгээр хэлбэл бид хувьсгал хийж байна. Тийм учраас сүлдэнд өөрчлөлт орж таарах байх. Гэвч энэ сүлдээ бүрэн утга санаагаар нь өөрчлөх биш, одоо байгаа сүлд, тэмдэгт засалт, өөрчлөлт хийх замаар, сүлдэнд Монгол хүний олон үеийн турш дээдлэн хүндэлж ирсэн морь, нар, газар, шороо, уул, усаа дээдлэх бэлэгдлийг анхаарч үзэхийг санал болгож байна.

Төрийн тогтолцооны хувьд Ерөнхийлөгч нь харьцангуй их эрх мэдэл бүхий Парламентын Бүгд Найрамдах улс байвал ямар вэ гэсэн саналтай байна. Парламентыг одоогийнхоор Их, Бага хуралтай, Их Хурал нь хэд байдаг юм, 120, 150 орчим депутаттай, түүнээс Бага Хурал нь... одоогийнхоо зарчмаар явбал яасан юм бэ, засгийн газрыг засгийн эрх барих эрхийг авсан тэр нам бүрэлдүүлдэг байхаар энэ хуулийн төсөлд заавал ямар вэ?

Засаг, захиргааны хуваарийн хувьд хошуу гэдэг үгийг, би орон нутагт олон жил байсан, надад хуучин үзэл их бий, гэхдээ хошуу гэдэг үгийг хуулинд байхыг би зөвшөөрч чадамгүй байна. Тийм учраас аймаг, сум, сум нь баг гэж л хуваагддаг баймаар байна.

Улсын нийслэлийг Улаанбаатар гэж заах саналтай байна. Ерөнхийлөгчид Засгийн газрыг чиглүүлдэг эрх олгохоор энэ хуулинд Ерөнхийлөгчийн эрхийг өргөтгөж бодмоор байна. Ерөнхийлөгчид сонгогдох хүн 40 нас хүрсэн, Монголын гурван үеийн уугуул иргэн байна гэж тодотгон заах саналтай байна. Бусад саналуудаа би дараа нь хэлье.

Б.Доржготов /262-р тойргийн депутат/ -Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг гурван жил тутамд шинэчлэн сонгож, 6 жилийн хугацаагаар сонгоно гэсэн гуравдугаар бүлгээ 21-р заалттай уялдуулан хэлэхэд энэ саналаас миний санал нь зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл 4 жилийн хугацаагаар шууд сэлбэл-

гүйгээр сонгох саналтай байна.

Хоёрдугаарт мөн бүлгийн заалттай уялдуулан манай Ерөнхийлөгчийн насны хувьд 40,50 гэж хэлэхэд бэрхшээлтэй ч гэлээ, одоогийн олон улсын практик одоог үндэслэж манай улсын хувьд Ерөнхийлөгчийг 40 наснаас дээш насны хүн байх нь зохистой гэж ойлгож байна.

Гуравдугаарт Монгол улсын их цаазын цэцийг Монгол улсын Үндсэн хуулийн шүүх хэмээн нэрлэж, Улсын дээд шүүхийн дотор багтааж, шүүх эрх мэдэлтэйгээр байгуулж болох болов уу гэж ойлгож байна.

Дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн төсөлд манай орны ард иргэдийн сайн дурын үндсэн дээр нягтран байгуулагдсан олон нийтийн байгууллагуудын эрх үүрэг, үйл ажиллагааны талаар шинэ Үндсэн хуульд тодорхой зүйл ороогүй учраас энэ талаар тодорхой зааж, шинэ заалт оруулж өгөх болов уу гэж бодож байна.

Мөн хуулийн болон БНМАУ-ын нэрийн хувьд хэвээр нь үлдээх саналтай байна. Энд миний хувьд бас нэг зүйлийг ойлгохгүй байгаа юм. Түргүнд ч зарим зүйлүүд яригдаж байна лээ. Энэ онц эрх, бүрэн эрхийн тухай асуудлыг би ойлгохгүй байна. Ер нь Онц эрх, бүрэн эрхийн тухай асуудлыг бас жичид нь тусгаж өгмөөр юм. Ер нь манайд онц эрх, бүрэн эрх нэлээд тодорхой зүйл байдаг. Олон улсын хуулийн жишиг дээр ямар байдгийг мэдэхгүй байна. Гэхдээ онц эрхтэй, бүрэн эрхтэй улсууд байдаг.

Тухайлбал БНМАУ-ын элчин гэхэд Онц бүрэн эрхтэй элчин сайд гэж ярьдаг. Энэ нь тодорхой хүмүүсүүдэд онц, бүрэн эрх өгч байгаа учраас үүнийг хуулинд шууд зааж болдоггүй юм уу? Энд иргэний эрхийн тухай асуудал, нэг хүний эрхийн тухай асуудал, ер нь Ерөнхийлөгчийн эрхийн тухай асуудал байдаг

учраас онц эрх, бүрэн эрхтэй хүмүүсүүд нь хуулинд заалттай байхад болох болов уу гэж боддог.

Төрийн сүлдийг хэвээр нь байлгах бөгөөд, төрийн сүлдийн тухай асуудлыг бид нэлээд сайн ойлголоо, ярилцаж байна. Үүнийг бид ямар учиртай шувуу зурсан бэ гэдгийг бид сая киноноос тодорхой ойлголоо. Миний хувьд шувууг зүүдний амьтан юм уу гэж ойлгож байна. Би хуучин цагаан шонхор гэсэн үүлдрийн шувуу манай суманд байхгүй гэж бодоод байсан юм. Тэгсэн энэ нь манай суманд бишаймагт ч байхгүй, сая кинонд харсан чинь Монголд байхгүй амьтан байж мэдэхээр юм байна. Тийм учраас байхгүй юмыг бид сүлд дээрээ тавиад яах вэ? байдгаар нь үүнийг хэвээр байлгах нь дээр гэж ойлгож байна.

Засаглалын хувьд гэвэл ардчилсан өөрчлөлтийн өнөөгийн нөхцөлд Парламентын засаглал байх нь нийцтэй. Тийм учраас Парламентын, тэхдээ одоогийн Бага Хурал, Их Хурал гэсэн хоорондоо авцалдахгүй олон танхим байснаас нэг л танхимтай Парламент байх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Одны анхаарал татсан ихээхэн эмзэг асуудал гэж бодож байна, орон нутгийн засаг захиргааны нэгжийн тухай асуудлыг. Өчигдөр бид Бага Хурлын дарга, Дэд Ерөнхийлөгчөөс ярьсан зүйлээс тодорхой тайлбар авсан. Энд яагаад үүнийг өөрчлөх шалтгаан байсан юм бол гэж бодсон. Төрийн засаглал, төрийн бүрэн эрх мэдлийн тухай асуудал байсан юм шиг байна гэж бид ойлгосон. Яагаад хошуу байгуулах гэж оролдсон юм бэ гэвэл гурван зүйлийг учир шалтгаантай нь уялдаатай авч үзсэнгүй.

Тухайлбал орон нутгийн засаг захиргааны нэгжийг байгуулах асуудлыг авч үзэхдээ нэгдүгээрт, төрийн, хоёрдугаарт эдийн засгийн, гуравдугаарт нийгмийн ийм гурван зүйлийг холбоотой авч үзээгүйгээр зөвхөн төрийн авч үзсэнээс хоёр зүйл маш их зөрчилтэй гэж үзэж байна.

Практикт засаг, захиргааны нэгж, үйлдвэрлэлийн нэгж хоёрыг хожуланг бид уялдаатай авч үзмээр байна. Бид их зүйл устгалаа. Хуучин суурь гэж байхгүй мөн томсгосон суурь байхгүй, баг байхгүй, бригад байхгүй, нэгдэл гэж байсан, нэгдэл ч байхгүй. Үлдэж байгаа ганц сум байсан, үүнийг аваад хаячихвал орон нутагт юм үлдэхгүй юм байна. Тэгээд төр, ард түмний холбоо холдох юм шиг байна. Үүнийг би депутат хүн бүр ойлгож байгаа байх гэж бодож байна. Жишээ нь Улаанбаатар хотын хороог нь Өмнөговь аймагт байгуулвал энд байгаа ард түмэн бухимдахаас өөр аргагүй. Энд үйлдвэрийг нь орхиод, ард түмнийг нь орхиод, хороог нь өөр газар тавьчихвал бүх хүн бухимдана. Түүн шиг бүх зүйлийг холдуулвал хэцүү байх болов уу гэж ойлгогдож байна.

Ер нь үйлдвэрлэлийн нэгжүүд нь засаг захиргааны нэгжид чухал туслалцаатай байсан. Хөдөөд одоо үйлдвэрлэлийн нэгж байхгүй болсон, засаг захиргааны нэгж нь өнөөдөр бэрхшээлтэй гэж яригдаж байна. Мөн үүнтэй холбоотой аймгийн нэгдлийн холбоо, нэгдлийн холбооны дээд зөвлөл гэсэн их юм байсан одоо мөн л буулгах, байхгүй болгох тухай асуудал ярьж байгаа юм гэнэ лээ. Үлдэж байгаа юм гэвэл Ардчилсан холбооны дэргэд Ардын аж ахуйтны холбоо бий болсон гэсэн, манай Засгийн газар сая төгрөг өгөх шиг боллоо. Үүнийг л манай суманд 400-гаад малчинд 400 компьютер, 400 хөдөлгөөнт тоглоом тавьж байгаад Улаанбаатар хотоос удирдахгүй юм бол яагаад ч энэ орон нутгийг удирдаж болохгүй байх нь байна шүү. Үүнийг ард түмэн ойлгож байгаа байх гэж бодож байна.

С.Пүрэв /240-р тойргийн депутат/ - Үндсэн хуулийн төслийг үүний урьд ч төслийг авч танилцаж, сонгогчиддоо ярьж, хэлж ойлгуулсан.

Ж.Уртнасан - Уучлаарай! та нэрсийн жагсаалтанд ороогүй юм байна шүү дээ. Чинбат уг хэлээрэй.

С.Пүрэв - Би Жумбаанбаатарын урьд талд байсан юм. Өглөө 240-р тойрог, С.Пүрэв гээд бичсэн шүү дээ. Чинбат миний дараа бий. Хүмүүс бүгд мэдэж байгаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн
Бичээч С.ТУУЛ

С.Пүрэв

Ц.БАЯРМАА

Ж.Уртнасан:—За бид учрыг нь олъё.Одоо Чинбат уг хэлнэ.

Ардын Их Хурлын 245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат:—Монгол улсын Их цаазын төсөл, шүүнийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан энэ төслийг сонсож мэдлээ.Тэгэхлээр энэ төсөл боловсруулахад ажилласан комисс, ажлын групп, мэргэжлийн аппарат, бусад хүмүүсүүд энэ төсөл дээр олон хоног, олон сар их хүч хөдөлмөр зарцуулсан нь мэдээж юм. Энэ утгаар нь авч үзэж, тэдний хөдөлмөрийг үнэлж, зохих хүндэтгэл илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.Гэвч уг төслийн субъект болж байгаа Улсын Бага Хурал, төсөл боловсруулах комиссын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж хэлмээр зарим нэг зүйл байна.

Их цаазын төслийн талаар ард түмнээс маш олон санал ирсэн. Ирсэн саналын утга агуулгууд нэлээн тодорхой байгаа.Тухайлбал Их цаазын төслийг нэлээд олон үе шаттай хэлэлцүүлснийг бид мэдэж байна.Бүх депутатууд өөр өөрийн тойрогт сонгогчидтойгоо уулзаж, тэдний санал хүсэлтийг харилцан ярилцаж, санал хүсэлтийг нь авсан.Их Хурлын депутатуудын бүсчилсэн зөвлөлгөөн хийсэн.Одоогоор ч гэсэн Ардын Их Хурлын II хуралдаанд оролцож байгаа депутатуудын санал бодлууд ерөнхийдөө нийтлэг нэг зүйл уруу чиглэгдэж байгаа нь мэдрэгдэж байна.Өөрөөр хэлбэл энд улсын нэр, хуулийн нэр, төрийн сүлд, далбаа, бусад асуудлуудыг хэвээр нь байлгаж гэсэн олон нийтийн нийтлэг санаа бодол явж байсан.Гэтэл одоо энэ асуудлыг Улсын Бага Хурал хоёр удаагийн хуралдаанаар энэ ард түмнийхээ санаа бодлыг үндсэнд нь нидэрчихлээ гэдэг юм уу юу гэдэг юм үндсэнд нь хааж боож амжжээ.Өөрөөр хэлбэл Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж байхад Монгол улс болгоод, Үндсэн хууль гэж байхад Их цааз болгоод, төрийн сүлдийг нь шувуу болгоод, тэгээд одоо төрийн дуулал нь ямар дуу байж байгаа юм, нэг дуу байгаа байх энэ мэтчилэнгээр ерөөсөө өөрчлөхийн дон туссан юм шиг бүх юмыг нь өөрчилсөн, үүнд ард түмэн төр засагтаа итгэх итгэл бол зарим нэг хэмжээгээр алдарч байна.Ер нь одоо энэ Улсын Бага Хурлын нөхдүүд чинь юу ч хийж мэдэх гэсэн санаа бод-

лууд гарч, энд олон түмэн нэлээн эмзэглэж байна. Үүнээс үүдэж энэ Үндсэн хуулийн шинэчлэх, энэ манай Үндсэн хууль шинэчлэгдлээ гэдэг ийм шалгуур нь бол хэдэн зүйл байх юм болов уу гэж бодогдож байна. Өөрөөр хэлбэл зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа нөхцөлд түүнд зохицсон төрийн тогтолцоо бий болгосноор Үндсэн хууль шинэчлэгдлээ гэж олон түмэн хүлээж авах ёстой гэж үзэж байна. Тэрнээс энэ бүх төрлийн нэрийг өөрчилснөөр Үндсэн хууль шинэчлэгдэх юм байна гэж ойлгохгүй байна. Хэвээрээ байж байгаа гэдгээрээ бол бас одоо манай Монголын ард түмэн бол хуучнаараа ингээд налайгаад байгаа юм байна гэсэн ойлголт ч бас буруу болов уу гэж бодогдож байна. Ялангуяа өнөөдөр манай эдийн засгийн байдал улам гүнзгий хямралд орсон, ард түмний аж амьдралын баталгаа өнөө маргаашаар хэмжигдэж байгаа энэ нөхцөлд бол манай ард түмний тэр зөн мэрэгч, мэргэн ухаан бол нэг хэсэгтээ хуучин нэр, сүлд, бүх зүйлийг хэвээр нь хадгалж байвал бас илүү зохимжтой байх юм болов уу гэсэн ийм ухаан байгаа болов уу гэж ингэж бодогдож байна.

Хоёрдугаарт бол энэ төрийн байгууламж Ерөнхийлөгчийн засаглал, гүйцэтгэн захирамжлах засаглал, парламентын засаглал, энэ газрын өмчийн тухай асуудал, цагаачлалын тухай асуудал үүнд л депутатуудын гол зөв онч мэргэн шийдвэр чиглэгдэх байх. Үндсэн хуулийн гол хэсэг ч үүнд чиглэгдэх байх, энэнийг яаж зохицуулснаар бид одоо шинэ Үндсэн хуулиа хууль шиг хууль болгох юм байна гэсэн ийм л зүйлүүд. Энд гол хүчээ чиглүүлэх нь зүйтэй юм. Тэрнээс биш одоо ер нь бүх нэрийг өөрчилж, энд гол анхаарлаа ханцуулах нь бас төдийлөн оновчтой биш байна гэсэн ийм зүйл хэлмээр байна. Ингээд Их цаазын төслийн зүйл, бүлэг тус бүрийг хэлэлцэх үед нь бусад саналаа тухайн үед нь оруулж саналаа оруулна гэж бодож байна.

Ардын Их Хурлын 424 дүгээр тойргийн депутат
Бадамсүрэн:- Тэгэхлээр та бидний хэлэлцэж байгаа энэ чухал бичиг баримт маань амьдралд бодитойгоор зардал чирэгцэл багатайгаар хэрэгжих, улс орныхоо онцлог, хэт ирээдүйг ухаалгаар

төсөөлөн тусгасан, олон улсын ерөнхий жишигт нийцсэн ийм хууль байгаагаар гэсэн байр сууринаас асуудалд хандаж байна. Ингээд дараахь хэдэн саналыг хэлье.

Нэгдүгээрт, газар, түүний хэвлийн талаар манай ард түмэн ихэд сонирхож, Үндсэн хуульд юу гэж тусгах бол гэдгийг ширтэн харж байна. Мөн түүний цаана гадаад орнууд чухам энэ асуудал Монгол улсын Үндсэн хуульд яаж тусгах бол гэдгийг ихээхэн сонирхож байна. Энэ нь ч гэсэн гадаадын зарим орнууд манай улсад цаашид хандах хандлага, манай гадаад харилцаанд нөлөө бүхий асуудал гэж үзэж байна. Ийм учраас газар, түүний хэвлийн асуудлыг Үндсэн хуульдаа юуг нь тусгах, цаашид батлагдан гарах газрын тухай хуульдаа юуг нь тусгах гэдгийг их ухаалгаар, алсын хараатай бодох ийм чухал асуудал гэж бодож байна. Тодорхой асууцлаа зүйлийг хэлэлцэхэд нь хэлье.

Дараагийн асуудал бол, нэг санал бол энэ засаг захиргааны нэгжийн талаар санал байна. Төсөлд тусгагдсан аймаг нь хошуунд, хошуу нь багт гэсэн заалттай санал зөрүүтэй байна. Аймаг, сум, баг гэсэн хуваарьтай байх саналтай байна. Энэ талынхаа зарим нэг үндэслэлийг хэлье гэж бодож байна. Юуний өмнө Дамдиндорж гуайн хэлсэнчлэн сумын төв нь сумын хөдөлмөрчид, малчдын үйлчилгээний төв гэдгийг үндэс байх ёстой гэж бодож байна. Өнөөдрийн энэ зохион байгуулалт ч гэсэн энэ үйлчилгээний төв нь малчид хөдөлмөрчдөөсөө холдож байгаа. Тухайлбал Өмнөговь аймгийн Хүрмэн сум гэхэд л зарим малчид суурь нь сумынхаа төвөөс 200 шахам км алслагдсан байгаа. Түүнийг одоо хошуу болгоод өшөө алсад аваачвал энэнийг малчид, хөдөлмөрчид ойлгохгүй байх аа.

Малчин хүний хөдөлмөрийн онцлог, энэ зам харилцааны байдалаас шалтгаалаад энэ сумын төв, үйлчилгээнийхээ төвд хүрэхэд ихээхэн хүндрэлтэй байдаг гэдгийг та бид ойлгож байгаа. Нөгөө талаар энэ улсын хөгжилтэй авч үзэж болох асуудал гэж бодож байна. Өнөөдөр манай оумууд нэлээн тодорхой хэмжээнд хөл цээрээ зогслоо гэж бодож байна. Энэнийгээ улс орныгоо цаашид жигд хөг-

4.

жүүлэхэд ч гэсэн одоо байгаа сумуудаа сум шиг сум болгоод хөдөө аж ахуй, үйлдвэрийн цогцолбор байлдаар хөгжүүлэх нь илүү үр дүнтэй байх гэж бодож байна.

Дараагийн нэг үндэслэл бол боловсон хүчний бодлоготой ч гэсэн холбож үзэх үндэстэй болов уу гэж бодож байна. Өнөөдөр гэхэд манай чадвартай эрдэмтэн мэргэд бол төв, суурин газартаа ихэнх нь төвлөрч байгаа. Хошуу байгууллаа гэж бодоход сумдад байсан одоо энэ нэлээн чадавхитай боловсон хүчин тэр төв уруугаа нэлээн тэмүүлэх хандлага гарна. Хошуу боллоо гэхэд өнөөдрийн сум энэ боловсон хүчний хувьд ч, одоо энэ байшин барилга, бусад тогтолцооныхоо хувьд яг энэ дүр төрхөөрөө үлдэнэ гэхэд би итгэхгүй байна. Нөгөө талаар зарим хүмүүсүүд энэ хошууны асуудлыг авч үзэхдээ хүн ам зүйн бодлоготой уялцуулж үзэж байх шиг байна. Энэн дээр би санал зөрөөтэй байна. Энэ хэдэн сумыг нэгтгээд нэг хошуу болгосноор манай малчид дураараа, тэнд нааш цааш нүүдэлж байх ийм үндэс бий болохгүй гэж бодож байна.

Манай малчид бол сэтгэл санаанаасаа илүү малдаа захирагдаж байдаг. Өөрөөр хэлбэл нутаг усандаа дассан малыг өөр газар суурьшуулахад нэлээн хүндрэлтэй асуудал бий. Манай малчид сурсан газрын шороо хоол гэж хэлсэн нь бол санамсаргүй асуудал биш гэж үзэж байна.

Нөгөө талын асуудал бол энэ бас зах зээлтэй ч бас холбоотой. Хувьчлал явагдаж байна. Энд өвөлжөө бууц, худаг усыг нь хувьчилсан тохиолдолд нэг их ч нааш цааш нүүдэллээд яваад байх ийм асуудалд хүрэхгүй байх. Мөн зах зээл ч гэсэн аль төвлөрсөн чиглэл уруугаа чиглэгцэж байгаа. Өнөөдөр гэхэд тэнд махны үнэ төв суурин газар ямар байна. Хөдөө нутагт ямар байна гэдгээс аваад үзэхэд ойлгомжтой байх аа гэж бодож байна.

Туравцугаар нэг асуудал бол зүгээр манай хүмүүс, депутатууд

та бид ч гэсэн нэлээн одоо тийм туйлшрах хандлага байна уу гэж надад ойлгогдож байна. Энэ бол миний хувийн бодол шүү. Нэг хэсэг нь олон зуун жилийн өмнөх уламжлалаа шууд авч сэргээх, нэг хэсэг нь манай эрин үе, түүний адил манай улс орон эрс өөрчлөгдлөө. Улс төрийн тогтолцоо, нийгэм, эдийн засгийн төрх байдал талаасаа ч гэсэн ийм байр сууринаас хандаж байна. Гэхдээ манай улс орон ард түмний сүүлийн 70 жилийн түүхэн, гэвч ээдрээтэй, нугачаатай энэ зурвас үеийг харгалзахгүй байх боломжгүй. Ийм учраас энэ бүх асуудлыг тусгаад одоо бэлгэдлийн чанартай улсын нэр, Үндсэн хуулийн нэр, энэ сүлд, далбааныхаа асуудлыг шийдэх ийм саналтай байна. Баярлалаа.

Ардын Их Хурлын 307 дугаар тойргийн депутат М. Доржсүрэн:
 -Бага Хурлын боловсруулсан хуулийн төслийг бид өчигдрөөс хойш ярилцаж бас кино үзэж, их зүйл мэдэж баяжууллаа мэдлэгээ. Тэгэхлээр энд бидний дутуу мэдэрч, Бага Хурлын гишүүдийн хөдөлмөрийг дутуу үнэлж байсан зүйл бас байсан гэдэгт эргэлзэх юм алга. Ингээд товчхон хэлэхэд түрүүчийн бидний бодож байсан бүх сүлд, тамга гээд бүгдийг өөрчилье гэсэн ийм сэтгэгдэлтэй ирсэн. Одоогийн байдал дээр бас зарим зүйл дээр өөрчлөлт хийхэд болох юм гэсэн ийм санал төрлөө. Жишээлэх юм бол одоо тэр соёмбо байна, мөн төрийн туг байна, эд нарыг өөрчилсөн хэлбэрээр нь батлахад болохгүй ч юм байхгүй юм байна гэсэн ийм саналтай буцаж байна. Энэнийгээ бол сонгогчиддоо ч хэлэх юм аа. Бусад улсын нэр байж байна, сүлд байж байна, мөн тамга гэх мэтийн зүйлүүдийг хуучнаар нь байлгая гэсэн энэ саналаа хэвээр нь байлгах саналтай байна. Энэ саналыг цаашид олон хүн давхардуулж хэлэх байх.

Ийм учраас энэ үндсэн зургаан зүйл дээр санал хураачихвал хүмүүсийн хэлэх үндсэн санааны нэлээн хэсэг нь шийдэгдэх болов уу гэж бодож байна. Бага Хурлын гишүүдийг бас, манай хөдөөгийн хөдөлмөрчид бага хүлээж авч байсан нэг зүйл бол энэ үндсэн зургаан зүйлийн нэр дээр их яригдаж байсан. Ийм учраас

энэнийг ингээд шийдвэл Бага Хурлын шүүмжлэлийг цааш нь үргэлжлүүлж Их Хурлынхан хүлээж авмааргүй байна.

Хоёрдугаарт нь газрын талаар байна. Нэгэнт зах зээлд шилжиж чөлөөтэй бүс бий болох, чөлөөтэй харилцах олон улсын харилцаа бий болж байгаа нөхцөлд мөн ч одоо газрыг хөдөлгөөнд оруулж болох юм шиг санагцлаа. Гэхдээ юүний өмнө газрыг их ухаалаг хэрэглэх ёстой гэж бодож байна. Ялангуяа гаднын хүмүүс, харьяалалгүй хүмүүст газар өгөх асуудлыг тусгайлан хуулиар батлахгүй бол энэ бас Монгол улсын удам угсаа, тусгаар тогтнолд нөлөөлөх зүйл байна уу гэсэн ийм эргэлзээ төрж байна. Энэнийг бас цаашид бодуштай юм шиг бодогцлоо.

Засаглалын хувьд Үндсэн хуулийн Их цаазын төсөлд орсонтой санал нэгтэй байна. Харин орон нутгийн засаг, удирдлагын хувьд хошуу гэдэг дотор баг багтахгүй байна. Ийм учраас багийн эрх, оцоогийн сумын эрх хоёр үндсэндээ ойролцоо байгаа учраас нэг хэсэгтээ сумыг хэвээр нь байлгаж, ер нь оруулах өөрчлөлтийг өнөөдөр зарлах биш, улс орныхоо өнөөгийн эдийн засаг, нийгмийнхээ байдлыг сайн судалж, хөдөлмөрчийн саналыг тусгасны үндсэн дээр дараагийн парламент, Их Хурлынхаа хэмжээнд шийдвэл яасан юм бэ гэсэн ийм саналыг хэлж байна. Бусад саналаар түрүүчийн хүмүүстэй адил байна.

СОРОНЗОН ХАЛБСТАЙ
ТУЛГАЖ НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

411-р тойргийн депутат Ц.Д. ваажид: -УБХ, Улсын ерөнхийлөгч Их цаазын төсөл дээр их ажиллажээ. Энийг зүй ёсоор үнэлж байна. Гэхдээ энэ дээр цаг үеэ зөв мэдэрч, олон түмнийхээ санаа сэтгэлийг тусгах талаар бас төдийлөн сайнгүй ажилласан гэсэн дүгнэлтийг зүй ёсоор хийж байна. Ингээд санал зөрүүтэй хэдэн асуудлын талаар хэлмээр байна. Тухайлбал эхлээд Их цааз гэсэн нэрнээс авахуулаад хүлээж авамгүй байна. Их цааз гэсэн нэр бол үнэхээр ард түмнийхээ бэлгэ дэмбэрэлийг бодсон ч ард түмнийхээ сэтгэлд буух талаас нь ч бодсон энийг үнэхээр хүлээж авамгүй байна. Энэний оронд бид үндсэн хууль км уу, үнэхээр болдоггүй бол их засаг гэсэн ийм хэлбэрээр байвал зүйтэй км гэсэн ийм санал байна. Нөгөө талаар улсын нэрийг өөрчлөх зайлшгүй шаардлага бол бидэнд гараагүй. Энэ бол ингэж зардал гаргаж байх бидэнд тийм эрх ч алга. Өнөөдөр ард түмний маань аж амьдрал, ямаршуу төвшинд байгаа билээ, гэтэл бид чинь зайлшгүй биш юманд хөрөнгө зараад байх тийм эрх бидэнд өнөөдөр алга. Энийг зүй ёсоор хэлмээр байна. Мөн төрийн сүлдний хувьд мөн ийм бодолтой байна. Төрийн сүлдний хувьд бол ганцхан энэ дээр коммунизмын улаан наран өөд гэдгийг нь өөрчлөөд тайлбар дээрээ бид ургахын улаан наран болгодог км уу, мандах наран болгодог км уу ингэж өөрчлөн засвар оруулаад, энэ хэвээр нь байлгах саналтай байна. За мөн харин төрийн тугны хувьд бол зайлшгүй өөрчлөх шаардлага боломж байна гэж үзэж байна. Төрийн туг бол яахав энд өөрчлөөд ч нэг их зардал гараад байх юу байхав. Ер нь одоо энэний хувьд бас их аятайхан бэлгэдэлтэй, хэлтгий заяа гэдгийг ч бодсон аль ч талаас нь бодсон төрийн тугийг хүлээж авах ийм бодолтой байна. 2-р зүйл бол энэ газар өмчлөлийн хувьд үнэхээр энийг бол газрыг өмчлөх асуудлыг бол хуульд ингэж орууламгүй байна. Энэний оронд харин газрыг эзэмшинэ гэдэг асуудлаар л бид оруулъя. Үнэхээр газар гэдэг маань бид өөрснөө хүн бий болгочихсон км биш ээ. Өөрснөө бид чинь газар, эх дэлхийгээсээ бий болсон улсууд. Тэгэхлээр ерөөсөө энийг нэг бодоход бид ээж ааваа миний өмч гэж хэлсэнтэй ялгаагүй гэж ойлгож байна. Тэгэхлээр энийг бид ерөөсөө хүлээж

авамгүй байна. Нөгөө талаар газрыг гадаадын иргэд түрээслэх тухай асуудал байна. Энэ дээр бид үнэхээр ийм улс орны эрх ашгийн үүднээс ийм асуудал гарч ирж болох юм. Хэрвээ тэгэх юм бол үүнийг бүх ард түмний санал асуулгаар шийдэж байх нь зүйтэй. гэж бодож байна. Тэгэхдээ эсвэл нөгөө талаар л хугацаа зааж өгмөөр байна. 10 жил гэдэг юм уу, 20 жил гэдэг юм уу, ийм тодорхой хугацаагаар түрээслүүлж болно, цаашдаа монгол улсын газар нутаг хэвээрээ байх юм гэсэн ийм тодотголыг зайлшгүй оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаар энэ төрийн тогтолцооны хувьд бол санал байна, энэ дээр энэ төсөлд заасан төрийн тогтолцоог бол үнэхээр хүлээж авамгүй байна. Хэрэв үүнийг хүлээж авах юм бол энэ 76 гишүүнтэй энэ парламент байгуулагдаад энэ тохиолдолд тойргийн сонгогчид хэт их олон болно, тойрог ч томроно, үүнээсээ үүнтэй адилхан сонгогчидоосоо депутат хэт алслагдана, ингээд ерөөсөө сонгогчдын өмнө хүлээх хариуцлага эрс суларна. Сонгогчдын зүгээс депутатыг огцруулах ч юм уу ямар нэгэн тийм асуудал үнэхээр одоо ингээд тийм магадлал барг байхгүй болно гэсэн үг. Тэгэхлээр энэ асуудлыг үнэхээр болохгүй. Өнөөдөр бид ардчиллыг хөгжүүлнэ гэж ярьж байгаа энэ нөхцөлд бол энэ манайд тохирохгүй гэж үзэж байна. Харин манай өнөөдрийн тогтолцоо бол нэлээн ардчилсан хэлбэрт дөхөж очсон ийм тогтолцоо гэж үзэж байгаа. Миний хувьд бол. Тэгэхлээр одоо энэ дээр бид өнөөдрийнхээ энэ байдлаар тэгэхдээ бид их засаг хуулиа баталчихаад ингээд цаашдаа их хурал л зөвхөн энэ өнөөдрийнх шиг ийм өндөр үүрэг хариуцлагатай биш байх байх. Тийм учраас энэний хувьд бид 215 гишүүнтэй, 2 тойргийг нэг тойрог болгосон ийм байдлаар зохион байгуулбал ямар вэ гэсэн ийм бодолтой байна. Улсын бага хурлыг 20-30 гишүүнтэй гэсэн түрүүчийн хүмүүсийн үгийг бол зөвшөөрч байна. За орон нутгийн тогтолцооны хувьд бол аймаг, сум, баг гэсэн ийм тогтолцоотой л байх нь зүйтэй. Тэр сумыг заавал хошуу болгож өөрчилснөөр бас л өнөө зардал чинь гарна. Өнөөдөр ядуу тарчиг байгаа амьдралтай ард түмэн маань энийг чинь зайлшгүй юм биш дээр яах гэж хөрөнгө зараад байгаа юм бэ гэдэг асуудалд хүрнэ, энийг бид ойлгоё гэсэн ийм бодолтой байна. За тэр хавсралт хуулийн хувьд бол өчигдөр Гончигдорж дарга ярилаа. Их цаазын нэг хэсэг гэж үзэх нь зүйтэй гэж, би бол тэгж үзэхгүй байна. Хавсралт хуулийг бол үнэхээр тусад нь онцгой байдлаар авч үзэх хэрэгтэй, ерөөсөө, энийг бол одоо бид улсын бага хурлын

тайлан, Засгийн газрын тайланг хэлэлцсэнийхээ дараагаар хавсралт хуулийг дахин нухацтай авч яримаар байна. Тэгэхгүй бол саян Дашбалбарын ярьдаг, бусад депутатуудын ярьдаг энэ байдал чинь гарч ирнэ. Энэ тэгэхгүй гэхийн баталгаа алга аа үнэхээр. Тийм учраас бид хавсралт хуулийг хамгийн сүүлд хэлэлцэх ийм саналтай байна. Ийм л байна.

229-р тойргийн депутат Т.Төмөрбаатар: -Үндсэн хууль боловсруулах талаар Улсын комисс, бага хурал их хөдөлмөр зарж зохих хэмжээнд боловсруулсан гэж үзэж байна. Цаашид энэ их хурлаар улам боловсронгуй болгож батлах нь өнөөдөр чухал ач холбогдолтой юм. Иймд Үндсэн хуулийн төсөлд сонгогчид, хөдөлмөрдөө төлөөлж зарим саналыг тайлбарлахгүйгээр шууд хэлбэ. I. Дэлхийн олон орнуудын мэдэх БНМАУ- гэсэн нэрийг дэмжиж байна. Хуулийн нэрийг Үндсэн хууль гэж тогтмоор байна. Ерөнхийлөгчид ихээхэн эрх эдлүүлж үүрэг хүлээлгэсэн хүлээлгэж ард түмнээс шууд сонгомоор байна. Ерөнхийлөгчийн насыг миний бодлоор бол 40-өөс дээш насны хүн байвал зүгээр болов уу гэж ингэж бодож байна. АИХ, УБХ гэсэн 2 танхимтай, төрийн тогтолцоог дэмжиж байна. Улсын бага хурал 30 орчим гишүүнтэй, байнгын ажиллагаатай, их хурал нь 200 орчим гишүүнтэй, жилд нэг удаа хуралддаг, тухайн жилд гарсан хуулиуд, эрх зүйн актыг баталгаажуулж, бага хурал, Засгийн газарт үнэлэлт өгдөг ард түмний дунд байнга ажилладаг танхим байлганаар санагдах юм. Эдгээр **төрийн тогтолцооны** хугацааг бүгдийг нь ижил 5 жилээр болгомоор байна. Төрийн соёмбо, далбаа, сүлдэнд зарим засвар хийж, тайлбарыг нь өөрчилж батлах саналтай байна. Гэхдээ шувуутай сүлд, их цааз гэж нэрлэсэн хуулийг олон түмэн хүлээж авахааргүй байгааг бас анхаарч үзмээр байна. Ер нь төслийг ард түмнээр хэлэлцүүлсэн боловч олон түмний санал бага тусгагдсан гэж үзэх үндэстэй байна, манай хууль монгол хүний амьдралд тохирох монгол уламжлалыг бататгасан ийм хууль байх ёстой болов уу гэж бодож байна. За газар, түүний хэвлий ямар ч үед өөрийн төрийн онцгой мэдэлд байх хөдөлшгүй өмч гэж үзвэл зохино. Харин ашиглалтын хэлбэр янз бүр байж болох талтай юм. Өмчийн олон хэвшлийг үндсэнд нь хуулиар заахыг цацуу хүмүүс бие биенээ дарлах, дарлагдах, мөлжлөгийн аливаа хэлбэрийг хэлбэргүй

байхыг хуульчлан заах, үүний дагуу иргэний үүрэгт иргэд бие биеийн амь нас, амгалан тайван байдал, өмчийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхаар хуулинд тодорхой заавал дараагийн салбар хуулиуд бас нэлээн учир зүйтэй гарах болов уу гэж ингэж бодож байна. Мөн төр, иргэний өмнө үүрэг хүлээхдээ хүний нэр төрийг хамгаалахад анхаарч, энэ талаар үндсэн хуулинд тусгах хэрэгтэй байна. Үндсэн хуулинд засгийн газрын үүрэг, хариуцлагыг нэлээд өндөржүүлэх, тодорхой тусгамаар санагдах юм. Одоогийн энэ манай засгийн газар ард түмний амьдралын төвшин үүний баталгааг урсгалд нь явуулж байгаагаас байгаа юм. Энийг тодорхой зорилготой, чиглэлтэй байлгаж одоо чиглүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Үүний тулд яам, газруудын үүргийг ч гэсэн тодорхой болгууштай байна. Дээр бага хурлын гишүүдийн тоог цөөлж хэлсэн нь бол яам, газруудын үүргийг бас өндөржүүлж, яам газрууд бас бага хурал, засгийн газартай хамтарч хууль боловсруулах тийм эрх хэмжээтэй байж, тэр одоо хариуцсан салбараараа монголын ард түмний өмнө тодорхой үүрэг хүлээмээр санагдаж байна. Өнөөдрийн яам, газрууд ер нь тайлбарлагч төдий байгааг шүүмжилж хэлмээр байна. Үндсэн хуулийн цэцийг онцгой бэхжүүлэх талаар олон түмний саналыг тусгах нь зүйтэй гэж бодож байна. Иймд улсын дээд шүүхийн бүрэлдэхүүнээс салангид нь хямдхан одоо нүсэр биш тийм аппараттайгаар үндсэн хуулийн цэцийг байгуулах нь зүйтэй гэж ингэж бодож байна. Дараа нь манай сумын хөдөлмөрчид, малчдын хүсэлт байна. Энд бол монгол улсын хөдөөгийн засаг, захиргааны нэгж нь тухайн мал сүрэг, аж ахуйгаа эрхлэх өөрийн мэдлийн 4 улирлын нутагтай болох шаардлагатай юм ийм л үндэслэлийг хошуу ч бай, сум ч бай одоо батална шүү гэсэн ийм хүсэлт байгаа юм. Ер нь бол өнөөдөр амьдрал дээр сум ч бай, хошуу ч бай өнөөдрийн байдлаар бол зайлшгүй өнөөдрийн зохион байгуулалт, өөрчлөлт гэх ёстой. Зарим сумд бол мал нь олон, нутаг байхгүй, өвөлжөө, хаваржаа байхгүй байна. Зарим газар өвөлжөө байна, хаваржаа байна, тэгтэл мал нь цөөн одоо эзэнгүйдэж байна. Энэ байдлыг одоо зохицуулж зохион байгуулах ёстой. Өнөөдрийн сумын зарим сум бол 40 орчим мянган малтай, засаг захиргааны нэгж нь яг ижилхэн одоо орон тоо ажиллаж байна. Зарим сумд зэргэлдээ 100 мянган малтай тийм сум ч байна. Энийг сум гэж нэрлэдэг ч бай, хошуу ч гэж нэрлэдэг бай ямар ч байсан өөрчлөх ёстой гэж бодож байна. Гэхдээ энэ өөрчлөлтийг

1995 он гэж бодож хойш нь тавибал өнөөдрийн сумууд өөрчлөгдөнө гээд олон жил хүлээгээд сууж байвал ажил ямар болох вэ гэдгийг бодож, ер нь энэ нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, өөрчлөлтийг даруйхан эхлэх ёстой болов уу гэж ингэж бодож байна. Монголын эдийн засгийг миний бодлоор бол хямралд орох байнга хямралд ороод байх эдийн засаг гэж ойлгохгүй байна. Энэ талаасаа бодож энэ биеэ даасан эдийн засагтай байна, бие дааж ажиллана гээд байгаадаа бол нэлээн их дүгнэлттэй ажилламаар байна. Энэ талаар энэ гадаад улстай янз бүрийн зээл тусламжийн асуудлыг бол их бодолцож үзэж энийг бол ард түмэнд их тайлагнамаар байна. Би энэ янз янзын зээл тусламцааг бол хөрөнгө оруулалтын шугмаар эргэж нөхөх чадвартай байдлаар ашигламаар байна, гэтэл манай зээл бол тийм биш байна. Өдөр тутмын аар саар хэрэгцээг хангах талаасаа их анхаарч байна. Нөгөө талаар иргэний хүнлэг ардчилсан нийгэм байгуулна гэсэн энэ зорилгын үүднээс авч үзвэл өмчийн олон хэлбэрийг аливаа хэлбэр гэж ингэж бүдүүрч тусгамааргүй байна. Улсын өмч, хоршооллын өмч, хувийн өмч, бусад хамтын өмч дундын өмч гэж нэрлэхгүй бол өнөөдр аливаа гэж хэлчихээд ерөөсөө нэг өмч рүү дагнаж ганцхан хувийн өмч л ноёлох байдалтай зүтгэж байгааг би бас зүүд их таарахгүй болов уу гэж ингэж бодож байна. Өнөөдрийн жалгын нэг байгаа суурьт суурь бүрийг хувийн өмчтэй болгочихлоо гэж бодоход эхлэлийн үед бид малчдад ямар үйлчилгээ байна вэ, тэнд одоо бараа таваарийн ямар хэрэгцээ байна, соёлын ямар үйлчилгээ очиж байна, цаашид яах вэ гэдэг тодорхойгүй ийм байгаа учраас өмчийн аливаа гэдэг үгийг энд нэрээр нь заагууштай байна. Ингээд би цаг болж байна, бусад саналыг бичиж өгье. Гэхдээ эцэст нь нэг үг хэлэхэд өнөөдрийн үндсэн хуулийн үнэн, зөв нь одоо бидний баталснаас хойш хоног ахих тутам тодорхой болно. 5, 10 жилийн дараа ч ач холбогдлоо алдахгүй байх гэж бодож байна. Би ийм учраас энэ компьютерийн энэ тоног төхөөрөмжийг ашиглаж шаардлагатай үед өгсөн саналыг нэрээр гаргах бололцоотой байвал зүгээр юм гэж бодож байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш. Бурмаа Ш. БУРМАА

225 дугаар тойргийн депутат И.Баасандорж:

-Улсынхаа хамгийн хүндтэй, хамгийн хүчтэй, тулгуур эх баримт бичгийг олон сар, жилийн хугацаанд зүсээ цайлгаж, ухаанаа ядартал хөдөлмөрлөсөн тус Их цаазыг боловсруулсан комиссын гишүүд, Улсын Бага Хурлын гишүүд та нөхдийн хөдөлмөр бүтээлийг гүнээ хүндэтгэж байгаагаа юуны урьд тэмдэглэж хэлэхийг хүсч байна.

Хуралдааны явцад түгээмэл нэг уур амьсгал бол энэ үзэл бодлын зөрүү тус бүрийн дагуу өөр өөрсдийн үзлийг баримтлах гэсэн нэгэн илрэл байгаа юм шиг депутат миний хувьд ажиглагдаж байна. Миний бодлоор бол асуудлын гол нь үзэл үзлийнхээ төлөө биш хамгийн гол нь улс орон, ард түмнийхээ язгуур эрх ашигт нийцүүлсэн тийм л түгээмэл үзэл бодлыг баримталж чадваас бидний гаргах баримт бичгийн хүч чадал түүгээр тодорхойлогдох болов уу гэж бодож байгаа юм.

Ингээд сонгогчдынхоо хүсэл эрмэлзлийг нэгтгэсний дагуу тэр сонгогч олноо төлөөлж зарим нэг саналыг энд тодруулж хэлэхийг хүсч байна. Юуны урьд бид эцэг эхээ 70, 80 нас хүрээд ирэхээр нь өөрчлөж шинэчлэх гээд нэрийг нь өөрчилж зүсийг нь хувиргах арга хэмжээ авдаггүйтэй нэгэн адил эх орон, улс орноо өөрчлөж шинэчилж байна гэдэг нэрээр зөвхөн БНМАУ гэдэг нэр, Үндсэн хууль гэдэг нэр хоёрыг өөрчлөх гэж тэмүүлээд байх нь өөрчлөлт шинэчлөлтэд харшлаад байх зүйл байхгүй байх тул энэ хоёр нэрийн тухайд хэвээр байлгах саналыг сонгогчдынхоо нэрийн өмнөөс дэвшүүлж тавьж байна.

Харин төрийн сүлдний тухай асуудал бол энэ хоёр нэртэй адил биш юм. Энэ тухайд бол бодолцох, санах асуудал их бий. Миний хувьд ч зохих ёсоор өөрчлөгдөх шинж тэмдгүүд энд, шаардлага байгаа болов уу гэдэгт итгэл төгс байгаа. Гэхдээ энд СССР-ийн загварыг өөрчлөх гэсэн хандлагыг урьтал бол-

гоод Америкийн загварыг дагачих хандлага руу орчих вий дээ гэсэн нэгэн санааг ч ургуулан бодвол яадаг юм бол гэж бодож байна.

Хоёрдугаарт, монгол иргэдэд хэзээ хэзээнээсээ тахиж шүтэж, хүндэлж бэлгэдэж ирсэн сүргийн манлай адуун сүргээсээ илүү үнэтэй цэнэтэй, ямар нэгэн нэр хочтой шувуу хэзээ, хаа ч байхгүй гэдэгт сонгогч манай хамт олон итгэл төгс санал нэгтэй байгаа шүү гэдгийг зориуд энд хэлье гэж бодож байгаа юм.

Энэтэй холбоотой энд сүлдтэй холбоотой санал дүгнэлтүүд байх ёстой. Түрүүний видео киногоор ухуулга хийсэн хэн ч билээ тэр хүн бол адууг иддэг, наймаалдаг, худалдаалдаг, зэрэг ийм санаануудаа тайлбарлаж байсан. Тэгвэл энэ сүлдэнд байгаа тариа ногоо ч гэсэн гандаж хугарч, унаж, хулгана зурамд хүртэл идүүлдэг. Тэнд байгаа араа төмөр ч гэсэн эвдэрч, элэгдэж хорогддог. Шувуу ч гэсэн үхнэ, хорогдоно, алагдана. Энэ бүхэнтэй харьцуулахад тэр бүх ухуулганд ч нэг их эргээд байхгүй, зорьж ирсэн бодлого чиглэлээ чигээр нь байлгана гэсэн бодлыг илэрхийлж хэлье гэж бодож байгаа юм.

Нөгөө талаар түүх гэж их ярьж байна. Түүхийг ярих ч ёстой. Түүхийг ярихаа байсан ёс бас байгаа. Тэгэхээр ямар үеийн түүх түүх болдог, ямар үеийн түүх түүх эс болдог гэдгийг өнөөдөртөө би ялгаж чадахгүй байна. Тийм учраас түүх түүх гэж туйл^шрахад юу бол гэдгийг энэ дээр санавал яасан юм бол оо гэж бодож байгаа юм.

Нөгөө талаар энэ засаглалын хувьд бол манай эрхэм депутатууд эргэж бодож, болгоож ухаараач. Тэгээд энд нөлөөлж тэдэнд юм зааж чиглэл өгөх гээгүй. Чиглүүлэгдээд байдаг хүн ч одоо байхгүй байх. Ер нь гол санаа юу байна вэ гэвэл өнөөдрийн манай эх орны байдал, өөрийн орны өвөрмөц байдал, энэ эдийн засгийн хямрал, энэ бүх зүйлтэй ургуулан бодож дүгнэлт хийхэд Ерөнхийлөгчийн чанга засаглалтай байж Засгийн эрхийг Ерөнхийлөгчид шилжүүлэх ийм засаглалыг давын өмнө тогтоож явах нь бидэнд нэн ач холбогдолтой болох болов уу

гэсэн санааг энд зориуд тэмдэглэж хэлбэ гэж бодож байгаа юм.

Харин энэ дотор танхимын хувьд нэг танхим бол боломжтой, бүтэмжтэй гэж үзэж байна. Тэр хуулийн төсөлд орсон Их Хурлын гишүүдийн 76 гэдэг тооны хувьд миний тухай аль аль талыг ч бодсон арай цөөдөж байна уу гэж боддог. Олшруулахаараа ямар тоотой байдаг юм бэ гэвэл би 152 гэсэн тоог хэрэгждэг ч бай, хэрэгждэггүй ч бай энд санаагаа нэмэрлэж хэлбэ гэж бодож байгаа юм.

Нөгөө талаар засаг захиргааны нэгжийн хувьд бол төсөлд заасан хувилбарыг үндсэнд нь зөвшөөрч байгаа, миний хувьд. Энд ялангуяа "хошуу" зэрэг захиргааны шинэ нэгжид шилжих асуудал бол хүн ам зүйн хувьд ч, эдийн засгийн хувьд ч, газар нутгийн хувьд ч, хөрөнгө зардлын хувьд ч ер нь зайлшгүй ийм хувилбар тооцоо болов уу гэж бодож байна. Энийг би Ерөнхийлөгчийн илтгэлдээ тавьсан, тусгасан санаатай санаа нэг, ойлгоц тэнд бүрэн дүүрэн авагдсан учраас энүүнд эргэлзэх юм алга гэж бодож байгаа юм.

Харин энэ дээр хамгийн гол юм бол бүх юманд Засаг дарга гэж байгаа, ер нь ухаандаа аймгийн даргыг бол Засаг дарга, хошуун дээр бол Засаг дарга биш хошуу захирагч, багийн дарга гэсэн ийм гурван нэр өгөхийг энд эрмэлзэж, хүсч байгаа юм.

Нөгөө талаар энэ дээр хэлэхэд ийм зүйл байна. Ер нь төгсгөл рүү нь хэлэхэд энэ хүндэтгэлтэй Үндсэн хууль, Их цаазаа батлах, батламжлах ёслол хийх юм байна лээ, программаар. Энэ батламжлах ёслол хийх үед төрийнхөө шинэ сүлдийг бэлэн болгож байрлуулж төрийнхөө шинэ далбааг байрлуулж, төрийнхөө шинэ дууллыг эгшиглүүлэнхэн байж энэ ёслолыг хийх юмсан гэсэн хүсэл байгааг хэлбэ гэж бодож байна. Гэхдээ төрийн дууллын хувьд бол би үгийн өөрчлөлт хийхээс аяан өөрчлөлт хийхгүй байх болтугай гэж бодож байдгаа бас тэмдэглэж хэлбэ гэж бодож байгаа юм.

Нөгөө талаар энэ хуулийн төсөл батлагдаад ирсэн нөхцөлд

ганц Ерөнхийлөгчийн илтгэлд буюу асуултад хариулсан юмнаас хувийн миний сэтгэлд таалагдахгүй байгаа юм бол энэ төсөлд заасан дагуу засаг захиргааны нэгжийг зохион байгуулахад тэр зохион байгуулалтыг 1995, 97 он хүргэж хийнэ гэсэн энэ санал бол их сэтгэлд таалагдахгүй байна. Ерөөсөө шинэ сонгууль хийгээд тэрнээс өмнө ч юмуу, маргааш нь ч юмуу энэ засаг захиргааны зохион байгуулалтыг шуурхай хийхгүй бол энд мөн ааг зоог, ээг ёг гэсэн ийм хандлагаас эдийн засаг, нөгөө хямрал, нөгөө сулрал, нөгөө хариуцлагагүй байдал улам үргэлжилнэ байх гэж их санаа зовж байгааг энд тэмцэглэж хэлбэ гэж бодож байгаа юм.

Төгсгөлд нь хэлэхэд энэ шүүх засаглалын хувьд их өндөр хэмжээгээр орсон байгаа. Энэ ч орох шаардлага ч бий. Гэхдээ түрүүн дашбалбар депутатын хэлснээр шүүх цэцийн тухай асуудалд их болгоомжлож бодох нь бас нэг санаа гэж бодож байна. Ер нь ний нуугүй хэлэхэд манай хуулийн ажилтнуудаас/би бүгдээрэнгий нь хэлээгүй шүү уучлаарай/ үхрийн маханд ч уярдаг, үнэн байдлыг ч гуйвуулдаг хуульчид цөөнгүй байгааг практик харуулж байгаа. Энэ нөхцөлд шүүх засаглалын хэм хэмжээ эрх дархыг бодолцох л шаардлага бас л зүй ёсоор тавигдах болов уу гэж бодогдож байгаа юм.

Ийм зүйлийг хэлээд бусад тодорхой ярих сэдэв дээр саналаа хэлэхийг эрмэлзэнэ.

149 дүгээр тойргийн депутат Т.Анигар: -Тэгэхээр өнөөдөр Үндсэн хуулийн төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлсэн энэ дунгийн тухай ярихад түрүүн нэг депутат хэлсэн, тэрэн дээр би жаахан өөрийнхөө санал бодлыг хэлбэ гэж бодож байна.

Үндсэн хуулийн I дүгээр бүлэгт улсын сүлд, далбаа, соёмбо, улсын нэрийг өөрчлөх тухай голчлон зааж, энэ дээр хүмүүсүүд бодлоо хэлж байх шиг байна. Тэгэхээр нутаг дэвсгэрийн олонх хүмүүсүүд, сонгогчид энэ дээр өөрчлөхгүй байх ийм саналыг нийтдээ өгсөн. Бас бус хүмүүсүүд бүгд хүмүүсийн санаа бол ижил биш байсан л даа. Гэхдээ энийн нэг л хөндөгд-

вөл бүгдээрээ хөндөгдөх учраас энэ дээр бас хойших депутатууд бүгд хэлнэ биз. Аль нэг байдлаар хөндөгдөхөд бүгдээрээ хөндөгдөнө. Ухаандаа, далбаа хөндөгдөх юм бол энэ дээр байгаа тууз хөндөгдөх, цаашилбал, соёмбо өөрчлөгдөхөд ухаандаа 5 хошуу нь авагдахаар бас л сүлдэнд өөрчлөлт орох энэ мэтчилэнгээр бүгд нэг нэгнээсээ хөндөгдөх учиртай юмаа.

Уул нь ч зарим талаа бодож үзээд ухаандаа манай сүлд бол зөвлөлтийн республикийн сүлдтэй төстэй, ямар нэгэн байдлаараа, хэн ч гэсэн хэлэхээр ийм л байгаа. Гэхдээ энийг өөрчлөх тухайн нөхцөл байдал, өнөөгийн байдалд эдийн засгийнхаа аль нэгэн байдлыг авч үзэх юм бол бүгд уялдаад өөрчлөгдөх учраас энэ байдлаасаа хөдөлмөрчид нэлээн эмзэглэж байх шиг байгаа юм. Тийм учраас миний санал бол нэгэнтээ хөдөлмөрчдийнхөө дийлэнхийн саналаар энэ бүгдийг өөрчлөхгүй байх ийм саналтай байна.

Нөгөө талаар энэ депутатуудын бүсийн зөвлөлгөөн хийгдсэн. Тэгэхээр энэ Үндсэн хуулийг урьдчилж ард түмнээр хэлэлцүүлсэн төслийг авч хэлэлцээд тэрэн дээр бас мөн депутатууд ард түмнээ төлөөлж үгээ хэлсэн, байдлыг хэлсэн. Ялангуяа энэ улсын саяын ярьсан сүлд, далбаатай холбоотой саналууд нэлээн гарсан, улсын нэртэй холбоотой. Тэгээд энийг цаашдаа энэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисст тухайн орон нутагт бүсийн зөвлөлгөөнд явсан улсууд нэртгэж дүгнэж, байдалаа хэлээгүй юмуу, эсвэл энд хууль боловсруулсан хүмүүсүүд маань өөрийнхөө бодол санаагаар ингээд урьдчилсан төсөл боловсруулсан юм уу, энийг нэлээн анхаармаар юм шиг санагдаж байгаа юм. Ингээд бүлгүүдтэй холбоотой өөрийнхөө хоёр гурван саналыг хэллэ.

2 дугаар бүлэгт хүний эрхийн тухай асуудал хөндөгдсөн. Тэгэхээр энэ хамгийн эхэнд хүн амьдрах эрхтэй гэсэн ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ бол энэ дээр хүний эрхийн түгээмэл тунхаг гэсэн энэ асуудлаа барьж нэрлэсэн байх. Нэрийг бас уг өгүүлбэрийн хувьд бас анхаармаар байна. Тэгэхээр хүн чинь нэгэнтээ амьдрах эрхтэй юм чинь үхэх эрхтэй баймаар юм. Тэгэхээр нэгэнтээ үхүүлэхгүй шахуу юм шиг иймэрхүү ойлгоц төрж болмоор. Тэгэхээр хүнийг амьдрах эрхийг бүрэн

баталгаатай хамгаалахад бас их хэцүү. Энэ чинь хоёр талын нэг нөлөө л надад санагдаад байгаа юм. Тэгэхээр энэ хүн алчихдаг хүн, түрүүн ч гэсэн хүнийг алах ял байж болохгүй гэсэн дээр манай Бага Хурлынхан нэлээн маргалдсан байсан, тэгэхээр энэнтэй холбогдож. Би чинь амьдрах эрхтэй хүн гэдэг асуудлыг чинь Үндсэн хуулиас бариад иймэрхүү зарга хийгээд байж болох нэг үндэстэй юм шиг байгаа. Тэгэхээр энэ "амьдрах" гэдэг асуудал бол нэлээн их баталгаажуулах талаасаа нэлээн бодолцмоор юм шиг санагдсан.

Нөгөө талаар хүний эрх, үургийн хувьд бол нэлээн бодолцмоор юм байх юм. Энэ дээр үнэхээр энэ хүмүүсүүдийн хэлсэнтэй эрх нь ихдээд үүрэг нь багадсан юм шиг ийм санаа орж байгаа юм. Тухайлбал, тэрэн дээр хөдөлмөрлөх эрхийг заавал хөдөлмөрлөнө гэж заагаагүй учраас одоо чинь ний нуугүй хэлэхэд энэ зах зээлийн үед хүмүүсүүд нь овжин нэг нь баяжаад хөдөлмөр хийж байгаа нэг нь нийгмийн баялаг бүтээж байгаа нэг нь хомсхондуу амьдарч байгаа шүү дээ. Тэгэхээр ийм цөөхөн хүн амтай, ийм монголын ард түмэн чинь хөдөлмөрлөх эрхийг хуулинд зааж өгөхгүй юм бол хөдөлмөрлөхгүй гээд бусдынхаа хөдөлмөрийг завшаад байх иймэрхүү юм тогтчихмоор юм шиг санагдаж байна. Энэ депутатууд өөрсдийнхөө санаа бодлыг ний нуугүй хэлнэ биз дээ.

Нөгөө талаар, үнэ төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг боловсруулна гээд. Тэгэхээр үнэхээр өнөөдрийн байдалд чинь хөдөлмөрчид ний нуугүй хэлэхэд эмнэлгийн тусламжийг ижэнх нь өөрсдөө худалдаж авч эмчилгээ хийлгэж байгаа. Тэгэхээр энэ үнэ төлбөргүй гэдгийг чинь баталгаажуулах баталгаа нь хаана байна вэ? Тухайлбал, эрүүл мэнд, боловсролын төсвийг чинь Засгийн газраас хэдэн сая төгрөгөөр хасаад баталсан шүү дээ. Тэгээд энэнтэй холбогдолтой чинь төсөв хүрэхгүй боловсрол, эрүүлийг хамгаалах систем цалингаа тавьж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ үнэ төлбөргүй гэдэг асуудлыг бид баталгаажуулах ямар баталгаа байгаа юм бэ? Энэ дээр нэгэнтээ хойшдоо бүлэг, зүйлээр хэлэлцэх дээр холбогдох хүмүүсүүд энэ дээр нэлээн бодолцмоор юм. Эрүүл мэндийн яам урьдчилсан

2005 оны төсөлд 1993 оноос эхэлж төлбөртэй үйлчилгээнд шилжих иймэрхүү юм тусгагдаад гарчихаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бүхнийг нэлээн бодолцож боловсруулах, холбогдох улсууд нь энэ хариултад ч байдаг юмуу, тухайн үед яригдахад асуувал хариулах болох байх, лавлах юм гарах байх. Тэрийг нэлээн бэлтгэлтэй баймаар санагдаж байна.

Тэрийн тогтолцооны хувьд парламентын энэ тогтолцоотой байхыг би хувьдаа энийг зөвшөөрч байгаа юм. Тэгэхээр харин өчигдөр дэд ерөнхийлөгчөөс асуух асуултад 76 Ардын Их Хурлын гишүүнийг сонгох асуудалд нэлээн будлиантай, тэгээд болох л юм шиг ярьчихсан. Тэгэхээр ийм мэдэхгүй юмыг чинь хүн дагаад гар өргөөд баталчихаж болохгүй байна. Тэр депутатуудыг сонгох асуудал их л будлиантай юм шиг санагдсан. Тэнд аймаг, хошуугаараа нэгдээд явах юм бол тус тус орон нутгийнхаа байдлыг харгалзаад баахан хүмүүс сонгох гээд сонгууль бол хичнээн ч дахин үе шатаар явах юм, баахан замбараагүй юм болмоор энийг ний нуугүй ойлгоц өгөөд ойлгоц өгсний дараа ойлгосны үндсэн дээр баталмаар юм. Очсон хойно хүн асуухад бид нар чинь хэлэх юм олдохгүй шүү дээ. Энийг дээрээс мандат өгөөд хүн яваад томилуулах, хуучин шиг томилолтын депутат байх юмуу, орон нутгаас сонгоно гэхэд энэ чинь хэдэн аймаг нэгтгэсэн цагт 70 хүнийг энэ хэдэн аймгуудаас гаргаж хэлэхэд тун хэцүү болох байх. Нөгөө талаар хүн олонтой нэг нь сонгочиход тэнд чинь үнэхээр мэдлэг боловсролын, аль нэгэн талаар Их Хуралд суух боломжтой хүн, сууж чадахгүй боломжгүй хүн тэр дотор нь ороод ирэх ийм боломж хангагдмаар юм шиг санагдаж байгаа юм.

Ерөнхийлөгчийн эрхийн тухай энд дурдсан байгаа. Ерөнхийлөгчийн эрхийг энэ дээр биччихээд сүүлд нь 33-ын 4-т бүрэн эрхийг тусгай хуулиар тодорхойлно гэсэн байгаа. Энэ дээр баахан эрх дурдсан, өөр дээр нь ямар эрхүүд байх юм. Тэгэхээр энэ заалтыг ч гэсэн бид хойшдоо хэлэлцэхдээ нэлээн бодолцмоор юм шиг санагдлаа. Ерөнхийлөгч улсын цол, цэргийн цол гэж байгаа. Улсын цол гэдэг чинь би бодохдоо энэ дээр

Хөдөлмөрийн баатар, гавьяат гэсэн. Бөхийн цол ч гэсэн байдаг шүү дээ. Улсын начин, улсын арслан, улсын заан гээд. Энэ юмнуудтай зэрэгцүүлээд бодолцоод үг, үсгийн засвар зарим юмнууд хиймээр юмнууд нэлээн байгаа юм.

Хүн амьдрах эрхтэй гэсэн асуудлыг ч гэсэн үг, үсгийн, өөрийнхөө үгээр монгол үг хэллэгээр бас засмаар юм шиг санагдаж байгаа юм.

Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд өнөөгийн нөхцөлд үнэхээр аймаг, хошуу нэгдэх асуудал үнэхээр хэцүү юм шиг санагдаж байгаа юм. Депутат түрүүн хэлсэн, Дамдиндорж депутат хэлж байсан. Үнэхээр үйлчилгээ нь хөдөөгийн хөдөлмөрчдөөс холдох гээд байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ тээвэр, бензон, тос шатахуунаас өгсүүлээд хөдөөд сүү, ноосноос өгсүүлээд цааш нааш нь болгох асуудал байна. Хөдөлмөргдийн үйлчилгээний асуудал ч холдоно, тэгээд сургууль соёлын асуудал байна. Баахан барилга байшин чинь хэдэн жилийн дараа эзгүйрээд балгас болох тийшээ хандах байх, энэ талаасаа нэлээн бодолцмоор юм шиг санагдах юм.

Тэгээд тухайн зүйл, бүлгүүд дээр өөрийнхөө саналыг давтан хэлнэ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Уртнасан -5 дугаар микрофон дээр Пүрэв бэлтгэж байгаарай. Үг хэлэх депутатууд нэрээ бодож ойртож байвал сайн байна.Цаг хугацаа бидэнд үнэтэй.

325 дугаар тойргийн депутат Дашзэвэг -- Биднийг сонгогчид маань тэнгэрийн дор төрж, төрийн хуулиндаа захирагддаг юм шүү. Ийм учраас одоо гаргах хуулиа удаан настай, чанартай хууль болгож ирээрэй гэж захисан. Гэтэл зарим хүмүүсүүд маань одоогийн энэ депутатууд маань сонгогчдын санал гэж өөрийнхөө мулгуу ухааныг тулгах гэж байна. Хоёрдугаарт, ер нь хөдөөгийн депутатууд маань окуны жаахан хомсдолтой учраас олигтой ч юм ярих болов уу даа гэсэн тээнэгэлзэл байна. Ямар ч байсан энэ Их цаазын төсөл дээр өөрийнхөө бодож байгаа саналыг хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт, Монгол улсын газрын тухай асуудал дээр миний хувийн санал байна. Энэ дээр ямар санал байна вэ гэхлээр зэрэг нэгдүгээрт, түрүүчийн одоо хуучин Үндсэн хуульд бол монгол улсын газар, түүний баялаг бол монголын ард түмний өмч мөн гэж заасан байсан. Гэтэл одоогийн төсөл дээр газар маань ард түмний өмч мөн бөгөөд төрийн өмч гээд заачихаж. Энэ дээр хоёрдмол санаа орсон учраас төрийнхөө өмчнөөс нэг хэсгийг авч гадаадын болоод харьяалалгүй хүмүүсүүдэд түрээслүүлнэ гэсэн санаанд сэтгэл нийлэхгүй байна. Энэ дээр ард түмний өмч мөн гэсэн санаагаар оруулбал яасан юм бэ гэсэн бодол байна.

Хоёрдугаарт, Монгол улсын төрийн дээд байгууллага байнга орцдог хотыг монгол улсын нийслэл гэнэ гэдэг дээр Улаанбаатар гэдэг үгийг оруулья гэсэн ийм санаа байна. Нөгөө тал дээр АИХ-ын гишүүнийг 6 жилээр сонгоод, АИХ-ын дарга, дэд дарга нарыг 3 жилээр сонгоно гэсэн зүйл байгаа юмаа, хоёр өөр зүйл дээр орчихсон. Үүнийг нэгтгэж нэг сонгуультай болговол яасан юм бэ гэсэн санаа байна. Ерөнхийлөгчийн насан дээр би 40-өөс дээш настай хүнийг ерөнхийлөгчөөр сонгоно гэсэн ийм санаан дээр санал нэгтэй байна. Мөн Үндсэн хуульд нэмэлт оруулах тухай

68 дугаар зүйл дээр ийм санал төсөл орсон байгаа юм. Их цаазад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хууль санаачлах эрх бүхий байгууллага албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Их цаазын цэц АИХ-д өргөн мэдүүлнэ гэсэн ийм үг орчихжээ. Би бодохдоо хууль санаачилдаг байгууллага нь Их хурал гэж бодож байна. Тэгээд бас хууль санаачилдаг эрхтэй нэг албан тушаалтан байна уу гэсэн юм бодогдоод байх юм. Албан тушаалтан гэж хоёр хун заахын оронд ард түмний саналаар гэсэн юм байж болоогүй юм уу гэсэн бас нэг ийм бодол байна аа. Нөгөө тал дээр энэ төрийн бэлэг тэмдэг, сүлд далбаан дээр сая бид видео бичлэг үзлээ. Энэ дээр сэтгэлд буухгүй байна. Энэ шувууны дүрс, бусад зүйлүүд олигтой бууж өгөхгүй байна. 2000 жилийн урьд нэг хүний зүүдэлсэн юмыг одоо тусгалаа гэж ойлголоо. Хоёрдугаарт 2006 онд тэртэй тэргүй өөрчлөгдөх юм байна гэж ойлголоо. Ингээд бид уул нь энэ удаад буугаагүй учраас буцаж очоод хөдөлмөрчдөдөө 2006 онд одоо энэ байгаагаараа өөрчлөгдөх юм гэнэ ээ, тэгэхдээ ийм ийм учиртай юм гэнэ ээ гэсэн сэтгэл санааны бэлтгэлтэй байх юмаа гэсэн ийм **төсөөлөлтэй** болчихлоо.

Нөгөө талаар бас нэг хүсэлт байна. Засаг, захиргааны нэгж зохион байгуулах дээр нэг хүсэлт байна. Саяын тэр видеогоор гаргадаг шигээ өөрөөр хэлбэл Дундговь, Өмнөговь, Төв аймаг гурвыг нэгтгэнэ, тийм тийм сумыг хооронд нь нийлүүлээд ийм хошуу болно гэсэн скиз зураглал байж, хийчихсэн байгаад энд оруулсан байх аа. Ийм учраас үүнийхээ талаар дахин нэг тийм зураг гаргадаг юмуу видео гаргадаг юмуу бидэнд сурталчилж өгөөч ээ гэж хүсч байна.

240 дүгээр тойргийн депутат Цүрэв - Үндсэн хуулийн төслийг хоёр удаа сонгогчид дээрээ ярьж хөөрч санал онолыг нь судалсан. Тэгэхлээр Үндсэн хуулийг хөдөлмөрчид **үндсэнд** нь сайшааж байгаа. Тэгэхдээ дотроо хөдөлмөрчдийн санаа сэтгэлд нийцэхгүй нилээд юмнууд байна аа нэр уснаас өгсүүлээд. Ингээд өчигдөр Улсын бага хурлын дарга бүтэн өдөр бидэнд асуултанд хариулт өглөө. Гэхдээ энэ дээр бид нарын хамгийн хариу авах гэсэн тулгамдаад байгаа асуудлыг тодорхой хариулж өгөхгүй байна. Энэ чухам ямар учиртай юм бол оо гэмээр байна. Ер нь бид

нар хэдхэн нэрийн тухай асуудал дээр өдрийг барлаа. Энэ дээр эхэнд нь тодорхой хариу өгчихсөн бол дахин дахин ингэж асуугаад баймааргүй байна. Өчигдөр депутат Дамдиндорж боловсруулж байгаад маргааш хариу өгөөч ээ гэсэн. Өнөөдөр нэг тулгаж байгаа юм шиг видеогийн бичлэг үзүүллээ. Энэнээс өөр юм бол болохгүй байна аа. Энэ дээр чухам ямар хариу авах гээд байгаа юм бэ гэхлээр улсын нэрийг, туг, сүлдийг өөрчлөх ямар шалтгаан байгаа юм бэ, үүнийг л би сонсчихмоор байгаа юм. Тэгээд үнэхээр л тийм юм даа гэж ойлгогдвол тэрийгээ цааш нь эргэцүүлж бодох бодолтой байна гэж үзэж байна.

Миний хувьд бол дагнан гучин хэдэн жил хөдөө ажиллаж байгаа. Одоо гучин хэдэн малчдын дунд ажилладаг хэсгийн ахлагч хүн. Ингээд бодоход ийм ийм юмыг үнэхээр бууж ойлгож чадахгүй байна. 76 гишүүн Их хурлын гишүүн байна аа гэхэд үүнийг чинь чухам яаж сонгох юм бэ, гэдгийг өчигдөр би ойлгоц авъя гээд чадсангүй ээ. Хуучин байдлаараа сонгох юм бол хөдөөнөөс нэг нэг тойргоос л өөрийнхөө мэдэх хүнийг сонгож байгаад ирмээр. Нэг бол дээр үеийн томилолтынх гэх шиг ийм ийм хүнийг танайд дэвшүүлбэ гээд явуулах юм бол өөр байх. Гэх жишээтэй бид нар нилээн юман дээр хариу авмаар байгаа юм.

Миний өөрийн санал ер нь хөдөлмөрчдийн ихэнхийн санал бол улсынхаа нэрийг, хуулийнхаа нэрийг өөрчлөхөө байя гээд байгаа юм. Энэ ер нь нийт олонхийн санал юм шиг байна аа. За сүлдний хувьд бол өнөөдөр ингээд үзэж байхад ер нь өөрчлөх шаардлага байдаг юмуу гэмээр юм миний тархи толгойд тусаж байна. Гэхдээ олон зуун жилийн өмнө тэр үеийн байлдан дагуулж явсан улсын зүүдэнд орж байсан шувууг сүлдэнд тусгаж хэрэггүй байх аа гэж бодож байна. Манай нэг наян хэдэн настай сонгогч сануулсан. Энэ сүү шимгүй, эвэр хошуутай махчин шувууг битгий тусгаж үзээрэй. Энэ чинь шонхор шувуу гэдэг чинь монгол оронд би дуулаагүй юмаа. Энэ харцаганы төрлийн шувуу гэнэ лээ. Харцага гэдэг чинь болжмор, аль жижиг гэмгүй амьтнаа барьж иддэг, энэ ч утгаараа гэсэн бид зөвшөөрөхгүй байна шүү гэсэн. Тэр ч байтугай өчигдөрийн өргөх бичигт 10 хүний нэртэй амь настайгаа холбоод мэдэгдэж байгаа юм бол цаана чинь ард түмний бүхмидал байна


гэдгийг бодож эрхбиш энэ дээр нэгийг бодож морьтой хүнээ заавал оруулж шинэчлэх юм бол энэ сүлдийг еөрчилмөөр байна шүү гэж бодогдож байна аа. Нөгөө талаар мөн Улаанбаатар нийслэлийн хувьд ч гэсэн бас нэг далд утга байна уу даа. Тодорхой юм ерөөсөө хэлэхгүй юмаа. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот оо гээд оруулчихсан баймаар санагдах юм. Үүнийг бол еөр утга байдаг бол тэрийг ойлгомоор байна. Газрыг өмчлүүлэх тухай асуудлыг ерөөсөө хөдөөгийн хөдөлмөрчид нэг ч зөвшөөрөхгүй байгаа юмаа. Үүнийг би дамжуулахгүй бол болохгүй. Газрыг хувьд өмчлүүлнэ гэдэг чинь яахав бэлчээрийг үгүй гэж байна аа. Энэ утгаар нь болох юмаа. Нэгэнт хувьд өмчилчихсэн юм чинь зарчих юм биш үү гэж улсууд их болгоомжлоод байна аа. Нэгэнт өөрийн өмч юм чинь гадаадын хүнд зарчих юм биш бизээ. Бүр гадаадынханд түрээслүүлнэ гэдэг байж болохгүй байх аа гэсэн ийм юм санал их байгаа. Үүнийг бодож үзүүштэй юм.

Энэ засаглалын хувьд бол ерөнхийд нь зөвшөөрч байна. Гэхдээ манай ерөнхийлөгч бол ерөнхийлөгчийн засаглал голлосон парламентын засаглал хосолсон засаглал байж болдоггүй юм уу. Би үүнийг ^{хууль} зүйн үүднээс юу ч мэдэхгүй юм. Миний бодоход ерөнхийлөгчийн засаглал өнөө үед **жаахан** голлох хэрэгтэй биш байгаа гэмээр, хөдөлмөрчид ер нь манай түргэн шуурхай шийддэг, хүчтэй засаглал хэрэгтэй байна шүү гэж их ярих юм. Болдог юм бол энэ хэлбэрийг сонгож авбал яасан юм бэ гэж бодогдоод байна. Ерөнхийлөгчийн хувьд бол насыг 40 наснаас дээш байх нь зүйтэй, хуучин хувилбараар гэсэн ийм хувийн санал байдаг юм. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно гэж байгаа. Хэрвээ тэр төрийн бэлэгдэл болж чадсан монголын ард түмэнд итгэгдсэн ийм ерөнхийлөгчөө дахиад сонгоё гэвэл тэр хүний нэрийг нь дэвшүүлээд дахиад улиран сонгох хугацааны хувьд заахгүй байвал яасан юм бэ гэж санагдах юм. Энэ нь бас ямар үндэслэл байдгийг мэдэхгүй юм. Заавал ингэж сонгоно гэдгийг, ийм юм байна.

Монгол улсын засаг захиргааны нэгжийн хувьд бол аймаг нийслэл, аймаг нь хошуунд, хошуу нь багт гээд цаацдаа хуваагдана гээд заасан байна. Тэгэхлээр би энэ дээр ганцхан хэлэхэд сум

гэдгийг хошуу гэж нэрлэхийн хэрэг байна уу. Хэрвээ байвал ямар үндэс байдаг юм бэ. Сум чигээрээ аймаг нь суманд гээд яваад хоёрын хооронд нэрний юмнаас улсууд их гайхалцаад, эмзэглээд байдаг юм биш үү. Хэрвээ сум чинь жижигдээд, багадаад байдаг юм бол хамаагүй нутаг дэвсгэр нь тэр нутгийнхаа улсуудаар хэлэлцүүлээд, тэр сумынхнаараа хэлэлцүүлээд, томруулаад нэг хоёроороо нийлж болдог юм бол нийлээд явчихаж болдоггүй юм уу гэж санагдаж байна аа. Баг гэдэг юм чинь үнэхээр үгүйлэгдээд байна. Одоо бол үнэн чанартаа тэр засаг чинь ард түмний холбоо хоёр чинь өнгөрсөн жилээс холдцорлоо. Бид нарыг байгаа хугацаанд эрс холдлоо. Одоо хуучин бол бид нэгдлийн бригад гэж байсан. Бригадаар дамжуулаад чи захиргааны нэгжийн үүрэг гүйцэтгэгч гээд 50 төгрөг өгчихөөд тэрийг захиргаа зараад байсан. Одоо тэр алга болсон. Одоо үндсэндээ хөдөөд хөдөлмөрчдтэй жинхэнэ уулздаг тийм засаг төрийн ажилтан алга болжээ. Ийм учраас баг чинь бол зайлшгүй хэрэгтэй. Тэр хуучин баг гэдгийг чинь байхад би биеэрээ тэнд чинь ажиллаж байгаад одоо хүртэл хөдөлмөрчдийн дотор байна. Тэгэхээр зарим хүмүүс бол багийг дээр үеийн багтай яг адилхан байна гэж сэтгэл толгойд нь буугаад байгаа юм шиг байна. Тэгэхээр одоогийн багийн дарга нилээн гартаа барьсан хуультай ингэж ажиллахгүй бол дээр үеийн багийн дарга шиг захиргаадаад хэн нэг хүнийг ерөөсөө чи тэг л гэхэд тэгдэг байсан бол одоо хүний боловсрол түвшингээс өөр болсон, хүний ухамсар ч тэрнээс өөр болсон, харьцаа зан ч тэрнээс өөр болсон. Ийм учраас үүнийг бас сайн бодож боловсруулуштай зүйл юм шүү гэдгийг бас болгооно биз дээ гэж бодож байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАШ
НИЙЛСЭН

 /Д. БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

Д.Гомбожав /420 дугаар тойргийн депутат/ -Энэ Үндсэн хуулийн талаар хэд хэдэн удаа хэлэлцэж санал авсан.Энэ ард түмний саналыг Бага Хурал дээр бага тусгаж төсөл оруулж ирсэн учраас энэ хэдэн нэр дээр их хэмжээний цаг авч ярьж байна. Энд нийт ард түмний сэтгэлгээ, энэ улсын нэр, сүлд, тэмдэг, хуулийн нэрийг өөрчлөхгүй байна гэсэн энэ саналыг Бага Хурал тун бага тусгажээ.Ийм учраас энэн дээр яаж ч ухуулав, таниулав, энд бол депутат болгон өөрийн бодолтой, ард түмний даалгавартай ирсэн.Энд бас тайлбар хэлмээр байна.БНМАУ гэдгийг өөрчлөх ямар ч үндэс байхгүй.

Бүгд найрамдах гэдэг бол найрамдал юуны бэлгэдэл энийг нөхдүүд мэдэж байгаа.Энийг нөхдүүд хасах юм бол бас юмыг ярьж байгаа хүмүүс бий.За ард гэдэг үгийг түрүүн ард анги гэсэн байдлаар тайлбарлаж байна билээ.Ер нь одоо ангич байдал, ардаа гэдгээ хасаж болохгүй.Ард гэдэгт манай малчин, ажилчин, сэхээтэн, бүх л давхарга багтаж байгаа гэдэг ийм ойлголт манай ард түмний дотор байна.

Сүлдний тухай асуудал байна.Шувууны дүрстэй, морины асуудал яригдаж байна.Шувуугаар дүрслээд одоо энэ сүлдийг хэзээ ч батлаж боломгүй санагдаж байна.Сэтгэлд буухгүй байна.Шувуу бол үнэндээ орон зайн хувьд авч үзлээ ч гэсэн яг монгол орондоо байна гэж хэлэхийн арга алга.Өнөөдөр шувуу монгол нутагт байна, маргааш өөр нутаг, өөр оронд хүрээд очиж болно.Монгол морь бол эргээд эх орондоо хэзээд гүйгээд ирдэг ийм уламжлалт сэтгэлгээтэй, ийм талаас нь ч аваад үзлээ гэсэн ер нь хүлээж авч боломгүй байна.

Дараагийн асуудал бол газрыг өмчлөх тухай асуудал байна. Газрыг өмчилнө гэж байна, түрээслэнэ гэж байна.Энэ хоёр асуудал дээр зөвшөөрөх үндэс алга.Газрыг өмчлүүлэх юм бол ирээдүйд ямар үр дагавар байх вэ гэдгийг бодолцох ёстой байна. Одоо энд нэг жишээ хэлэхэд дуудлагын худалдаагаар дэлгүүр

худалдаж байна. Энэ зөвхөн жинхэнэ монгол иргэддээ очиж чадаж байна уу үгүй юу гэдэгт бас яриа хөөрөө байж байгаа. Өөр орны хүмүүс монгол иргэдийн + Нэрээр дэлгүүр худалдаж авчихаад одоо үйл ажиллагаагаа явуулж байна. Тэрэн шиг асуудал болж болохгүй гэх үндэс байхгүй. Баталгаа байхгүй. Ийм учраас газрыг өмчлөх асуудал, газрыг түрээслэх асуудал бол байж болохгүй, улсын бүрэн эзэмшилд, мэдэлд байх ёстой ийм асуудал гэж үзэж байна.

Хүний эрхийн тухай асуудал байж байна. Хүний эрхийн тухай асуудал дээр хөдөлмөрлөх эрхтэй гэдэг асуудлыг нэлээн чанга зааж өгмөөр байна. Өнөөдөр манайд юу хэрэгтэй байна вэ гэвэл ерөөсөө л хөдөлмөр хэрэгтэй байна. Өнөөдөр манай хүмүүсийн доктор ямар сэтгэлгээ давамгайлж байна вэ гэвэл панз, наймааны байдлаар амьдрах гэсэн ийм сэтгэлгээ давамгайлж, жинхэнэ хөдөлмөрлөж, юм хийж, материаллаг баялгийг үйлдвэрлээ гэсэн энэ сэтгэлгээ хомсдож байгаа. Ийм учраас олон өмчийн хэлбэр буй болж үүсч байгаа ч гэлээ гэсэн хөдөлмөрлөх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж өгөх хэрэгтэй байна. Энэ бол заавал аль өмч дээрээ ч гэсэн хөдөлмөрлөх үүрэгтэй байх ёстой гэж заах асуудлыг хийх хэрэгтэй байна.

Нөгөө нэг асуудал бол төрийн тогтолцооны асуудал байна. Төрийн тогтолцооны асуудлын хувьд миний хувьд нэг шаттай парламенттай Их Хуралтай, Ерөнхийлөгчийн засаглалтай ийм төрийн байгууламж манайд чухал байна. Энүүний нотолгоо болгож хэлэхэд нэг жилийн хугацаанд байгуулагдсан Бага Хурал, Их Хурал хоёр ямаршуу байдалтай ажиллаж байна вэ? Үнэн хэрэг дээрээ Их Хурал маань жилдээ ганц удаа хуралдаж, өнөөдөр л эрхээ эдэлж ярьж байна. Энэ хооронд юу болсон нь одоо бид Бага Хурал, Засгийн газрын тайлан дээр тодорхой болох байх. Тийм учраас нэг Их Хуралтай Ерөнхийлөгчийн засаглалтай ийм төрийн байгууламжийг байгуулах асуудал манай өнөөдрийн аль ч талаараа зохимжтой ийм асуудал гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэн дээр одоо Ерөнхийлөгч нь Засгийн газраа барьдаг ийм байдал чухал байна. Өнөөдөр манайд сахилга, дэг жу-

3.

рам гажуудаж байгаа, олон эерэг үзэл гарч байгаатай холбоотой Ерөнхийлөгчийн хатуу засаг захиргаа засаглал хэрэгтэй байна. Энэ асуудлыг Үндсэн хуулиар баталгаажуулж, энэ алдаж байгаа, болохгүй байгаа энэ асуудлыг засаглах талаар нэлээн анхаарал тавих хэрэгтэй байна. Засаглал хомсдож байгаа асуудал бол энэ эдийн засаг нийгмийн бухимдалд оруулах нэг гол үндэслэл болж байгаа.

Нөгөө талаар энэ Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгчийг сонгох асуудал, хугацааг нэгдсэн хугацаанд оруулж таван жилийн хугацаатай болгох хэрэгтэй байна. Их Хурлын гишүүдийг нийт ард түмэндээ хоёр жил тутам тайлагнадаг, өргөн тайлан явуулж шүүмжилж, ард түмний үнэлэлт дүгнэлтийг өгч, энүүгээр шүүж баталгаажуулах асуудлыг хуулинд тусгаж өгөх хэрэгтэй байна.

Засаг захиргааны нэгжийн хувьд сумыг хошуу болгох, аймгийг нэгтгэх энэ асуудал өнөөдөртөө үнэхээр болохгүй байна. Өнөөдөр тэр, засгийг хүчтэй болгох л юм бол ард түмэн тэр, засгийн холбоог улам ойртуулах шаардлагатай байгаа юм. Одоо миний хувьд багаас сумыг хүртэл ажиллаж байгаа ийм хүн. Баг гэдэг чинь ямар баг байх юм бэ? Дээр үеийн баг байх юм уу? Өөр одоогийн сумын захиргааны эрх мэдлийг эдэлсэн тийм баг байх юм уу гэдэг асуудал тодорхой биш байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо аймгийг нэгтгээд хэдэн аймаг болгох юм, сумдыг нэгтгээд хэдэн хошуу болгох юм гэдэг ийм концепц тооцоо эм бидэнд ойлгогдохгүй байгаа учраас энэ асуудлыг хэлэлцэхэд бэрх байна. Ер нь ямар ч байлаа гэсэн сумыг цөөлж, хошуу болгох асуудал таарахгүй. Энд бол одоо маш их бухимдал гарна ард түмний. Хөрөнгө ч их үрэгдэнэ. Жинхэнэ, явж явж нөгөө малчид бүдүүлгийнхэн л хэлмэгдэж байдаг тэр асуудал үргэлжилнэ.

Нэгдүгээрт үйлчилгээгүй болж байгаа, бригадгүй болж байгаа, халуун усгүй болж байгаа, улаан булангүй болж байгаа, одоо засаг захиргааны нэгжээсээ холдоод ингээд эцсийн эцэст

хэлмэгдэх юм бол малчид болно. Энэ асуудлыг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Энэ бүх асуудлыг анхаарч, дээрх асуудал дээр депутатууд нэлээн өөр өөрсдийн бодолтой хандах зайлшгүй шаардлагатай байна. Энэ талаас түрүүний ярьснаар тэр аймаг, хошуу болгох тооцоо, судалгааг депутатуудад танилцуулах шаардлагатай байна.

Ш. Солномдаш /276 дугаар тойргийн депутат/ -Би уул нь сонгогчдын санал, өөрийн бодол санал гэсэн хоёр чиглэлээр нэлээд хэдэн юм хэлье гэж бодсон юм. Гэвч минут багтахгүй байж мэднэ. Яахав би сонгогчдын захиж хэлсэн, зайлшгүй энд уламжлах ёстой тийм саналуудыг хэлж, өөрийнхөө саналыг нэг удаа хойш тавья. Амжвал яахав хэлнэ. Тэгэхээр би нэгэн зүйлийг ажиглаж мэдэрч байна. Энд юу вэ гэхээр эх орны дөрвөн зүг, найман зовхисоос цугларч, энд ирсэн депутатууд болон, мөн улс орны өнцөг булан бүрт амьдарч байгаа бидний сонгогч олон түмэн хоорондоо уулзаж зөвшилцөөгүй, үгсээгүй, тохиролцоогүй мөртлөө нэлээд олон асуудал дээр санал дүйгээд байгаа нь их сонин, сонирхолтой санагдаж байна. Энэ нь юу байна вэ гэхээр энэ асуудал зайлшгүй чухал, үнэхээр олон түмний анхаарлыг татсан, амин гол асуудал юм байна гэж Үндсэн хуульд тусгагдсан энэ асуудал дотроос тодорч байна гэж би ингэж ойлгож байна. Энэнд юуны өмнө давхардуулан хэлэхэд улсын нэр, үндсэн хууль гэсэн нэрийг мөн хэвээр нь байлгая. Төрийн сүлд, далбааг мөн хэвээр нь байлгая. Газар, түүнийг гадаадын иргэдэд түрээсээр эзэмшүүлэхгүй байя гэсэн зэрэг олон саналууд байгаа юм.

Тэгэхээр энэ бүхэн бол ингээд хоорондоо хэлэлцсэн юм шиг, нэгсээд үгсээд тохирчихсон юм шиг нийлээд байгаа асуудал нь энэ асуудал үнэхээр бүх нийтийн анхаарлыг татсан онцгой чухал асуудал байна гэж бидэнд ажиглагдаж байна. Ийм ч учраас энэн дээр депутат нөхдүүд бид нар чухлыг бодож, анхаарлаа нэлээн төвлөрүүлж, нэлээн тогтож хандаж, зохистой шийдвэр гаргах нь зүйтэй байх гэж бодогдож байна.

Тэгэхээр манай тойргийн сонгогчид ч эдгээр зүйл дээр яг санал нэг байгаа юм. Би энэ далимд энэ үгийг хэлж, санал нэгсэж байгаагаа хэлье гэж бодож байна. Нөгөө талаар Үндсэн хуулийн хоёрдугаар хэсэг буюу хүний эрх, эрх чөлөө гэдэг бүлэг дээр депутатууд тодорхой ярьж байна. За энэн дээр эрх нэлээн олон байна гэж ярьж байна. Байх нь ч зүйтэй эд байх. Гэхдээ би энэн дээр бас зарим нэгэн зүйл дутагдаж байна гэж бодож байна. Энийг яахав дараа санал хураахад оруулж өгвөл сайн байна гэж хэлье гэж бодож байна. Болохгүй бол хасна биз ээ.

Энд юу байна вэ гэхээр шударга үнэний төлөө тэмцэл, ажил хэрэгч чанараасаа болоод хавчигдах, нэр хүндээр доройтох зэргээр хохирохоос хамгаалуулах эрхтэй гэсэн нэгэн зүйлийг нэмж оруулмаар санагдаж байгаа юм. Нөгөө нэг зүйл бол иргэдийн эрхийн тухай асуудал байна, үүргийн тухай асуудал байна. Энэ үүрэг дээр цөөн байна ч гэж хүмүүс ярьж байсан. Цөөн байгаа тул би нэг юм нэмчихье гэж байгаа юм биш. Ер нь бас нэг үгүйлэгдэж байгаа зүйл болов уу гэж нэгэн саналыг хэлье гэж бодож байна.

Энэ нь юу вэ гэхээр зэрэг өнөөгийн монголчууд бидний дотор, өөрөөр хэлбэл монгол мах цусанд төрсөн бидний дотор тухайлбал бүр онцолж хэлбэл бидний залуу үед монгол сэтгэл, монгол ёс суртахуун, монгол хүмүүжил ихээхэн дутагдаж байна. Энийг бид юугаар тайлбарлаж явж ирсэн бэ гэвэл энэ бол дөрөвдөг үр ачаа асран хүмүүжүүлж, хүнийг хүн болгох нь ээж аавын үүрэг, иргэний үүрэг гэдэг юмаар бид ерөнхийлж орхиж ирсэн. Энэнээсээ болж бид нар нэлээн их гашуун үнэнийг амсаж байгаа. Ийм учраас хүнийг хүмүүжүүлэх, гал голомтоо хүн шиг хүнээр залгуулах, монгол түмнээ үргэлж бадрааж байхын тулд бид монгол хүнээ монгол хүн болгож, жинхэнэ тэр төрсөн хүнээ монгол хүмүүжлээр хүмүүжүүлж, монгол сэтгэл, монгол ёс суртахуунтай, хойч үеэ бойжуулахын тулд Үндсэн хуульд энэ талаар үүрэг болгож, иргэний үүрэг дээр нэмж оруулах нь зүйтэй юм гэж ингэж бодогдож байна. Нөгөө талаар гуравдугаар бүлэг буюу монгол улсын төрийн байгуулалтын асуудал дээр авч ярихад парламентын засаглалын талаар тавигдаж байгаа санал, заасан заалтуудыг үндсэнд нь зөвшөөрч байна.

Депутатын тоо далан хэд байгаа нь үнэхээр цөөхөн санагдаж байна. Энэ бол улс эх орны үйл ажиллагаанд сонгогдсон нөхцөлдөө хүрч ажиллах боломжгүй юм байна гэж бодож байна. Ингээд хувийн санал бол лав 150-иас доошгүй гишүүнтэй байх нь зүйтэй байх гэсэн ийм бодлыг оруулж байна.

Нөгөө талаар мөн энэ бүлэг дээр намуудын асуудалтай холбоотой, засаглалын асуудалтай холбоотой ийм асуудал байна. Энэ юу байна вэ гэвэл сонгуульд ялсан нам Засгийн газрыг дангаараа бүрдүүлдэг зарчмын дагуу ийм өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах нь зүйтэй юм гэсэн ийм бодол орж байна.

Нөгөө талаар тэр засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай дөрөвдүгээр бүлгийн 64 дүгээр зүйл дээр ерөөсөө юу яамаар байгаа юм. Хошуу дарга гэдгийг бид түрүүн ярилаа, ерөөсөө тэр санал дээр гарсан. Хошуу бинь сум байлгая гэж. Тэгэхээр тэр сумын ч болдог юм уу, одоо ингээд үндсэн нэгжийн Засаг даргыг бол жинхэнэ халуун бүл дотроосоо гэхгүйгээр, ер нь таньдаг мэддэг, зан араншингаа авалцсан, ажил амьдралаа мэддэг, тухайн нутгийнхаа зан заншлыг мэддэг ийм хүнээ түүгээр удирдуулах гэж байгаа олон түмэн нь шууд нэр дэвшүүлж сонгодог, тэр сонгосныг нь аймгийн Засаг дарга баталдаг байвал зүйтэй юм гэсэн ийм саналыг оруулж байна.

Эцэст нь хэлэхэд депутат бид нар дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу ийм нөхцөлд олон талаасаа нэлээн хавчилттай ингэж хуралдаж байна. Энийг юугаар тайлбарлах гэж байна вэ гэвэл нэг талаас бидэнд сонгогчдын захиа даалгавар гэж бий. Нөгөө талаас энд бид нарыг тэгж ч ийн нь тийш нь бодол санааг урвуулж хөрвүүлэх гэсэн олон зүйлийн сонин хэвлэлийн болоод, уг үсэг ярианы элдэв ухуулга таниулга ийм юмнууд бидэнд хийгдэж байгаа. Энэ бүлд биднийг амар байлгаж, тайван тогтуун байж, үйл ажиллагаагаа хэлэлцэх боломжийг алдагдуулж, ёстой иймэрхүү тогтворгүй, таагүй байдалд оруулж байгаа явдал бол зөндөө гарч байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр миний бодлоор

7.

бол энэ туйлбаргүй хүн буцахдаа амархан, тугалган жад шантрах-
 даа амархан гэсэн ийм ухагдахуунд бид бүхнийг дүйцүүлэн үзэж
 өгч байгаа үнэлэлт юм болов уу гэж ингэж бодож байна. Тэгэхээр
 ингэснээрээ биднээс уул асуудлыг хэлэлцэхэд сайн үр дүнг үзүү-
 лэхгүй, энэ бол харин муу үр дагавартай байж мэднэ. Ийм учраас
 энэнээс хойш, хурал бол яагаа ч үгүй эхнийхээ шатанд л явж
 байна, бидэнд хэлэлцэх олон асуудал байна, тэр бүхнийг хэлэл-
 цэхэд бол сэтгэл санааны талаар олон тийш нь татаж чангаалгүй,
 таагүй байдалд оруулалгүй, хувь хүн хүнийхээ хувьд аажуу
 тайван ухаан бодлоо зарцуулах боломжоор хангаж өгөөсэй гэдгийг
 хэлье гэж бодож байна.

Соронзон хальстай тулгаж
 нийлсэн



ЭНХТУЯА

Бичээч Уранчимэг

1991-XI-15
Кассет № 73
18.20-18.30

Г.Сосорбарам /ЗГБ дугаар тойргийн депутат/ -Би үгээ хоёр чиглэлээр хэлэхийг хүсч байна.Нэгдүгээрт сонгогчдынхоо санал хүсэл, зоригийг Их Хуралдаа давтагдсан ч, давтагдаагүй ч, хүссэн ч хүсээгүй ч хэлэх нь зүйтэй гэж ингэж үзэж байна.Өөрөөр хэлбэл Төв аймгийн Баянжаргалан сумын сонгогч, хөдөлмөрчдийн нэрийг барьж хэлээгүй би, сумын хурал, гүйцэтгэх захиргааны албан ёсны дүгнэлттэй баталгаажсан ийм саналыг хэлэх гэж байгаа юм.

Нэгдүгээрт, Их цаазын нэрийг Үндсэн хууль хэвээр байлгах гэсэн энэ саналыг манай сумын сонгогч хөдөлмөрчид хэлээрэй гэсэн.Хоёрдугаарт, Монгол улсын нэрийг ард гэдэг үгээс цэрлэх хэрэггүй юмаа, БНМАУ гэсэн нэрийг хэвээр үлдээх саналыг оруулаарай гэсэн.

Гуравдугаарт төрийн бэлгэдлийг хэвээр байлгах хэрэгтэй шүү гэж ингэж үзсэн.Энэ төрийн бэлгэдэл дотроос өнөөдрийн байдлаар бол зарим нэгэн зүйлийг өөрчлөхөд болохгүй гэх юмгүй юм шиг санагдаж байна.

Дөрөвдүгээрт, газрыг өмчлөхөд учир байна.Өөрөөр хэлбэл гадаадын иргэдэд өгөх буюу түрээслэх асуудлыг зөвшөөрөхгүй. Монголын ард түмэн монголын газар нутгийн эзэн байх ёстой гэсэн ийм зүйлийг тавьсан юм.Манай хөдөөгийн сонгогч, хөдөлмөрчдийн ихээхэн санаа зовж байгаа нэг асуудал бол засаг захиргааны тогтолцооны тухай асуудал байгаа юм.Засаг захиргаа, хөдөө орон нутагт амьдралд нь, судас зүрхэнд нь ажиллаж байгаа хөдөөгийн сумдын дарга нар энэ талаар их бухимдаж байгаа юм.Тэднийг өөрийнхөө байр суурийг хамгаалж байна гэж үзэж болохгүй.Тэд амьдралыг үнэнээр туулж мэдэрч байгаадаа үнэнийг хэлж байгаа гэж бодож байгаа юм.Өөрөөр хэлбэл одоогийн энэ тогтолцоо аймаг, сум, баг гэсэн зохион байгуулалтыг хэвээр нь байлгаач гэсэн энэ хэдэн саналыг манай сонгогч олон түмэн энэ зүйлийг Их Хуралд сонордуулаарай гэсэн ийм таван зүйл байгаа юм.

Үүнийг сонордуулъя. За өөрийн хэлэх гэсэн хэд гурван санал байна.

Нэгдүгээрт, Бага Хурал манай Их цаазын төслийг комиссын нөхдүүд маань ард түмний саналыг тусгахдаа бас харьцангуй дуутуу дүгнэлт хийв үү гэж ингэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл гурван төрийн нүүр үзэж байгаа манай хөдөөгийн ард түмний дотор ухаантай ч бий, эрдэмтэй ч бий, энэ бүгдийг өнөөдөр мэдэхгүй, чадахгүй, боловсролгүй, мэдлэггүй гэдэг байдлаар дүгнэж боломгүй байна. Ийм учраас ард түмний тэр саналыг одоо бас их анхаарч үзэх буюу одоо энэ депутатуудын саналыг ихээхэн анхаараасай гэж ингэж үзэж байгаа юм.

Өнөөдөр төрийн далбаа, тугийг ч ямар янзтайхан байгааг одоо үзэж харлаа. Өнөөдрийн саян үзүүлж байгаа туг, далбааны сүлд урлагийн хувьд ч гэсэн дунд нь байрлана гэж ингэж бидэнд үзүүллээ. Гэтэл энэ тархи манлайдаа хүндэлж явах соёмбо маань толгой нь уруугаа харчих вийдээ. Өөрөөр хэлбэл нуталараад ирэхийн үед байнга энэ далбаа салхинд намирч байхгүй. Гэтэл энэ шүтээн ний маань соёмбо доошоо харчихдаг болохвий гэж ийм бодол ч төрж байна.

Түүнээс гадна энэ хуулинд гадаад үг хэрэглэхгүй гэж зорьсон мөртлөө субъект гэдэг үгийг хэрэглэжээ. Энийг ч гэсэн монгол нэр томъёонд шилжүүлмээр санагдаж байна. Шонхор шувууны тухайд бол бас л сэтгэлд нэг л бууж өгөхгүй байна. Махчин ч юм уу, хаанахын ч юм, сүүтэй ч юм уу, нисдэг ч юм уу, нисдэггүй ч юм уу үнэхээрийн мэдрэхгүй байна. Байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Балгэдэл нь балгэдэл байх ёстой л юм байж. Мэдрээгүй балгэдэл байх юм уу, одоо ямар учиртай юм, энийг би нэлээн эргэлзэж байна. Тэгэхээр ер нь бол одоо энэ морь гэдэг асуудал байдаг юм уу, энэ солиход ямар ч гэсэн шувуу байхыг хувиасаа зөвшөөрөмгүй байна.

Төрийн тогтолцооны хувьд хоёр шаттай нэг танхимтай байх. Тэгэхдээ Их Хурал нь 150 гишүүнтэй, Бага Хурал нь 30 гишүүнтэй

ийм байвал яасан юм бэ гэж нэг ийм санал бодогдоод байгаа юм.

Хошуу, засаг дарга гурван жилээр, сум, багийн засаг даргыг гурван жилээр томилно гэж ингэж тусаж байна. Гурван жил баг, хошууны засаг дарга юу хийх юм бэ? Гурван жилийг хүлээж байгаад л яваад өгнө биз дээ. Эхний жил нь шинэ юм танилцагдаагүй юм гээд өнгөрнө. Хоёр дахь жил нь тэгс ингэсхийнэ. Гурав дахь жил нь би өөрчлөгдөх юм гэж бодно. Энэнээс эхлээд амьдралд нэлээн ойролцоо байлгамаар ийм санагдаж байгаа юм.

Мөн өөрөөр хэлбэл энэ засаг захиргааны анхан шатны нэгжийн тухай асуудал дээр болдог юм бол энийг хариуцсан Бага Хурлын гишүүн, сая тэнд нэг депутат хэллээ. Видео-гий нь үзүүлдэггүй юм гэхэд, схемээр үзүүлээд ярилцаж болмоор санагдаж байна. Өөрөөр хэлбэл баг гэдэг чинь ямар бүтэцтэй, ямар ахуй, соёлын үйлчилгээтэй, ямар янзын юм байх юм бэ? Өөрөөр хэлбэл одоогийн тусаж байгаагаар бол засаг даргатай, нарийн бичгийн даргатай гэсэн ийм орон тоо санагдаад байна. Энийг тодотгож яривал нэлээн баттай болох болов уу. Ингэхгүй бол энэ чинь одоо үймчихээд, шуугичихаад яадгаа ч алдчихна. Ийм учраас болдогсон бол схем хийгээд ч юм уу, ингээд тэр Бага Хурлаас хууль оруулсан, санаачилж байгаа хүмүүс энийг оруулж өгвөл сайн байна гэж ингэж бодож байна. За бусад зүйлийг бичгээр өгье.

Соронзон хальстай тулгаж

нийлсэн

Д.АЛТАНЦЭЦЭГ

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.15

Кассет № 74

18.30-18.45

140 дүгээр тойргийн депутат Т.Гантөмөр:

Энэ Үндсэн хуулийн төсөлд манай ард түмний санаа бодол туссан. Энэ боловсрогдсон. Энэ дээр бага зэрэг зөрчил байна л даа. Юуны өмнө энэ нэр томъёо, сүлд, оруулсан төсөлтэй зөрчилдөөд бид нарын мэдэрч байгаагаар олон нийтийн санал бодол, энэ төсөл хоёр хоорондоо зөрчилдөөд байгаа.

Тэгэхээр үүнд хандах асуудлаараа би хоёр зүйл ярьж гэж бодож байна. Энэ нэг талаасаа санал бодол харгалзах шаардлагатай. Хэрэгжих үүднээс нь авч үзэх. Өөрөөр хэлбэл бид сайн хууль боловсруулъя гэвэл хэрэгжих, хэрэгжүүлэх хүмүүсийн санаа бодлыг үзэхээс арга байхгүй.

Энэ эхнээсээ аваад нэр хүндгүй хүлээж авах юм бол энэ хууль амьдрах насны хувьд мөн тэр хэмжээгээрээ байна гэдэг нэг ийм үндэслэл байна.

Хоёрдугаар асуудал нь хэрвээ олонхийн санал энэ асуудалд өөрчлөхгүй гэж хандаж байгаа үед бид захиргаадалтын аргаар өөрчилнө гэж, энэ өөрчлөх асуудал буруу биш байж болно. Өөрчлөхийн бол энэ чинь эрхийн асуудал, хүний. Өөрөөр хэлбэл дээдэлж, шүтэж, биширч явах ёстой зүйлийг захиргаадалтын аргаар болиулна гэсэн үг. Энэ утгаараа авч үзэхэд үүнийг өөрчлөхгүй байх нь зүйтэй юмаа гэсэн ийм саналтай байна.

Засаг захиргаа, засаглалын хувьд бол парламентын засаглал, Ерөнхийлөгчийн засаглал байнаа гэдэг загвар байгаа тэр загварт тохируулж тэр улсын тогтолцоог мэдэж бий болгодоггүй байх. Юуны өмнө тохирсон нөхцөл байдалдаа таарсан ийм тогтолцоо бий болгоод, тэгээд дараа нь энэ нь Ерөнхийлөгчийнхөө гэдэг тэр хувилбартаа таарч байгаа юм уу? Парламентын гэдэг хувилбартаа таарч байгаа юм уу? тэр байдлаар нь ангилж үзэж ашигладаг байх.

Тэгэхээр зэрэг үүнд Ерөнхийлөгчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх асуудлыг хиймээр байгаа юм. Энэ асуудал дээр ярихаар зэрэг диктатур тогтоно, төр эргэж магадгүй гэсэн ийм зүйлийн юм яригдаад байгаа юм. Энэ бол нөгөө утгаар нь би авч үзмээр байгаа юм. Өнөөдөр төр эргэх баталгаа нь энэ нэг хүний засаглал ч юмуу, энэ дээд төрийн тогтолцооныхоо асуудлаас гадна нийгмийн ул суурьтай байгаа. Өөрөөр хэлбэл эдийн засгийн хямралтай байгаа хүмүүсийн сэтгэл санаа бухимдалд байгаа. Хэрвээ бид үүнийг тодорхой хэмжээнд зохицуулж чадахгүй юм бол энэ төр эргэх ч юм уу? Диктатур тогтох асуудлын үндсэн асуудал энд байгаа.

Тийм учраас энэ нэг жилийн хугацаанд олсон ардчиллын үр хөврөл байдаг юм уу? бид энэ зориод байгаа асуудлаа хэрэгжүүлбэ гэж үнэхээр хүсч байгаа юм бол энэ хямрал, бухимдлыг тодорхой хэмжээнд барих шаардлагатай, үүнийг барихын тулд бас төвлөрсөн удирдлага шаардлагатай байгаа юм.

Ерөнхийлөгчийн засаглал, асуудал хүчийг нэмж өглөө гэхэд хамт олноороо юмыг шийдэх сайхан. Гэхдээ хамт олноороо шийдсэн юмыг хамт олноороо удирдаж болдоггүй. Үүнийг амьдрал дээр мэднэ.

10 хүн удирдаад гарахад хоёр санаатай хүн, хоёр хүн толгойлж энэ бүтдэггүй. Ийм учраас бид нар энэ зориод байгаа, тэмцээд байгаа юмаа ямар ч байсан хадгалахын тулд, хамгаалахын тулд юуны өмнө ардчиллыг хамгаалахын тулд энэ төвлөрсөн нэг удирдлага зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Нөгөө талаар бид ардчиллын цэвэр сонгодог хөгжсөн орны хувилбарыг шууд энэ манай нийгэм, эдийн засгийн нөхцөл дээр тавьж болохгүй.

Эдийн засгийн баталгаа байж ардчилал хөгжинө, нийгмийн баталгаа байна, түүнийг хэрэгжүүлэх хүний оюн санааны хөгжил, түүний хөгжлөөс хамаарна.

3.

Манай хүмүүсийн хөгжил, нөгөө одоо бид нарн хэрэгжиж тавих гээд байгаа тэр хоёрын хоорондын хөгжлийн ялгааг бид нар ойлгохоос арга байхгүй. Хүн хэрэгжүүлэх учраас энэ утгаар нь авч үзэх хэрэгтэй. Ингээд энэ дээр юу ярих гээд байна вэ гэхээр ерөөсөө . Засгийн тэргүүнийг ерөнхийлөгч, Засгийн газрыг томилдог энэ асуудлыг энэ дээр оруулбал яасан юм бэ? Засгийн газар парламентад тайлагнадаг байна биз, Ерөнхийлөгчийг парламент сонгодог ийм байж болох байх.

Нөгөө талаар Засаг, захиргааны асуудал дээр нэг асуудал байна. Энэ дээр одоо бол өөрчлөх цаг нь бишээ. Яагаад вэ гэвэл энэ чинь гадаад, социалист орнуудад задрах процесс явагдаж байна. Үндэсний асуудал хөндөгдөж байна. Манай орон нутагт ч гэсэн нутгархах, хуучин багаараа сэргэх, үндэсний асуудал яригдаж байгаа ийм үед хөндөгдөөгүй байгаа асуудлыг бид нар заавал ингэж хөндөж тавих юм бол энэ асуудал бүр эсэргүүцэлтэй тулгарна.

Энэ хийгдэхэд асар их эсэргүүцэлтэй тулгарна. Нийгмийн нөхцөл бүрдээгүй байна. Нөгөө талаас энд үндэслэл тавигдаад байна л даа. Өөрөөр хэлбэл захиргааны системийг өөрчилж байгаад, эдийн засгийнхаа хэвшлийг түүнд тааруулах юм шиг. Энэ эсрэгээрээ баймаар байна. Өнөөдөр эдийн засгийн шинэ хэвшил, шинэ асуудал тавигдаж байгаа учраас энэ нь зүй жамгаараа нэг хэсэгтээ хөгжиг. Тэгээд үүнд нь захиргааны систем нь хэрэв тохирохоо байж байгаа бол тэр тохирохоо байж байгаа үед нь өөрчилье. Өнөөдөр сум бол аймаг бол эдийн засгийн шинээр бий болж байгаа, эдийн засгийн хэвшил, анхны нэгжүүдэд тохирохгүй байгаа тийм хандлага түүнийг саатуулж байгаа юм байхгүй, ийм учраас зохиомлоор үүнийг мөн л төр засгаас аж ахуйг удирддаг системдээ захируулж аваачих шаардлага алгаа гэсэн ийм юм байна.

Цэрэвдүгээрт нь, нэг зүйл ийм юм . Ер нь асуудалд хандах юман дээр ийм зүйл байх юм. Энэ хуучин юмыг байлгана гэдэг асуудал дотор учир байна. Энэ хуучинсаг үзэл биш юм ерөөсөө.

Асуудалд яаж хандаж байна вэ? бодитой юу, бодьгүй юу гэдгээрээ хуучинсаг, шинэлэг гэдгээрээ яригдахаас биш, хуучин юмыг л байлгана гээд байвал хуучинсаг гэдэг асуудлаараа хандаж болохгүй ийм юм баймаар байх шиг байна. За өөр юмгүй.

165 дугаар тойргийн депутат Ч.Гомбосүрэн:

Бага Хурал Үндсэн хуулийн төсөл боловсруулсан комиссынх оруулж байгаа энэ БНМАУ-ын Их цаазын төсөл, Үндсэн хуулийн төслийг хүч хөдөлмөр орсон, өнөөдрийн бидний энэ хуралдаж байгаа II хуралдаанаар монгол улсынхаа их хуулийг боловсруулж гаргах, ийм бүрэн боломжтэй, хөдөлмөр, бүтээл шингэснийг өндөр үнэлж байна.

Тэгээд хэдэн зүйлийн санал хэлье. Нэгдүгээрт хэлэх зүйл бол бид өнөөдөр өөрчлөх зүйлээ хэр зэрэг онож байгаа юм бэ? Магадгүй Бага Хурлаас боловсруулсан, төсөлд зарим нэг зүйлийг депутатуудад үлдээж, өөрсдийнхөө саналыг толилуулж байгаа гэдгийг ойлгож байна. Ер нь оролдох ёстой, өөрчлөх ёстой зүйлээ хэр зэрэг зөв сонгож авах вэ гэж өнөөдөр анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай байна гэдэг ийм зүйл надад ойлгогдож байгаа.

Энэ юу гэсэн үг вэ гэхээр өнөөдөр бид улсынхаа нэрийг засаг захиргааныхаа гол асуудалтай холбоотой хөдөлмөрчдийн дургүй байгаа зүйлийг хүчээр тулгаж гэж байгаа энэ зарим хандлагууд бол үнэхээр амьдрал дээр биелэх үндэсгүй байна. Өнөөдөр ард түмэн зарим нэг тийм хэлбэрийн төдий нэг шинэчлэхийн төлөө, өөрчлөхийн төлөө гэсэн сэтгэлээр хандаж байгаа зүйлийг үнэхээр хүлээж авахгүй байгааг бид бас хэлэх ёстой гэж үзэж байна.

Ингээд нэг зүйлийг хэлэхэд сөрөг ганц нэг асуудлаар, сөрөг зүйл гарч болзошгүй гэдэг зүйлээр хоёр зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт нь юу байна вэ гэхээр бид энэ газрын тухай асуудалтай холбогдоод хоёр саналбайна. Энэ санал юу байна вэ гэхээр нэгдүгээрт, энэ газрын тухай асуудлын ер нь хэтийн хандлага бол зөв зүйтэй гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Тэгэхдээ өнөөдөр цаг нь мөн үү? үгүй юу? үүнийг бид Үндсэн хуульдаа өнөөдөр тунхаглах тэр цаг үед нь ирчихээд байна уу? үгүй юу? Энэ дээр эмзэглэж байгаа сөрөг хоёр зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт бид цөөхөн, монголчууд 2 сая. Бид нэг 20 сая 30 сая бол бас өөр байна. Бид өнөөдөр эдийн засгийн талаар эрийн цээнд хүрчихсэн, өөрөө өөрийгөө тэжээж амьдраад яваад байх чадалтай болсон. Ийм үед бол нэг өөр байна. Тэгэхээр энэ цаг үеийг зөв мэдрэмжтэй хандахгүй бол бидэнд сэтгэл эмзэглүүлж байгаа нэг тийм асуудал байна.

Хоёр дахь нь, монголд хаана ч давтагдашгүй, тийм нүүдлийн хэлбэрээр ашигладаг, монголын газар нутаг ер нь өөр дэлхийд ч гэсэн аль нэг оронд давтагдашгүй ийм л их эх оронд бид амьдарч байгаа болов уу гэж төсөөлж явдаг юм. Энэ нь юу вэ гэхээр монголчууд үнэхээр бэлчээр нутгаа нүүдлийн журмаар эзэмшдэг, бид байгалийн бүрэн хараат нөхцөлд мал аж ахуйгаа эрхэлдэг, манай хөрш байгалийн ургамлын үржил шим, хөрс ялгавартай, зарим газар нь нэлээд хамжээнд цөлжиж байгаа, зарим нөхцөлд бид ер нь тодорхой хүн хувьдаа юм уу? түрээслээд, өмчлөөд авчихсан байхад тэр хүн өөрийнхөө юмыг хэнтэй хувааж, гадаадын ямар харьяат хүнтэй хувааж эзэмшинэ тэр хүний өөрийн хэрэг. Тэгэхээр нөгөө цөөхөн улс маань тийм зүйл жаахан лавшруулбал яанаа гэдэг ийм сэтгэл төрөөд байгаа юм. Ингээд бид юу ч гэсэн монголчууд өөрийнхөө эх орны эзэн байх энэ бололцоо нөхцөлийг их тал талаас нь бодох юмсан гэсэн нэг ийм зүйл бодогдоод байгаа юм.

Хоёрдахь зүйл, монголчууд бид туйлшрах талаар бол хэдэн үеийн турш бидэнд ойлгогдоод байгаа хэд хэдэн эвгүй туйлшрал байна.

6.

Энэ юу вэ гэхээр зэрэг 1930-аад оны үеэр гадны тусламжгүйгээр нэг хоёр жилийн дотор 700 гаруй сум хийд бид нэрлэгдэж байсан түүх соёлынхоо өв уламжлалыг хоморголон \odot устгасан ийм зүйлээ бид сэтгэл эмтрэн шагшин ярьцгааж байгаа. 59 онд бүгдээрээ нэгдэлжинэ гэж нэгэн зэрэг уулгалж асуудлыг шийдсэн гашуун сургамжийг өнөөдөр элдэв янзын нэрээр мэдэрч сонсож байгаа.

Гэтэл өнөөдөр зарим талаар бид 100 сая долларын юмаар эдийн засгийнхаа уут юмыг урагш нь сэгсэрсэн, доош нь сэгсэрсэн тухай яригдаж байхад, бас олон бригадын төв, хэсгийн төв, ерөмдмөл худаг, хашаа, түүнээс дутахааргүй юм өнөөдөр үрэгдээд хайран яйран болоод балгас болоод байж байгааг бид бас харж байгаа. Гэтэл нөгөө хэдэн сум маань одоо хлш хөшуу болгоно гээд хоморголчихвол дахиад нэг хэсэг балгастай үлдэхгүй байгаа.

Ийм балгастай үлдэхгүй гэх баталгаа алгаа. Тэгэхээр ийм нүгэлтэй юм хийх асуудлыг бид заавал хийж байх улс юм уу? Үүнийг жаахан ухаарч бодвол яасан юм бэ? гэсэн ийм зүйлийг хэлье гэж бодсон юм.

Гуравдугаарт хэлэх зүйл бол, өнөөдөр бид видео \odot кино үзлээ. Тэгэхээр ийм хүүхдийн тоглоом шиг юм үнэхээр хэрэггүй байна. Үнэхээр энэ бол юу гэх юм бэ дээр, монгол сэтгэл зүй гэдэг юм уу? бид нарыг арай иймэрхүү сэтгэл зүйтэй улсууд, хүчтэйхэн нэг сайхан кино үзүүлээд, аятайхан хөгжим уянгалуулаад, тэгээд зөвхөн шиг тайлбарлаад хамгийн эцэст нь заа нөхдүүд та нар үүнийг яг дагана шүү, хэрвээ үүнийг дагахгүй бол монгол хүн биш шүү гэсэн ийм ойлголтоор төгсгөвөл бараг болно биз дээ гэсэн ийм сэтгэлээр арай хандаагүй байгаа.

Би энэ шувууны талаар нэг тайлбарлая гэж санаад байна. Энэ яагаад гэвэл би сөрж байгаа юм бишээ. Юм мэддэг хүмүүсээс сонссон юмаа хэлье. Тэгэхээр тэр өнөөдрийн гаргадаг манай монголын 1206 оны сүлдний тухай хүмүүсүүд ингэж ярьж байна.

Ираныг эзлээд нэг эзэлсэн тэр омгийн, нэг хошууны, одоогоор бол нэг омгийн, нэг омгийнхны цэргийнхний туг юм байна. Тэнд тэр харцага шувуутай туг, энэ бол түүний сүлд ч биш, тэгэхдээ энэ бол эзэн Чингисийн сүлд гэж хэлчихээд, ингээд сүр бадруулаад, ингээд байх юмаа. Морь гэдэг чинь иддэг, уудаг, яадаг, яадаг гэнээ, гэтэл дэлхийн 7 хөгжилтэй орны нэг Канад улсад төрийнхөө сүлдэнд модны навчаар төрийн сүлдээ хүндэлж дээдэлдэг байна. Энэ чинь модны навч чинь едөрт ер нь яаж унадаг, яаж ургадгийг бид мэдэрнэ. Ингээд юмыг өөрчлөхийн тулд итгүүлэхийн тулд ингэж худлаа тайлбарладаг юмаа болимоор байнаа гэдгийг хэлмээр байна.

Хамгийн сүүлд нь ганцхан санал байна. Энэ засаг төрийн хувьд, төрийн тогтолцооны хувьд парламентын хэлбэрийг бид сонгож авах хэрэгтэй. Энэ бол гарцаагүй, хоёр танхимтай байх хэрэгтэй, депутат гэж нэрлэнэ үү? их хурлын гишүүн гэж нэрлэнэ үү, энэ бол одооны байдлаар 140-150-д байвал зүйтэй. Байнгын ажиллагаатай, урьдах парламентын хэлбэр нь 30-аас илүүгүй байх шаардлагатай. 76 хүн чинь цөмөөрөө туслахтай, тэр байтугай хүн болгон нэг нэг аппарат байгуулах тухай яригдсан шүү өчигдөр. Тэгэхээр бид одоо 76 хүнээ нэг нэг туслах дээр аппарат нэмээд ингээд монгол улс зөвхөн энэ удирдлагад 150-160 хүн ажиллах бололтой юм шиг байх юм. Урьдчилаад тооцоолоод үзэхэд лав л цалин нь одооны ханшаар 6 сая орчим төгрөг сард авч байх ийм л юм тогтолцоо үүсэх гээд байгаа. Ийм зүйлүүдийг хэлье, тэгээд цаг дууссан учраас дараа хэлэх зүйлүүдээ хэлье. Баярлалаа.

Ж. Уртнасан: Баярлалаа. Тайван сууна уу, депутат нараа. Энд зармалын чанартай олон юмнууд байна. Өнөөдрийн хуралдаанд уг хэлэх асуудлыг ингээд тасалъя. Маргааш өглөөний хуралдаан дээр 3 дугаар микрофон, 58 дугаар тойргийн депутат Рэнцэн-балаас эхэлж уг хэлнэ. Төв байгаа, энэ голоор сууж байгаа депутатуудаас сүрхий гомдол ирлээ. Энэ юу вэ гэхээр бид одоо голд суугаа депутатууд микрофоноос хол, тэгээд сая микрофон дээр санал бичихэд тэрүүхэн нутаг дэвсгэрийн чанартай бичигдээд

бид үлдэв. Тийм учраас голын депутатуудад зориулж 9 дүгээр микрофон нээж өгнө үү. Бид угээ хэлбэ гэж голд суугаа депутатууд 27 хүн саналаа ирүүлснийг хүлээн авч маргааш өглөө 8 гэсний дараа 9 дүгээр микрофон нээж та бүгдийг дэс дараагаар энд урьж байна.

Одоо Монголын ардчилсан Намын дарга Бат-Үүл өөрийн биеэр нэгэн зарлал сонсоё гэж ихэд хүсэмжилсэн учраас зарлалыг сонсоё.

52 дугаар тойргийн депутат Бат-Үүл:

Би уг хэлэх гэж гараагүй, урилга та бүхэнд зарлах гэж индэр дээр гарсан. Улс орныхоо түүхэн шинэ эрин үеийг тунхаглан нээхээр хуран цугларсан депутат та бүхэнд зориулан МОН-ын үндэсний хорооноос өнөөдрийн 19.30 минутанд Улаанбаатар ресторанд хүндэтгэлийн зоог барина. Энэхүү зоогт БНМАУ-ын Ерөнхийлөгч, БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч, Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар, эрхэм хүндэт депутат та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

167 дугаар тойргийн депутат Ж. Гүрбазар: Би ганц санал хэлэх үү? даргаа. Надад бол урих барих юм байхгүй л дээ. Би депутатуудтайгаа нэг саналаа солилцох уу гэсэн юм. Буруу байж болно, уучлаарай; Бид явцаа их зөв мэдэрч байвал бид нарын гарах шийдвэр их мэргэн болох болов уу?

Нэг ийм юмыг болгоогоод үзээч депутатууд аа. Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн мэдүүлсэн БНМАУ-ын Үндсэн хууль ч байна уу? Их цаазын төслийг БНМАУ-ын Ардын Их Хурлын II дахь чуулган үндсэндээ хүлээгээд авчихлаа. Үндсэндээ хүлээгээд авнаа гэдэг чинь ерөнхий хэлэлцүүлгийн нэг талыг бараг үгүй болж байнаа гэсэн үг. Тэгэхээр эндээс үүдээд тодорхой юм руугаа өншөдөр дуусгая гэж байгаа юм биш, тодорхой юм руугаа хурдан орох гэж байгаа юм биш үү.

Үндсэн хуулийн ерөнхий хэлэлцүүлэг гэдгийг би бодохдоо энэ Үндсэн хуулийг Их Хурал авах уу? үгүй юу? энэ Үндсэн хууль 1960 оны Үндсэн хуультай, 1940 оны Үндсэн хуультай, хүн төрөлхтөний түгээмэл тунхаглалтай таарч байна уу? үгүй юу гэдгийг бид ярих ёстой байсан байх. Тэгэхээр таарсан учраас депутатууд тодорхой хэсэг бүлэг рүү ярилаа.

Хоёрдугаарт, би айж байна. Ерөөсөө эндээс харин хуульдаа муугаар нөлөөлнө. Яагаад гэвэл ямар нэгэн бүлгийн ухуулга, мар ямар нэгэн юмыг одоо бие биендээ тавьж эхэллээ. Ёстой амандаа ус балгасан юм шиг байж байгаад бүлэг дээр орох ёстой, яриа бол. Харин Ерөнхий Үндсэн хуулийн хэм хэмжээ, хүн төрөлхтөний үндсэн хуулиудын хэм хэмжээг бид ярих ёстой. Энэ нь депутатуудад таалагдаж, үндсэн хуулийг байгуулсан комисс, Улсын Бага Хурал баяр хүргэхээр юм байна гэдгийг би ойлголоо. Их Хурал хүлээгээд авчихаж.

Тийм учраас мэргэн оюундаа бодоод дараа тодорхой хэлэлцүүлэгтээ орох юм биш биз дээ.

Ж. Уртнасан: Зарлал мэдээллийн шинж чанартай асуудлыг цааш үргэлжлүүлбэ.

Тэгэхээр та бидний түрүүн баталсан депутатуудын хороо саяхан хуралдсан депутатын хороо хуралдаж, өөрийн дарга, орлогч нарыг, нарийн бичгийн дарга нарыг сонгосон.

Депутатын хорооны даргаар Гомбожав гуай томилогдсон. Нарийн бичгийн даргаар Данзангийн Лүндээжанцан сонгогдсон. Энэ депутатын хороо хуралдаад өөрийнхөө анхдугаар протколыг та бидний сонорт хүргэж байна. Энэ депутатын хороо байгуулсан тухай тогтоолыг нэгэнт санал хураах учраас өглөө та бүхэнд сонсоё гэж бодож байна.


Депутатуудын хорооны анхдугаар хурлаар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж 325 дугаар тойр гийн депутат

Гомбожавыг, хорооны нарийн бичгийн даргаар 15 дугаар тойргийн депутат Лундээжанцанг сонголоо. Монгол улсын Их цаазын төслийн эх баригчаар улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Б.Чимид, депутатуудын хорооны нарийн бичгийн дарга Лундээжанцан нарыг томиллоо. Тус хорооны дэргэд Их цаазын Үндсэн бүлгүүдээр ажлын 5 хэсэг байгууллаа гэсэн байна.

Депутатуудын хорооны гишгүүдийг 7 цагт танхимдаа үлдэхийг хүссэн байна.

Хуралдааны танхимд нутаг дэвсгэрийн бүлгийн ахлагч нарыг түр үлдэхийг зарлаж байна. Одоогийн байдлаар уг хэлэх, санал давхардсан учраас гээд 2 депутат өөрийнхөө нэрийг татаж авлаа. 19 депутат саналаа бичгээр ирүүлснийг бид эмхтгэж, ажлын группт шилжүүлнэ.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.15.
Кассет № 75
18.45-19.00

Ж. Уртнасан — Депутатын хэлсэн үг, саналыг бичгээд өгвөл мэдээлэх үү, Их Хурлын материалыг тухайлбал депутатуудын Үндсэн хуулийн талаар хэлсэн үг, саналыг тусгай товхимол болгож гаргах уу гэж байна. Мөн бичгээр авбал хэн авах вэ гэж байна. Бичгээр авахыг манай орлогч дарга Моондой авна. Энд хэлсэн үг бүхэн бүхэл ᠔тэн ном болж, түүхэнд үлднэ.

Хурлын дарга Ж. Уртнасан танаа. Сүлд, далбаа, төрийн бэлэгдэл боловч, хувь хүний өмч бүтээл байдаг гэсэн. Тиймээс одоогийн сүлдийг зохиогч, ардын зураач Ц. Цүлтэм гуайгаар үг хэлүүлж өгөхгүй юу. Хуучин сүлдийг хөдөлмөрчид одоогоор өөрчлөхийг хүсэхгүй байгаа юм. Гэтэл Чимид дарга зохиогчийг өөрөө өөрчлөхийг зөвшөөрсөн гэж байсан. Автор зөвшөөрнө гэдэг нь өөрөө бас нэгийг бодсон байж магадгүй.

Хоёрт, далбааг зохиогч нь Б. Ринчин гуай доктор үнэн үү гэж байна. Энд тайлбар өгүүлэхийг ажлын хэсгийн ахлагч бид Маамад дамжуулна. Үүнийг сонордуулъя, бид маргааш энд хариу өгөх нь зүйтэй байх.

Ардын Их Хурлын депутатуудаас хэвлэл мэдээллийн албаны хам зөвшөөрөл хүсч байна. Зарим депутатууд өглөө, өдрийн ирцийг авч байх үед ойр орчныхоо ирээгүй депутатуудын ирцийг өгч байгаа явдал сүүлийн үед ажиглагдах боллоо. Үүнийг хэвлэл, мэдээллээр зургаар мэдээлэх зөвшөөрөл олгоно уу. Энэ явдал нь дээрээс харахад их сайхан тодорхой харагдаж байна гэж хэвлэл, мэдээллийнхэн ирүүлж байна.

Дашзэвгэ, Гүнджалам депутатуудаас хүсэлт ирсэн. Засаг захиргааны нэгжийн асуудлаар хэд, хэдэн сарын турш групп ажиллаж шинжлэх ухааны үндэстэй цогцолбор материал боловсруулсан. Холбогдох зураг, схем өгч байгаа байхд Бага Хурлын дарга энэ талаар юу ч хэлсэнгүй. Энэ нь гайхалтай. Энэ бэлэн материалыг цаг тогтоож, депутатуудад танилцуулж өгөхийг хүсье. Ийм материал байгааг та тэндээсээ хэлж өгнө үү гэдгийг хүссэн байна.

2.

Материал байгаа, хэрэв та бүхнийг хүсвэл бид энд зааланд тавьж энэ материалыг үзүүлж, сонирхуулж болно. Ийм зарлалын чанартай зүйлүүд байна. Өнөөдрийн хуралдааныг дэгийнхээ дагуу амжилттай явуулж дуусгаж байна. Манай орлогч дарга Моондой өнөөдрийн хэвлэл мэдээллийн зүйлүүдийг эмхтгээд гол зүйлүүдийг та бүхэнд сонгоё.

Уучлаарай, бас нэг зүйлийг хэлэхгүй орхиж болохгүй байна. Өчигдөр та бүхний сонорт цухас дурдаад орхисон, манай орон даяар Отгонбаярын хэрэг гэж дуулиантай явж байгаа эхлэл, төгсгөлгүй хэргийн холбогдолтой Авирмэд, Буджав, Уранчимэг, Дамбий нар депутат Гүрбазараар дамжуулж та бидэнд шаардах бичиг ирүүлсэн. Энэ шаардах бичгийг та бүхэнд зөвхөн сонордуулаад орхисон. Өнөө өглөө II-р сарын 15-ны өдрийн 10 цагт уулзъя гэсэн. Депутат Гүрбазар, манай орлогч дарга Лоохууз гуай нар хүлээн авах байранд нэг цагийн турш хүлээсэн боловч энэ хүмүүс ирсэнгүй. Өөрсдийнхээ шаардлагыг Монголын хүний эрхийн хороо Эмнести Интернешнл-д явуулна гэсэн илгээлт байгаа юм. Үүнийг та бүхэнд сонордуулъя. Энэ хүмүүс өөрсдөө уулзахаар ирсэнгүй. Тийм учраас депутатад энэ шаардахыг дамжуулна.

Д.Моондой /278-р тойргийн депутат/ -Эрхэм хүндэт депутатууд аа! Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдааны нэр дээр байгууллага иргэдээс бичгээр 22, цахилгаанаар 8, утсаар 17, хүлээн авах байраар 15 хүн ирж, санал, хүсэлт тавилаа.

Сүхбаатарын районы 16-р хорооны тэргүүлэгч өндөр настан Индорж: Депутатууд асуудлыг шийдвэрлэхдээ төрийн ноён нуруу сайтай хандах, би тоймлоё.

Сүхбаатар районы 8-р хорооны иргэн Содномцэрэн, Найрамдлын районы 9-р хорооны иргэн Пүрэв нар, мөн Найрамдлын районы 4-р хорооны өндөр настан Дэлэг нараас өнгөрсөн онд Ардын Их

3.

Хурлын сонгууль муу явагдаж, хүнээ олж сонгоогүйгээс өнөөдөр депутатуудын нүүр, царай харагдаж, депутатууд хэрэлдэж байна. Хуралдаанаас ард түмний сэтгэлд нийцсэн сайхан шийдвэр гаргана гэдэгт би хувьдаа тэнгэлзэж байна. Мөн сайн хууль гарч чадахгүй байна гэж бодож байна гэсэн байна.

Найрамдлын районы 2-р хорооны иргэн Жигмид /утсаар/ II-р сарын 14-ний байдлаар 30 депутат хуралдаа оролцоогүй байна. Үүний шалтгааныг ард түмэнд мэдээлнэ үү гэж байна.

Сүхбаатарын районы 18-р хорооны иргэн Нэргүй/утсаар/ II-р сарын 14-ний депутатаар зохиолч Бямбаа жил гурай хугацаанд сонгогчидтойгоо нэг ч удаа уулзсангүй. Хэл амтай сонгогчдоод алга болсон. Тийм учраас тайланг нь бүх депутатуудаар хэлэлцүүл гэсэн байна.

Төв аймгийн Зуунмод хотын өндөр настан Намжилдорж: -Шийдвэрлэх, хэлэлцэх гэж буй асуудлынхаа голыг барихгүй, аар, саар юмаар хөөцөлдөх, маргалдах, хэт нэг тийшээ туйлширч цаг алдаж байна.

Октябрийн районы ОСГ-ны 26-р хорооны өндөр настан Буузгараас: Зарим депутатууд хуралд идэвхгүй оролцож байна. Хурал тасалдаг депутатууд байна. Мөн хуралд санал өгөхөөс түдгэлзэж байгаа депутат байна. Энэ нь уг депутат асуудалд хир хандаж байгаагийн баримт юм.

Их цаазын төслийн талаар олон санал ирсэн. Сүхбаатарын районы 6-р районы иргэн Шагдаргочоогоос: Ардын Их Хурлын 75 гишүүнтэй, байнгын ажиллагаатай болгох нь их зардал гарах нээ. Иймд гишүүдийн тоог цөөлөх, Их цаазын төсөлд ямар нийгэмд хүрэх, түүний бааз суурь нь тодорхой бус байна. Байдлаас үзэхэд өмнөх 70 жилийн алхмаасаа ухрах гээд байгаа юм шиг ойлгогдож байна. Их цааз биш Үндсэн хуулиар нь нэрлээ.

Түүхий эдийн нэгдэлд ажилладаг Авирмэд, Хотын барилга, трестийн жолооч Буджав, Нийгэм хангамжийн автобаазын инженер Жаргалсайхан нараас. Төрийн сүлдийг хуучнаас нь таван хошууг аваад, бусдыг нь хэвээр байлгая. Төрийн дуг, далбааг хэвээр байлгая гэж бас хүсэлт тавьсан байна.

Төв аймгийн Зуунмод хотын өндөр настан Намжилдоржоос: Парламентын засаглалыг хоёр шаттай байхаар бодож, Ардын Их Хурлын депутатын гишүүдийг 100 хүнтэй, Улсын Бага Хурлыг 25 хүнтэй байлгах нь зүйтэй. 25 хүн байнга ажиллагаатай байх. Үндсэн хуульд газрыг төрийн өмчид байлгах, хувьд өмчлүүлэхгүй, эзэмшүүлэхгүйгээр тусгах нь зүйтэй.

Октябрийн районы 21-р хорооны өндөр настан Доржоос, мөн хорооны иргэн Даваадорж, Улсын Их дэлгүүрийн ажилтан Надмид, Сарантуяа, Бямбажав нарын 32 хүн утсаар ярьсан байна.

Үндсэн хуулийг газрыг өмчлүүлэхээр тусгаж байгаа нь маш тохиромжгүй, мөн зохисгүй гэж үзэж байна. Газрыг түрээслэж болохгүй гэсэн байна.

Сүхбаатарын районы 16-р хорооны тэргүүлэгч, өндөр настан Ишдорж, Найрамдлын районы 2-р хорооны иргэн Жигжид, Октябрийн районы 10-р хорооны өндөр настан Олзвой нараас.

Их цааз гэсэн үгээ ард түмэнд тайлбарлаж өгөө чээ. Иргэдийн тавьж байгаа санал, хүсэлтийг Ардын Их Хуралд танилцуулж байх гэж байна.

МоАН-ын Багануурт дахь зөвлөлдөх төвийн дарга Бэгзсүрэнгээс.

Их цаазын төслийг хэлэлцэж байгаад баяртай байна. Улс орон, ард түмнийхээ нийтлэг эрх ашиг, сайн сайхны төлөө өндөр хариуцлага, идэвх чармайлттай ажиллан, Монгол улсын Их цаазыг амжилттай батлана гэдэгт итгэж байна.

Октябрийн районы 16-р хорооны тэргүүлэгч Ишдорж, 18-р хорооны Нэргүй, УИД-ийн Надмид, нарын 32 хүн, мөн Октябрийн районы Пүрэв, Загаржав нар утсаар ярьсан.

Төрийн сүлд далбааг хэвээр байлгах.

Найрамдлын районы 1-р хорооны иргэн Дорлигсүрэнгээс Үндсэн хуульд хүний эрхийн тухай бүлэгт хохирогчийн эрхийг хамгаалах тухай асуудлыг тусгах нь зүйтэй. Өөрийн буруугаас бусдад зодуулсан, гэмтэл авсан, ах, дүү төрөл төрөгсөд нь амь үрэгдсэн Г.М. тохиолдолд буруутай этгээдээр хохирлыг төлүүлж байх гэсэн байна.

Сүхбаатарын районы 25-р хорооны иргэн Бямбаагаас. Ардын Их Хурлын ажиллагаанд амжилт хүссэн байна.

Сүхбаатарын районы 13-р хорооны иргэн Эрдэнэбилэгээс. Бэлчээрийн эзэмшлийн газрыг хувьд өмчлүүлэхгүй байхаар Их цаазад тусгах.

Сүхбаатарын районы 23-р хорооны иргэн, мөн 24-р хорооны иргэн Өвгөнхүү, Даваахүү нараас.

Цагаачлалын тухай хууль гаргахгүй байх гэсэн байна.

Сүхбаатарын районы 4-р хорооны иргэн хуульч Цэрэнбалтаваас.

Цэргийн шүүхийг татан буулгаж, цэргийн гэмт хэргийг энгийн шүүхээр таслан шийдвэрлэж байхаар Үндсэн хуулийн төсөлд тусгажээ. Үүнийг зохимжгүй зүйл гэж үзсэн байна.

Төв аймгийн малын их эмч Доржсүрэнгээс

Улсын нэрийг Монгол улс, Үндсэн хуулийг Их засаг гэж нэрлэе. Хөдөө орон нутаг, сумдыг хуралгүй болгоё гэсэн санал тавьсан байна.

Дараа нь эвсэл, холбоодоос захидал, мэдэгдэл ирсэн байна.

Монгол улсын улс төрийн хэлмэгдэгсэдийн холбооноос бидэнд уриалга ирүүлсэн. Энд Монгол улсын үндэсний соёл, хүний эрх чөлөө, сүсэг бишрэл, сүүлийн 70 жилд ихээхэн хэлмэгдэж байсныг Үндсэн хууль авч үзээ чээ гэсэн байна.

Дараа нь төрийн өмчийг монопол эрхийг эсэргүүцэх хөдөлгөөнөөс уриалга ирсэн байна. Үүнд жишээ нь Эрдэнэт комбинат Засгийн газрын тогтоол гаргуулж, зөвлөлтийн барилгын удирдах объектууд, Шарын гол, Хөтөл, Ингэттолгойн САА-дыг нэгтгэн концерн болгож улсын таван монопол хөрөнгөтэй үйлдвэрийн газар болж байгааг эсэргүүцсэн уриалга байна. Ийм л саналууд байна.

Та бүхэнд баярлалаа, өнөөдрийн хуралдаан завсарлаж байна. Сайхан амраарай!

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ц.Баярмаа

Ц.БАЯРМАА

Бичсэн С.ТУУЛ